



БАРУУН БҮСИЙН ЛОГИСТИКИЙН НЭГДСЭН ТӨВ ТЕХНИК ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДЭСЛЭЛ

Агуулга: Увс аймаг болон Баруун 5 аймаг, Улаанбаатар хот, ОХУ-аас дамжин өнгөрүүлэх бүх төрлийн импорт, экспортын тээвэрлэлтэнд дэмжлэг үзүүлэх зорилготой Логистикийн нэгдсэн төвийг байгуулах талаарх техник эдийн засгийн үндэслэл

Захиалагч: Увс аймгийн Засаг даргын тамгын газар

Гүйцэтгэсэн: Нью Урбанизм ХХК

Варм Бьюлдинг Констракшн ХХК

Улаанбаатар хот

2023 он

БАРУУН БҮСИЙН ЛОГИСТИК ТӨВ БАЙГУУЛАХ ТЕХНИК, ЭДИЙН ЗАСГИЙН
ҮНДЭСЛЭЛ, ЗУРАГ ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЖИЛ
ХХААХҮЯ/202102058

ЭЦСИЙН ТАЙЛАН

ХҮЛЭЭН АВСАН: УВС АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

УВС АЙМГИЙН ЗДТГ-ЫН ХОХБТХ-ИЙН ДАРГА	Ж.ЭРДЭНЭТОГТОХ
УВС АЙМГИЙН ЗДТГ-ЫН ХОХБТХ-ИЙН МЭРГЭЖИЛТЭН	Т.БАТБАЯР
УВС АЙМГИЙН ЕРӨНХИЙ АРХИТЕКТОР	Б.ЭНХБАЯР
УВС АЙМГИЙН ХХААГ-ЫН ДАРГА	С.ЦОЛМОН

БОЛОВСРУУЛСАН: НЬУ УРБАНИЗМ ХХК

ЗАХИРАЛ

З. ТУЯА

Улаанбаатар хот

2023 он



ГҮЙЦЭТГЭСЭН БАГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Нэр	Албан тушаал	Хариуцсан хэсэг	Гарын үсэг /тамга/
УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ:			
З.ТУЯА	НЬЮ УРБАНИЗМ ХХК-ийн Захирал	Удирдлага зохион байгуулалт	
Г.САЙНБАЯР	ВАРМ БЮЛДИНГ КОНСТРАКШН ХХК-ийн Ерөнхий захирал	Удирдлага зохион байгуулалт	
АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН:			
Г.САЙНБАЯР	Ерөнхий архитектор	Архитектур төлөвлөлт	
Х.ЕСӨН-ЭРДЭНЭ	Мэргэшсэн архитектор	Архитектур төлөвлөлт	
Б.ДАВААХҮҮ	Мэргэшсэн барилгын инженер	Барилга бүтээц	
Д.БИЛГҮҮН	Барилгын инженер	Барилга бүтээц	
Ч.СЭНЭДНАСАА	ХАС-ын инженер	Халаалт, агаар сэлгэлт	
Г.ХУЛАН	Мэргэшсэн ЦБУ-ын инженер	Ус хангамж, ариутгах татуурга	
Б.БАТ-ЭРДЭНЭ	Мэргэшсэн цахилгааны инженер	Цахилгаан хангамж	
Х.БОЛОРТУЯА	Мэргэшсэн холбооны инженер	Мэдээлэл, холбоо хангамж	
Б.БААСАНСҮРЭН	Мэргэшсэн барилгын төсөвчин	Барилгын төсөв	
П.ЭНХБОЛД	Мэргэшсэн эдийн засагч	Тайлбар бичиг нэгтгэл, нийгэм эдийн засгийн төлөвлөлт	



Гүйцэтгэгч: “Нью Урбанизм” ХХК, “Варм Бюлдинг Констракшн” ХХК

Хаяг: Улаанбаатар хот, СБД дүүргийн 1-р хороо, Олимпийн гудамж,
9-19 тоот

Утас: 98006237

И-мэйл: info@newurbanism.mn



АГУУЛГА

ТОВЧИЛСОН ҮГСИЙН ЖАГСААЛТ	6
ЗУРГИЙН ЖАГСААЛТ	7
ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ	9
БҮЛЭГ 1. ЕРӨНХИЙ ТАНИЛЦУУЛГА.....	14
1.1 ҮНДЭСЛЭЛ БА ХЭРЭГЦЭЭ ШААРДЛАГА	14
1.1.1 Эрх зүйн үндэслэл.....	14
1.1.2 Нийгэм-эдийн засгийн үндэслэл	14
1.2 ЗОРИЛГО БА ЗОРИЛТ.....	16
1.3 ХАМРАХ ХҮРЭЭ	18
1.4 АРГАЧЛАЛ.....	19
БҮЛЭГ 2. ТӨСЛИЙН ТАЛБАЙН ОДООГИЙН БАЙДЛЫН СУДАЛГАА	21
2.1 ИНЖЕНЕР ГЕОЛОГИЙН НӨХЦӨЛ.....	22
2.1.1. Инженер геологийн судалгааны үндэслэл.....	22
2.1.2. Судалгааны ажлын аргачлал	22
2.1.3. Байр зүйн зураг.....	23
2.1.4. Уур амьсгал.....	24
2.1.5. Геоморфологийн хэв шинж ба физик-геологийн үзэгдэл үйл явц.....	25
2.1.6. Геологийн тогтоц	25
2.1.7. Гидрогеологийн нөхцөл	26
2.1.8. Геокриологийн нөхцөл	26
2.1.9. Инженер-геологийн ангилал ба ул хөрсний физик-механик шинж чанар	26
2.1.10. Инженер геологийн судалгааны дүгнэлт	34
2.2 БАЙГАЛЬ ОРЧНЫ НӨХЦӨЛ.....	35
2.2.1. Физик газарзүйн нөхцөл.....	35
2.2.2. Цаг уурын нөхцөл	36
2.2.3. Физик бохирдол	40
2.2.4. Усны чанар	41
2.2.5. Хөрсөн бүрхэвч.....	42
2.2.6. Ургамлан нөмрөг	42
2.2.7. Амьтны аймаг.....	43
2.3 ИНЖЕНЕРИЙН ДЭД БҮТЦИЙН ОДООГИЙН БАЙДЛЫН СУДАЛГАА.....	44
2.3.1. Дулаан хангамж	44
2.3.2. Ус хангамж, ариутгах татуурга	44
2.3.3. Цахилгаан хангамж	45



2.3.4.	Мэдээлэл, холбоо.....	46
2.4	УЛААНГОМ ХОТЫН НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН ОДООГИЙН БАЙДАЛ.....	47
2.4.1	Засаг захиргаа	47
2.4.2	Хүн ам	48
2.4.3	Эдийн засаг	49
2.4.3	Нийгмийн дэд бүтэц	50
БҮЛЭГ 3.	НӨХЦӨЛ БАЙДЛЫН СУДАЛГАА.....	51
3.1.	ЛОГИСТИКТОЙ ХОЛБООТОЙ ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ.....	52
3.1.1	Эрх зүйн орчин.....	52
3.1.2	Төрөөс тээврийн салбарт баримталж буй стратегийн чиглэл, алсын хараа .	54
3.1.3	Төрөөс авто замын талаар баримталж буй бодлого	60
3.1.4	Монгол улсын нэгдэн орсон тээврийн олон улсын гэрээ, хэлэлцээр, конвенциуд 67	
3.1.5	Монголын транзит тээврийн талаар баримталж буй бодлого	73
3.2	МОНГОЛЫН УЛСЫН ЛОГИСТИК ХӨГЖЛИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ	76
3.2.1	МУ-ын ачаа тээвэр, логистикийн хөгжил.....	76
3.2.2	Тээврийн нэгдсэн үзүүлэлт.....	81
3.2.3	Монгол Улсын тээврийн сүлжээ, бараа бүтээгдэхүүний нийлүүлэлтийн гинжин хэлхээ 85	
3.3	МУ-ЫН ХУДАЛДААНЫ САЛБАРЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ	92
3.3.1	Гадаад худалдаа	92
3.3.2	Дотоод худалдаа	96
3.3.3	Боомтын статистик.....	97
3.4	АВТО ТЭЭВРИЙН СТАТИСТИК.....	102
3.4.1	Дэд бүтэц ба орлого	102
3.4.2	Зорчигчид ба ачаа тээвэр.....	106
3.5	УВС АЙМГИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН НӨХЦӨЛ.....	108
3.5.1	Хүн ам, өрх	108
3.5.2	Хөдөлмөр эрхлэлт	108
3.5.3	Аж үйлдвэр	109
3.5.4	Хөдөө аж ахуй.....	112
3.5.5	Худалдаа, үйлчилгээ.....	117
3.6	УВС АЙМГИЙН ЛОГИСТИКИЙН ӨНӨӨГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ	118
3.6.1	Увс аймгийн авто зам, ачаа тээврийн одоогийн байдал.....	118
3.6.2	Увс аймгийн хилийн боомтын одоогийн байдал	122
3.6.3	Увс аймгийн гадаад худалдаа.....	125



3.6.4	Увс аймгийн бараа бүтээгдэхүүний хэрэглээ, одоогийн нөөц	127
3.6.5	Увс аймгийн агуулахуудын одоо байгаа багтаамж, хүчин чадал	128
3.7	АВТО ЗАМЫН ХӨДӨЛГӨӨНИЙ МЭДЭЭЛЭЛ.....	129
3.7.1	Орон нутгийн авто замын хөдөлгөөн.....	129
3.7.2	Олон улсын авто замын хөдөлгөөн	135
БҮЛЭГ 4. ҮНЭЛГЭЭ, ДҮГНЭЛТ		136
4.1	SWOT ШИНЖИЛГЭЭ.....	136
4.2	PEASTLE ШИНЖИЛГЭЭ	138
4.3	АВТО ТЭЭВРИЙН ХЭТИЙН ТӨЛӨВИЙГ ҮНЭЛЭХ НЬ	138
4.4	МОНГОЛ УЛСАД ТЭЭВЭР, ЛОГИСТИКИЙН САЛБАРЫГ ХӨГЖҮҮЛЭХЭД ЦААШИД АВАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ САНАЛ.....	140
БҮЛЭГ 5. ТӨЛӨВЛӨЛТИЙН ШИЙДЭЛ		141
5.1	БҮС ОРЧМЫН ХӨГЖЛИЙН ЗОРИЛТУУД	141
5.1.1	Увс аймгийн хөгжлийн зорилтууд	141
5.1.2	Улаангом хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө.....	149
5.2	УВС АЙМГИЙН АЧАА ТЭЭВЭРЛЭЛТ, ХАДГАЛАЛТЫН ХЭТИЙН ТӨЛӨВ... 153	
5.2.1	Хүн амын хэтийн төлөв, хүнсний бараа бүтээгдэхүүний хэрэгцээ.....	153
5.2.2	МАА, ГТ, барилгын материал, аж үйлдвэрийн бараа бүтээгдэхүүний хэрэгцээ 154	
5.2.3	Хүнсний ногооны хэрэгцээ.....	155
5.2.4	Үйлдвэрлэлийн хэтийн зорилго.....	155
5.2.5	Гадаад худалдааны хэтийн төлөв	155
5.2.6	Агуулахын багтаамж, хүчин чадлын хэрэгцээ	156
5.3	БАРУУН БҮСИЙН ЛОГИСТИК ТӨВ БАЙГУУЛАХ ҮЗЭЛ БАРИМТЛАЛ, ШИЙДЭЛ 157	
5.3.1	Үндэслэл ба хэрэгцээ шаардлага	157
5.3.2	Зорилго, хамрах хүрээ ба тавигдах шаардлага	160
5.3.3	Үндсэн шийдэл.....	161
5.3.4	Логистикийн төв байгуулснаар бий болох үр дүн	163
5.3.5	Ажиллах хүч, үйлчлүүлэгчийн тооцоо	165
5.4	БИЗНЕСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА	165
5.4.1	Үндсэн үйл ажиллагаа.....	165
5.4.2	Хадгалалтын дэглэм ба онцгой горим.....	168
5.4.3	Менежмент шийдэл.....	168
5.4.4	Ажиллах хүчний тоо, цалингийн сан.....	170
БҮЛЭГ 6. АРХИТЕКТУР ТӨЛӨВЛӨЛТ		171



6.1	АРХИТЕКТУР-ОРОН ЗАЙН ТӨЛӨВЛӨЛТИЙН КОНЦЕПЦ	172
6.1.1	Ерөнхий төлөвлөгөө	172
6.1.2	Үүрэг зориулалтын бүсчлэл.....	174
6.1.3	Барилгажилт	175
6.2	ӨНДӨРЖИЛТ БА УЛААН ШУГАМ ТӨЛӨВЛӨЛТ	179
6.3	ЗАМ ТЭЭВРИЙН СҮЛЖЭЭ ТӨЛӨВЛӨЛТ	180
6.4	БАРИЛГА, БАЙГУУЛАМЖИЙН ТӨЛӨВЛӨЛТ	181
6.4.1	Оффис лабораторийн барилга	181
6.4.2	Хүнсний ногооны агуулах	186
6.4.3	Өргөн хэрэглээний дулаан агуулах	189
6.4.4	Хөлдөөгч хөргүүртэй агуулах	193
6.4.5	Хөдөө аж ахуйн агуулах.....	195
6.4.6	Уурын зуухны барилга	198
6.4.7	Дэд өртөөний барилга.....	199
БҮЛЭГ 7. ИНЖЕНЕРИЙН ДЭД БҮТЦИЙН ТӨЛӨВЛӨЛТ		200
7.1	ИНЖЕНЕРИЙН ХАНГАМЖИЙН ТОДОРХОЙЛОЛТ	201
7.2	ЦАХИЛГААН ХАНГАМЖ	201
7.3	ДУЛААН ХАНГАМЖ.....	203
7.4	УСАН ХАНГАМЖ, АРИУТГАХ ТАТУУРГА.....	206
7.5	ХОЛБОО МЭДЭЭЛЛИЙН СҮЛЖЭЭ	208
БҮЛЭГ 8. БАЙГАЛЬ ОРЧНЫ ХАМГААЛАЛ БА ГАМШГИЙН МЕНЕЖМЕНТ		209
8.1	НОГООН БАЙГУУЛАМЖИЙН ТӨЛӨВЛӨЛТ	209
8.2	ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТ	214
8.3	ГАМШГИЙН МЕНЕЖМЕНТ.....	216
БҮЛЭГ 9. САНХҮҮГИЙН ЭДИЙН ЗАСГИЙН ТООЦОО БА ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ		218
9.1	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТООЦОО	219
9.1.1	Жишиг норм ба итгэлцүүр	219
9.1.2	Барилга байгууламж ба тохижилтын хөрөнгө оруулалт.....	220
9.1.3	Дэд бүтцийн хөрөнгө оруулалт	221
9.1.4	Нийт хөрөнгө оруулалт	223
9.2	ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ САНАЛ	223
9.2.1	Хэрэгжүүлэх үе шатны санал	223
9.2.2	Хэрэгжүүлэх үе шатны хөрөнгө оруулалт	225
9.3	МЕНЕЖМЕНТ ТӨЛБӨРИЙГ ТООЦОХ НЬ	226
9.4	ТЕХНИК ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТ	229



ТОВЧИЛСОН ҮГСИЙН ЖАГСААЛТ

МУ	Монгол улс
УИХ	Улсын Их Хурал
ЗГ	Засгийн газар
УБ	Улаанбаатар
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ИДБ	Инженерийн дэд бүтэц
ЭЗ	Эдийн засаг
ТЭЗҮ	Техник эдийн засгийн үндэслэл
ҮСХ	Үндэсний статистикийн хороо
ХО	Хөрөнгө оруулалт
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
УДДТ	Ус дулаан дамжуулах төв
ИБАХ	Инженерийн бэлтгэл арга хэмжээ
УХАТ	Усан хангамж ариутгах татуурга
ААНБ	Аж ахуйн нэгж байгууллага

Нэгжийн үзүүлэлт:

кг	килограмм
тн	тонн
кв	квадрат
л	литр
м ²	метр квадрат
м ³	метр куб
кВ	килловатт
МВ	мегаватт



ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. 1 Увс аймгийн Улаангом сум Улаанбаатар хотоос.....	18
Зураг 1. 2 Улаангом хот дахь шинээр төлөвлөгдөж буй Логистик төвийн байршлын схем19	
Зураг 2. 1 Судалгааны талбайн байршил	22
Зураг 2. 2 Инженер геологийн үйл ажиллагаа	22
Зураг 2. 3 Байр зүйн зураг	23
Зураг 2. 4 Ул хөрсний тархалт.....	26
Зураг 2. 5 Увс аймгийн газарзүйн зураг.....	36
Зураг 2. 6 Уур амьсгалын диаграмм	37
Зураг 2. 7 Агаарын температурын явц, хандлага.....	38
Зураг 2. 8 Жилийн нийлбэр тунадасны явц хандлага.....	38
Зураг 2. 9 Жилийн нийлбэр тунадасны олон жилийн дундаж хазайлт (Завхан, Баруунтуруун)	38
Зураг 2. 10 Ус судлалын ажиглалтын харуулууд	41
Зураг 2. 11 Улаангом сумын хүн ам, өрхийн суурьшил	48
Зураг 2. 12 Хүн амын насны бүтэц.....	48
Зураг 2. 13 Улаангом сумын эдийн засаг	49
Зураг 3. 1 Монгол улсын Зам тээврийн салбарт баримталж буй бодлогын баримт бичиг55	
Зураг 3. 2 Авто замын салбарт хэрэгжсэн төсөл, арга хэмжээнүүд.....	61
Зураг 3. 3 Азийн Автозамын сүлжээнд нэгдэн орсон байдал	64
Зураг 3. 4 Транзит тээврийн коридорууд ба гадна холболтууд.....	73
Зураг 3. 5 Монголын транзит тээврийн бодлого.....	75
Зураг 3. 6 МУ-ын тээвэр, логистик газрын зураг.....	76
Зураг 3. 7 Логистикийн гүйцэтгэлийн индекс /LPI/-ээр байр эзлүүлсэн байдал, 2018 он77	
Зураг 3. 8 Тээврийн нэгдсэн үзүүлэлт	81
Зураг 3. 9 Тээврийн хэрэгслийн хөрөнгө оруулалт, дүнд эзлэх хувиар.....	82
Зураг 3. 10 Тээврийн салбарын орлого, тээврийн төрлөөр, тэрбум төгрөг.....	84
Зураг 3. 11 Нийт зорчигчид, тээврийн төрлөөр	84
Зураг 3. 12 Үндэсний тээвэр логистикийн сүлжээ 2018 он.....	85
Зураг 3. 13 Монгол Улсын импортын нийлүүлэлтийн гинжин хэлхээ.....	86
Зураг 3. 14 Монгол Улсын тээвэр, логистикийн сүлжээний зураглал	88
Зураг 3. 15 Махны түүхий эдийн нийлүүлэлтийн гинжин хэлхээ	88
Зураг 3. 16 Хүнсний ногооны өртгийн сүлжээний зураглал	89
Зураг 3. 17 Ачаа тээвэрлэлтийн үндсэн зураглал.....	89
Зураг 3. 18 Улаанбаатар хот руу чиглэсэн бараа бүтээгдэхүүний урсгал.....	90
Зураг 3. 19 Улаанбаатар хот дахь тээвэрлэлт, түгээлтийн урсгалууд.....	91
Зураг 3. 20 Гадаад худалдааны эргэлт	92
Зураг 3. 21 Монгол улсын гадаад худалдааны бараа эргэлт, ерөнхий тойм	92
Зураг 3. 22 Худалдааны борлуулалт, тэрбум төгрөг	96
Зураг 3. 23 Монгол улсын дотоодын бараа бүтээгдэхүүний нийлүүлэлт	97
Зураг 3. 24 Хилийн боомтуудаар нэвтэрсэн ачаа (импорт+экспорт) – 2019 онд.....	98
Зураг 3. 25 Улсын хилээр орсон тээврийн хэрэгслийн тоо 2019 оны байдлаар.....	98
Зураг 3. 26 Монгол улсын автозамын сүлжээ.....	102
Зураг 3. 27 Сайжруулсан замын урт, км.....	102



Зураг 3. 28 Хатуу хучилттай авто замын бүтэц	103
Зураг 3. 29 Хатуу хучилттай авто замын хучилтын төрөл.....	103
Зураг 3. 30 Авто замын сүлжээ	103
Зураг 3. 31 Авто тээврийн салбарын орлого	106
Зураг 3. 32 Авто зорчигчийн үзүүлэлт	106
Зураг 3. 33 Авто тээврийн ачаа тээвэр.....	107
Зураг 3. 34 Ачааны автомашины тоо.....	107
Зураг 3. 35 Ажилд эрхэлж буй хүн амын боловсролын түвшин.....	109
Зураг 3. 36 Баруун бүсийн улсын чанартай авто замын сүлжээ.....	120
Зураг 3. 37 Увс аймгийн бараа эргэлт, 2019 оны байдлаар, мян.тн-оор.....	120
Зураг 3. 38 Боршоо хилийн боомтоор нэвтэрсэн тээврийн хэрэгсэл, зорчигчдын тоо .	123
Зураг 3. 39 Авто замын хөдөлгөөний эрчим	129
Зураг 3. 40 Авто замын хөдөлгөөний эрчим, тээврийн хэрэгслийн төрлөөр.....	130
Зураг 3. 41 Авто замын хөдөлгөөний эрчмийн тооллого хийсэн цэгүүд	130
Зураг 3. 42 Баруун бүсийн хөдөлгөөний эрчмийн тооллогын цэг.....	131
Зураг 3. 43 Боомтуудаар нэвтэрсэн тээврийн хэрэгсэл	135
Зураг 5. 1 Увс аймгийн эдийн засгийн орон зайн бүсчлэл	141
Зураг 5. 2 Улаангом дахь агропаркын байршил.....	146
Зураг 5. 3 Улаангом хотын хөгжлийн тэргүүлэх чиглэл	149
Зураг 5. 4 Улаангом сумын хэтийн төлөв-2030	150
Зураг 5. 5 Монгол Улсын хот хөдөөгийн хүнсний хэрэгцээний бүтэц.....	153
Зураг 5. 6 Увс аймагт бүтээгдэхүүн импортлох логистик үйл ажиллагааны схем	158
Зураг 5. 7 Увс аймгаас бүтээгдэхүүн экспортлох логистик үйл ажиллагааны схем	158
Зураг 5. 8 Баруун бүсийн логистик төвийн суурь нөхцөл	161
Зураг 5. 9 Баруун бүсийн логистик төвийн дотоод зохион байгуулалт, бүтэц	163
Зураг 5. 10 Үйл ажиллагааны схем	165
Зураг 5. 11 Менежмент шийдэл	168
Зураг 5. 12 Үл хөдлөхийн менежмент бүтэц	169
Зураг 5. 13 Оролцогч талууд, менежмент, бодлого	170
Зураг 5. 14 Удирдлага зохион байгуулалтын бүтэц	171
Зураг 6. 1 Орчны тойм.....	172
Зураг 6. 2 Ерөнхий төлөвлөгөө.....	173
Зураг 6. 3 Баруун логистик төвийн үзэгдэх байдал.....	173
Зураг 6. 4 Үүрэг зориулалтын бүсчлэл	175
Зураг 6. 5 Барилгажилт	175
Зураг 6. 6 Өндөржилт	179
Зураг 6. 7 Улаан шугам	180
Зураг 6. 8 Замын сүлжээ төлөвлөлт ба хөдөлгөөний схем	180
Зураг 6. 9 Оффис лабораторийн барилга.....	182
Зураг 6. 10 Оффис лабораторийн барилгын дотоод зохион байгуулалт	182
Зураг 6. 11 Оффис лабораторийн барилгын үзэгдэх байдал	186
Зураг 6. 12 Хүнсний ногооны агуулахын төлөвлөлт.....	187
Зураг 6. 13 Хүнсний ногооны агуулахын дотоод зохион байгуулалт	188
Зураг 6. 14 Хүнсний ногооны агуулахын үзэгдэх байдал	188



Зураг 6. 15 Өргөн хэрэглээний дулаан агуулахын төлөвлөлт	190
Зураг 6. 16 Өргөн хэрэглээний дулаан агуулахын дотоод зохион байгуулалт	190
Зураг 6. 17 Өргөн хэрэглээний дулаан агуулахын үзэгдэх байдал	191
Зураг 6. 18 Хөлдөөгч хөргүүртэй агуулахын төлөвлөлт	193
Зураг 6. 19 Хөлдөөгч хөргүүртэй агуулахын дотоод зохион байгуулалт	194
Зураг 6. 20 Хөлдөөгч хөргүүртэй агуулахын үзэгдэх байдал	195
Зураг 6. 21 Хөдөө аж ахуйн агуулахын төлөвлөлт	196
Зураг 6. 22 Хөдөө аж ахуйн агуулахын дотоод зохион байгуулалт	197
Зураг 6. 23 Хөдөө аж ахуйн агуулахын үзэгдэх байдал	198
Зураг 6. 24 Уурын зуухны барилга	199
Зураг 6. 25 Дэд өртөөний барилга	200

Зураг 7. 1 Инженерийн хангамжийн шийдэл	201
Зураг 7. 2 Инженерийн шугам сүлжээ нэгдсэн	201
Зураг 7. 3 Гадна цахилгааны шугам	202
Зураг 7. 4 Дотор цахилгааны шугам	202
Зураг 7. 5 Дулаан хангамжийн төлөвлөлт	204
Зураг 7. 6 Eurozigi фирмийн зуухууд	206
Зураг 7. 7 УХАТ төлөвлөлт	207
Зураг 7. 8 Холбоо мэдээллийн сүлжээ төлөвлөлт	208
Зураг 7. 9 Холбооны сувагчлал байгуулалт	209

Зураг 8. 1 Ногоон байгууламжийн төлөвлөлт	209
Зураг 8. 2 Хог хаягдал цуглуулах, зайлуулах схем	215
Зураг 8. 3 Гамшиг гэсэн ойлголт дараах хүчин зүйлүүдээр тодорхойлогдоно	217
Зураг 8. 4 Гамшгаас хамгаалах менежмент	217
Зураг 8. 5 Гамшгийн менежмент	217

Зураг 9. 1 Хэрэгжүүлэх үе шат	223
-------------------------------------	-----

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 2. 1 Цаг уурын үзүүлэлт	24
Хүснэгт 2. 2 Ул хөрсний механик шинж чанарын нормчлогдох үзүүлэлтүүд	34
Хүснэгт 2. 3 Ул хөрсний улирлын хөлдөлтийн гүн, овойлтын зэрэг, газар шорооны ажлын зэрэг, хувийн цахилгаан эсэргүүцэл	35
Хүснэгт 2. 4 Сарын дундаж температур болон хур тунадасны хэмжээ (Улаангом)	37
Хүснэгт 2. 5 Агаарын жилийн дундаж температурын 10 жилийн өөрчлөлт	38
Хүснэгт 2. 6 Гадаргын усны шинжилгээний дүнг MNS45865:98 стандарттай харьцуулсан	41
Хүснэгт 2. 7 100 хүнд ногдох үүрэн холбооны хэрэглэгчийн тоо	46
Хүснэгт 2. 8 Нийгмийн дэд бүтцийн үзүүлэлт	50

Хүснэгт 3. 1 Логистикийг ерөнхий байдлаар зохицуулсан эрх зүйн актуудын лавлагаа-1: Хуулиуд	52
---	----



Хүснэгт 3. 2 Логистикийг ерөнхий байдлаар зохицуулсан эрх зүйн актуудын лавлагаа-2: УИХ-ын тогтоол, бодлогын баримт бичиг.....	53
Хүснэгт 3. 3 Логистикийг ерөнхий байдлаар зохицуулсан эрх зүйн актуудын лавлагаа-3: Олон улсын гэрээ, конвенци.....	53
Хүснэгт 3. 4 Алсын хараа 2050-д тусгаснаар эдийн засгийн тэргүүлэх чиглэлүүдэд гарах үр дүн	57
Хүснэгт 3. 5 Нэгдсэн орсон олон улсын гэрээ, конвенциуд.....	67
Хүснэгт 3. 6 Төмөр замаар дамжин өнгөрөх нүүрсний тээвэрлэлтэд үзүүлэх хөнгөлөлт	70
Хүснэгт 3. 7 Төмөр замаар дамжин өнгөрөх чингэлэг тээвэрлэлтэд үзүүлэх хөнгөлөлт	71
Хүснэгт 3. 8 Монгол улсын Логистикийн гүйцэтгэлийн индекс /LPI/, 2018 он*	77
Хүснэгт 3. 9 Дэлхийн бүс нутгуудийн Логистикийн гүйцэтгэлийн индекс /LPI/-ээр байр эзлүүлсэн байдал, 2018 он	78
Хүснэгт 3. 10 2018 оны логистикийн гүйцэтгэлийн индекс	79
Хүснэгт 3. 11 Тээвэрлэлтийн бүтэц, тээврийн төрлөөр	81
Хүснэгт 3. 12 Хөрөнгө оруулалтын салбарын бүтэц, хувиар	82
Хүснэгт 3. 13 Бүх төрлийн тээврийн үндсэн үзүүлэлт, улсын дүн, жилээр.....	83
Хүснэгт 3. 14 Логистикийн салбарын үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж байгууллагууд.....	85
Хүснэгт 3. 15 Логистикийн салбарын ажилчид	85
Хүснэгт 3. 16 Импортын гүйцэтгэл, мян. ам.доллар	93
Хүснэгт 3. 17 Экспортын гүйцэтгэл, мян. ам.доллар.....	94
Хүснэгт 3. 18 Гадаад худалдааны бараа эргэлт, тээврийн төрлөөр, сая ам.доллар.....	95
Хүснэгт 3. 19 Худалдааны салбарт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллагын тоо	96
Хүснэгт 3. 20 Ачаа тээвэр, боомтоор, тн	99
Хүснэгт 3. 21 Импортын ачаа тээвэр, бүтээгдэхүүний төрлөөр, тн: 2010-2020 онд	99
Хүснэгт 3. 22 Экспортын ачаа тээвэр, бүтээгдэхүүний төрлөөр, тн: 2010-2020 онд	100
Хүснэгт 3. 23 1 тн ачааны дундаж үнэлгээ: 2010-2020 онд	101
Хүснэгт 3. 24 Авто тээврийн үндсэн үзүүлэлт.....	105
Хүснэгт 3. 25 Ашиглалтад орсон зам, гүүр /оноор/	105
Хүснэгт 3. 26 Увс аймгийн хүн ам, 10 жилээр	108
Хүснэгт 3. 27 Увс аймгийн хүн амын ердийн өсөлт, 10 жилээр	108
Хүснэгт 3. 28 Увс аймгийн хөдөлмөр эрхлэлтийн байдал.....	108
Хүснэгт 3. 29 Аж үйлдвэрийн салбарын нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэлт, оны үнээр...	110
Хүснэгт 3. 30 Аж үйлдвэрийн салбарын гол нэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлт	111
Хүснэгт 3. 31 Увс аймгийн нийт малын тоо, төрлөөр /мян/	112
Хүснэгт 3. 32 Бүх малын тоо, сумаар	112
Хүснэгт 3. 33 Үхрийн тоо, сумаар.....	113
Хүснэгт 3. 34 Хонины тоо толгой, сумаар	113
Хүснэгт 3. 35 Тэжээвэр амьтдын тоо, төрлөөр	114
Хүснэгт 3. 36 Тэжээвэр амьтдын тоо, сумаар.....	114
Хүснэгт 3. 37 Газар тариалан (га)	115
Хүснэгт 3. 38 Хураан авсан төмс, сумаар	115
Хүснэгт 3. 39 Хураан авсан хүнсний ногоо, сумаар	116
Хүснэгт 3. 40 Жимс жимсгэнэ тариалсан талбай, төрлөөр (га)	117
Хүснэгт 3. 41 Хураан авсан жимс жимсгэнэ, улс, аймаг, жилээр.....	117
Хүснэгт 3. 42 Худалдааны салбарын борлуулалт, бүс, аймаг, нийслэлээр.....	117
Хүснэгт 3. 43 Зочид буудлын салбарын орлого, бүс, аймаг, нийслэлээр.....	118



Хүснэгт 3. 44	Нийтийн хоолны салбарын орлого, бүс, аймаг, нийслэлээр	118
Хүснэгт 3. 45	Увс аймгийн ачаа, зорчигч эргэлт	121
Хүснэгт 3. 46	Увс аймгийн техникийн хяналтын үзлэгийн дүн, давхардсан тоогоор.....	121
Хүснэгт 3. 47	Оношилгоонд орсон авто тээврийн хэрэгслийн нийт тоо, сумаар	121
Хүснэгт 3. 48	Увс аймгийн ачаа тээвэр, 2020.12-р сараас 2021.06-р сард QR кодоор тээвэрлэж байх үеийн нөхцөлөөр	124
Хүснэгт 3. 49	Боршоо хилийн боомтоор орж ирж байгаа барааны ангилал	125
Хүснэгт 3. 50	Увс аймгийн гадаад худалдаа	125
Хүснэгт 3. 51	Увс аймгийн импортын гол нэрийн бараа	126
Хүснэгт 3. 52	2020 онд зорчсон авто машины нэгтгэл.....	131
Хүснэгт 5. 1	Хүнсний үйлдвэрийн хүчин чадал.....	148
Хүснэгт 5. 2	Улаангом хотын хөгжлийн зорилтууд	149
Хүснэгт 5. 3	Увс аймгийн сумдын хүн амын хэтийн төлөв	152
Хүснэгт 5. 4	Увс аймгийн сумдын өрхийн хэтийн төлөв	152
Хүснэгт 5. 5	Увс аймгийн хүн амын жишсэн хүнсний хэрэгцээ 2035 он.....	154
Хүснэгт 5. 6	Улаангом хотын төрийн болон зарим үйлчилгээний газрын төмс, хүнсний ногооны хэрэгцээ	155
Хүснэгт 5. 7	Зоорийн багтаамж	156
Хүснэгт 5. 8	Зоорь, агуулахын хэрэгцээ	157
Хүснэгт 6. 1	Ерөнхий төлөвлөгөөний хэмжээс.....	173
Хүснэгт 6. 2	Барилгажилтын хэмжээс.....	177
Хүснэгт 6. 3	Оффис лабораторийн барилгын өрөөний зохион байгуулалт	184
Хүснэгт 6. 4	Хүнсний ногооны агуулахын өрөөний зохион байгуулалт.....	189
Хүснэгт 6. 5	Өргөн хэрэглээний дулаан агуулахын өрөөний зохион байгуулалт.....	192
Хүснэгт 6. 6	Хөлдөөгч хөргүүртэй агуулахын өрөөний зохион байгуулалт	195
Хүснэгт 6. 7	Хөдөө аж ахуйн агуулахын өрөөний зохион байгуулалт	197
Хүснэгт 7. 1	Цахилгааны төлөвлөлт, 1-р ээлж	202
Хүснэгт 7. 2	Цахилгааны төлөвлөлт, 2-р ээлж	203
Хүснэгт 7. 3	Дулаан зарцуулалт	204
Хүснэгт 7. 4	Дулаан хангамжийн төлөвлөлт	204
Хүснэгт 7. 5	УХАТ материалын тооцоо	207
Хүснэгт 7. 6	Холбоо мэдээллийн сүлжээ төлөвлөлт	209
Хүснэгт 8. 1	Ногоон байгууламжийн төлөвлөлт.....	211
Хүснэгт 8. 2	Баруун бүсийн логистик төвийн хог хаягдлын эх үүсвэр	214
Хүснэгт 8. 3	Хог хаягдлын тооцоо	216
Хүснэгт 9. 1	Барилга байгууламжийн хөрөнгө оруулалт	220
Хүснэгт 9. 2	Тохижилтын хөрөнгө оруулалт.....	220
Хүснэгт 9. 3	Тээврийн дэд бүтцийн хөрөнгө оруулалт.....	221
Хүснэгт 9. 4	Дулаан хангамжийн хөрөнгө оруулалт	221



Хүснэгт 9. 5 УХАТ хөрөнгө оруулалт	221
Хүснэгт 9. 6 Мэдээлэл холбооны хөрөнгө оруулалт	221
Хүснэгт 9. 7 Цахилгааны хөрөнгө оруулалт	222
Хүснэгт 9. 8 Цахилгааны хөрөнгө оруулалт	223
Хүснэгт 9. 9 Үе шатны хөрөнгө оруулалт	225
Хүснэгт 9. 10 Үйл ажиллагааны зардал ба 1 м2 талбайд ногдох өртөг	228
Хүснэгт 9. 11 Техник эдийн засгийн үзүүлэлт	229



УДИРТГАЛ

Увс аймгийн төв, Улаангом сумын нутаг дэвсгэрт баригдах Баруун бүсийн Логистикийн төв байгуулах техник эдийн засгийн үндэслэл, зураг төсөл боловсруулах ажлыг Увс аймгийн засаг даргын баталсан №..... тоот зургийн даалгавар, Увс аймгийн засаг даргын тамгын газартай байгуулсан ... тоот гэрээг тус тус үндэслэн Нью Урбанизм ХХК боловсруулж эцсийн тайланг танилцуулж байна.

Баруун бүсийн Логистикийн төв байгуулах техник эдийн засгийн үндэслэл, зураг төсөл боловсруулах ажлыг хийхдээ юуны өмнө Алсын хараа-2050 Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлого, “Улаангом хотын 2030 оны хөгжлийн ерөнхий төлөвлөгөө”, Увс аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр болон Монгол улсын тээврийн салбарт баримталж буй бодлого төлөвлөлтийн ажлууд, тэдгээр баримт бичигт тусгагдсан үзэл баримтлал, хөгжлийн чиг хандлагыг мөрдлөгөө болгосон.

85.3 мянган хүн ам, 22.3 мянган өрхтэй Увс аймгийн Улаангом, Тариат сумуудын нутаг дэвсгэрт шинээр төлөвлөгдөж буй Баруун бүсийн Логистикийн нэгдсэн төв нь Баруун 5 аймаг, ОХУ-аас дамжин өнгөрүүлэх импорт, экспортын тээвэрлэлтийн хэтийн төлөвт үндэслэн шаардлагатай хүчин чадал, технологийн шийдэлтэй, ногоон хөгжлийн чиг хандлагыг мөрдлөг болгосон орчин үеийн Логистик төв юм.

Энэхүү судалгаа, төлөвлөлтийн ажлыг хийж гүйцэтгэхдээ дараах ажлуудыг мэргэжлийн байгууллага, эрдэмтэдтэй хамтран хийж гүйцэтгэлээ. Үүнд:

1. “Эл Эм Ланд” ХХК:
 - Инженер геологийн судалгаа,
2. “Лэнд Тэст” ХХК:
 - Байр зүйн зураг,
3. “Варм Бьюлдинг Констракшн” ХХК:
 - Архитектур төлөвлөлт,

Ийнхүү эцсийн тайланд Захиалагчаас өгсөн санал зөвлөмжийг тусган төлөвлөлтийн шийдлийг Захиалагчид ба бусад холбогдох байгууллагуудтай Эскиз зургууд, технологийн шийдлүүдийг зөвшилцөж эцэслэсэн болно.



БҮЛЭГ 1. ЕРӨНХИЙ ТАНИЛЦУУЛГА

Бүлгийн дэд агуулга:

- ⇒ Үндэслэл ба хэрэгцээ шаардлага
- ⇒ Зорилго ба зорилт
- ⇒ Байршил

Аргачлал

1.1 ҮНДЭСЛЭЛ БА ХЭРЭГЦЭЭ ШААРДЛАГА

1.1.1 Эрх зүйн үндэслэл

Энэхүү ТЭЗҮ-ийн эрх зүйн үндэслэлийг дараах байдлаар тодорхойлж байна. Үүнд:

- ✗ Монгол улсын УИХ-ын 2020 оны №52-р тогтоол: *“Алсын хараа-2050” Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлого*”
- ✗ Монгол улсын УИХ-ын 2010 оны №23-р тогтоол: *Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл*,
- ✗ Монгол улсын УИХ-ын 2020 оны №24-р тогтоол: *“Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”*
- ✗ Монгол улсын Засгийн газрын 2020 оны №203 тогтоол: *Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө*,
- ✗ Монгол улсын Засгийн газрын 2018 оны №321 тогтоол: *Төрөөс авто тээврийн салбарт баримтлах бодлого*
- ✗ Увс аймгийн ИТХ-ын 2021 оны №4/01 тогтоол: *Увс аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл*
- ✗ Увс аймгийн ИТХ-ын 2021 оны №4/02 тогтоол: *Увс аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр*,
- ✗ Монгол улсын төсвийн хөрөнгөөр 2021 онд санхүүжүүлэх төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалт XVII.4.1,

1.1.2 Нийгэм-эдийн засгийн үндэслэл

Логистик гэдэг нь үйлдвэрлэгчээс гарсан бараа бүтээгдэхүүнийг хамгийн хямд зардлаар хэрэглэгчид хүргэх бүх үйл ажиллагааны цогц юм.

Логистик нь үйлдвэрлэгч, тээвэрлэгч, худалдаачин, хэрэглэгчийг нэгээс нөгөөд бараа бүтээгдэхүүнээ цаг алдалгүй хүргэх үйл ажиллагааг нэгдсэн зохион байгуулалтад оруулснаараа энэ 4 оролцогч талуудыг хооронд нь холбож өгөх зангилаа болох юм. Ингэснээрээ логистикийн үйл ажиллагааг сайжирснаар үйлдвэрлэл, худалдаа, тээвэр бие бие харилцан дэмжсэнээр үйл ажиллагааг улам өргөжүүлж, зах зээлийн боломжоо тэлж, эдийн засгийн өндөр үр өгөөж хүртэх боломжтой болох юм.



Логистикийн үйл ажиллагааг оновчтой төлөвлөхийн тулд худалдаа, үйлдвэрлэл, тээврийн одоогийн сүлжээ, түүний алдаа дутагдал, оролцогч талуудыг үйл ажиллагаанд гарч байгаа хүндрэлтэй талыг олж судлах шаардлагатай болно. Ингэснээрээ дээрх үйл ажиллагааг хаана, хэрхэн засах, үйл ажиллагаануудаа уялдуулах ямар гарц боломж байгааг олж нээнэ. Иймд бид энэхүү зөвлөх үйлчилгээний явцад Увс аймагт үйл ажиллагаа явуулж байгаа холбогдох оролцогч талуудыг хамруулсан уулзалтуудыг зохион байгуулсан.

Одоогийн байдлаар Монгол Улсад логистикийн нэгдсэн зохион байгуулалт хараахан бүрэн утгаараа бий болоогүй байна. Хэрэглээний бүхий л төрлийн бараа бүтээгдэхүүний дийлэнх хувийг гадаад улсуудаас импортолж байна. Үүний хамгийн гол корридор буюу сүлжээ нь Замын-Үүдээр бараа бүтээгдэхүүн оруулж ирэн төмөр замаар тээвэрлэн Улаанбаатар хотод буулгаж улмаар худалдааны томоохон зах, худалдааны төвүүд рүү дамжин жижиглэнгийн худалдаанд түгээгдэж байна. Харин орон нутгийн худалдаа эрхлэгчид Нарантуул, Барс зэрэг зах худалдааны төвүүдээс бараагаа цуглуулан татан авдаг нэг гол нийтлэг сүлжээ бий болоод байна. Ийм учраас хэдий алслагдсан ч бүх аймгууд Улаанбаатар хотоос хүнсний болон өргөн хэрэглээний бараагаа татан авахаар ирж байна.

Бид энэхүү ажлынхаа хүрээнд Зам, тээврийн хөгжлийн яам, Авто тээврийн үндэсний төв, Зам, тээвэр хөгжлийн төв, Увс аймгийн ЗДТГ, Увс аймгийн Авто тээврийн төв гэх мэт холбогдох байгууллагуудаас аймгийн ачаа эргэлтийн талаар мэдээллийг шүүж, холбогдох мэдээллүүдийг авсан хэдий ч ачаа эргэлтийг уг мэдээллүүдэд үндэслэн нарийн тодорхойлох боломжгүй байна. Түүнчлэн энэ талаар Эдийн засаг, хөгжлийн яам, МҮХАҮТ, Азийн хөгжлийн банк зэрэг байгууллагуудаас хийсэн судалгааны материалуудыг үзэхэд ачаа эргэлтийн одоогийн байдлыг нарийвчлалтай гаргаж чадаагүй байна. Зөвхөн Ковид-19 цар тахлын үед ачаа тээврийг QR кодоор явуулж байсан 2020.12-р сараас 2021.06 сар хүртэлх ачааны бүртгэл хийсэн мэдээллийг хүлээн авч боловсруулалт хийсэн.

Увс аймгийн хэмжээнд 1990 онд гурил 10163 тн, нарийн боов 596 тн, ундаа 171 тн, гоймон 213 тн, чацарганы тос 1800 кг, иоджуулсан давс 652 тн, тараг 719 мян.л, арвайн гурил 551 тн, хивэг 3015 тн, саван 57 тн зэрэг ихээхэн бүтээгдэхүүн үйлдвэрлэж байсан байна. Тухайн үед гурилаар баруун аймгуудыг хангаж, бусад барааг аймгийн болон улсын хэрэгцээнд нийлүүлж байсан. Эдгээр бүтээгдэхүүнээс заримыг нь одоо огт үйлдвэрлэхгүй бөгөөд эрс буурч 2020 онд гурил 234 тонн гурил үйлдвэрлэсэн байна.

Малын тэжээл хивэг үйлдвэрлэлээр аймгийн хэрэгцээг бүрэн хангах боломжтой байхад ОХУ-аас импортолж байна. Увс аймаг 2021 онд 30 мянган тонн улаан буудай хураан авсан байна. Мах, махан бүтээгдэхүүний үйлдвэрлэл, гутал, монгол гэрийн үйлдвэрлэл сэргэж гадагшаа экспортлох, махны нөөцийг тодорхой хэмжээгээр нэмэгдүүлж боломж байна. Аймгийн хэмжээнд 3.4 сая толгой мал байгаагаас жилд дотоодын махны хэрэгцээнд 276,6 мян/толгой мал, арилжааны болон төвийн бүсийн хүн амын хэрэгцээнд 213,1 мян/толгой мал буюу нийт 4,7 мян/тонн махыг бэлтгэн нийлүүлэх бүрэн боломжтой байна.

1990 онд аймгийн хэмжээнд нийт 3391.4 тн төмс хурааж авч байсан. Үүнд Баруунтуруун, Давст, Наранбулаг, Өлгий зэрэг сумдууд одоогийнхоор 2-3 дахин их төмс хураан авч байсан байна. 2020 оны байдлаар аймгийн хэмжээнд нийт 2787.2 тн төмс хураан авсан, үүний 1953 тн Улаангомд хураан авсан байна. Аймгийн хэмжээнд томоохон хэмжээний агуулах зорьгүй улмаас нөөцөлж чадахгүй байна. Намар Улаанбаатарт 1 кг төмс 500 төгрөг байхад Улаангомд 2 дахин үнэтэй байна.



Увс аймгийн хувьд хүнд даацын ачаа тээврийн 100 гаруй жолоочид Увс аймгаас мах, малын гаралтай түүхий эд гэх зэрэг хязгаарлагдмал бараа бүтээгдэхүүнийг Улаанбаатар хот болон бусад томоохон хот сууринуудад авч ирж, буцахдаа Улаанбаатар хотын томоохон зах худалдааны төв дээрээс ачаа тээвэрлүүлэгчид ирж төрөл бүрийн бараагаа түүвэр ачаа цуглуулж, ачаагаа дүүргэх хүртлээ 7-10 хоног хүлээгээд явж байна. Энэ хугацаанд бараа бүтээгдэхүүний хадгалалтын горим болоод чанар алдагдах, өөр өөр хадгалалт, тээвэрлэлтийн гаралтай бүтээгдэхүүнүүд нэг дор ачигдан бие биеийнхээ чанарт нөлөөлөх зэргээр асуудлуудыг дагуулж байна. Улмаар алслагдсан аймгуудын хоол боловсруулах замын өвчлөл харьцангуй их байна.

Худалдаа, тээврийг өдийг хүртэл оновчтой зохион байгуулж чадаагүй байгаагаас шалтгаалан эдийн засагт ихээхэн ачаалал үүсгэж, нэмэлт зардлыг үүсгэж байна. Энэхүү нэмэлт зардал нь макро эдийн засгийн талаасаа хэрэглэгчид очих үнийн түвшинг өсгөх, бизнесийн ашгийг бууруулах зэрэг нөлөөлөл үзүүлж байна. Хамгийн чухал нь худалдаа, тээврийн оновчгүй зохион байгуулалт нь хүнсний аюулгүй байдал, хүн амын эрүүл ахуйд ихээхэн нөлөөлж байна. Иймд логистикийн системийг оновчтой төлөвлөх, тээвэр, худалдаа, үйлдвэрлэлийг цогцоор нь нэгдсэн системд оруулан зохион байгуулах нь үйл ажиллагааны үр ашгийг нэмэгдүүлж, орон нутгийн бизнесийн үйл ажиллагааг дэмжиж, үйл ажиллагааны үр өгөөжийг нэмэгдүүлж, үргүй зардлыг багасган эдийн засагт мөнгөн болон мөнгөн бус олон тооны үр өгөөжийг бий болгох юм.

Баруун бүсийн товарын хэрэглээ нь Улаанбаатар хотоос бага бага хэмжээгээр олон давтамжтайгаар хангагддаг онцлогтой. Энэ нь худалдан авагч бүр бага хэмжээний ачааг өндөр үнээр тээвэрлэхэд хүрдэг ба нэгдсэн зохион байгуулалтад орж товарын хангалтыг их хэмжээгээр зориулалтын агуулахад хэрэглэгчдэд ойр байршилд хадгалснаар тээврийн үнэ өртөг буурч, эцсийн барааны үнэ буурах нөхцөл болох юм.

Нэг талаас том оврын зориулалтын агуулахын аж ахуй байхгүй, нөгөө талаас бага багаар тээвэрлэх замаар нэгж бараанд ногдох тээврийн өртөг өндөр байгаатай уялдуулан хэрэглэгчдэд олгох бараа, бүтээгдэхүүний үнийг бууруулах агуулахын аж ахуйг нэгдсэн байдлаар төлөвлөх хэрэгцээ шаардлагад энэхүү төсөл үндэслэгдэж байна.

1.2 ЗОРИЛГО БА ЗОРИЛТ

Энэхүү техник эдийн засгийн үндэслэл нь Увс аймагт Баруун 5 аймгийн товарын хэрэгцээг хангах чадвартай төвлөрсөн агуулахын аж ахуй, логистикийн үйл ажиллагаа бүхий нэгдсэн төвийн хөгжлийн хэтийн төлөв, орон зайн төлөвлөлтийн шийдлийг санал болгох явдал юм. Шинээр байгуулагдаж буй Нэгдсэн логистик төвийг төлөвлөхдөө олон улсад логистик төв байгуулж буй туршлагад харгалзан түүний эмх цэгцтэй, нарийн зохион байгуулалтын шийдэлд үндэслэсэн болно.

Төслийн зорилго нь :

- Увс аймагт Баруун 5 аймгийн товарын хэрэгцээг хангах чадвартай, тээвэрлэлт, ачааны төвлөрсөн цэг байгуулан дэд бүтцийн сүлжээнд холбогдсон тээврийн логистикийн төв байгуулах явдал,
- Төслийн ажлын зураг, төсөл боловсруулалтын үе шатанд болон түүний дараа тухайн төслийг хэрэгжүүлснээр хүний эрүүл мэнд, байгаль орчинд учруулж



болзошгүй сөрөг нөлөөллийн хэмжээ, үр дагавар, хамрах хүрээ, учруулах хохирлын хэмжээг тогтоож, түүнийг багасгах, арилгах арга хэмжээ, технологийн шийдэл, төслийн хэрэгжүүлэх хамгийн оновчтой хувилбарыг тогтооход оршино.

Үүний тулд шийдвэрлэж буй үндсэн асуудлууд нь:

- Тооцоолсон газрыг орон нутаг шийдвэрлэж харуул хамгаалалт бүхий хашаа барих
- Увс аймаг болон бусад баруун аймгуудын хөгжлийн чиг хандлага, үндсэн чиглэлийг тодорхойлох, хязгаарын нөхцөлүүдийг гаргаж ирэх,
- Газар дээрх орчныг инженер геологи, байгаль орчны үнэлгээгээр судалж тодорхойлох,
- Барилгажилтын талбайг газар нутгийн багтаамж, ачаа тээврийн эрэлт хэрэгцээнд тулгуурлаж тогтоох,
- Одоо байгаа ачаа эргэлтийн нөхцөлийг тодорхойлох,
- Логистик төвийн ажлын байрны тоо, өргөтгөх нөхцөл, тэдгээрийн хүчин чадлыг тодорхойлох,
- Хэрэгжүүлэх үе шатны төлөвлөгөө, санхүүжилтийн шийдлийг боловсруулах,
- Нөхцөл байдлын шинжилгээг хийж ачаа тээвэр, нийгэм-эдийн засаг, байгаль орчин, барилга байгууламжууд, инженерийн ба тээврийн дэд бүтцийн одоогийн байдлын дүн шинжилгээ боловсруулалт хийж үнэлэлт дүгнэлт өгөх,
- Дэд бүтцийн хангамжийн хувилбаруудыг нарийвчлан боловсруулах,
 - Бие даасан дулаан хангамж бүхий дулаан, цэвэр усны иж бүрэн системийн зураг, төсөв
 - Төлөвлөж байгаа газрын хэмжээнд нэгдсэн зам талбай, пүүний нэгдсэн зураг төсөв
 - Цахилгаан хангамжийн иж бүрэн зураг төсөв
 - Бие даасан цаашлаад үйлдвэрийн бүсэд хамаарах ариутгах татуургын систем бүхий цэвэрлэх байгууламж
 - Шаардлагатай бүтээгдэхүүнийг шинжлэх лаборатори барьж байгуулах зураг төсөв
- Тээвэрлэлтийг хамгийн хямд зардлаар шуурхай хүргэх боломжийг судлан шийдвэрлэх
- Логистикийн төвд байгаль орчинд ээлтэй, сүүлийн үеийн дэвшилтэт техник, технологийг нэвтрүүлэх
- Үйлчилгээ эрхлэгчдийн хөдөлмөрийг хөнгөвчилсөн, үр ашигтай тээвэрлэлтийг зохион байгуулах шийдлийг санал болгох,



- Логистик төвийг үе шаттай хөгжүүлэх төлөвлөлтийн шийдлийг боловсруулах,
- ТЭЗҮ-д тулгуурлан логистик төвийн **ерөнхий** төлөвлөгөө хийж мэргэжлийн байгууллагаар баталгаажуулах
- Эхний ээлжид нэн шаардлагатай барилгажилт, агуулахын зураг төсөв

Логистик төв байгуулагдсанаар Баруун бүсийн ард иргэдийн товарын хангалт, нөхцөл сайжирч, ачаа тээврийн урсгалыг нэмэгдүүлэхэд төрөөс үзүүлэх дэмжлэг нэмэгдэнэ гэж үзэж байна. Тухайлбал:

- Урьдчилсан байдлаар 200-300 орчим байнгын ажлын байр бий болно,
- Увс аймгийн хөгжил эрчимжинэ,
- Ачаа тээврийн урсгал нэмэгдэнэ,
- Олон улсын шаардлагад нийцсэн агуулахын аж ахуйтай болох,
- Ажилчдын эрүүл аюулгүй орчинд ажиллаж, амьдрах нөхцөл бүрдэх,
- Одоогоор ашиглалт багатай, нийгэм эдийн засгийн өгөөжгүй байгаа газар нутаг дахин төлөвлөгдсөнөөр эдийн засгийн эргэлтэд орох зэрэг болно,


Баруун бүсийн Логистик төвийг төлөвлөхдөө Нэгдсэн төв байдлаар төлөвлөхийг санал болгож байгаа ба энэ нь хөрөнгө оруулалт татах, нэгдсэн удирдлагаар хангах болон хэрэгжилтийн үеийн ба үйл ажиллагаа явуулах үеийн олон хүндрэлтэй нөхцөлөөс зайлсхийх боломжийг олгоно.

1.3 ХАМРАХ ХҮРЭЭ


Улаангом нь Увс аймгийн төв юм. Увс нуурын хотгорын баруун урд захад, Хархираа уулын бэлд оршдог. Мөн ОХУ-ын хилийн ойролцоо оршдог. Газар нутаг нь 39 км² бөгөөд Улаанбаатараас 1456 км зайтай газарт оршино.

Баруун бүсийн Нэгдсэн Логистик төв нь Увс аймгийн Тариалан сумын 3-р баг дамнан Улаанбаатараас Улаангомыг чиглэсэн авто зам дагуу аймгийн төвөөсөө 7.5 км зайд, авто замаасаа 300 м зайд 345.5x523м хэмжээтэй 50 га талбайд байршсан.

Зураг 1.1 Увс аймгийн Улаангом сум Улаанбаатар хотоос



Зураг 1.2 Улаангом хот дахь шинээр төлөвлөгдөж буй Логистик төвийн байршлын схем



1.4 АРГАЧЛАЛ

Техник эдийн засгийн үндэслэл (ТЭЗҮ) гэдэг тухайн төслийн суурь судалгаанд үндэслэн техник, технологи, хүчин чадал, эдийн засаг, нийгмийн үр ашгийн тооцоонд тулгуурлан харьцуулалтын аргаар стратеги, хэтийн төлөвийн чиг хандлагыг тодорхойлох үйл ажиллагааг хэлнэ.

Увс аймгийн төв Тариалан сумын нутаг дэвсгэрт байрших Баруун бүсийн логистикийн нэгдсэн төвийн техник эдийн засгийн үндэслэл, зураг төслийн ажлыг боловсруулахдаа



Монгол улсын хууль, журам, стандартууд болон барилга хот байгуулалтын зохих норм дүрмийг баримталснаас зураг төсөл боловсруулах норм дүрэмд нийцсэн байдлаар хийж гүйцэтгэж байна.

ТЭЗҮ-ийг боловсруулахад хэрэглэсэн норм дүрмийг дурдвал:

- Хот, тосгоны төлөвлөлт, барилгажилтын норм ба дүрэм (БНБД 30-01-04);
- Хот, суурины гудамж, зам төлөвлөлт (БНБД-32-01-04)
- Хот, суурины хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулах аргачилсан заавар (УББ 11-202-00);
- Хот, суурин газарт хот байгуулалтын иж бүрэн үнэлгээ өгөх аргачилсан заавар (УББ 30-201-09);
- Үндэсний хөгжил, шинэтгэлийн хорооны даргын 2020 оны 06 сарын 18-ны өдрийн А-56 дугаар тушаалын 7-р хавсралт “Төслийн техник, эдийн засгийн урьдчилсан судалгаа хийх аргачлал”,
- Үндэсний хөгжил, шинэтгэлийн хорооны даргын 2020 оны 06 сарын 18-ны өдрийн А-56 дугаар тушаалын 4-р хавсралт “Төслийн санхүүгийн үр ашгийн шинжилгээ хийх аргачлал”,

Одоогийн байдлын судалгаа

Газар дээрх судалгааг хийхдээ: 2021 оны 8 сараас 12 саруудын хооронд төлөвлөлтийн нутаг дэвсгэрт очиж газар дээр нь хэмжилт судалгаа хийх, баримтжуулах, фото зураг авалт хийх, ярилцлага хийх зэргээр шаардлагатай мэдээллийг цуглуулж шинжилгээ хийсэн. Үүний үр дүнд төлөвлөлтийн нутаг дэвсгэрийн инженер геологийн нөхцөл, байгаль орчны үзүүлэлт болон тус бүс орчмын зам тээврийн хангамж, инженерийн дэд бүтцийн талаар төлөвлөлтөд хэрэгтэй мэдээ мэдээллийг газар дээр нь тодорхойлсон,

Судалгааны ажлыг Увс аймаг болон Улаанбаатар хотод тухайн ажилтай холбогдох дараах байгууллагуудтай уулзаж, санал солилцох мэдээлэл авах ажлууд хийгдсэн болно.

Эдгээр газруудын холбогдох хүмүүстэй уулзаж санал хүсэлтийг авсан. 2022 оны 03 сарын 22-ноос 04 сарын 11-ний хооронд төслийн талбайд инженер геологийн ажлыг хийж гүйцэтгэсэн. Судалгааны ажлын хүрээнд аймаг, сумын болон одоогийн цэвэрлэх байгууламжийн удирдлагуудтай уулзаж орон нутгийн хөгжийн одоо ирээдүйн талаарх ерөнхий мэдээллийг авсан бөгөөд газар дээр танилцах ажлуудыг хийж гүйцэтгэсэн.

Статистик судалгааг хийхдээ: Бүх статистик мэдээллийг ҮСХ болон Увс аймгийн захиргаанаас гаргасан тайлан мэдээ болон төлөвлөлтөд хамрагдсан хэсгийн мэдээлэлд үндэслэсэн болно,



Төлөвлөлтийн шийдэл

Одоогийн байдлын судалгаа, дүгнэлт, цэвэрлэх байгууламжийн технологийн шийдлээс хамааруулж төлөвлөлтийн шийдлийг боловсрууллаа.

Төлөвлөлтийн шийдлийг гаргахдаа: Захиалагчаас өгсөн бусад удирдамж болон санал, төслийн талбайн инженер геологийн нөхцөл, байгаль орчны үзүүлэлт, жишиг холболтын зургуудад дүн шинжилгээ хийж төлөвлөлтийн хувилбар боловсруулан шийдлийг холбогдох эрх бүхий байгууллагуудтай зөвшилцсөний үндсэн дээр гаргасан,

Ажлын байр: Технологийн шийдэл, барилга байгууламжууд, ажлын гормын хүчин чадалд тусгасан ажлын байрны тооцоог авч хэрэглэсэн,

Инженерийн тооцоолол: Ерөнхий төлөвлөгөөнд дурдагдсан барилга байгууламжийн хүчин чадалд тулгуурласан,

Хөрөнгө оруулалтын төсөвт өртгийн тооцоог хийхдээ

- Барилгын төсөвт өртгийн хувьд хийхдээ УБ хот дахь жишиг үнэлгээг байгалийн зарим хүчин зүйлийн нөлөөллийн болон тээврийн илтгэлцүүрүүдээр үржүүлж авна. 2016 оны 12 сарын 28-ний өдөр ЗГ-ын 203-р тогтоолоор баталсан “Барилгын байгууламжийн нэгж хүчин чадлын жишиг үнэлгээг хэрэглэх дүрэм” /БД 81-106-16/ ашиглана.
- Ингэхдээ үнийн итгэлцүүрийг авч үзэхдээ Барилга хот байгуулалтын сайдын 2022 оны 03 сарын 31-ны өдрийн 74-р тушаалаар баталсан үнийн индексийг ашигласан;
- Тус норм, дүрэмд тусгагдаагүй аливаа объект, тоног төхөөрөмжийн өртгийг зах зээлийн үнээр тусгав,

БҮЛЭГ 2. ТӨСЛИЙН ТАЛБАЙН ОДООГИЙН БАЙДЛЫН СУДАЛГАА

Бүлгийн дэд агуулга:

- ✂ Инженер геологийн нөхцөл
- ✂ Байгаль орчны нөхцөл
- ✂ Инженерийн дэд бүтцийн одоогийн байдлын судалгаа
- ✂ Улаангом хотын нийгэм эдийн засгийн нөхцөл



2.1 ИНЖЕНЕР ГЕОЛОГИЙН НӨХЦӨЛ

2.1.1. Инженер геологийн судалгааны үндэслэл

Зураг төсөл, судалгаа шинжилгээний “Эл Эм Ланд” ХХК болон Увс аймгийн ЗДТГазрын ХБТХОХ-тай хамтран байгуулсан ажил гүйцэтгэх гэрээг үндэслэн Увс аймаг, Тариалан сумын нутаг дэвсгэр, 3-р багт баригдах баруун бүсийн ложистик төвийн барилгын талбайд ажлын зургийн үе шатанд зориулсан инженер-геологийн судалгааны ажлыг захиалагчаас ирүүлсэн ажлын даалгаврын дагуу 2022 оны 03-р сарын 22-ны өдрөөс 2022 оны 04-р сарын 11-ний өдөр хүртэл хийж гүйцэтгэлээ.

Зураг 2. 1 Судалгааны талбайн байршил



2.1.2. Судалгааны ажлын аргачлал

Судалгааны талбайд инженер-геологийн судалгааны ажлыг явуулахдаа БНБД 11-03-01-ийг баримтлан, төлөвлөж буй барилгын сууринд нөлөөлөх гүний хэмжээнд ул хөрсний зузаалаг, тархалт, шинж чанар, хөрсний усны түвшинг тодруулах зорилготой инженер-хайгуулын ажлын 9 цооногийг 8.0-8.4 метрийн гүнтэйгээр нийт 73.7 тууш метр өрөмдөж, инженер-геологийн тэмдэглэл хийв. 1:1000-ны масштабтай байр зүйн зурагт цооногуудыг байршуулан, цооногийн амсрын өндөржилтийг тус зургаас авсан ба өрөмдлөгийн ажлыг БГМ-1 ЗИЛ 131 маркийн өрмийн машинаар, баганат өрөмдлөгийн аргаар хийж гүйцэтгэсэн.

Өрөмдсөн цооногуудаас эвдэрсэн бүтэцтэй 14ш, эвдрээгүй бүтэцтэй 25ш, нийт 39ш дээж авч хөрсний физик шинж чанарын шинжилгээний туршилтыг Стандартчилал, хэмжил зүйн газраас итгэмжлэгдсэн “Экотех Проект” ХХК-ийн ул хөрс судлалын лабораторид MNS 2143:2000 стандартын дагуу 2022 оны 03-р сарын 30-аас 2022 оны 04-р сарын 06-ны өдрүүдэд гүйцэтгэж, үр дүнг боловсруулан хянан баталгаажуулсан.


Зураг 2. 2 Инженер геологийн үйл ажиллагаа



2.1.3. Байр зүйн зураг

Байр зүйн М:500 масштабтай зураглалыг Лэнд Тэст ХХК нь 2022 оны 02 дугаар сарын 07-наас 2022 оны 02 дугаар сарын 8-ны хооронд Kolida K9-E маркийн 1 ширхэг GNSS багажийг ашиглаж хээрийн хэмжилтийг хийж гүйцэтгэсэн.

Зураг 2. 3 Байр зүйн зураг



2.1.4. Уур амьсгал

Судалгааны район нь барилга байгууламжийн төлөвлөлтөд хэрэглэгдэх цаг уурын үзүүлэлтийн хувьд Монгол орны нийт нутгийн адил эх газрын эрс тэс уур амьсгалтай. Өвөлдөө хүйтэн, зундаа сэрүүвтэр, цаг уурын хувьд хуурайвтар цөл, говийн нөлөөнд ихээхэн автагдсан өндөр уулын өвөрмөц уур амьсгалтай, богино хугацаанд өөрчлөгдөж байдаг. Судалгааны районы уур амьсгалын үзүүлэлтүүдийг “Барилгад хэрэглэх уур амьсгал ба геофизикийн үзүүлэлт” (БНБД 23-01-09)- ийн Увс аймгийн Тариалан, Улаангом станцуудын үзүүлэлтээр өгч хүснэгтээр үзүүлээ.

Хүснэгт 2. 1 Цаг уурын үзүүлэлт

Цаг уурын үндсэн үзүүлэлтүүд	Тоон утга
Гадна агаарын температур дундаж утга	-3.5° C
1-р сарын дундаж	-29.9°С
2-р сарын дундаж	-26.4°С
7-р сарын дундаж	16.6°С
Агаарын үнэмлэхүй их температур	36°С
Агаарын үнэмлэхүй бага температур	-40.2°С



Гадна агаарын тооцооны температур 5 өдөр 3 өдөр 1 өдөр	-37.5°C -37.8°C -38.2°C
Салхины дундаж хурд, м/сек: Жилийн дундаж Өвлийн дундаж	1.5 0.8
Хур тунадас: Жилд унах дундаж хэмжээ Хоногт унах дундаж хэмжээ	144.9мм 66.8мм
Цасны ачаалал	50.0кг/м ²
Салхины шахац 5жилд 1удаа	23.0 кг/м ²
Галлагааны хугацааны үзүүлэлт: Галлагаа эхлэх Галлагаа дуусах Үргэлжлэх хугацаа	22/IX 10/V 230

2.1.5. Геоморфологийн хэв шинж ба физик-геологийн үзэгдэл үйл явц

Судалгааны талбай нь геоморфологийнхоо хувьд уулын бэл, хормойд зөөгдөл-хуримтлалын хэв шинжит гадаргууд хамаарагдах бөгөөд баруун урдаас зүүн хойшоо аажмаар намссан хэвгий тогтоцтой, газрын гадаргуугийн үнэмлэхүй өндөржилт нь 984.56-988.78 метр, өндөржилтийн зөрүү 4.22 метр байна.

Судалгааны талбайд физик-геологийн үзэгдэл, үйл явц хөгжөөгүй.

2.1.6. Геологийн тогтоц

Судалгааны талбайд ургамлын үндэс бүхий өнгөн хөрсний доороос Плейстоцен-голоцены настай, Делюви-пролювийн /dp Q₁₋₂/ гаралтай, цайвар, цайвар шаргалаас бор шаргал өнгийн жижиг ширхэгтэй элс, хайргархаг элс, хайрга агуулсан элсэнцэр, хайргархаг элсэнцэр, элсэнцэр чигжээстэй хайрга, хайрга агуулсан шавранцар ул хөрс илэрсэн. Элсэн чигжээстэй хайрганы мишил үе агуулсан байна. Ул хөрсний тархалт зузаалгийг зүсэлтээр зурж үзүүлээ.



Зураг 2. 4 Ул хөрсний тархалт



2.1.7. Гидрогеологийн нөхцөл

Судалгааны талбайд 7.9-8.2м хүртэл гүн өрөмдөхөд газар доорх ус илрээгүй. /2022 оны 03-р сарын 22-26-ны өдрүүдийн байдлаар/

2.1.8. Геокриологийн нөхцөл

Судалгааны район нь олон жилийн цэвдэг хөрс тохиолдлын тархалттай бүслүүрт хамаарагдах бөгөөд судалгааны талбайд 8.2 метр хүртэл гүн өрөмдөхөд олон жилийн цэвдэг хөрс илрээгүй. /2022 оны 03-р сарын 22-26-ны өдрүүдийн байдлаар/

2.1.9. Инженер-геологийн ангилал ба ул хөрсний физик-механик шинж чанар

Судалгааны талбайд тархсан ул хөрсийг нас, гарал үүсэл, ширхгийн бүрэлдэхүүн, физик шинж чанараас нь хамааруулж, инженер-геологийн 6 төрлийн элемент болгон ангиллаа. Жижиг ширхэгтэй элс /ИГЭ-1/, хайргархаг элс /ИГЭ-2/, хайрга агуулсан элсэнцэр /ИГЭ-3/, хайргархаг элсэнцэр /ИГЭ-4/, элсэнцэр чигжээстэй хайрга /ИГЭ-5/, хайрга агуулсан шавранцар /ИГЭ-6/ ул хөрсүүд харилцан адилгүй зузаалагтайгаар тархсан.

ИГЭ-1. Жижиг ширхэгтэй элсэн ул хөрс /dpQ₁₋₂/

Бор саарлаас бор хүрэн өнгөтэй, Плейстоцен-голоцены настай, Делюви-пролювийн /dp Q₁₋₂/ гаралтай, бага чийгтэй, жижиг ширхэгтэй элсэн ул хөрсний ширхгийн бүрэлдэхүүний дундаж утгыг тодорхойлбол (%):

- Хайр, хайрга 4.4
- Элс 77.0



- Тоос 8.6
- Шавар 10.0 тус тус агуулагдана.

Ул хөрсний физик шинж чанарын үзүүлэлтийн дундаж утгыг тодорхойлбол:

- Байгалийн чийг, W_c 0.031
- Урсалтын хязгаар, W_L -
- Имрэгдлийн хязгаар, W_p -
- Уян налархайн тоо, J_p -
- Хатуу хэсгийн нягт, γ , г/см³ 2.66
- Эзлэхүүн жин, ρ , г/см³ 2.01
- Хуурай хэсгийн нягт, ρ_d , г/см³ 1.95
- Сүвшил, n , % 26.87
- Сүвшлийн итгэлцүүр, e 0.368
- Чийглэгийн зэрэг, S_r 0.23
- Консистенц, J_L -

Хөрсний механик шинж чанарын үзүүлэлтийн норматив болон тооцооны утгыг БНБД 50-01-16-ийн 1-р хавсралт хүснэгт 1-ээр өгвөл:

Норматив утга:

- Зууралдлын хүч $C^H = C^H = 6.0\text{кПа}$
- Дотоод үрэлтийн өнцөг $\varphi^H = \varphi^H = 36.0^\circ$
- Хэв гажилтын модуль $E = 45.0\text{МПа}$

Тооцооны утга:

- Зууралдлын хүч $C^I = 4.0\text{кПа}$
- Дотоод үрэлтийн өнцөг $\varphi^I = 32.4^\circ$
- Тооцооны эсэргүүцэл $R_0 = 300\text{кПа}$

"Барилга байгууламжийн буурь, суурийн зураг төсөл зохиох норм ба дүрэм" БНБД 50-01-16-аар 5.3.6-ийн дагуу жижиг ширхэгтэй элсэн /ИГЭ-1/ ул хөрсний нунтаглалтын үзүүлэлт $D > 5$, чийглэгийн зэрэг $S_r = 0.23$ байгаа нь сулавтар овойлттой ул хөрсөнд нормчлогдоно.

Жижиг ширхэгтэй элсэн ул хөрсний газар шорооны ажлын зэрэг гэсгэлэн нөхцөлд гар аргаар малтахад I байна. Улирлын хөлдөлтийн норматив гүн-3.57м.



Жижиг ширхэгтэй элсэн ул хөрсний эзлэхүүн жингийн тооцооны үзүүлэлт:

$$P_{0.95}=1.99\text{г/см}^3 ; P_{0.85}=2.00\text{г/см}^3 \text{ байна.}$$

Жижиг ширхэгтэй элсэн ул хөрсний хувийн цахилгаан эсэргүүцэл:

Хуурай нөхцөлд 2000-10000 Ом.м

Чийгтэй нөхцөлд 200-600 Ом.м байна.

ИГЭ-2. Хайргархаг элсэн ул хөрс /dpQ₁₋₂/

Бор саарал, бор хүрэн өнгөтэй, Плейстоцен-голоцены настай, Делюви-пролювийн /dp Q₁₋₂/ гаралтай, бага чийгтэй, бул чулуутай, элсэн чигжээстэй хайрганы мишил үе агуулсан, хайргархаг элсэн ул хөрсний ширхгийн бүрэлдэхүүний дундаж утгыг тодорхойлбол (%):

- Хайр, хайрга 46.3
- Элс 43.6
- Тоос 4.6
- Шавар 5.5 тус тус агуулагдана.

Ул хөрсний физик шинж чанарын үзүүлэлтийн дундаж утгыг тодорхойлбол:

- Байгалийн чийг, W_C 0.029
- Урсалтын хязгаар, W_L -
- Имрэгдлийн хязгаар, W_P -
- Уян налархайн тоо, J_P -
- Хатуу хэсгийн нягт, γ , г/см³ 2.66
- Эзлэхүүн жин, ρ , г/см³ 2.13
- Хуурай хэсгийн нягт, ρ_d , г/см³ 2.07
- Сүвшил, n , % 22.30
- Сүвшлийн итгэлцүүр, e 0.288
- Чийглэгийн зэрэг, S_r 0.26
- Консистенц, J_L -

Хөрсний механик шинж чанарын үзүүлэлтийн норматив болон тооцооны утгыг БНБД 50-01-16-ийн 1-р хавсралт хүснэгт 1-ээр өгвөл:

Норматив утга:



- Зууралдлын хүч $C^H = C^I = 2.0\text{кПа}$
- Дотоод үрэлтийн өнцөг $\varphi^H = \varphi^I = 40.0^\circ$
- Хэв гажилтын модуль $E = 45.0\text{МПа}$

Тооцооны утга:

- Зууралдлын хүч $C^I = 1.33\text{кПа}$
- Дотоод үрэлтийн өнцөг $\varphi^I = 36.3^\circ$
- Тооцооны эсэргүүцэл $R_0 = 500\text{кПа}$

Хайргархаг элсэн /ИГЭ-2/ ул хөрс нь овойлтгүй ул хөрсөнд нормчлогдоно. Хайргархаг элсэн ул хөрсний газар шорооны ажлын зэрэг гэсгэлэн нөхцөлд гар аргаар малтахад III байна. Улирлын хөлдөлтийн норматив гүн-3.86м.

Хайргархаг элсэн ул хөрсний эзлэхүүн жингийн тооцооны үзүүлэлт:

$$P_{0.95}=2.08\text{г/см}^3 ; P_{0.85}=2.10\text{г/см}^3 \text{ байна.}$$

Хайргархаг элсэн ул хөрсний хувийн цахилгаан эсэргүүцэл:

Хуурай нөхцөлд	2000-10000 Ом.м
Чийгтэй нөхцөлд	200-600 Ом.м байна.

ИГЭ-3. Элсэнцэр ул хөрс /dpQ₁₋₂/

Бор хүрэн өнгөтэй, Плейстоцен-голоцены настай, Делюви-пролювийн /dp Q₁₋₂/ гаралтай, хатуу консистенцтэй, хайрга агуулсан элсэнцрийн мишил үе агуулсан, бул чулуу агуулсан, элсэнцэр ул хөрсний ширхгийн бүрэлдэхүүний дундаж утгыг тодорхойлбол (%):

- Хайр, хайрга 6.4
- Элс 70.5
- Тоос 9.3
- Шавар 13.8 тус тус агуулагдана.

Ул хөрсний физик шинж чанарын үзүүлэлтийн дундаж утгыг тодорхойлбол:

- Байгалийн чийг, W_c 0.038
- Урсалтын хязгаар, W_L 0.188
- Имрэгдлийн хязгаар, W_p 0.146
- Уян налархайн тоо, J_p 0.043



• Хатуу хэсгийн нягт, γ , г/см ³	2.68
• Эзлэхүүн жин, ρ , г/см ³	2.00
• Хуурай хэсгийн нягт, ρ_d , г/см ³	1.93
• Сүвшил, n , %	27.91
• Сүвшлийн итгэлцүүр, e	0.390
• Чийглэгийн зэрэг, S_r	0.26
• Консистенц, J_L	<0

Хөрсний механик шинж чанарын үзүүлэлтийн норматив болон тооцооны утгыг БНБД 50-01-16-ийн 1-р хавсралт хүснэгт 2, 3-аар өгвөл:

Норматив утга:

- Зууралдлын хүч $C^H = C^I = 21.0\text{кПа}$
- Дотоод үрэлтийн өнцөг $\varphi^H = \varphi^I = 29.0^\circ$
- Хэв гажилтын модуль $E = 32.0\text{МПа}$

Тооцооны утга:

- Зууралдлын хүч $C^I = 14.0\text{кПа}$
- Дотоод үрэлтийн өнцөг $\varphi^I = 25.2^\circ$
- Тооцооны эсэргүүцэл $R_0 = 325\text{кПа}$

Элсэнцэр /ИГЭ-3/ ул хөрсний хөлдөлтийн овойлтын зэрэг $R_f=0.205$, кредит чийг $W_{cr}=0.143$ байгаа нь сулавтар овойлттой ул хөрсөнд нормчлогдоно. Элсэнцэр ул хөрсний газар шорооны ажлын зэрэг гэсгэлэн нөхцөлд гар аргаар малтахад II байна. Улирлын хөлдөлтийн норматив гүн-3.57м.

Элсэнцэр ул хөрсний эзлэхүүн жингийн тооцооны үзүүлэлт:

$$P_{0.95}=1.91\text{г/см}^3 ; P_{0.85}=1.95\text{г/см}^3 \text{ байна.}$$

Элсэнцэр ул хөрсний хувийн цахилгаан эсэргүүцэл: 60-120 Ом.м байна.

ИГЭ-4. Хайргархаг элсэнцэр ул хөрс /dpQ₁₋₂/

Бор саарал, бор хүрэн өнгөтэй, Плейстоцен-голоцены настай, Делюви-пролювийн /dp Q₁₋₂/ гаралтай, бул чулуу агуулсан, хатуу консистенцтэй, хайргархаг элсэнцэр ул хөрсний ширхгийн бүрэлдэхүүний дундаж утгыг тодорхойлбол (%):

- Хайр, хайрга 42.8



- | | | |
|---------|------|----------------------|
| • Элс | 43.8 | |
| • Тоос | 6.0 | |
| • Шавар | 7.4 | тус тус агуулагдана. |

Ул хөрсний физик шинж чанарын үзүүлэлтийн дундаж утгыг тодорхойлбол:

- | | |
|---|-------|
| • Байгалийн чийг, W_c | 0.034 |
| • Урсалтын хязгаар, W_L | 0.173 |
| • Имрэгдлийн хязгаар, W_p | 0.137 |
| • Уян налархайн тоо, J_p | 0.036 |
| • Хатуу хэсгийн нягт, γ , г/см ³ | 2.67 |
| • Эзлэхүүн жин, ρ , г/см ³ | 2.13 |
| • Хуурай хэсгийн нягт, ρ_d , г/см ³ | 2.06 |
| • Сүвшил, n , % | 22.86 |
| • Сүвшлийн итгэлцүүр, e | 0.298 |
| • Чийглэгийн зэрэг, S_r | 0.31 |
| • Консистенц, J_L | <0 |

Хөрсний механик шинж чанарын үзүүлэлтийн норматив болон тооцооны утгыг БНБД 50-01-16-ийн 1-р хавсралт хүснэгт 4, 6-аар өгвөл:

Норматив утга:

- | | |
|-------------------------|--------------------------------------|
| • Зууралдлын хүч | $C^H = C^I = 20.0\text{кПа}$ |
| • Дотоод үрэлтийн өнцөг | $\varphi^H = \varphi^I = 43.0^\circ$ |
| • Хэв гажилтын модуль | $E = 35.0\text{МПа}$ |

Тооцооны утга:

- | | |
|-------------------------|--------------------------|
| • Зууралдлын хүч | $C^I = 13.3\text{кПа}$ |
| • Дотоод үрэлтийн өнцөг | $\varphi^I = 37.4^\circ$ |
| • Тооцооны эсэргүүцэл | $R_0 = 450\text{кПа}$ |

Хайргархаг элсэнцэр /ИГЭ-4/ ул хөрсний нунтаглалтын үзүүлэлт $D > 5$, чийглэгийн зэрэг $S_r = 0.31$ байгаа нь сулавтар овойлттой ул хөрсөнд нормчлогдоно. Хайргархаг элсэнцэр ул хөрсний газар шорооны ажлын зэрэг гэсгэлэн нөхцөлд гар аргаар малтахад III байна. Улирлын хөлдөлтийн норматив гүн-3.84м.



Хайргархаг элсэнцэр ул хөрсний эзлэхүүн жингийн тооцооны үзүүлэлт:

$$P_{0.95}=2.07\text{г/см}^3 ; P_{0.85}=2.10\text{г/см}^3 \text{ байна.}$$

Хайргархаг элсэнцэр ул хөрсний хувийн цахилгаан эсэргүүцэл: 80-250 Ом.м байна.

ИГЭ-5. Элсэнцэр чигжээстэй хайрган ул хөрс /dp Q₁₋₂/

Бор саарал өнгөтэй, Плейстоцен-голоцены настай, Делюви-пролювийн /dp Q₁₋₂/ гаралтай, хатуу консистенцтэй, бул чулуу агуулсан, элсэнцэр чигжээстэй хайрган ул хөрсний ширхгийн бүрэлдэхүүний дундаж утгыг тодорхойлбол (%):

- Хайр, хайрга 57.3
- Элс 32.1
- Тоос 5.2
- Шавар 5.4 тус тус агуулагдана.

Ул хөрсний физик шинж чанарын үзүүлэлтийн дундаж утгыг тодорхойлбол:

- Байгалийн чийг, W_c 0.033
- Урсалтын хязгаар, W_L 0.179
- Имрэгдлийн хязгаар, W_p 0.135
- Уян налархайн тоо, J_p 0.044
- Хатуу хэсгийн нягт, γ , г/см³ 2.68
- Эзлэхүүн жин, ρ , г/см³ 2.15
- Хуурай хэсгийн нягт, ρ_d , г/см³ 2.08
- Сүвшил, n, % 22.20
- Сүвшлийн итгэлцүүр, e 0.286
- Чийглэгийн зэрэг, S_r 0.30
- Консистенц, J_L <0

Хөрсний механик шинж чанарын үзүүлэлтийн норматив болон тооцооны утгыг БНБД 50-01-16-ийн 1-р хавсралт хүснэгт 4, 6-аар өгвөл:

Норматив утга:

- Зууралдлын хүч $C^H = C^I = 16.0\text{кПа}$
- Дотоод үрэлтийн өнцөг $\varphi^H = \varphi^I = 44.0^\circ$
- Хэв гажилтын модуль $E = 45.0\text{МПа}$



Тооцооны утга:

- Зууралдлын хүч $C^I = 10.6 \text{кПа}$
- Дотоод үрэлтийн өнцөг $\phi^I = 38.3^\circ$
- Тооцооны эсэргүүцэл $R_0 = 450 \text{кПа}$

Элсэнцэр чигжээстэй хайрган /ИГЭ-5/ ул хөрсний нунтаглалтын үзүүлэлт $D > 5$, чийглэгийн зэрэг $S_r = 0.30$ байгаа нь сулавтар овойлттой ул хөрсөнд нормчлогдоно. Элсэнцэр чигжээстэй хайрган ул хөрсний газар шорооны ажлын зэрэг гэсгэлэн нөхцөлд гар аргаар малтахад IV байна. Улирлын хөлдөлтийн норматив гүн-3.93м.

Элсэнцэр чигжээстэй хайрган ул хөрсний эзлэхүүн жингийн тооцооны үзүүлэлт:

$$P_{0.95} = 2.11 \text{г/см}^3 ; P_{0.85} = 2.13 \text{г/см}^3 \text{ байна.}$$

Элсэнцэр чигжээстэй сайрган ул хөрсний хувийн цахилгаан эсэргүүцэл: 110-300 Ом.м байна.

ИГЭ-6. Хайрга агуулсан шавранцар ул хөрс /dpQ₁₋₂/

Бор саарлаас бор хүрэн өнгөтэй, Плейстоцен-голоцены настай, Делюви-пролювийн /dp Q₁₋₂/ гаралтай, хатуу консистенцтэй, хайрга агуулсан шавранцар ул хөрсний ширхгийн бүрэлдэхүүний дундаж утгыг тодорхойлбол (%):

- Хайр, хайрга 15.4
- Элс 58.6
- Тоос 9.5
- Шавар 16.5 тус тус агуулагдана.

Ул хөрсний физик шинж чанарын үзүүлэлтийн дундаж утгыг тодорхойлбол:

- Байгалийн чийг, W_c 0.049
- Урсалтын хязгаар, W_L 0.201
- Имрэгдлийн хязгаар, W_p 0.125
- Уян налархайн тоо, J_p 0.076
- Хатуу хэсгийн нягт, γ , г/см^3 2.70
- Эзлэхүүн жин, ρ , г/см^3 2.04
- Хуурай хэсгийн нягт, ρ_d , г/см^3 1.94
- Сүвшил, n , % 27.98



- Сүвшлийн итгэлцүүр, e 0.389
- Чийглэгийн зэрэг, S_r 0.34
- Консистенц, J_L <0

Хөрсний механик шинж чанарын үзүүлэлтийн норматив болон тооцооны утгыг БНБД 50-01-16-ийн 1-р хавсралт хүснэгт 2, 3-аар өгвөл:

Норматив утга:

- Зууралдлын хүч $C^H = C^I = 47.0 \text{ кПа}$
- Дотоод үрэлтийн өнцөг $\varphi^H = \varphi^I = 25.0^\circ$
- Хэв гажилтын модуль $E = 33.0 \text{ МПа}$

Тооцооны утга:

- Зууралдлын хүч $C^I = 31.3 \text{ кПа}$
- Дотоод үрэлтийн өнцөг $\varphi^I = 21.7^\circ$
- Тооцооны эсэргүүцэл $R_0 = 325 \text{ кПа}$

Хайрга агуулсан шавранцар /ИГЭ-6/ ул хөрсний хөлдөлтийн овойлтын зэрэг $R_f=0.195$, кредит чийг $W_{cr}=0.142$ байгаа нь байгалийн нөхцөлдөө сулавтар овойлттой ул хөрсөнд нормчлогдоно. Хайрга агуулсан шавранцар ул хөрсний чийглэгийн зэрэг нэмэгдэхэд дунд зэргийн овойлт үүсгэх нөхцөлтэй байна. Хайрга агуулсан шавранцар ул хөрсний газар шорооны ажлын зэрэг гэсгэлэн нөхцөлд гар аргаар малтахад II байна. Улирлын хөлдөлтийн норматив гүн-2.94м.

Хайрга агуулсан шавранцар ул хөрсний хувийн цахилгаан эсэргүүцэл: 40-80 Ом.м байна.

2.1.10. Инженер геологийн судалгааны дүгнэлт

Судалгааны талбай нь геоморфологийнхоо хувьд уулын бэл, хормойд зөөгдөл-хуримтлалын хэв шинжит гадаргууд хамаарагдах бөгөөд баруун урдаас зүүн хойшоо намссан хэвгий тогтоцтой, инженер-геологийн 6 элементэд ангилсан, газар хөдлөлтийн 8 (500 жил) баллын бүсэд оршдог зэргийг хамааруулан инженер-геологийн төвөгшлийн ангиллаар дунд зэргийн нөхцөлтэй талбайд ангилагдаж байна.

Судалгааны талбайд 8.0-8.4м гүн өрөмдөхөд газар доорх ус илрээгүй.

Судалгааны район нь олон жилийн цэвдэг хөрс ТОХИОЛДЛЫН тархалттай бүслүүрт хамаарагдах бөгөөд судалгааны талбайд 8.2-8.4 метр гүн өрөмдөхөд олон жилийн цэвдэг хөрс илрээгүй.

Хүснэгт 2. 2 Ул хөрсний механик шинж чанарын нормчлогдох үзүүлэлтүүд

ИГЭ-ийн дугаар	Хөрсний нэр	Зууралдлын хүч, кПа, (кгс/см ²)	Дотоод үрэлтийн өнцөг, градус	Хэв гажилтын модуль, МПа, (кгс/см ²)	Тооцооны эсэргүүцэл, кПа, (кгс/см ²)
----------------	-------------	---	-------------------------------	--	--



		C ^{II}	C ^I	φ ^{II}	φ ^I	E	R ₀
ИГЭ-1	Жижиг ширхэгтэй элс	6.0 (0.06)	4.0 (0.04)	36.0	32.4	45.0 (450)	300 (3.0)
ИГЭ-2	Хайргархаг элс	2.0 (0.02)	1.33 (0.0133)	40.0	36.3	45.0 (450)	500 (5.0)
ИГЭ-3	Элсэнцэр	21.0 (0.21)	14.0 (0.14)	29.0	25.2	32.0 (320)	325 (3.25)
ИГЭ-4	Хайргархаг элсэнцэр	20.0 (0.20)	13.3 (0.133)	43.0	37.4	35.0 (350)	450 (4.5)
ИГЭ-5	Элсэнцэр чигжээстэй хайрга	16.0 (0.16)	10.6 (0.106)	44.0	38.3	45.0 (450)	450 (4.5)
ИГЭ-6	Хайрга агуулсан шавранцар	47.0 (0.47)	31.3 (0.313)	25.0	21.7	33.0 (330)	325 (3.25)

Хүснэгт 2.3 Ул хөрсний улирлын хөлдөлтийн гүн, овойлтын зэрэг, газар шорооны ажлын зэрэг, хувийн цахилгаан эсэргүүцэл

ИГЭ-ийн дугаар	Хөрсний нэр	Улирлын хөлдөлтийн норматив гүн, м	Овойлтын зэрэг	Газар шорооны ажлын зэрэг	Хувийн цахилгаан эсэргүүцэл, ом.м
ИГЭ-1	Жижиг ширхэгтэй элс	3.57	Сулавтар овойлттой	I	Хуурай нөхцөлд 2000-10000 Чийгтэй нөхцөлд 200-600
ИГЭ-2	Хайргархаг элс	3.86	овойлтгүй	III	
ИГЭ-3	Элсэнцэр	3.57	Сулавтар овойлттой	II	60-120
ИГЭ-4	Хайргархаг элсэнцэр	3.84	Сулавтар овойлттой	III	80-250
ИГЭ-5	Элсэнцэр чигжээстэй хайрга	3.93	Сулавтар овойлттой	IV	110-300
ИГЭ-6	Хайрга агуулсан шавранцар	2.94	Сулавтар овойлттой	II	40-80

2.2 БАЙГАЛЬ ОРЧНЫ НӨХЦӨЛ

2.2.1. Физик газарзүйн нөхцөл

Увс аймаг


Увс аймаг нь Монгол улсын баруун хязгаарт Их нууруудын хотгорт оршдог, 69.6 мянган ам дөрвөлжин км нутаг дэвсгэртэй, аймгийн нийт хилийн урт 1267 км. Баруун талаараа Баян-Өлгий аймаг, өмнө талаараа Ховд аймаг, зүүн талаараа Завхан аймаг, хойд талаараа ОХУ-ын Тува улстай 575км газар нутгаар хиллэн оршдог. ОХУ-ын Тува улсын Кызыл хотоос 436км зайтай, БНХАкаси улсын Абакан хотоос -690км, БНАлтай улсын Горно-Алтайск хотоос 800км, Алтайн хязгаарын Барнаул хотоос 1040км, Новосибирск хотоос 1230км зайтай оршдог.



Нийслэл Улаанбаатараас 1400 орчим км алслагдсан. Аймгийн төв Улаангом сум д.т.д 939 метр өндөрт оршдог. Увс, Хяргас нуур түүний эргэн тойрны говийн бүс, Хархираа, Түргэн, Ханхөхийн өндөр уулс бүхий говь, цөлөөс өндөр уулын мөнх цас, мөсөн гол хүртэлх төв Азийн гадагш урсгалгүй ай савын босоо бүслүүрийн бүхий л хэв шинжийг тусгасан ландшафт газарзүйн өвөрмөц тогтоцтой.

Нутаг дэвсгэрийн 8.2 %-ийг уулын ойт хээр, 14.5 %-ийг өндөр уулын, 37.7 %-ийг хээрийн, 39.6 %-ийг говь цөлийн бүс эзэлдэг. Байгалийн мужлалаар Увс, Хяргас нуурын хотгорын цөлжүү хээр, хуурай хээрийн дэд муж, Ханхөхийн нурууны дундаж өндөр бэлэрхэг уул бүхий хээр, хуурай хээр, ар хажуугийн ойн дэд муж, Монгол Алтайн зүүн хэсгийн /Хархираа, Түргэн/ цулдам уул, хотгор ян сарьдаг, уулын нуга, уулын хээрийн дэд мужид тус тус багтана. Хамгийн нам цэг нь д.т.д 758.9 метрт буй Увс нуурын түвшин, хамгийн өндөр цэг нь д.т.д 4250 метрт өргөгдсөн Цагаан Дэглий оргил юм. Хархираа, Түргэний салбар уулс д.т.д 4000 метрээс дээш өндөртэй 31 цаст оргилуудтай.

Зураг 2. 5 Увс аймгийн газарзүйн зураг



2.2.2. Цаг уурын нөхцөл

Ерөнхий төлөв

Их нууруудын хотгор, Алтайн салбар уулсын бүсэд орших тул эрс тэс эх газрын уур амьсгалтай. Увс нуурын хотгор нь эргэн тойрон уулсаар хүрээлэгдсэн уулс хоорондын хотгор төдийгүй төв Азийн антициклоны төв юм. Өвлийн улиралд агаарын даралт 1-р сард 1054 гПа болж, агаарын температур 1-р сард Зүүнговь, Тэс, Улаангом зэрэг ихэнх сумдад -52°C хүрдэг нь монгол оронд тэмдэглэгдсэн хамгийн бага утга тул Увс нуурын хотгорыг Монгол орны хамгийн хүйтэн газар гэж үздэг.




Улаангом нь Монголын хамгийн хүйтэн нутгийн нэг бөгөөд өвөл -52°C хүрдэг бол зун $+40^{\circ}\text{C}$ гаруй градус болтлоо халдаг. 2009 оны оны 01 сард шөнөдөө -46°C хүрч хүйтэрсэн гэсэн судалгаа байна.

Хүснэгт 2. 4 Сарын дундаж температур болон хур тунадасны хэмжээ (Улаангом)

	1-р сар	2-р сар	3-р сар	4-р сар	5-р сар	6-р сар	7-р сар	8-р сар	9-р сар	10-р сар	11-р сар	12-р сар		
Мах. Температур ($^{\circ}\text{C}$)	-26.0	-23.4	-11.6	6.5	19.0	24.5	25.4	23.3	17.3	7.2	-5.8	-21.2	Ø	3
Мин. Температур ($^{\circ}\text{C}$)	-36.6	-35.4	-24.9	-6.0	3.7	10.1	12.2	9.7	3.3	-5.4	-15.6	-30.6	Ø	-9.5
Тунадас (мм)	2	2	3	4	6	26	35	23	13	5	7	4	Σ	130
Нартай цаг (h/d)	4.4	5.6	7.5	8.9	10.1	10.6	9.9	9.6	8.3	6.3	3.4	3.4	Ø	7.3
Агаарын чийгшил (%)	75	74	79	63	42	48	56	60	59	66	76	77	Ø	64.5

Зураг 2. 6 Уур амьсгалын диаграмм



Агаарын температур, түүний өөрчлөлт, хур тунадасны өөрчлөлт


Увс аймгийн нутаг дэвсгэр нь хотгор гүдгэрийн ялгаа ихтэй байдаг учраас өвөл зуны температурын ялгаа их байдаг. Жилийн хамгийн хүйтэн сар нь 1-р сар бөгөөд хүйтний улирлын жилийн дундаж температур нь Тэс, Баруунтуруун, Улаангом, Малчин, Зүүнговь, Түргэн, Давст сумын нутгаар 31,0-35,1 градус, Хар-ус, Завхан, Өндөрхангай сумын нутгаар 22,1-28,3 градус хүйтэн байна. Жилийн дулаан сар нь 7-р сар бөгөөд дундаж температур нь нийт сумын нутгаар 18.4-26.2 градус дулаан байна.

Судалгааны материалаас үзэхэд: Агаарын дундаж температур 2005 онд Тэс суманд $-37,40^{\circ}\text{C}$, Улаангом, Баруунтуруун суманд $-34,9-35,20^{\circ}\text{C}$ хүрч тус тус хүйтэрч байсан байна. Агаарын үнэмлэхүй бага температур Тэс суманд 2005 онд $-50,50^{\circ}\text{C}$, Зүүнговь суманд $-51,30^{\circ}\text{C}$ хүрсэн байна. Хөрсний хамгийн их температур 2004 онд Улаангом өртөөнд $66,5^{\circ}\text{C}$, Тэс суманд $63,5^{\circ}\text{C}$ хүрч, 40 хэмээс дээш халуун өдрийн тоо тухайн сардаа /31 өдөр/ их халуун ажиглагдаж байсан байна.



Агаарын дундаж температураас харахад сүүлийн жилүүдэд температур өсөж дулаарах хандлагатай байгаа бөгөөд сүүлийн 30 жилд 1,0 градусаар дулаарсан байна.

Зураг 2.7 Агаарын температурын явц, хандлага



Агаарын жилийн дундаж температурын 10 жилийн өөрчлөлтийн хүснэгтээс харахад дунд арав жилд илүү дулаарч 1.1-1.6 градусаар дулааралт ажиглагдсан байна.

Хүснэгт 2.5 Агаарын жилийн дундаж температурын 10 жилийн өөрчлөлт

Он	Хар-ус	Завхан	Баруунтуруун	Малчин	Тэс	Улаангом	Өндөрхангай
1983-1993	-1.4	-0.3	-3.9	-3.6	-3.3	-3.4	-1.8
1993-2003	-0.3	1.6	-2.6	-2.6	-2.5	-1.8	-1.1
2003-2013	-0.7	0.8	-2.7	-3.5	-3.5	-2.2	-1.6

Хур тунадасны өөрчлөлт



Увс аймагт хур тунадасны 70-80 хувь нь дулааны улиралд унадаг байна.

Зураг 2.8 Жилийн нийлбэр тунадасны явц хандлага



Хур тунадасны хувьд хур тунадасны өөрчлөлт ерөнхийдөө явц хандлагын хувьд ойролцоо байгаа ба судалгаа хийсэн хугацаанд 1994, 2003 онуудад тунадас ихтэй жилүүд байсан байна. Хур тунадасны хувьд харилцан адилгүй өөрчлөлт явагдсан байна. Газар нутгийн хувьд авч үзвэл:

Зураг 2.9 Жилийн нийлбэр тунадасны олон жилийн дундаж хазайлт (Завхан, Баруунтуруун)



Дээрх судалгааг хийж үзэхэд тунадасны өөрчлөлт харилцан адилгүй байна. Завхан, Өмнөговь, Тэс нутгаар хур тунадас буурсан, уулархаг газраар хур тунадас нэмэгдсэн байна. Үүнээс харахад их нууруудын хотгороор хуурайшилт явагдаж уулын бүс өөрчлөлт харьцангуй бага эсрэгээрээ тунадас нэмэгдсэн байна.

Эдгээр жилүүдэд хур тунадас багасаж, дулааны хангамж ихтэй, чийг багатай байснаас ургамлын ургалтад муугаар нөлөөлж ган болсонтой холбоотой хөрс эвдрэл элэгдэлд орж, элсний нүүлт, цөлжилт болох магадлалтай байна. Гэхдээ энэхүү тунадасны бууралт нь харилцан адилгүй ялангуяа зарим онцлог жилээс болж жишээ нь 1994 онд Малчин суманд бусад жилүүдээс харьцангуй их тунадас орсон байна.

Агаарын чанар

Төслийн байршилтай холбогдуулан авч үзэх нэг асуудал нь шороон шуурга юм. Хүчтэй салхи болон түүнтэй холбоотой үүсдэг шороон шуурга нь хөрс элэгдэх, агаарын булингаршил ихсэж алсын бараа муудах, агаар бохирдуулах нөлөөтэй. Төсөл хэрэгжих нутагт хүний үйл ажиллагааны улмаас хөрс элэгдэж, эвдэрч салхины хүч нэмэгдэх үед шороогоор шуурч агаар бохирдуулах нь сүүлийн жилүүдэд нэлээд нэмэгдэж байгаа тул агаарын бохирдолд шороон шуурганы нөлөөг тооцох нь чухал юм.

Улаангом сумын хэмжээнд агаарын чанарыг хянах суурин харуул 1990 онд байгуулагдсан. Агаарын чанарын хяналт шинжилгээг Увс аймгийн хэмжээнд Улаангом хотод агаарын чанарыг хянах Улаангом-01 харуул дээр хүхэрлэг хий /SO₂/, азотын давхар исэл /NO₂/, угаарын хий /CO/, тоос, тоосонцор /PM₁₀/ зэрэг бохирдуулагчдыг ажиглалтын горимын дагуу нойтон химийн болон автомат хэмжилтийн аргаар тодорхойлж байна.



Улаангом хотын агаарт түгээмэл бохирдуулах бодис хүхэрлэг хий /SO₂/, азотын давхар исэл /NO₂/, тоосонцор /PM_{2.5}, PM₁₀, нийт тоос/-ын агууламжийг тодорхойлсон байна. 2020 оны 01-р сарын 17-оос 01 сарын 31-ний өдрийг хүртэлх 10 хоногийн агаарын чанарын Улаангом 01 харуулын хяналт шинжилгээний дүнгээс үзэхэд:

- Агаар дахь хүхэрлэг хийн дундаж агууламж 20 мкг/м³, хамгийн их нь 66 мкг/м³,
- азотын давхар ислийн дундаж агууламж 26 мкг/м³, хамгийн их нь 40 мкг/м³,
- агаарын чанарын стандарт /MNS 4585:2016/ дахь хүлцэх агууламжаас хэтрээгүй хэвийн хэмжээнд байлаа.

PM_{2.5}, PM₁₀ микрометр болон нийт тоосонцрын хэмжилтийг энэ 10 хоногт 24 цагаар 2 удаа хийсэн. Хэмжилтийн дүнгээс үзвэл:

- PM_{2.5} тоосонцрын дундаж агууламж 134 мкг/м³, их агууламж нь 148 мкг/м³,
- PM₁₀ тоосонцрын дундаж агууламж 150 мкг/м³, их агууламж нь 164 мкг/м³,
- нийт тоосонцрын дундаж агууламж 137 мкг/м³, их агууламж нь 150 мкг/м³ байлаа.

Агаарын чанарын стандарт /MNS 4585:2016/ дахь хүлцэх агууламжаас ажиглалтын хугацаанд PM_{2.5} тоосонцор 2.4-2.9 дахин, PM₁₀ тоосонцор 1.3-1.6 дахин давсан байна.

Өмнөх 10 хоногтой харьцуулахад: Хүхэрлэг хийн дундаж агууламж 2 дахин, их агууламж нь бага зэрэг нэмэгдсэн ба азотын давхар ислийн агууламж өмнөх хэмжээнд байлаа. Тоосны агууламж өмнөх 10 хоногоос 1.4 дахин ихэссэн байна.

2.2.3. Физик бохирдол

Сүүлийн жилүүдэд физик-экологийн ухааны зааг дээр үүссэн “Физик бохирдол” хэмээх судалгааны шинэхэн чиглэл эрчимтэй хөгжиж байна. Энэ шинэ чиглэлийн дотор орчны “шуугианаар бохирдох”-нь чухал байр суурийг эзэлж байна. Монгол улсад 1996 онд гадаад орчны дуу шуугианыг Нийгмийн эрүүл мэндийн хүрээлэн анхлан судлахад Улаанбаатар хотын гудамжны дуу шуугианы дундаж түвшин (ДШДТ) 71дБА байсан байна.

Харин 2003 оны Монгол улсын томоохон хотуудын дуу шуугианы түвшингийн судалгаагаар дундаж түвшин 63,6 дБА байсан ба УБ хотын төв гудамжны дуу шуугианы оргил үе нь 08-09 цагт байна. /НЭМХ, 2003/ Дуу шуугианы түвшин өндөртэй орчинд олон жил амьдарсан болон ахимаг настай хүмүүс дуу шуугианд илүү өртдөгөөс гадна автомашинаас гарах дуу шуугиан их нөлөөлдөг нь тогтоогдсон байна. Улаанбаатар хотын төв замын дагуух суурьшлын орчинд дуу шуугианы бохирдол хэвийн хэмжээнээс хэтэрч хүний эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх хэмжээнд хүрч байна.

Төслийн талбай нь суурьшлаас зайтай, чимээ аниргүй нам гүм шинээр олгогдсон газар тул дуу шуугианы бохирдол ҮГҮЙ байна.




2.2.4. Усны чанар

Уг төсөл хэрэгжих газар нь Увс аймгийн нутаг дэвсгэрт Увс голоос ... км-т байрлах тул Увс голоор төлөөлүүлэв.

Төсөл хэрэгжих газар буюу Увс аймагт Байгаль орчны шинжилгээний лаборатори нь 2019 оны 11 дүгээр сард гадаргын усны хяналт-шинжилгээний хөтөлбөрийн дагуу Боршоо-Боршоо, Увс нуур-Давст, Хархираа-Тариалан, Тэс-Тэс хяналт-шинжилгээний 4 ус судлалын ажиглалт, шинжилгээний харуултай байдаг бөгөөд цэг тус бүрээс усны сорьц авч, усны химийн найрлага, чанарын үзүүлэлтүүдийг тодорхойлдог байна.

Зураг 2. 10 Ус судлалын ажиглалтын харуулууд



Усны чанарын хяналт шинжилгээг одоогийн байдлаар жилдээ гадаргын усны 130 сорьцод рН, ЕС, BOD, COD, биогенийн элементүүд, хүнд металлууд, нефтийн бүтээгдэхүүн зэрэг 20-22 үзүүлэлтийг тодорхойлж байна. Жил бүрийн хөтөлбөрт ажлын хүрээнд гадаргын усны чанарын хяналт-шинжилгээний дүнгээр бохирдлын индексийг бодож, усны чанарын зэргийг тогтоон 6 ангиллаар үнэлгээ өгдөг. Бохир усны хяналт шинжилгээг тус лаборатори нь 1995 оноос хойш Улаангом сумын төв цэвэрлэх байгууламжийн усанд хяналт тавьж, сар бүр орж байгаа болон гарч байгаа усанд рН, ЕС, BOD, COD, биогенийн элементүүд, хүнд металлууд болон цэвэршүүлэлтийн зэргийг тодорхойлж байна.

2019 оны 11 дүгээр сард хийсэн Увс аймгийн гадаргын усны шинжилгээний дүнг бохирдлын гол үзүүлэлтүүдээр MNS4586-98 усны чанарын стандарттай харьцуулан дараах хүснэгтэд үзүүлээ.

Хүснэгт 2. 6 Гадаргын усны шинжилгээний дүнг MNS4586:98 стандарттай харьцуулсан

№	Усны объект хяналт шинжилгээний цэг	Бохирдуулагч бодис, мг/л					
		O ₂	БХХ ₅	ПИЧ	NH ₄	NO ₂	P
1	Боршоо-Боршоо			0.6	0.14	0.001	0.006
2	Увс нуур-Давст			11.3	0.66	0.003	0.013
3	Хархираа-Тариалан			0.3	0.12	0.001	0.003
4	Тэс-Тэс			0.6	0.25	0.001	0.007



Усны чанарын стандарт MNS45865:98	6<	3	10	0.5	0.02	0.01
-----------------------------------	----	---	----	-----	------	------

Увс аймгийн гадаргын усны 2019 оны 11 дүгээр сарын хяналт-шинжилгээний дүнгээс үзэхэд, Боршоо-Боршоо, Хархираа-Тариалан, Тэс-Тэс хяналт-шинжилгээний цэгийн дээжүүд MNS 4586-98 усны чанарын стандарт дахь хүлцэх агууламжаас давсан бохирдолгүй, цэвэр байсан. Увс нуурын усанд эрдэс азотын агууламж ХА-аас давсан бохирдол илэрсэн байна.

2.2.5. Хөрсөн бүрхэвч

Газарзүйн мужлалаар Хархираа, Түргэний уулс нь өндрийн бүсшилийн Алтайн хэв шинжид, Хан Хөхийн уулс нь хангайн өмнөдийн хэв шинж, Увс, Хяргас нуурын хотгор нь холимог бүсшилийн их нууруудын хотгорын дэд мужид хамрагдана. Аймгийн нутгийн нам хотгор, говь хээр газраар цөлөрхөг хээрийн бор, цайвар хүрэн, хүрэн, уулархаг газраар уулын хүрэн, уулын хар шороон, уулын нугын, уулын нугат хээрийн, нуур голын эрэг орчмын газраар хужир мараалаг хэв шинжийн хөрсүүдтэй. Төсөл хэрэгжих газар нь Их нууруудын хотгорын цөлөрхөг хээрт багтаж байна. Нутгийн ихэнх хэсгээр хүрэн хөрстэй бөгөөд хар шороон хөрс тун бага хувийг эзэлнэ. Увс нуурын хотгорт кайнозойн хурдас өргөн тархсан төдийгүй Улаангом орчимд 500 метр хүрдэг.

2.2.6. Ургамлан нөмрөг

Ургамлан нөмрөг, ургамлын бүрэлдэхүүн нь тухайн газар нутгийн экологийн тэнцвэрт байдлыг хадгалахад чухал үүрэгтэй тул тухайн газар нутгийн ургамлан нөмрөг, ургамлын бүтэц бүрэлдэхүүний онцлогийг нарийвчлан тогтоох шаардлагатай.

Төслийн талбай нь Монгол орны ургамал газарзүйн мужлалаар Их нууруудын хотгорын цөлөрхөг хээрийн тойрогт хамаарна. Төслийн талбайд нийт 9 овгийн 15 төрлийн 17 зүйл ургамал бүртгэгдсэн. Зүйлийн тоогоороо Poaceae (6 зүйл) Chenopodiaceae (2 зүйл) Asteraceae (4 зүйл) овгууд тэргүүлж байна. Амьдралын хэлбэр болон насны байдлаар авч үзвэл өвслөг олон наст ургамал давамгайлж байна. Төслийн талбайн ургамлыг аж ахуй, ач холбогдол болон хэрэглээ талаас нь авч үзвэл:

- 3 зүйл хөл газрын ургамал,
- 2 зүйл эмийн болон ашигт ургамал,
- 14 зүйл бэлчээр хадлангийн ургамал тохиолдов

Төслийн талбайд цөлийн-баглуурт, өдлөг хялгана-баглуурт, элдэв бударганаулаан бударганат, зах хэсгээр өдлөг хялгана-хазаарганат, өдлөг хялганатаанат, өдлөг хялгана-агьт гэх мэт цөлөрхөг хээрийн ургамалжилттай.

Их нууруудын хотгор нь манай улсын дорнод, төвийн нутгуудаас байгаль, цаг уурын нөхцөл, гадарга, байршилтын хувьд нэлээд өвөрмөц газар бөгөөд ландшафт нь ерөнхийдөө цөлөрхөг учир энд тачир сийрэг ургамалтай цөлийн хээр зонхилно. Их нууруудын хотгорын гадаргыг бүхэлд нь авч үзвэл сайрархуу-хайргархаг чулуун бүрхүүлтэй, урдаасаа хойшоо



налуу, асар өргөн гүнзгий сав газар юм. Төслийн талбайд цөлийн-баглуурт, өдлөг хялгана-баглуурт, элдэв бударганаулаан бударганат, зах хэсгээр өдлөг хялгана-хазаарганат, өдлөг хялганатаанат, өдлөг хялгана-агьт гэх мэт цөлөрхөг хээрийн ургамалжилтай байна.

Ургац: Биомассын хэмжээг намар ургамал хагдралтын үед үзэхэд дунджаар 30 г/м² байна. Тухайн үеийн биомассыг ургацад шилжүүлбэл 3,0 ц/га ургацтай болно.

Allium polyrrhizum, Artemisia frigida зэрэг 2 зүйлийн эмийн болон ашигт ургамал ургаж байна. 1995 онд “Байгалийн ургамлын тухай” хуулиар баталсан нэн ховор статус бүхий болон Монгол орны Улаан номд (2014) мөн нэн ховор ургамлаар бүртгэгдсэн зүйл байхгүй. Мөн Улаан дансны (2011) Бүс нутгийн үнэлгээгээр ховордлын зэргээр үнэлэгдсэн ургамал байхгүй.

2.2.7. Амьтны аймаг

Улаангом сумын нутаг нь амьтны газар зүйн мужлалаар Уулархаг азийн дэд их мужийн Монголын – Төвөдийн муж, түүний ойт хээрийн ба хээрийн дэд мужийн Монгол дагуурын тойрог ба говийн дэд мужийн хойд говийн тойргийг дамнан (А.Г.Банниковынхоор) оршдог тул харьцангуй ялгаатай амьдрах орчинтой, амьтны аймаг нь зүйлийн бүрэлдэхүүнээр баялаг, ховор, ховордсон зүйл олонтойгоор онцлог.

Монгол Дагуурын хээрийн тойрогт жижиг хөхтнөөс үлийн цагаан оготно, дагуур огдой, шар чичүүл, туурайтнаас цагаан зээр, мах идэшт амьтдаас үен, өмхий хүрнэ, хярс, үнэг, чоно зонхилно. Амьтны зүйлийн бүрэлдэхүүн, оршин амьдрах хэлбэр, тоо толгой, зарим зонхилогч зүйл амьтдын биологи экологийн нарийвчилсан судалгааны ажлыг доктор Д.Цэнджав, дэд профессор, доктор Б.Лхагвасүрэн, С.Амгаланбаатар, Б.Бүүвэйбаатар, Г.Сүхчулуун нар хийсэн байна. Дээрх судлаачдын судалгаа шинжилгээний дүнд Даланжаргалан суманд 7 багт хамаарах 35 зүйлийн хөхтөн амьтныг одоогийн байдлаар тэмдэглээд байна. Тэдгээрийн дотор шавж идэштэн 1, сарьсан далавчтан 4, туруутан 4, мах идэштэн 10, туулайтан 3, мэрэгчтэн 12 зүйл байна. Зэрлэг амьтан, ургамлын ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенци (CITES) I, II хавсралтад тус нутгийн хөхтөн амьтдаас 6 зүйл орсон байдаг. Монгол улсын улаан ном (1997)-нд 8 зүйл хөхтөн бүртгэгдсэнээс гадна Улаан данс (2006)-ны бүс нутгийн хэмжээнд устаж болзошгүй ангилалд 4 зүйл, эмзэг 1 зүйл, ховордож болзошгүй 5 амьтан тус сумын нутагт амьдарч байгаа нь хамгаалах холбогдол бүхий газар болохыг илтгэнэ.

Улаангом сумын хөхтөн амьтад дотроос зүйлийн тоо, тархац, орон зайн байршил, эзэмшил нутаг, тоо нягтшил, нөхөн үржил, нөхөн төлжил, экосистемийн тогтолцоо, биогеоценозын нөлөөллөөр мэрэгчтэн багийнхан, аж ахуйн ач холбогдлоор махчтан багийнхан тэргүүлж, туруутан, туулайтан дараалах зэрэглэлтэй байна.

Шавьж

Хуурай хээрийн шавжийн бүлгэмдэлд Шулуун далавчтан (Orthoptera), Ижил далавчтан (Homoptera), Хар цох (Tenebrionidae), Буглаа цох (Meloidae), Шөвгөр цох (Curculionidae), Илтсэн сахалт цох (Scarabaeidae) тус тус хамаарна. Нийт шавжийн тоо нэн олон боловч тархалт нь жигд биш. Хавар ба зуны эхэн үед зүйлийн бүрэлдэхүүн хамгийн олон янз болно. Унаган зүйл элбэг. Амьтны аймгийн тоо толгой, төрөл зүйл байгаль цаг уурын эрс



өөрчлөлтөд мэдрэг байдаг бөгөөд жил тутам эрчимтэй явагдаж буй цөлжилт, хотжилтын нөлөөнд их хэмжээгээр цөөрч байна.

2.3 ИНЖЕНЕРИЙН ДЭД БҮТЦИЙН ОДООГИЙН БАЙДЛЫН СУДАЛГАА

Төлөвлөлтийн нутаг дэвсгэр нь ямар нэг дэд бүтцийн хангамж үгүй, greenfield талбар юм. Тиймээс дэд бүтцийн хангамжийг Увс аймгийн Улаангом хотын нөхцөлөөр авч үзлээ.

2.3.1. Дулаан хангамж

Увс аймгийн төв Улаангом сумын анхны станц нь 1986 онд баригдсан, 1990 оны эдийн засгийн шилжилтийн дараа хувьчлагдаж 2003 онд уураас халуун усны үйлдвэрлэлд шилжсэн. Уг станц нь 39 МВт хүчин чадалтай бөгөөд жилд 12-18 мянган тонн нүүрс хэрэглэдэг. Тус компани нь өөрсдийн эх үүсвэрээр дамжуулах хоолойн хэсгийг хэсэгчлэн засварлаж, сайжруулсан байна. Дулааны станц болон улсын мэдэлд байдаг түгээлтийн шугам сүлжээний зарим хэсгийн ашиглалтыг хувийн компани хариуцдаг. "Улаангомьн 2 дугаар дулааны станц" ТӨХК нь 2014 онд ашиглалтад орсон бөгөөд ойролцоогоор 1500 айл өрх, 340 байгууллагыг дулаанаар, айл өрхийн 75 хувь, байгууллагуудын 25 хувийг халуун усаар хангадаг.

Улаангомьн дулааны станцууд нь зөвхөн хүйтний улиралд (10-р сарын 1-ээс 5-р сарын 1-ний хооронд) ажилладаг тул бусад үед оршин суугчид, албан байгууллагууд усаа өөрсдөө ихэвчлэн цахилгаан халаагуураар халаадаг. Төрийн өмчийн дулааны станцад холбогдсон шугам сүлжээний зарим хэсэг нь баригдаад 3-10 жил болсон бөгөөд ашиглалтын нөхцөл сайн байна. Халаалтын сүлжээнд холбогдоогүй айл өрхүүд нүүрс, мод, аргал түлж халаадаг энгийн зуух ашигладаг. Арай томхон хэмжээний барилгуудыг нүүрс голчлон ашигладаг тохируулгагүй, нам даралтын шаталтын зуухаар халаадаг.¹

2.3.2. Ус хангамж, ариутгах татуурга

Ус хангамж

Увс аймагт Монгол улсын Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг НААҮГ-ын даргын 1999 оны 6 дугаар сарын 17-ны А/14 дүгээр тушаалын дагуу 1999 оны 9 дүгээр сарын 21-нд байгуулагдсан "Чандмань-Увс" ХХК үйл ажиллагаа явуулж, Улаангом сумын албан байгууллага, аж ахуйн нэгж болон айл өрхүүдэд цэвэр ус түгээж, хэрэглээнээс гарсан бохир усыг татан зайлуулахаас гадна гэр хороололд худаг, усан сан, нийтийн халуун усны үйлчилгээ үзүүлэн ажиллаж байна.

Компани нь захиргаа аж ахуй, усан хангамж, сувагжуулалт, засвар үйлчилгээ, нийтийн халуун ус, худаг-усан сан гэсэн нийт 5 салбар хэсэгтэй, 60 ажилтны бүтэц орон тоотой үйл ажиллагаа явуулж байна.

¹ АХБ, "Аймаг, сумын хөгжлийн хөрөнгө оруулалтын хөтөлбөр", 2020 он



Ариутгах татуурга

Улаангом дахь одоо байгаа бохир ус цэвэрлэх байгууламж нь 1986 онд баригдсан механик цэвэрлэх байгууламжийн талбай дээр байдаг бөгөөд 1990-ээд оны эхэн дэх эдийн засгийн шилжилтийн үеэс ажиллахаа больсон. Одоогоор маш бага хэмжээний цэвэрлэгээ (BOD-г 25-27% багасгадаг) хийж байна. Зуны аадар борооны үеэр дамжуулах шугам хоолой руу нэвчих уснаас илүүтэйгээр таг хавхалгагүй үзлэгийн худагт дүүрсэн ус цэвэрлэх байгууламжийн ажиллагаанд нөлөөлдөг. Цэвэрлэх байгууламж руу бохир ус дамжуулдаг даралтат шугам болон шүүлтүүр бүхий өргөх төхөөрөмжид засвар, шинэчлэлт хийх шаардлагатай. Даралтат шугам нь хуучин механик цэвэрлэх байгууламжийн нэг хэсэг нь байсан тунгаах цөөрмийг хангадаг насос бүхий бага хэмжээний бялхаах сав хүртэл явдаг. Иймээс цаашид тоног төхөөрөмжүүдийг сайжруулах шаардлагатай байгаа.²

2.3.3. Цахилгаан хангамж

“Баруун бүсийн эрчим хүчний систем-ББЭХС” Төрийн өмчит хувьцаат компани нь ОХУ-ын “Интер РАО ЕЭС” компани (Увс аймгийн Давст сумын Боршоо боомт), БНХАУ-ын “Шиньжянь” цахилгаан эрчим хүчний компани (Ховд аймгийн Булган сумын Ярант боомт), Дөргөний усан цахилгаан станц/УЦС/-аас тус цахилгаан эрчим хүч худалдан авч Ховд, Увс, Баян-Өлгий болон Говь-Алтай аймгуудын зарим сумдыг цахилгаан эрчим хүчээр хангаж байна. Одоогийн байдлаар ББЭХС нь нийт эрчим хүчний түгээлтийн 72.0 хувийг импортын цахилгаан эрчим хүчээр, 28.0 хувийг Дөргөний УЦС-аас тус хангаж байна.

“Баруун бүсийн эрчим хүчний систем ТӨХК нь 1 кВт.ц эрчим хүчийг ОХУ-аас 2.77 рубль буюу 2017 оны валютын ханшаар 116.3 төгрөг, БНХАУ-аас 0.65 юань буюу 240.5 төгрөг, Дөргөний УЦС-аас 33 төгрөгөөр тус худалдан авч байсан бөгөөд 1 кВт.ц цахилгаан эрчим хүчний өөрийн өртөг нь 199 төгрөг болж байжээ.

Эрчим хүчний зохицуулах хорооноос Баруун бүсэд тогтоосон хэрэглэгчдэд борлуулах цахилгаан эрчим хүчний дундаж үнэ 102.3 төгрөг бөгөөд 1 кВт.ц тутам 96.7 төгрөгийн алдагдал хүлээж байна.

Баруун бүс нутгийн эрчим хүчний хэрэглээ сүүлийн жилүүдэд 3,8-10,4 хувиар тогтмол өсөж байгаа бөгөөд дээрх аймгуудын түгээх компаниудын захиалснаас үзэхэд 2018 оны импортоор авах эрчим хүч 2017 оны хүлээгдэж байгаа гүйцэтгэлээс 13,3 хувиар нэмэгдэж, 125493 мян кВтц болох талаар Эрчим хүчний яамнаас гаргасан байна. “Баруун бүсийн эрчим хүчний систем” ТӨХК-ий алдагдлыг бууруулах зорилгоор 2018 онд улсын төсөвт мөн 8.6 тэрбум төгрөгийн татаас олгохоор тусгагдсан болно. Мөн 2018 оны 1 дүгээр сарын 0-ний өдрөөс эхлэн 2021 оныг 1 дүгээр сарын 0-ний өдрийг хүртэл төлөвлөгөөгөөр 2018 онд 2.3 тэрбум төгрөг, 2019 онд 2.4 тэрбум төгрөг, 2020 онд 2.6 тэрбум төгрөг буюу нийт 7.4

² АХБ, “Аймаг, сумын хөгжлийн хөрөнгө оруулалтын хөтөлбөр”, 2020 он



тэрбум төгрөгийг чөлөөлүүлэхээр Гаалийн болон Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн төслийг баталсан.^{3 4}

2012 онд Баруун аймгууд гадаадаас өндөр үнээр эрчим хүч импортолдог байдлыг шийдвэрлэх зорилгоор тусгай зөвшөөрөл эзэмшигч Баруун бүсийн энерги ХХК нь Засгийн газрын түвшинд гэрээ байгуулан 60МВт-ийн (54 нь нүүрс, 6 нь нар хосолсон станц) цахилгаан станцыг Увс аймгийн Улаангом суманд барихаар гэрээ байгуулсан. 2016 онд концессийн гэрээг зураг төсөл боловсруулах, санхүүжүүлэх, барих, ашиглах, шилжүүлэх гэсэн таван үе шаттайгаар 30 жилийн хугацаатай байгуулсан. Энэхүү төсөл дээр тус компани ХБНГУ-д үйл ажиллагаа явуулдаг, Монгол-Германы хамтарсан “SaxEnergy Mongolia” компанитай хамтран ажиллахаар тохиролцсон байна.

Азийн хөгжлийн банк (АХБ)-ны Захирлуудын зөвлөл сэргээгдэх эрчим хүчний хэд хэдэн төрлийн технологид суурилсан 41 мегаваттын хүчин чадалтай сэргээгдэх эрчим хүчний төвлөрсөн бус хангамжийн системийг (Увс аймгийн Өмнөговь суманд 10 мегаваттын салхин станц барихаар төлөвлөсөн) Монголд анх удаа хөгжүүлэх зорилгоор 80 сая ам.долларын зээлийн төслийг баталсан. Энэхүү систем нь Монгол Улсын баруун бүсийн хөгжлөөр хоцронгуй, алслагдмал аймгуудад цахилгаан, эрчим хүч, дулаан нийлүүлэх юм. Эрчим хүчний систем дэх нүүрсхүчлийн ялгарлыг бууруулах ач холбогдолтой юм.

2.3.4. Мэдээлэл, холбоо

Увс аймгийн нийт 32 сум, суурин газарт үүрэн холбооны 4 компанийн үйлчилгээ хүрсэн байна. Оператор компаниуд сүлжээгээ хүргэхдээ шилэн кабель голчлон ашигласан бол шилэн кабель ороогүй багуудад тоон релей болон висатын үйлчилгээ ашигласан байна. Увс нуурын орчим орон нутгийн зүгээс дэд бүтэц байгуулан Юнител, Мобиком компанийн сүлжээг оруулсан бол Хяргас, Айраг нуурын орчимд болон Зүүнхангай сумын А зэрэглэлийн автозам дагуу Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сангийн санхүүжилтээр дэд бүтэц байгуулан Жи-Мобайлын сүлжээ орсон байна.

Увс аймгийн бүх суманд үүрэн холбооны үйлчилгээ орсон боловч сумууд нь сүүлд шилэн кабелийн сүлжээнд холбогдсон, уулархаг бүс нутагт байрладаг зэргээс шалтгаалан сүлжээний хамрах хүрээ бага, 100 хүнд ногдох үүрэн холбооны хэрэглэгч болон 4G хэрэглэгчийн тоо улсын дунджаас бага байна.

Хүснэгт 2. 7 100 хүнд ногдох үүрэн холбооны хэрэглэгчийн тоо ⁵

№	Үзүүлэлт	Увс	Улсын дундаж
1	100 хүнд ногдох үүрэн холбооны хэрэглэгч	89.6	115.6
2	100 хүнд ногдох 3G хэрэглэгч	50	74
3	100 хүнд ногдох 4G хэрэглэгч	6.1	18
4	100 хүнд ногдох суурин телефон хэрэглэгч	0.8	4.6
5	100 хүнд ногдох олон сувгийн дамжуулах үйлчилгээ эрхлэгчийн хэрэглэгч	77.6	96.6

³ Гаалийн болон Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийг 2017 оны 12 сарын 13-нд өргөн мэдүүлж, УИХ яаралтай горимоор хэлэлцсэнээр 12 сарын 22-нд батлуулсан.

⁴ Импортын цахилгаан эрчим хүчийг гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх дүнгийн хэмжээгээр улсын төсвөөс санхүүжүүлэх шаардлагатай татаасын хэмжээ буурах, баруун бүс нутгийн хэрэглэгчдийг тогтвортой, зохистой үнэ тариф бүхий эрчим хүчээр найдвартай хангах чухал ач холбогдолтой

⁵ <http://crc.gov.mn/contents/raw/9/17/1196/MARKET-and-Tariff.pdf>



Улсын хэмжээнд үүрэн холбооны сүлжээний хамрах хүрээ, хэрэглэгчийн тоо нэмэгдэхийн хэрээр суурин телефон хэрэглэгчийн тоо буурч байсан бол 2011 онд IPTV гуравласан үйлчилгээ нэвтэрснээр суурин телефон хэрэглэгчийн тоо өсөх болсон. Увс аймагт 2017 оны 7 дугаар сард Юнивишн ХХК IPTV үйлчилгээгээ оруулсан бол Скаймедиа ХХК-ийн үйлчилгээ хараахан нэвтрээгүй байна. Иймд Увс аймгийн суурин телефон хэрэглэгчийн тоо буурсан хэвээрээ байна.

2.4 УЛААНГОМ ХОТЫН НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН ОДООГИЙН БАЙДАЛ

2.4.1 Засаг захиргаа

Дөрвөд далай ханы аймаг, Зоригт ханы аймгийг нэгтгэж 1925 онд Чандмань уулын аймгийг байгуулж, улмаар 1931 оны 2 сарын 6-нд Увс аймгийн хилийн заагийг тогтоосноор Увс аймгийн засаг захиргааны хуваарь үүссэн.

Увс аймаг нь засаг захиргааны нэгжийн хувьд 19 сум 92 багт хуваагддаг. Нутаг дэвсгэрийн хэмжээг баруун бүсийн аймгуудтай харьцуулбал 16.8% буюу Говь-Алтай, Завхан, Ховд аймгийн дараа 4 дүгээрт ордог. Аймгийн төвөөс хамгийн ойрхон сум Түргэн 28 км. хамгийн алслагдсан нь Зүүнхангай сум 350 км зайтай.

1992 онд шинэ Үндсэн хууль болон Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн дагуу Улаангом сум болсон. Улаангом сум нь А,Б бүсэд хуваадаг, газар нутаг нь 260.4 мянган га, засаг захиргааны нэгжийн хувьд 12 багтай, 8.8 мянган өрх, 32.9 мянган хүн амтай, 247 мянган толгой малтай Увс аймгийн төв сум. Улаангом сум /хот/ нь хойд талаараа Давст, баруун талаараа Түргэн, урд талаараа Тариалан, зүүн талаараа Наранбулаг сумтай тус тус хиллэдэг.


Улаангом хот нь ОХУ-ын Тува улсын Хандгайт боомтоос 115 км зайтай. Хотын доторх авто зам 39.2 км, явган хүний зам 43.2 км, дугуйн зам 2.1 км, сайжруулсан зам 3.4 км тус тус байна.



2.4.2 Хүн ам

Хүн ам нь халх, баяд, хотон, буриад, торгууд, дөрвөд ястан үндэстэн амьдардаг. 2021 оны жилийн эцсийн байдлаар 32912 хүн, 8856 өрх суурьшиж байгаа ба 1 өрх 3.72 хүнтэй байна. Увс аймгийн хүн амын 39% нь Улаангом сумандаа амьдардаг, жилд хүн ам нь 1.6% өсдөг төвлөрөл ихтэй суурьшлын бүс юм. Инженерийн төвлөрсөн хангамжтай нийтийн орон сууцны 2-9 давхар барилгуудад нийт өрхийн 15% буюу 1406 өрх амьдарч байгаа ба жилд орон сууцжуулалт 150-200 сууцаар нэмэгддэг.

Зураг 2. 11 Улаангом сумын хүн ам, өрхийн суурьшил




Эх

сурвалж: ҮСХ, www.1212.mn

Насны бүтцийг харахад хүн амын 38.6% нь хүүхдүүд, 54.2% нь хөдөлмөрийн насны иргэд, 7.2% нь тэтгэврийн насныхан байна.

Зураг 2. 12 Хүн амын насны бүтэц



Эх сурвалж: YCX, www.1212.mn

Хүн амын 85% нь гэр хороололд амьдардаг. Гэр хороолол нь өрх бүр тодорхой хэмжээний эдэлбэр газартай, амины сууц барьж, туслах аж ахуй эрхлэх боломжтой боловч усан хангамж, бохирын болон хог хаягдлын зайлуулалт, халаалт, холбоо харилцааны тогтсон системгүй, эрүүл ахуйн шаардлага хангагдаагүй, хөрсний бохирдол ихтэй, зам харилцаа, тохижилт хангалтгүй, ахуйн үйлчилгээ, эмнэлэг, сургууль, цэцэрлэгийн хангамж хүрэлцээ муу.

Гэр хорооллын сууцнуудын дийлэнх нь тухайн газрын байгаль цаг уурын нөхцөл, орон сууцны барилгын эрүүл ахуй, аюулгүй байдлын шаардлагыг тусгаагүй, хүмүүс өөрсдийн эдийн засгийн боломждоо тулгуурлан барьсан зураг төсөлгүй, инженерийн бус барилгууд юм.


2.4.3 Эдийн засаг

Үйлдвэрлэл үйлчилгээ ЖДҮ олонтой, цаашид өргөжих боломжтой. Гадаад зах зээлд ойрхон. ОХУ, БНХАУ-тай эдийн засаг, худалдаа, бүх талын харилцаа холбоо хамтын ажиллагааг хөгжүүлэхэд ойр дөт юм. Байгаль орчин аялал жуулчлалын салбарыг хөгжүүлэх үзэсгэлэнт Увс нуур, Хархираа Түргэний сүрлэг өндөр салбар уулстай. Газрын доорх ашигт малтмалын нөөц баялагтай. Гол брэнд бүтээгдэхүүн болох чацарганы бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг өргөжүүлэх бүрэн боломжтой.

Тус сум нь аймгийн нийт газар тариалангийн үйлдвэрлэлийн 80, жимс жимгэсний үйлдвэрлэлийн 90 орчим хувийг дангаараа хангадаг, 500 гаруй үйлдвэр, аж ахуйн нэгж байгууллага үйл ажиллагаа явуулдаг.

Сумын хэмжээнд 2021 оны жилийн эцсийн байдлаар 247.09 мянган толгой малтайгаас тэмээ 0.62 мянга, адуу 13.91 мянга, үхэр 33.29 мянга, хонь 115.89 мянга, ямаа 83.38 мянга тус тус байна. Суманд 650 малчин өрх, 716 малтай өрх байгаа нь сумын нийт өрхийн 20 орчим хувийг эзэлж байна. Сумын хэмжээнд нийт 366 га-д газар тариалан эрхэлдэг. Үүнээс 158 га-д нь төмс, хүнсний ногоо 125 га-д, улаан буудай 80 га, бусад 3 га -д нь арвай овъёос тариалж байна.

Зураг 2. 13 Улаангом сумын эдийн засаг



Эх сурвалж: Увс аймгийн статистикийн газар, www.uvs.nso.mn

Сумын эдийн засагт хөдөө аж ахуй голлох байр суурьтай ба үйлдвэрлэл багатай, үйлчилгээний салбар дунд зэрэг хөгжсөн. Сумын төрийн байгууллагуудад 3194 хүн ажиллаж байна.

2.4.3 Нийгмийн дэд бүтэц

Ерөнхий боловсролын 6 сургууль, сургуулийн өмнөх боловсрол олгох 10 цэцэрлэг, хувийн хэвшлийн 3 цэцэрлэг, эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээ үзүүлдэг 4 өрхийн эрүүл мэндийн төв, Хөдөлмөрийн дээд сургууль, Улаангом коллеж зэрэг байгууллагууд тус тус үйл ажиллагааг явуулж байна. Дээд сургуульд суралцагсдын тоо харьцангуй тогтмол, МСҮТ-д суралцагсдын тоо бага хэмжээгээр буурах хандлагатай.

Хүснэгт 2. 8 Нийгмийн дэд бүтцийн үзүүлэлт



1	Сургууль	хүүхэд	7707
2	Сургуулийн дотуур байр	ор	58
3	Цэцэрлэг	хүүхэд	1744
4	Эмнэлэг	ор	40
5	Спорт заал	тоо	6
6	Биеийн тамирын талбай	м2	350
7	Соёлын төв	тоо	1
8	Номын сан	суудал	1
9	Банк	тоо	6
10	Халуун ус	тоо	8

Эх сурвалж: Увс аймгийн статистикийн газар,
www.uvs.nso.mn

Ерөнхий боловсролын 12 жилийн 6 сургуулийн 266 бүлэгт 7707 хүүхэд өдрөөр суралцаж, албан бус боловсролын дүйцсэн хөтөлбөрөөр бага суурь, бүрэн дунд боловсрол нөхөн олгох сургалтад 78 иргэн суралцаж байна. Бага ангийн хамран сургалт 97.5 хувь, суурь боловсролын хамран сургалт 98.0 хувьд хүрсэн. Ерөнхий боловсролын

сургуулиуд мэргэжлийн багшаар 100 хувь хангагдсан ба мэргэжил дээшлүүлэх, хөрвөх сургалтад 112 багш хамрагдсан. Нийт 577 ажиллагчид байгаагийн 403 үндсэн багш байна.

Төрийн өмчийн 8 цэцэрлэгийн 51 бүлэгт 1744 хүүхэд хамрагдан хүмүүжиж байгаагаас гэр цэцэрлэгт 211 хүүхэд хамрагдаж, сургуулийн өмнөх боловсролын хамралт 83.5 хувьд хүрсэн.

Улаангом суманд өрхийн эрүүл мэндийн 4 төв үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд 12 их эмч, 17 сувилагч, 5 туслах ажилтан, 4 жолооч, 1 нягтлан бодогчтойгоор Улаангом сумын иргэдэд үйлчилж, хөдөөгийн айл өрхүүдэд багийн 4 эмч анхан шатны эрүүл мэндийн тусламж үйлчилгээг үзүүлж байна.

300 хүний суудалтай соёлын төв, 5300 гаруй үзмэртэй түүх соёлын дурсгалт зүйлсийн музей, спорт заал, тус бүр 10-40 ортой 10 зочид буудал, 1380 суудалтай зоогийн газар, төвийн хэсэгт 10 хүний 2 халуун усны газар, гэр хороололд тус бүр 2-3 хүний 6 халуун усны газар, 150 гаруй дэлгүүр, худалдаа үйлчилгээний салбарууд, үсчний газар 9, гоо сайхны газар 4, зурагчин 4, тоглоомын 9 газар ажиллаж байгаа боловч үйлчилгээний чанар, хангамж, байршил нь шаардлагын хэмжээнд хүрэхгүй байгаагаас гадна сүүлийн жилүүдэд худалдаа үйлчилгээ давамгайл хөгжиж, харин ахуйн үйлчилгээ хоцронгуй хөгжиж байна.

БҮЛЭГ 3. НӨХЦӨЛ БАЙДЛЫН СУДАЛГАА

Бүлгийн дэд агуулга:

- ✎ Логистиктой холбоотой хууль эрх зүйн зохицуулалт
- ✎ Монголын улсын логистик хөгжлийн өнөөгийн байдал
- ✎ МУ-ын худалдааны салбарын өнөөгийн байдал
- ✎ Авто тээврийн статистик
- ✎ Увс аймгийн өнөөгийн эдийн засаг, нийгмийн нөхцөл
- ✎ Увс аймаг дахь логистикийн өнөөгийн нөхцөл байдал



3.1. ЛОГИСТИКТОЙ ХОЛБООТОЙ ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

3.1.1 Эрх зүйн орчин

Манай улсын хувьд логистикийн тухай ойлголт нь дан ганц үйлчилгээний салбарын тээвэр гэсэн ойлголтоор төсөөлөн үзэж, асуудал нь хөрөнгө мөнгөний асуудлаас шалтгаалдаг гэсэн хандлага нийтлэг юм. Гэвч логистикийн тухай ойлголт нь нийгмийн бүхий л салбарыг хамарсан, маш өргөн цар хүрээтэй, эдийн засгийн бүхий оролцогчдод хүрч үйлчилдэг салбар юм.

Манай улсын хувьд логистикийн салбарын хөгжил муу, энэ талаарх ойлголт нь шинэлэг учир эрх зүйн зохицуулалт нь маш хангалтгүй байдаг. Харин 2012.05.22-ны өдөр батлагдсан Инновацийн тухай хуулийн 21.1.5-д “агуулах, тээвэрлэлт, логистикийн үйлчилгээ үзүүлэх” гэсэн зохицуулалтаас бусдаар логистикийн салбарын зохицуулалт бараг байхгүй гэж үзэж болохоор байдаг. Мөн түүнчлэн манай улсын хууль тогтоомж, бодлогын баримт бичгийн хүрээнд логистикийн салбарын эрх зүйн зохицуулалт дутмаг төдийгүй, аливаа нэг салбарын хувьд бүрэн цогц байдлаар зохицуулсан байдал хангалтгүй, нэгдсэн бодлого байхгүй байна.

Хүснэгт 3. 1 Логистикийг ерөнхий байдлаар зохицуулсан эрх зүйн актуудын лавлагаа-1: Хуулиуд

Д/д	Хууль эрх зүйн актын нэр, агуулга	Зохицуулж буй салбар
1	Автотээврийн тухай хууль /1999.06.04/	<ul style="list-style-type: none"> × Тээврийн логистик × Тээврийн сүлжээ, дамжин өнгөрөх × Цахилгаан, эрчим хүч дамжин өнгөрөх логистик
2	Алтанбулаг худалдааны чөлөөт бүсийн эрх зүйн байдлын тухай /2002.06.28/	<ul style="list-style-type: none"> × Тээврийн логистик × Бараа бүтээгдэхүүн дамжин өнгөрөх, агуулах, гаалийн талбай × Цахилгаан, дулаан дамжуулах шугам сүлжээ
3	Авто замын тухай хууль /1998.01.02/	<ul style="list-style-type: none"> - Тээврийн нэгдсэн логистик - Бараа бүтээгдэхүүн худалдааны логистик
4	Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль /2006.06.29/	<p>Татвар ногдуулах орлогоос хасаж тооцох заалт нь:</p> <ul style="list-style-type: none"> - үйлдвэрлэл, технологийн төвийн эрчим хүч үйлдвэрлэх, - дамжуулах шугам сүлжээ, цэвэр усан хангамж, бохир усны шугам, - цэвэрлэх байгууламж, авто зам, төмөр зам, харилцаа холбооны дэд бүтэц бий болгоход оруулсан хөрөнгө.
5	Агаарын зайг нисэхэд ашиглах тухай хууль /2003.05.30/	<ul style="list-style-type: none"> - Агаарын тээврийн логистик
6	Гаалийн тухай хууль /2008.05.20/	<ul style="list-style-type: none"> - Тээврийн логистик - Бараа бүтээгдэхүүн дамжин өнгөрөх, агуулах, гаалийн талбай - Тээврийн сүлжээ, дамжин өнгөрөх - Цахилгаан, эрчим хүч дамжин өнгөрөх логистик
7	Замын-Үүд худалдааны чөлөөт бүсийн эрх зүйн байдлын тухай /2003.06.20/	<ul style="list-style-type: none"> - Тээврийн логистик - Бараа бүтээгдэхүүн дамжин өнгөрөх, агуулах, гаалийн талбай - Тээврийн сүлжээ, дамжин өнгөрөх - Эрчим хүчний шугам сүлжээ
8	Инновацийн тухай /2012.05.22/	<ul style="list-style-type: none"> - Нэгдсэн логистикийн үйлчилгээ үзүүлэх - Сургалт-судалгаа-үйлдвэрлэлийн сүлжээ бий болгох;
9	Өрсөлдөөний тухай хууль /2010.06.10/	<ul style="list-style-type: none"> - Тээврийн логистик
10	Төмөр замын тээврийн тухай хууль /2007.07.05/	<ul style="list-style-type: none"> - Тээврийн логистик - Бараа бүтээгдэхүүний агуулах



11	Усан замын тээврийн тухай хууль /2003.11.28/	- Тээврийн логистик - Бараа бүтээгдэхүүний агуулах
12	Улсын нисэхийн тухай хууль /2003.05.30/	- Агаарын тээврийн логистик
13	Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхийн эдийн биржийн тухай хууль /2011.06.02/	- Тээврийн логистик - Бараа бүтээгдэхүүний агуулах
14	Хүнсний тухай хууль /2012.12.20/	- Бараа бүтээгдэхүүний агуулах
15	Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай /2012.12.20/	- Тээврийн логистик - Бараа бүтээгдэхүүний агуулах
16	Хот байгуулалтын тухай хууль /2008.05.29/	- Мэдээлэл, технологийн сүлжээ, дамжин өнгөрөх - Цахилгаан, эрчим хүч дамжин өнгөрөх логистик
17	Чөлөөт бүсийн тухай хууль /2002.06.28/	- Тээврийн логистик - Бараа бүтээгдэхүүний агуулах
18	Цагааннуур худалдааны чөлөөт бүсийн эрх зүйн байдлын тухай /2003.12.18/	- Тээврийн логистик - Бараа бүтээгдэхүүний агуулах - Цахилгаан, дулаан дамжуулах шугам сүлжээ, цэвэр усан хангамж
19	Эрчим хүчний тухай хууль /2001.02.01/	- Цахилгаан, дулаан дамжуулах шугам сүлжээ, цэвэр усан хангамж

Эх сурвалж: www.legalinfo.mn

Хүснэгт 3. 2 Логистикийг ерөнхий байдлаар зохицуулсан эрх зүйн актуудын лавлагаа-2: УИХ-ын тогтоол, бодлогын баримт бичиг

Д/д	Хууль эрх зүйн актын нэр, агуулга	Зохицуулж буй салбар
1	УИХ-ын 2010.06.24 №32 тогтоол “Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлого”	✗ Тээврийн логистик дамжин өнгөрөх
2	УИХ-ын 2016.02.05 №19 тогтоол Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030	✗ Тээврийн логистик ✗ Эрчим хүчний шугам сүлжээ
3	УИХ-ын 2003.06.12 № 24 тогтоол Монгол улсын бүсүүдийн хөгжлийн дунд хугацааны стратеги батлах тухай	✗ Тээврийн логистик дамжин өнгөрөх ✗ Бараа бүтээгдэхүүн агуулах, ✗ Эрчим хүчний шугам сүлжээ
4	УИХ-ын 2005.04.21 № 25 тогтоол Монгол улсын мянганы хөгжлийн зорилтыг батлах тухай	✗ Тээврийн логистик, дамжин өнгөрөх ✗ Бараа бүтээгдэхүүн агуулах, эрчим хүчний шугам сүлжээ
5	УИХ-ын 1996.05.03 №26 Монгол улсын хөгжлийн үзэл баримтлалыг батлах тухай	✗ Тээврийн логистик дамжин өнгөрөх ✗ Бараа бүтээгдэхүүн агуулах,
6	УИХ-ын 2010.06.24 №34 тогтоол Төрөөс өндөр технологийн аж үйлдвэрийн талаар баримтлах бодлого батлах тухай	✗ Тээврийн логистик дамжин өнгөрөх ✗ Бараа бүтээгдэхүүн агуулах,
7	УИХ-ын 2010.06.24. №32 тогтоол Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлого батлах тухай	✗ Тээврийн логистик дамжин өнгөрөх ✗ Бараа бүтээгдэхүүн агуулах,
8	УИХ-ын 2005.06.09 №32 Сэргээгдэх эрчим хүчний үндэсний хөтөлбөр батлах тухай	✗ Эрчим хүчний шугам сүлжээ
9	Монгол улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр	✗ Тээвэр логистик ✗ Логистик төв
10	Алсын хараа 2050 урт хугацааны хөтөлбөр	✗ Тээвэр логистик ✗ Логистик төв

Эх сурвалж: www.legalinfo.mn

Хүснэгт 3. 3 Логистикийг ерөнхий байдлаар зохицуулсан эрх зүйн актуудын лавлагаа-3: Олон улсын гэрээ, конвенци



Д/д	Хууль эрх зүйн актын нэр, агуулга	Зохицуулж буй салбар
1	Далайд гарцгүй улсын дамжин өнгөрөх худалдааны тухай конвенц <i>1965 оны 7 дугаар сарын 8-ны өдөр баталж, 967 оны 6 дугаар сарын 9-ний өдөр хүчин төгөлдөр болсон</i>	<ul style="list-style-type: none"> ✕ Тээврийн логистик дамжин өнгөрөх ✕ Бараа бүтээгдэхүүн агуулах,
2	Дэлхийн худалдааны байгууллага байгуулах тухай марракешийн хэлэлцээр <i>1994 оны 4 дүгээр сарын 15-ны өдөр баталж, 1995 оны 1 дүгээр сарын 1-ний өдөр хүчин төгөлдөр болсон</i>	<ul style="list-style-type: none"> ✕ Тээврийн логистик дамжин өнгөрөх ✕ Бараа бүтээгдэхүүн агуулах, ✕ Худалдааны логистик
3	Монгол, Хятадын хилийн дэглэмийн тухай МУЗГ, БНХАУ-ын ЗГ хоорондын гэрээ 2010 оны 06 дугаар сарын 01-ний өдөр	<ul style="list-style-type: none"> ✕ Тээврийн логистик дамжин өнгөрөх
4	Бараа худалдах-худалдан авах олон улсын гэрээний тухай нэгдсэн үндэстний байгууллагын конвенц <i>1980 оны 4 дүгээр сарын 11-ний өдөр баталж, 1988 оны 1 дүгээр сарын 1-ний өдөр хүчин төгөлдөр болсон</i>	<ul style="list-style-type: none"> ✕ Тээврийн логистик дамжин өнгөрөх ✕ Бараа бүтээгдэхүүн агуулах,
5	Аж үйлдвэрийн өмчийг хамгаалах тухай Парисын конвенц <i>1970 оны 4 дүгээр сарын 26-ны өдөр буюу 1970 оны 5 дугаар сарын 19-ний өдөр хүчин төгөлдөр болсон /Монгол Улс 1984 оны 11 дүгээр сарын 13-ны өдөр соёрхон баталсан/</i>	<ul style="list-style-type: none"> ✕ Тээврийн логистик дамжин өнгөрөх

Эх сурвалж: www.legalinfo.mn

3.1.2 Төрөөс тээврийн салбарт баримталж буй стратегийн чиглэл, алсын хараа

Ерөнхий зүйл

Тээврийн салбар нь өргөн уудам нутагтай, хүн ам харьцангуй сийрэг суурьшилтай манай улсын хувьд эдийн засагт чухал ач холбогдолтой салбарын нэг бөгөөд манай улсын эдийн засагт судасны үүрэг гүйцэтгэдэг.

Монгол нь эдийн засгаараа тэргүүлэгч 2 их гүрний дунд оршдог далайд гарцгүй эх газрын гүний орны хувь эдийн засаг нь хөрш орнуудынх нь зах зээл, эдийн засгийн нөхцөл байдлаас ихээхэн хамаарч байдаг ба уламжлалт байдлаар хөрш орнууд руугаа түүхий эд, ашигт малтмал, хагас боловсруулсан бүтээгдэхүүн экспортолж, мөн орнуудаас хүнс болон эцсийн бүтээгдэхүүн импортолдог худалдааны зүй тогтолтой бөгөөд энэ байдал одоо ч хадгалагдсан хэвээр байгаа юм.


Тээврийн салбарын гол үйлчилгээ бол ачаа болон зорчигчийг нэг цэгээс нөгөө цэгт хүргэх үйлчилгээ билээ. Дэлхийн улс орнуудын газар нутгийн байршлаас үл хамааран эдийн засаг, хамтын ажиллагаа эрчимтэй хөгжиж байгаа өнөө үед тээвэр логистикийн салбарын гүйцэтгэх үүрэг улам бүр өсөн нэмэгдсээр байна.

Аливаа улс орон эдийн засаг, нийгмийн хөгжлөө түргэтгэх хэрэгцээ шаардлагад гол тээг болдог салбар нь тээврийн салбарын хөгжил, логистикийн дэд бүтцийн бэлэн байдал байдаг бөгөөд тээврийн үйлдвэрлэл, үйлчилгээг хөгжүүлэхэд тухайн салбар дахь тээвэр



үйлчилгээний бизнесийг дэмжих явдал нь чухал ач холбогдолтой. Энэ нь нэг талаас дэлхийн тээврийн салбарын хөгжлийн хурд, түүний үйл явц, тухайн орны тээврийн салбарт баримталж буй бодлого, стратеги, менежменттэй шууд холбоотой.

Зураг 3. 1 Монгол улсын Зам тээврийн салбарт баримталж буй бодлогын баримт бичиг



Энэ үүднээс тухайн улс өөрийн нөөц баялагт тулгуурласан тээврийн үйлдвэрлэл, үйлчилгээний жижиг дунд үйлдвэр болон үйлдвэрлэгчдийг дэмжих, энэхүү салбар ажиллагсдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх, ажлын байрыг шинээр бий болгох, шинэ бүтээгдэхүүнийг зах зээлд бий болгох болон өөрийн бүс нутгийн тээврийн зах зээлийг хөгжүүлэх, аль болох тээврийн үйлчилгээний бизнесийн орчин, тулгамдаж буй асуудлыг бага багаар шийдвэрлэх явдал юм.

Одоогоор манай улсын тээврийн салбарыг хөгжүүлэх бодлогууд нь "Алсын хараа-2050"-д дурдагдсан Дэд бүтцийн салбарын бодлого болох "Эдийн засгийн өсөлтийг хангах зам, тээвэр, логистикийн сүлжээг хөгжүүлнэ" болон "Хэрэглэгчийн эрэлт, хэрэгцээнд нийцсэн, эдийн засгийн үр ашигтай, аюулгүй, ая тухтай тээврийн үйлчилгээг өргөжүүлэн хөгжүүлнэ" гэсэн зорилтуудад бүхэлдээ чиглэгдэж байгаа ба хүчин төгөлдөр мөрдөгдөж буй бодлогын баримт бичиг болон манай улсын нэгдэн орсон олон улсын конвенциуд мөн үүнд нийцэж байгаа болно.

Алсын хараа-2050 урт хугацааны хөтөлбөр

2020 онд шинээр батлагдсан "Алсын хараа-2050" Монгол улсын урт хугацааны хөтөлбөр нь "Монгол улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030"-ыг халж гарч ирсэн шинэ бодлогын баримт бичиг бөгөөд энэхүү баримт бичигт нийцсэн ажлуудыг хийж хэрэгжүүлэх, төслүүдийг энэхүү баримт бичигт нийцүүлж өөрчлөн сайжруулах ажил явагдаж байна.



Зорилт 4.1.Макро эдийн засгийн тогтвортой орчныг бүрдүүлж, дундаж давхаргыг нийгмийн зонхилох бүлэг болгоно.

- 4.1.16.Дамжин өнгөрүүлэх тээвэр, худалдаа, экспортод чиглэсэн үйлдвэрлэлийг тээвэр, логистик, хилийн дэд бүтцийн хамт байгуулан эдийн засгийн эрчимтэй өсөлтийг хангана.

Зорилт 4.2.Эдийн засгийн тэргүүлэх салбаруудыг хөгжүүлж, экспортын баримжаатай эдийн засгийг бий болгоно.

- 4.2.1.Нэмүү өртөг шингээсэн уул уурхай, стратегийн мега төслүүд, боловсруулах аж үйлдвэр, хөдөө аж ахуй, эрчим хүч, тээвэр, логистик, төрөлжсөн аялал жуулчлал, түүнийг дагасан үйлчилгээ, жижиг, дунд үйлдвэрлэл, мэдлэгжсэн бүтээлч үйлдвэрлэлийг эдийн засгийн тэргүүлэх салбар болгон хөгжүүлнэ.
- 4.2.2.Хөдөө аж ахуй, тээвэр логистик, төрөлжсөн аялал жуулчлалын салбарыг бүс, орон нутгийн хөгжлийг дэмжих замаар хөгжүүлнэ.

Зорилт 4.4.Бүс нутгийн эдийн засаг, худалдааны интеграцад нэгдэж, худалдааг хөнгөвчилнэ.

- 4.4.4.Эдийн засгийн коридор бий болгох гурван талт хэлэлцээрийг боловсронгуй болгож, Монгол Улс тээвэр, логистик, хот байгуулалт, хил дамнасан худалдаа, аялал жуулчлалын дэд бүтцийн бүтээн байгуулалтын төслийг хэрэгжүүлнэ.
- 4.4.6.Олон улсын агаарын карго тээврийн логистикийн төв байгуулж, ачааны төвлөрөл бий болгоно.
- 4.4.11.Гадаад, дотоод зах зээлүүдтэй холбогдох зорилгоор тээвэр логистикийн нэгдсэн сүлжээг хөгжүүлэх, дэд бүтцээ үр өгөөжтэй байлгахын тулд дамжин өнгөрөх тээврийн гэрээ хэлэлцээрүүдийг сайжруулж хэрэгжүүлнэ.

Зорилт 8.1.Бүс нутгийн эдийн засгийн интеграцад дэд бүтцийн нэгдсэн сүлжээгээр бүрэн холбогдож, эдийн засгийн эрчимтэй өсөлтийг хангах суурь нөхцөлийг бүрдүүлнэ.

- 8.1.1.Олон улс, бүс болон орон нутгийн чанартай дараах чиглэлийн авто замуудыг байгуулна. Үүнд: “Ховд”–“Улаангом”;
- 8.1.4.Олон улсын тээвэр логистикийн 3, бүсийн тээвэр логистикийн 6, орон нутгийн тээвэр логистикийн 33 төвийг тус тус барина.
- 8.1.5.Шинэ нийслэл болон Дорнод, Өмнөговь, Ховд, Увс, Завхан, Хөвсгөл аймгуудыг 4С зэрэглэлийн агаарын хөлөг хүлээн авах хүчин чадалтай аэродром, зорчигч үйлчилгээний цогцолбор бүхий олон улсын нисэх буудалтай болгоно.

Зорилт 8.3.Хөдөө аж ахуйг байгальд ээлтэй, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицсон, эрсдэл даах чадвартай, нийгмийн хөгжлийн чиг хандлага, хэрэгцээ, шаардлагад нийцсэн, хариуцлагатай, бүтээмж өндөр, тогтвортой үйлдвэрлэлтэй эдийн засгийн тэргүүлэх салбар болгон хөгжүүлнэ.



- 8.3.8. Хөдөө аж ахуйн эрчимжүүлсэн үйлдвэрлэлд техник, технологийн шинэчлэлийг үе шаттай хэрэгжүүлж, кластер, логистик, санхүүгийн түрээсийн үйлчилгээг хөгжүүлнэ.

Зорилт 9.5. Үндэсний онцлог бүхий аялал жуулчлал, соёлын үйлчилгээ, үйлдвэрлэлийг бий болгосон, Зүүн хойд азийн тээвэр, логистикийн болон олон улсын харилцааны зангилаа төв болсон дагуул хотуудыг хөгжүүлнэ.

- 9.5.1. Дагуул, хаяа хот, тосгоныг тус бүрд нь худалдаа, үйлчилгээ, боловсрол, соёл, эрүүл мэнд, хөдөө аж ахуй, хүнс, хөнгөн үйлдвэрлэл, тээвэр логистик, аялал жуулчлалын чиглэлээр төрөлжүүлэн хөгжүүлж ажлын байрыг нэмэгдүүлэх замаар Улаанбаатар хотын төвлөрлийг сааруулна.

Логистикийн талаар тусгасан зорилтууд:

- **Үндэсний тээвэр, логистикийн тогтолцоог хөгжүүлэх чиглэлээр** - Олон улсын чанартай тээвэр, логистикийн төвүүдийг байгуулж, үндэсний тээвэр логистикийн тогтолцоог хөгжүүлнэ.
- **Боловсруулах салбар давамгайлсан эдийн засгийн бүтцийг бүрэлдүүлж, хүнсний аюулгүй байдлыг хангах чиглэлээр** - Үйлдвэрийн аргаар боловсруулсан хүнсний бүтээгдэхүүний хэмжээг нэмэгдүүлэх, түүхий эдийн хадгалалт, тээвэрлэлт, үйлдвэрлэл, борлуулалтад чиглэсэн тээвэр, логистикийн тогтолцоог хөгжүүлнэ.
- **Олон улсын стандартад нийцсэн холимог сүлжээ бүрдүүлэх чиглэлээр** - Авто зам, төмөр зам, агаарын тээвэр болон тээвэр логистикийн төвүүдийн бүтээн байгуулалтыг үргэлжлүүлэн хийж, олон улсын стандартад нийцүүлнэ.

“Алсын хараа-2050” баримт бичгийг хэрэгжүүлснээр тээвэр, логистикийн аж ахуйн ДНБ-д эзлэх хувийг 2030 онд 4.8%, 2040 онд 9.7%, 2050 онд 11.6% болгож нэмэгдүүлнэ гэж төлөвлөсөн байна.

Хүснэгт 3. 4 Алсын хараа 2050-д тусгаснаар эдийн засгийн тэргүүлэх чиглэлүүдэд гарах үр дүн

Үзүүлэлт / он	2030	2040	2050
ДНБ /2018 оны ханшаар/	32.1 тэрбум ам.доллар	54.0 тэрбум ам.доллар	77.7 тэрбум ам.доллар
1 хүнд ногдох ДНБ	8299 ам.доллар	12004 ам.доллар	14682 ам.доллар
Эдийн засгийн салбарын ДНБ-нд эзлэх хувь:			
Уул уурхай	31.4%	26.8%	25.3%
Боловсруулах аж үйлдвэр	14.6%	20.3%	27.4%
Тээвэр, логистикийн аж ахуй	4.8%	9.7%	11.6%
Бусад	49.2%	43.2%	35.7%

Эх сурвалж: “Алсын хараа-2050”

Увс аймагт хэрэгжүүлэхээр тусгасан зорилтууд:



- Бүсийн босоо, хэвтээ тэнхлэгийн авто замуудыг барьж, мезо, микро бүсүүдийн төвүүдийг улс, бүсийн чанартай авто замын сүлжээтэй холбож, тээвэр, логистикийн төвүүдийг байгуулна. **Увс, Ховд аймгийн нисэх онгоцны буудлыг олон улсын зэрэглэл (4С)-тэй болгох**
- Баруун бүсэд сэргээгдэх эрчим хүчийг дэлгэрүүлэх - Увс, Ховд, Баян-Өлгий аймгуудад
- Сумдын төвийг хатуу хучилттай авто замаар холбох - Увс аймаг Өлгий сум
- Улаангом хотын бүсийн тээвэр, логистикийн төв байгуулах

Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл

Алсын хараа-2050-д нийцүүлэн 2020 оны УИХ-ын 23-р тогтоолоор батлагдсан Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд Логистик төвтэй холбоотой дараах зорилтууд тусгагдсан.

Зорилт 4.2.Эдийн засгийн бүтцийн шинэчлэлийг эхлүүлж, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэн, экспортод чиглэсэн хүнд, хөнгөн үйлдвэрлэлийг хөгжүүлнэ:

- 4.2.9.олон улсын чанартай тээвэр, логистикийн төвүүдийг байгуулсан байна.

Зорилт 8.1.Эдийн засгийн тэргүүлэх бүс нутаг, салбаруудыг дэд бүтцээр холбоно:

- 8.1.3.байгаль орчинд ээлтэй, эрэлтэд нийцсэн, тогтвортой, хүртээмжтэй, аюулгүй тээврийн үйлчилгээг хөгжүүлж, авто замын сүлжээ, үндэсний тээвэр логистикийн тогтолцоог хөгжүүлнэ.
- 8.1.8.бүсчилсэн хөгжлийн бодлогын хүрээнд эхний ээлжид алслагдсан зарим аймгуудад гадаадын хөнгөлөлттэй зээл, буцалтгүй тусламжийн хөрөнгөөр “Аймаг, сумын төвийн бүсчилсэн хөгжлийн хөрөнгө оруулалтын хөтөлбөр” төслийг Баян-Өлгий, Увс, Ховд, Дорнод аймгуудад хэрэгжүүлнэ.

Дээрх баримт бичгийн хүрээнд боловсруулсан Монгол Улсын 2021-2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөрт Увс аймагт дараах ажлуудыг хэрэгжүүлэхээр төлөвлөжээ. Үүнд:

- 2020-2021 онд - Сонгино сум-Хяргас нуурын зүүн хаяа чиглэлийн 135.5 км хатуу хучилттай автозам төсөл /Концессын эргэн төлөлт/
- 2022-2026 онд - Увс аймгийн цахилгаан станц, цахилгаан дамжуулах шугам барих төсөл

Мөн санхүүжилтийн эх үүсвэрийг шийдвэрлэх шаардлагатай төсөл, арга хэмжээ

- 2021-2025 онд - Увс аймгийн Дэглий цагаан нисэх буудлын хүчин чадлыг нэмэгдүүлэх төсөл
- 2022-2023 онд - Ховд-Улаангом чиглэлийн 163 км хатуу хучилттай автозамын төсөл



ТЭЗҮ, зураг төсөл боловсруулах шаардлагатай дараах төсөл, арга хэмжээнүүдийг төлөвлөжээ. Үүнд

- 2021-2024 онд - Улаанбаатар хотын баруун, зүүн хэсэгт төрөлжсөн тээвэр, логистикийн төв байгуулах төсөл (ТЭЗҮ, зураг төсөл боловсруулах шаардлагатай төсөл, арга хэмжээ),
- 2022-2024 онд - Сэлэнгэ, Дархан-Уул, Орхон, Өвөрхангай, Ховд аймгуудад хүнсний бүтээгдэхүүн, түүхий эд, газар тариалан, хөдөө аж ахуй, барилгын материалын үйлдвэрлэлд түшиглэсэн орон нутгийн логистикийн төвүүдийг байгуулах (ТЭЗҮ, зураг төсөл боловсруулах шаардлагатай төсөл, арга хэмжээ),

Монгол улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр

Шинээр байгуулагдсан ЗГ-ын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт Зам тээврийн салбарын чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар логистик төвтэй холбоотой дараах бодлогын арга хэмжээнүүд тусгагджээ. Үүнд:

3.3. Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн үйлдвэрлэл, борлуулалтын сүлжээг хөгжүүлж, гол нэрийн хүнсний бүтээгдэхүүний хэрэгцээг дотоодоос бүрэн хангаж, импортыг орлох болон экспортын баримжаатай бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэмжинэ.

- 3.3.12. Хөдөө аж ахуйн тээвэр, борлуулалтын логистикийн сүлжээг байгуулж, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний бэлтгэн нийлүүлэлтийн чанарын хяналт, баталгаажуулалтын оновчтой тогтолцоог бүрдүүлнэ.

3.4. Байгаль, түүх, соёлын өвд түшиглэсэн тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлнэ.

- 3.4.1. Төрөөс аялал жуулчлалыг хөгжүүлэх бодлогын хүрээнд “Тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх төсөл-I”-ийг Хөвсгөл, Хэнтий, “Тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх төсөл-II”-ийг Архангай, Баян-Өлгий, Өвөрхангай, Увс, Ховд зэрэг аймагт хэрэгжүүлж, орон нутгийн иргэд, аж ахуйн нэгжийн орлогыг нэмэгдүүлнэ.
- 3.4.6. Баян-Өлгий, Увс, Ховд, Өвөрхангай, Архангай, Баянхонгор, Өмнөговь, Дорнод, Завхан аймгуудад аялал жуулчлалын дэд бүтцийг хөгжүүлж, отоглох цэг, авто зам дагуу үйлчилгээний цогцолборуудыг байгуулна. Говийн бүсийн аялал жуулчлалыг хөгжүүлнэ.

3.6. Эдийн засгийн өсөлтийг хангахуйц, тээврийн ухаалаг системд суурилсан үндэсний тээвэр, логистикийн сүлжээг байгуулна.

- 3.6.3.3. Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Тяньжин хотын Дуньзян боомтод олон улсын тээвэр, логистикийн төвийн төслийг эхлүүлнэ.
- 3.6.3.4. төмөр замын сүлжээг түшиглэн олон улсын стандартад нийцсэн хуурай боомтыг барьж байгуулна. Нийслэлийн Налайх дүүрэгт Улаанбаатар төмөр замыг түшиглэн олон улсын стандартад нийцсэн ачаа тээвэр, логистикийн төвийг төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд барьж байгуулна.



Шинэ Сэргэлтийн Бодлого

УИХ-ын 2021 оны 106-р тогтоолоор Коронавируст халдвар /КОВИД-19/-т цар тахлын эдийн засагт үзүүлж байгаа сөрөг нөлөөллийг бууруулж, эдийн засгийн суурийг тэлэх зорилгоор "Шинэ сэргэлтийн бодлого"-ыг баталсан.

"Шинэ сэргэлтийн бодлого" нь Монгол Улсын эдийн засгийн хараат бус, бие даасан байдлыг бэхжүүлэх, Коронавируст халдвар /КОВИД-19/-т цар тахлын эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, хөгжлийг хязгаарлагч хүчин зүйлийг цаг алдалгүй шийдвэрлэж, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогыг үр дүнтэй хэрэгжүүлэх суурь нөхцөлийг бүрдүүлэх, эдийн засаг, дэд бүтэц болон төрийн бүтээмжийг сайжруулахад чиглэсэн 10 хүртэлх жилийн хугацаанд хэрэгжих дунд хугацааны зорилтот хөтөлбөр юм.

"Шинэ сэргэлтийн бодлого"-ыг хэрэгжүүлснээр урт хугацаанд эдийн засгийн өсөлт дунджаар 6 хувьд хадгалагдаж, нэг хүнд ногдох үндэсний орлого 2 дахин нэмэгдэж, ажиллах хүчний оролцооны түвшин 65 хувьд хүрнэ. Боомтын хүчин чадлыг 3 дахин нэмэгдүүлж, эрчим хүчний эх үүсвэрийг 2 дахин өсгөнө. "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогод дэвшүүлсэн эхний үе шатны зорилго, зорилт хангагдах суурь нөхцөл бүрдэнэ гэж үзсэн.

"Шинэ сэргэлтийн бодлого"-ын хүрээнд төр-хувийн хэвшил, хөрөнгө оруулагчдын идэвхтэй түншлэлд тулгуурлан Монгол Улсын хөгжлийг хязгаарлаж буй зургаан багц асуудлыг шийдвэрлэх ба Логистик төв нь Хот хөдөөгийн сэргэлт хэмээх 4-р зорилтод хамааралтай байна. Тус зорилтын 4-р дэд зорилтод:

Зорилт 4.3. Аймгийн төвүүдийг бие даасан хот болгон хөгжүүлж, орон нутаг төсвийн орлогоо бие даан бүрдүүлэх санхүү, эдийн засгийн боломжийг бүрдүүлнэ

Зорилт 3.5. Хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний нөөцтэй уялдуулан боловсруулах үйлдвэрийн хүчин чадлыг нэмэгдүүлэх замаар хагас боловсруулсан бүтээгдэхүүний экспортын хувь хэмжээг бууруулан нэмүү өртөг шингэсэн эцсийн бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлнэ - – гэж заажээ.

Энэ зорилтын хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагаа нь:

Төрөөс ноос ноолуур, арьс шир, мах болон экспортын ач холбогдол бүхий бусад түүхий эдийн нэгдсэн агуулах болон тээвэр, логистикийн дэд бүтцийг сайжруулах арга хэмжээг үе шаттайгаар хэрэгжүүлэх

Тус зорилтыг хэрэгжүүлснээр Экспортын ач холбогдол бүхий түүхий эд, бүтээгдэхүүний нэгдсэн агуулах болон тээвэр, логистикийн дэд бүтцийг сайжруулсан байхаар заажээ.

3.1.3 Төрөөс авто замын талаар баримталж буй бодлого

Төрөөс баримтлах үндсэн бодлого⁶


⁶ <https://www.legalinfo.mn/annex/details/8735?lawid=13718> , “Төрөөс автотээврийн салбарт баримтлах бодлого” , 2019 оны 09 сарын 05-нд хянан үзэв



Улс орны эдийн засаг, нийгмийн хөгжилд нийцүүлэн авто замын сүлжээг өргөжүүлэн хөгжүүлэх талаар сүүлийн жилүүдэд авто замд ихээхэн хөрөнгө оруулалт хийгдэж замын сүлжээн дэх хатуу хучилттай замын хэмжээ хурдацтай нэмэгдэж байна.

Нийслэлийг аймгийн төвүүдтэй хатуу хучилттай авто замаар холбох зорилт амжилттай хэрэгжиж 2022 онд бүх аймгийн төвүүд холбогдож дууссан. Цаашдаа Бүх сум суурин газруудыг /200 гаруй/ хатуу хучилттай авто замын сүлжээнд холбох хэтийн төлөвтэй.

Зураг 3. 2 Авто замын салбарт хэрэгжсэн төсөл, арга хэмжээнүүд



Эх

сурвалж: Зам тээврийн яам

Авто замын салбар нь Монгол улсын дэд бүтцийн онцгой ач холбогдол бүхий салбарын нэг бөгөөд өргөн уудам нутаг дэвсгэртэй Монгол орны хувьд тус салбар нь улс орны эдийн засаг нийгмийн хөгжлийг дэмжиж байна. Тээврийн бусад төрлүүдтэй харьцуулахад өргөн уудам нутаг дэвсгэртэй, дэд бүтэц сул хөгжсөн манай улсын хувьд автотээврийн хэрэгцээ, шаардлага өсөн нэмэгдэж, тээвэрлэлтийн гүйцэтгэлээс харахад тээврийн төрлүүдээр гүйцэтгэсэн нийт зорчигч тээврийн 98 хувийг, ачаа тээврийн 65 хувийг автотээврийн хэрэгслээр тээвэрлэж байна.

Засгийн газрын 2018 оны 10 дугаар сарын 24-ний өдрийн 321-р тогтоолоор “Төрөөс автотээврийн салбарт баримтлах бодлого”-ын баримт бичгийг баталлаа. Ингэснээр автотээврийн салбар анх удаа бие даасан бодлогын баримт бичигтэй болжээ.

Бодлого нь автотээврийн салбарын удирдлага, зохион байгуулалтын бүтэц, хүний нөөц, автотээврийн ажил, үйлчилгээ, дэд бүтэц, эрдэм шинжилгээ, сургалт, судалгаа, үйлдвэрлэлийг тээврийн бусад төрлүүдтэй уялдуулан хөгжүүлэх, бодлогын нэгдмэл байдлыг хангахад шаардлагатай орчныг бүрдүүлэхэд чиглэж, шинжлэх ухаан, технологи, аж үйлдвэр, аялал жуулчлал, хүнс, хөдөө аж ахуй, эрдэс баялаг, эрчим хүч, ногоон хөгжил, орон нутаг, бүсчилсэн хөгжлийн бодлоготой нягт уялдаатай хэрэгжихээр заасан ба автотээврийн салбарыг эдийн засгийн өсөлтийг хангах, эрэлтэд нийцсэн, тогтвортой, эдийн засгийн үр ашигтай, аюулгүй, ая тухтай, байгаль орчинд ээлтэй, бүс нутагт өрсөлдөхүйц



тээврийн үйлчилгээ үзүүлэгч, нийгмийн тэргүүлэгч салбар болгон хөгжүүлэхэд оршиж байна.



Бодлогоор автотээврийн салбарын эрх зүйн орчныг сайжруулах, бизнесийг дэмжих, автотээврийн ажил үйлчилгээг нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар хангах, хүний нөөцийн болон тээврийн байгууллагуудын чадамжийг дээшлүүлэх,

тээврийн сүлжээ төлөвлөлтийг хот, тосгоны ерөнхий төлөвлөлтөд нийцүүлэх, аюулгүй, найдвартай, хосолсон, үр ашигтай, ая тухтай, байгаль орчинд ээлтэй тээврийн үйлчилгээг үзүүлэх, автотээврийн дэд бүтэц, тээвэр логистикийн сүлжээг хувийн хэвшлийн оролцоотой барьж байгуулах, дэвшилтэт техник технологийг нэвтрүүлэх, судалгаа шинжилгээ, баталгаажуулалт, хяналтын тогтолцоог нэвтрүүлэх чиглэлээр үндсэн 8 стратегийн зорилтыг дэвшүүлсэн.

Үүнд:

1. Мэргэжил, ур чадварт тулгуурласан орчин үеийн хүний нөөцийн менежменттэй хослуулсан, өрсөлдөх чадвар бүхий удирдлага, зохион байгуулалтын тогтолцоог бүрдүүлэх;
2. Чанартай, хүртээмжтэй, хосолсон тээврийн дэд бүтцийг бий болгох замаар олон улсын тээврийг хөгжүүлэх;
3. Тээврийн төрлүүдийн харилцан уялдааг хангасан, өрсөлдөх чадвар бүхий аюулгүй, ая тухтай зорчигч тээврийн үйлчилгээ үзүүлдэг болох;
4. Хөдөө аж ахуй, аж үйлдвэрийн салбарын эрэлтэд тулгуурласан, хүн амыг эрүүл ахуйн шаардлага хангасан хүнс, өргөн хэрэглээний барааны дотоодын тээврийн сүлжээг бий болгох;
5. Байгаль орчинд ээлтэй, эдийн засгийн үр ашигтай тээврийн үйлчилгээ үзүүлдэг болох;
6. Тээвэрлэлтийн болон авто замын сүлжээний аюулгүй байдлын цогц менежментийг бий болгох;
7. Техник, технологийн дэвшилд суурилсан тээврийн хэрэгслийн техникийн хяналт, авто үйлчилгээ, бүртгэлийн цогц үйлчилгээг хөгжүүлэх;
8. Автотээврийн салбарын хөгжлийг судалгаа, шинжилгээний үр дүнд үндэслэн тодорхойлж, автотээврийн салбарт инновацийг нэвтрүүлэх.

Бодлогыг хэрэгжүүлснээр автотээврийн салбарыг хөгжүүлэх, тээврийн бусад төрлүүдтэй уялдах, хослох боломж бүхий үндэсний тээврийн нэгдсэн сүлжээг бүрдүүлэх, үүгээр дамжуулан олон улсын болон бүс нутгийн тээврийн сүлжээнд нэгдэх боломж бүрдэнэ гэж



үзэж байна. Логистик төв орчмын тээврийн сүлжээний хөгжилтэй холбоотой байж болох бодлогын заалтуудыг харвал:

- Хөрш орнуудын хооронд болон монгол улсын нутаг дэвсгэр, хот, суурин газарт аюулгүй, шуурхай, багтаамж ихтэй тээврийн сүлжээг төлөвлөж хөгжүүлэх;
- Монгол улсын тээврийн сүлжээг олон улсын болон бүс нутгийн тээврийн коридоруудтай холбох замаар монгол, орос, хятад гурван улсын эдийн засгийн коридорыг хөгжүүлэх;
- Худалдаа, тээврийг хөнгөвчлөх, эдийн засгийн коридорыг хөгжүүлэх санаачилгыг дэмжин азийн авто замын сүлжээнд холбогдсон зүүн, баруун, төв коридороор дамжин өнгөрөх автотээврийг хөгжүүлэх;
- Уул уурхайн бүтээгдэхүүнийг хөрш болон гуравдагч орнуудад экспортлох хосолсон тээвэр, логистикийн сүлжээг бий болгох;
- Хэрэглэгчдэд хүртээмжтэй, эдийн засгийн үр ашигтай, тогтвортой, найдвартай, аюулгүй, хосолсон зорчигч тээврийн үйлчилгээ үзүүлдэг болох;
- Зорчигч тээврийн үйлчилгээний цогцолборыг төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд аймаг бүрт байгуулж, зорчигч тээврийн үйлчилгээг өртөөчлөх, шуудангийн үйлчилгээтэй холбох замаар зохион байгуулж, тээвэрлэлтийн үр ашгийг нэмэгдүүлэх;
- Автотээврийн дэд бүтцийг аялал жуулчлалын гол чиглэлүүдийн дагуу хөгжүүлж, гадаад, дотоодын жуулчдын эрэлтэд нийцсэн жуулчин тээврийн үйлчилгээний төрлийг нэмэгдүүлж, чанарыг сайжруулах;
- Хувийн автотээврийн хэрэгслээр хөрш орнууд болон олон улсад аялах эрх зүйн орчинг бүрдүүлэх.
- Тээвэрлэлтийн тусгай горим шаарддаг хүнсний бүтээгдэхүүн, түүхий эдийг тээвэрлэх сүлжээг бий болгож, энэ чиглэлийн тээвэр, логистикийн төвийг төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд байгуулж, хөгжүүлэх;

Дэд бүтэц сул хөгжсөн манай орны хувьд 21 аймаг, 330 суманд ачаа, шуудан, зорчигч тээврийн үйлчилгээг хүргэх хамгийн тохиромжтой тээврийн төрөл нь автотээвэр бөгөөд үндэсний тээвэр, логистикийн сүлжээгээр дамжуулан дотоодын тээвэр, худалдаа, хамтын ажиллагааг хөгжүүлэх, олон улсын тээврийн сүлжээнд нэгдэх шаардлага тулгарч байна.

Иймд тээвэр, логистикийг хөгжүүлэх чиглэлд дараах зорилтуудыг тавьсан байна. Үүнд:

- 2.3.2.4. Улаанбаатар хот, Дорноговь аймгийн Замын-Үүд, Сайншанд, Дорнод аймгийн Чойбалсан, Сэлэнгэ аймгийн Алтанбулагийн олон улсын хуурай боомт, Баян-Өлгий аймгийн Цагааннуурын чөлөөт бүсийг түшиглэн олон улсын чанартай тээвэр, логистикийн төв байгуулах;
- 2.3.4.2. тээвэрлэлтийн тусгай горим шаарддаг хүнсний бүтээгдэхүүн, түүхий эдийг тээвэрлэх сүлжээг бий болгож, энэ чиглэлийн тээвэр, логистикийн төвийг төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд байгуулж, хөгжүүлэх;



- 2.3.4.3. газар тариаланд түшиглэсэн орон нутгийн тээвэр, логистикийн төвийг төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд байгуулж, хөгжүүлэх;
- 2.3.4.4. барилгын материалын үйлдвэрлэлд түшиглэсэн орон нутгийн тээвэр, логистикийн төвийг төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд байгуулж, хөгжүүлэх;
- 2.3.4.5. Улаанбаатар хотод ачаа тээврийн төрөлжсөн тээвэр, логистикийн төвүүдийг төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд байгуулж, хөгжүүлэх;
- 2026 он гэхэд 6 логистикийн төв байгуулах

Гадаад харилцаа

Монгол улсын Автозамын гадаад харилцаа нь хөрш 2 орнуудын нутаг дэвсгэрээр дамжин өнгөрөх тээвэр хийх, хөрш орнуудын авто тээврийг өөрийн нутаг дэвсгэрээр дамжин өнгөрүүлэхтэй холбоотойгоор нэгдэн орсон 2 талт ба 3 талт, улмаар олон улсын гэрээ, конвенциудад нэгдэн орсноор илэрдэг.

Монгол Улс 1993 оноос эхлэн “Олон улсын авто тээврийн харилцааны тухай” Засгийн газар хоорондын хэлэлцээрийг ОХУ, БНХАУ, Казахстан, Украин, БНАСАУ, Турк, Киргиз, Беларусь, Латви улстай байгуулж, олон улсын хэмжээнд авто тээврийн салбарын үйл ажиллагааг хөгжүүлэх, худалдаа, тээврийг хөнгөвчлөх, хяналтын үйл ажиллагааг хялбаршуулах чиглэлээр гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэн ажиллаж байна.



Азийн Автозамын сүлжээнд нэгдэн орох бодлогын дагуу 2004 оны 4 сард Азийн автозамын сүлжээний тухай Засгийн газар хоорондын хэлэлцээрт АН-3, АН-4, АН-32 гэсэн чиглэлээр 4286 км автозамаар нэгдэн орохоор тусгасныг УИХ 2005 онд баталсан байдаг.

Улмаар “Монгол-Орос-Хятадын Эдийн засгийн коридор байгуулах хөтөлбөр”-ийн дагуу 2018 онд ОХУ болон БНХАУ-тай авто тээврээр транзит тээвэр хийх “Азийн авто замын сүлжээгээр олон улсын авто тээвэрлэлт гүйцэтгэх тухай Засгийн газар хоорондын хэлэлцээр”ийг 2018 онд байгуулсан. Хэлэлцээрийн үндсэн агуулга, зарчим нь хөрш зэргэлдээ болон гуравдагч орнуудын худалдаа, тээвэр, эдийн засгийн харилцааг хөгжүүлэх, худалдаа, тээврийг хөнгөвчлөх, тээврийн төрлүүдийн харилцан уялдааг хангах, авто тээврийн салбарын хамтын ажиллагааг дэмжих, авто тээврийн салбарын үйл ажиллагаанд хамааралтай олон улсын байгууллагын стандарт, зөвлөмжийг талууд нэгдсэн зохицуулалттай хэрэгжүүлэх эрх зүйн зохицуулалтыг бүрдүүлэхэд оршиж байна.

Зураг 3. 3 Азийн Автозамын сүлжээнд нэгдэн орсон байдал



Хэлэлцээрийн дагуу Монгол Улс болон гуравдагч орнуудын хооронд ТИР конвенцийн хүрээнд ачаа тээвэрлэлт зохион байгуулах боломж бүрдсэн ба ачааг анхны цэгээс эцсийн цэг хүртэл саадгүй, аливаа хяналт шалгалтгүй, шуурхай хүргэдэг болсон. Монгол, Орос, Хятад гурван улсын санаачилсан энэ хэлэлцээрт бусад улс орнууд ч нэгдэх эрмэлзлээ илэрхийлж байна. Хэлэлцээрийн үр дүнд манай улсын гадаад худалдаа 20 орчим хувиар нэмэгдэнэ, мөн 200 орчим жолооч байнгын ажлын байртай, олон улс дамнасан зам тээврийн дэд бүтцийг дагаад 3000-4000 ажлын байр нэмэгдэнэ гэсэн урьдчилсан тооцоотой байна.

Түүнчлэн Ази-Европыг хамарсан худалдаа, тээвэр, гааль, татвар, даатгалын асуудлууд хөнгөвчлөгдөх, авто замын дамжин өнгөрөх тээвэрлэлтийг эхлүүлэхтэй холбогдуулан Азийн авто замын сүлжээний АН3 болон АН4 авто замд орчин үеийн дэвшилтэт тоноглол, төлбөр хураах системийг нэвтрүүлэх, олон улсын авто замын дагуу жолооч, зорчигчдын ая тухтай амрах үйлчилгээний цогцолбор, тээврийн хэрэгслийн засвар үйлчилгээний төвүүдийг байгуулах боломж бүрдсэн.

Ачаа ба Зорчигчийг тээвэрлэх нь⁷

Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын сайдын 2009 оны 201 дүгээр тушаалаар Автотээврийн хэрэгслээр ачаа, зорчигч тээвэрлэх дүрмийг баталсан байдаг. Дүрмээр Монгол улсын нутаг дэвсгэрт автотээврийн хэрэгслийг ашиглах болон ачаа, зорчигч тээвэрлэлтийн ажил, үйлчилгээ эрхлэгчид болон тэдгээрээр тээвэрлүүлж буй этгээдэд тавигдах шаардлага, хүлээх эрх, үүргийг тодорхойлж, түүнтэй холбогдсон харилцааг зохицуулсан байдаг. Дүрмээр улс хоорондын ачаа, зорчигч тээвэрлэлтийг холбогдох олон улсын гэрээ, хэлэлцээрийн дагуу гүйцэтгэхээр заасан ба Монгол Улсын хил нэвтрэн хийгдэх зорилготой хот хоорондын болон орон нутгийн байнгын ачаа тээвэрлэлтийг улс хоорондын тээвэрлэлтэд хамруулна гэж заажээ.

Дүрэмд Ачаа тээвэртэй холбоотой анхаарах заалтууд нь:

⁷ <https://www.legalinfo.mn/annex/details/5231?lawid=7667> , Автотээврийн хэрэгслээр ачаа, зорчигч тээвэрлэх дүрэм ,



- Жингийн хэмжээ ба ачааны шинж чанараас нь хамаарч тээврийн хөлсийг тээвэрлэгч өөрөө тогтооно,
- Тээвэрлэгч нь ачааны шинж чанар, овор хэмжээ, тээвэрлэлтийн нөхцөл, тээвэрлэлтэд тавих шаардлага, тоо хэмжээ зэргээс хамааруулж тухайн төрөл, ангиллын ачаанд тохирсон хөдлөх бүрэлдэхүүний зориулалт, төрлийг сонгож тээвэрлэлтийг гүйцэтгэнэ.
- Аюултай ачаа, овор ихтэй, урт, хүнд ачаа, хүнсний түргэн гэмтэх, эмзэг бүтээгдэхүүнийг зөвхөн зориулалтын буюу тухайн ачааг тээвэрлэхэд тусгайлан бэлтгэсэн автотээврийн хэрэгслээр тээвэрлэнэ.
- Автотээврийн хэрэгслийн оврын болон жингийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ стандартаар тогтоосноос хэтэрсэн тохиолдолд тухайн аймаг, нийслэлийн замын цагдаагийн газар болон автозамын газартай тээвэрлэлтийн хөдөлгөөний замнал, цагийн хуваарийг тохиролцож баталгаажуулсан байх бөгөөд холбогдох /Овор ихтэй, урт, хүнд ачааны тээвэрлэлт. Ангилал. Ерөнхий шаардлага MNS 5345:2003/ стандартын дагуу тээвэрлэнэ;
- Хүнсний түргэн гэмтэх, эмзэг бүтээгдэхүүнийг тогтоосон горимынх нь дагуу хөргөгч бүхий /рефрижератор/ битүү бүрхүүлтэй зориулалтын автотээврийн хэрэгслээр холбогдох /Хүнсний түргэн гэмтэх, эмзэг бүтээгдэхүүнийг тээвэрлэх. Ангилал. Ерөнхий шаардлага MNS 5343:2003/ стандартын дагуу тээвэрлэнэ,
- Ачааны баглаа, боодол, сав, бэхэлгээ, битүүмжлэлт /лац, ломбо/, хаягийг холбогдох стандарт, техникийн нөхцөлийн дагуу хийсэн байх,
- Ачааг ачиж буулгахад шаардагдах машин механизм, бусад хэрэгсэл болон хүн хүчийг бэлтгэж, зам талбайг чөлөөтэй байлгах,
- Ачааг ачихдаа сайтар бэхлэх, задгай ачаа тээвэрлэхэд унаж, гээгдэхээс хамгаалсан бүтээлэг хэрэглэх, мөн хөдөлгөөний аюулгүй байдал болон ачааны бүрэн бүтэн байдалд нөлөөлөхгүй, автотээврийн хэрэгсэлд эвдрэл, гэмтэл учруулахгүй байх шаардлагыг хангах

Авто тээврийн хуульд заасны дагуу "улс хоорондын тээвэрлэлт" гэж Монгол Улсын хилийг нэвтрэн хийх тээвэрлэлтийг хэлэх ба "Улс хоорондын ачаа, зорчигч тээвэрлэлтийг автотээврийн хэрэгслээр гүйцэтгэх журам"-аар Олон улсын автотээврийн харилцааны тухай Засгийн газар хоорондын хэлэлцээрийг хэрэгжүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулдаг. Тус журамд заагдсан Логистик төвийн тээврийн үйл ажиллагаатай холбоотой анхаарал татсан дараах заалтууд байна.

Ачаа тээврийн хувьд:

- Хоёр улсын хоорондын болон тэдгээрийн нутгаар дамжин өнгөрөх ачаа тээвэрлэлтийг тэдгээр улсад тээвэрлэлт гүйцэтгэх зохих зөвшөөрлийн бичгийн үндсэн дээр гүйцэтгэнэ.



- Түргэн гэмтэх, эмзэг хүнсний бүтээгдэхүүн, аюулгүй ачааг Монгол Улсын болон олон улсын стандартын шаардлага хангасан тусгай зориулалтын тээврийн хэрэгслээр тээвэрлэнэ.
- Тээврийн хэрэгслийн ачаатай болон ачаагүй өндөр нь 3.5м, өргөн 2.5м ачаа нь тээврийн хэрэгслийн арын хашлагаас 2м, нэг чиргүүлтэй тээврийн хэрэгслийн нийт урт нь 20м, хоёр буюу түүнээс дээш чиргүүлтэй мөн механикжсан тээврийн хэрэгсэл чирэх үед ерөнхий урт нь 24 м-ээс илүүгүй, хэрэв илүү бол зөвшөөрөл авна.

3.1.4 Монгол улсын нэгдэн орсон тээврийн олон улсын гэрээ, хэлэлцээр, конвенциуд

Доорх хүснэгтэд Монгол улсын нэгдэн орсон олон улсын бүх гэрээ хэлэлцээрүүдийг үзүүлжээ.

Хүснэгт 3.5 Нэгдсэн орсон олон улсын гэрээ, конвенциуд

Гэрээ, конвенцийн нэр	Байгуулагдсан огноо	Хүчин төгөлдөр болсон огноо	Монгол Улсын нэгдэн орсон огноо
Гаалийн хамтын ажиллагааны холбооны тухай Брюсселийн конвенц	1953		1992
Барааг тодорхойлох, кодлох уялдуулсан системийн тухай Брюсселийн Хэлэлцээр	1988	1988.01.01	1993
Замын хөдөлгөөний тухай Конвенц	1968.11.08	1978.06.06	1997
Замын дохио, тэмдгийн тухай Конвенц	1968	1978.06.06	1997
Норматив баримт бичиг, эталон, хэмжих хэрэгсэл, стандартчилал хийх зорилгоор гадагш гаргах, оруулахад гаалийн хураамж, татвар төлөхөөс чөлөөлөх, түүнчлэн тусгай зөвшөөрөл авахгүй байх тухай Хэлэлцээр	1995		1999
ТИР Карнейг хэрэглэн барааг олон улсын хэмжээнд тээвэрлэх тухай конвенц	1975		2001
Азийн авто замын сүлжээний тухай Засгийн газар хоорондын хэлэлцээр	2004.04.28		2005.04.21
Гаалийн бүрдүүлэлтийн горимыг хялбарчлах, уялдуулах тухай ОУ-ын конвенц	1973.05.18		2006.05.26
Ачааг хилээр нэвтрүүлэхэд хийх хяналт, шалгалтын нөхцөлийг уялдуулах тухай олон улсын конвенц	1982.10.21		2007.05.04
Даацын тэмдэглэгээний тухай 1966 оны олон улсын конвенцийн 1988 оны протокол	1988.11.11		2007.05.04
Транс Азийн төмөр замын сүлжээний тухай хэлэлцээрийг соёрхон батлах тухай			2007.10.18
Барааг түр хугацаагаар оруулах тухай Стамбулын конвенц	1990.06.29	1993.11.27	2007.10.18
Далайд гарцгүй улсын дамжин өнгөрөх худалдааны тухай Нью-Йоркийн конвенц	1965.07.08	1967.06.09	1966.05.11

Эх сурвалж: <http://www.vienna.embassy.mn/index.php?moduls=15>

Төмөр замын тээврийн олон улсын хэлэлцээр

Далайд гарцгүй орны хувьд экспортын бүтээгдэхүүнийг дэлхийн зах зээлд гаргах далайн боомтуудтай болох, Монгол Улсын нутгаар дамжин өнгөрөх тээврийн эргэлтийг



нэмэгдүүлэх нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор уг хэлэлцээрийг байгуулах ажил 9 жил үргэлжилсний эцэст 2018 онд байгуулжээ.

2043 оны 9 дүгээр сарын 07-ныг хүртэл буюу 25 жилийн хугацаанд тогтвортой тарифын хөнгөлөлт эдлэхээр болов. Тухайлбал, нүүрсний тээвэрт Нэгдсэн нэвтрэх тарифаас 66.4 хувь, чингэлэг тээвэрт 52 хувийн хөнгөлөлт эдэлнэ. Ингэснээр уул уурхайн бүтээгдэхүүний экспортын үнийн өрсөлдөх чадварыг хангах нөхцөл бүрдэнэ. Мөн төмөр замаар дамжин өнгөрөх ачааг улсын хилээр нэвтрүүлэх ажиллагааг хөнгөвчлөх нөхцөлийг бүрдүүлэх, ачаа тээврийн өсөлтийг дэмжих, эрчим хүч болон төмөр замын тээврийн суурь бүтцийн хөгжил, харилцан уялдааг хангах замаар Монгол Улсын экспортлогчдод далайд саадгүй гарах нөхцөл бүрдэж байна.

Мөн бусад чиглэлийн дамжин өнгөрөх ачаа тээврийн тарифтай өрсөлдөхүйц байхаар хэлэлцээрт тусгасан байна. Өөрөөр хэлбэл, Монгол Улсаас БНХАУ-аар дамжуулан тээвэрлэж буй ачаа тээврийн тариф буурсан тохиолдол хоёр орны холбогдох салбарынхан тохиролцож, ОХУ-аар дамжих тээврийн тарифыг бууруулах боломжтой аж.

БНХАУ-тай байгуулсан транзит тээврийн хэлэлцээр

Монгол Улс, БНХАУ хооронд зам, тээврийн салбарын харилцаа, хамтын ажиллагааны асуудлаар байгуулсан баримт бичиг

1. Монгол Улс Хятад улсын нутаг дэвсгэрээр далайд гарах болон буцах, дамжин өнгөрөх тээвэр хийх тухай Засгийн газар хоорондын хэлэлцээр
 - Монгол Улсын ашиглах нэр заасан далайн боомтыг тоог нэмэгдүүлж Хойд Хятадын бүс нутаг болон Зүүн Хойд Хятадын бүс нутгийн гадаад худалдаанд нээлттэй Дандонг, Далиен, Жиньжоу, Ингоу, Цинь Хуангдао, Хуанг Хуа, Тяньжин зэрэг нийт 7 боомтыг ашиглахаар болов. Өмнө нь Монгол Улс зөвхөн Тяньжин хотын олон улсын Синьган боомтыг ашиглах гэрээтэй байв.
 - Далайн боомтод хүрсэн Монгол Улсын ачааг гуравдагч улсын хөлөг онгоцоор тээвэрлэх боломжийг бүрэн нээсэн. Өмнө нь зөвхөн Монгол Улс, БНХАУ-ын төрийн далбааг мандуулсан хөлөг онгоцоор тээвэрлэх гэрээтэй байсан. Гааль, НӨАТ-ын татвар төлөхгүй
2. Төмөр замын дамжин өнгөрөх тээврийн хамтын ажиллагааны тухай Засгийн газар хоорондын хэлэлцээр
 - Монгол Улсын бараа бүтээгдэхүүнийг БНХАУ-ын нутаг дэвсгэрээр төмөр замаар дамжуулан тээвэрлэх чиглэл, тоо хэмжээ, тарифын хөнгөлөлт, татвар хураамжийн нөхцөлүүд, тэдгээрийн үйлчлэх хугацаа зэргийг Монгол Улсад маш ашигтай байдлаар тохиролцсон. Монгол Улсын бараа бүтээгдэхүүн БНХАУ-ын нутаг дэвсгэрээр дамжин нэр дурдсан далайн долоон боомтоор дамжин бусад улсад экспортлоход өрсөлдөх чадвартай байхуйц худалдааны нөхцөл, эрх зүйн орчин бүрдсэн.



3. Төмөр замын хамтын ажиллагааг хөгжүүлэх тухай Засгийн газар хоорондын харилцан ойлголцлын санамж бичиг
 - Хоёр улсын хооронд хилийн төмөр замын шинэ боомтууд байгуулахаар тохиролцов,
 - Ази-Европын хооронд хоёр улсын нутаг дэвсгэрээр дамжин өнгөрөх төмөр замын тээврийг идэвхтэй хөгжүүлж, дамжин өнгөрөх тээврийн хэмжээг үлэмж нэмэгдүүлэхэд хамтран ажиллахаар тохиролцов,
 - Төмөр замын тээврийн салбарын боловсрол, судалгаа шинжилгээний чиглэлээр хамтын ажиллагааг хөгжүүлэх, мэргэжилтэн бэлтгэх, мэргэжил дээшлүүлэх, түүнчлэн Монгол Улсад зам, харилцааны их сургууль байгуулах чиглэлээр хамтран ажиллахаар тохиролцов.
4. Монгол-Хятадын хилийн төмөр замын хэлэлцээрийг шинэчлэн байгуулах тухай Монгол Улсын Зам, тээврийн яам, БНХАУ-ын Улсын Төмөр замын газар хоорондын харилцан ойлголцлын санамж бичиг
 - Хоёр улсын хооронд хилийн төмөр замын 4 шинэ гарц байгуулахаар тохиролцож үүнтэй холбоотойгоор 1955 онд хоёр улсын хооронд байгуулсан “Монгол-Хятадын хилийн төмөр замын хэлэлцээр”-ийг шинэчлэн байгуулахаар тохиролцов. Замын-Үүдээс гадна төмөр замын дөрвөн гарцыг Шивээхүрэн, Бичигт, Гашуунсухайт, Нөмрөгт гэсэн боомтуудаар нээхээр хоёр тал тохирсон.

ОХУ-тай байгуулсан транзит тээврийн хэлэлцээр

Монгол Улс, ОХУ хооронд зам, тээврийн салбарын харилцаа, хамтын ажиллагааны асуудлаар байгуулсан баримт бичиг

1. Иргэний нисэхийн салбарт хамтран ажиллах тухай Монгол Улсын Зам, тээврийн яам, ОХУ-ын Тээврийн яам хоорондын протокол
2. УБТЗ-ын шинэчлэл, хөгжлийн стратегийн түншлэлийн тухай Монгол Улсын Зам, тээврийн яам, ОХУ-ын “Оросын төмөр зам” НХН хоорондын хэлэлцээр
 - УБТЗ-ын одоо байгаа коридорыг жилд 100 сая тн хүртэл ачаа тээвэрлэх хүчин чадалтай болгох, ингэхдээ УБТЗ-ыг цахилгаанжуулах, хос болгох,
 - Салхит-Эрдэнэтийн салбар төмөр замын шугамыг баруун хойд чиглэлд үргэлжлүүлэн Монгол Улс, ОХУ-ын хилд хүргэж, ОХУ руу төмөр замын шинэ гарц нээх, улмаар ОХУ-ын Тува улсын Кызылтэй холбосноор ОХУ-ын уул уурхайн бүтээгдэхүүнийг Монголын нутгаар дамжуулан БНХАУ-д гаргах шинэ замнал бий болгох,
 - Монгол Улсын нутаг дэвсгэрээр дамжин өнгөрөх төмөр замын тээвэрлэлтийг нэмэгдүүлэх “Богдхан” төмөр замыг барих, Монгол Улсын



баруун бүс нутгаар дайран өнгөрөх босоо чиглэлийн шинэ коридор байгуулах талаар хамтран ажиллахаар тохиролцов.

- Хамтран ажиллах тухай МИАТ ХК болон “Аэрофлот” компани хоорондын санамж бичиг

Түүнчлэн ОХУ-ын Ерөнхийлөгчийн Монгол Улсад хийсэн ажлын айлчлалын үеэр болж өнгөрсөн хоёр талын уулзалт, хэлэлцээн дээр Монгол Улсын эдийн засагт өндөр ач холбогдолтой дараа тохиролцоонд хүрсэн. Үүнд:

- Монгол Улс БНАСАУ дахь ОХУ-ын хөрөнгө оруулалттай Ражин боомтод хувь эзэмшиж, хамтран ашиглах тохиролцоонд хүрэв. Ингэснээр Монгол Улс анх удаа өөрийн далай боомттой болно.
- Орос, Монгол, Хятад гурван улсыг дамнасан төмөр замын дамжин өнгөрөх тээврийг хөгжүүлэхэд идэвхтэй хамтран ажиллах, Монгол Улсын нутгаар дамжин өнгөрөх ОХУ-аас БНХАУ-ыг чиглэсэн ачаа тээврийн хэмжээг 2015 он гэхэд 6 сая тонн, 2020 он гэхэд 20 сая тоннд хүргэж ажиллахаар тохиролцов.

ОХУ-тай байгуулсан дамжин өнгөрөх хэлэлцээр нь 8 зүйлтэй ба 25 жилийн хугацаанд хүчин төгөлдөр мөрдөгдөхөөр заасан. Хэлэлцээрт дараах зорилтыг хангасан нөхцөлүүдийг тусгажээ.

- Хоёр улсын нутаг дэвсгэрээр төмөр замаар дамжин өнгөрөх ачаа тээвэрт тарифын уян хатан бодлого хэрэгжүүлэх;
- Төмөр замын ачаа тээвэрт бусад чиглэлүүдтэй харьцуулахад өрсөлдөхүйц тарифын нөхцөлийг урт хугацаанд хангах;
- Төмөр замаар тээвэрлэж буй ачааг улсын хилээр нэвтрүүлэх ажиллагааг хөнгөвчлөх нөхцөлийг бүрдүүлэх;
- Хоёр улсын төмөр замын ачаа тээврийн өсөлтийг хөхиүлэн дэмжих;
- Ачаа тээврийн өсөлтийн эрчим болон төмөр замын тээврийн суурь бүтцийн хөгжил харилцан уялдааг хангах;
- Монгол улсын экспортлогчдод далайд саадгүй гарах нөхцөлийг бүрдүүлэх зэрэг болно.

Хүснэгт 3. 6 Төмөр замаар дамжин өнгөрөх нүүрсний тээвэрлэлтэд үзүүлэх хөнгөлөлт

№	Хөнгөлөлтийн төрөл	Үржүүлэх коэффициент	Хөнгөлөлт
1	ННТ-ын 3 дугаар бүлэг “Тээврийн төлбөрийг хураах, тооцох аргачлал”-ын “Тээвэрлэлтийн онцгой нөхцөл” хэсгийн 23 дугаар заалт “Тээвэрлэгчийн эзэмшлийн бус вагоноор ачаа тээвэрлэхэд суурь тарифыг үржүүлэх коэффициент”	0.85	15%
2	Тусгаар Улсуудын Хамтын Нийгэмлэгийн гишүүн орнуудын төмөр замуудын олон улсын харилцаанд ачаа тээвэрлэх тарифын бодлогын хавсралт 3, 1 дүгээр бүлэг “Тарифын хэлэлцээрийн гишүүн төмөр замуудаар дамжин гуравдагч орноос, гуравдагч орон руу ачаа	0.80	20%



№	Хөнгөлөлтийн төрөл	Үржүүлэх коэффициент	Хөнгөлөлт
	тээвэрлэх” /ТУХНАТТБ/, 3 дугаар зүйл “Монгол Улс, БНАСАУ, БНСВУ-аас/руу дамжин өнгөрөх”, 3.1 дэх заалт “Монгол улсаас болон Монгол улс руу Оросын төмөр замуудаар дамжуулан тээвэрлэхэд 2 дугаар ангиллын ачааны тээвэрлэлтэд ННТ-ын суурь тарифыг жингийн нормоос хамааруулан үржүүлэх коэффициент”		
3	“Оросын төмөр замууд” НХН-ийн Ерөнхий хорооны 2017 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн №61 дүгээр хурлын протокол /2018.01.01 – 2018.12.31 хооронд хүчин төгөлдөр/-ын 1 дүгээр хавсралт, 9.3-т “Монгол Улсаас ОХУ-ын төмөр замуудаар дамжуулан тээвэрлэх нүүрсний тээвэрлэлтийн өөрийн эзэмшлийн болон түрээсийн вагоноор гүйцэтгэх, түүнчлэн эдгээр вагоныг хоосноор буцаахад ТУХНАТТБ-ын тарифыг үржүүлэх коэффициент”	0.42	58%

Хүснэгт 3. 7 Төмөр замаар дамжин өнгөрөх чингэлэг тээвэрлэлтэд үзүүлэх хөнгөлөлт

№	Хөнгөлөлтийн төрөл	Хөнгөлөлтийн коэффициент
	Тусгаар Улсуудын Хамтын Нийгэмлэгийн гишүүн орнуудын төмөр замуудын олон улсын харилцаанд ачаа тээвэрлэх тарифын бодлого /2018 онд хүчин төгөлдөр үйлчилнэ./	
	Хавсралт 3, 1 дүгээр бүлэг “Тарифын хэлэлцээрийн гишүүн төмөр замуудаар дамжин гуравдагч орноос, гуравдагч орон руу ачаа тээвэрлэх”, 3 дугаар зүйл “Монгол Улс, БНАСАУ, БНСВУ-аас/руу дамжин өнгөрөх”, 3.2 дахь заалт “Чингэлгийг тээвэрлэлтэд ННТ-ын суурь тарифыг тээврийн зайнаас хамааруулан үржүүлэх коэффициент”	
1	- 1500 км ба түүнээс доош	1.00
	- 1501 – 2000 км	0.85
	- 2,001 – 3,000 км	0.70
	- 3,001 – 4,000 км	0.50
	- 4,001 – 5,000 км	0.30
	- 5,000 км–ээс дээш	0.25
	“Оросын төмөр замууд” НХН-ийн Ерөнхий хорооны 2017 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн №61	
3	2 дугаар хавсралт, хүснэгт №2-ийн 1.1 дэх хэсэгт болон “Оросын төмөр замууд” НХН-ийн Ерөнхий хорооны 2017 оны 12 дугаар сарын 12-ний өдрийн №61 дүгээр хурлын протокол /Наушкиас Беларусь-Польшийн хилийн нэвтрэх цэгүүд хүртэл/ “тээвэрлэгчийн бус хувийн эзэмшлийн тусгай зориулалтын тавцант вагоноор их даацын ачаатай чингэлгийг 57-71 вагоноор бүрдүүлсэн чингэлгийн Оросын төмөр замуудаар дамжуулан галт тэргээр тээвэрлэх”	20 фут- 522 шв.фр, 40 фут-1044 шв.фр

Авто тээврийн олон улсын хэлэлцээр

Одоогоор хүчин төгөлдөр 2 талт ба олон талт дараах автозамын хэлэлцээрүүд байна. Үүнд

1. Авто тээврээр олон улсын зорчигчид, ачаа тээвэрлэх тухай Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Казахстан Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр /1993.10.22



2. Олон улсын авто тээврийн харилцааны тухай Монгол Улсын Засгийн Газар, Украин Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр /1995.06.27
3. Олон улсын авто тээврийн харилцааны тухай Оросын Холбооны Улсын Засгийн газар, Монгол Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр /1996.02.07/
4. Тээврийн салбарт ажиллах тухай Монгол улсын засгийн газар, Бүгд Найрамдах Ардчилсан Солонгос ард улсын засгийн газар хоорондын хэлэлцээр, /1996.05.10/
5. Олон улсын автотээврийн харилцааны тухай Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Турк Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр /2002.06.02/
6. Олон улсын автотээврийн харилцааны тухай Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Беларусь Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр /2003.12.10/
7. Олон улсын автотээврийн харилцааны тухай Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Киргиз Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр /2004.03.01/
8. Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хоорондын автотээврийн хэлэлцээр /2011.06.16/
9. Эдийн засгийн коридор хөтөлбөрийн хүрээнд МУ, ОХУ ба БНХАУ-ын хооронд байгуулсан гуравласан “Азийн авто замын сүлжээгээр олон улсын автотээвэрлэлт гүйцэтгэх тухай Засгийн газар хоорондын хэлэлцээр”, /2018.04.12/

Дээрхээс хамгийн сонирхолтой нь Автотээврийн 3 талт хэлэлцээр бөгөөд энэ хүрээнд дараах АН-4, АН-3 чиглэлийн дараах боомтуудыг олон улсын авто тээврийн боомт болгон хувиргасан. Үүнд:

АН-3 чиглэлээр: (ОХУ) Улаан-Үүд – Хиагт / (Монгол улс) Алтанбулаг – Дархан – Улаанбаатар – Сайншанд – Замын Үүд / (БНХАУ) Эрээн – Бээжингийн гадна тойргоор – Тяньжин

АН-4 чиглэлээр: (ОХУ) Новосибирск – Барнул – Горно Алтайск – Ташанта / (Монгол улс) Улаанбайшинт – Ховд Ярантай / (БНХАУ) Такешикан – Өрөмч – Каши – Хонгираф

Засгийн газар хоорондын энэхүү гурван талт хэлэлцээр байгуулагдсанаар Ази-Европыг хамарсан худалдаа, тээвэр, гааль, татвар, даатгалын асуудлууд хөнгөвчлөгдөх, авто замын дамжин өнгөрөх тээвэрлэлтийг эхлүүлэхтэй холбогдуулан Азийн авто замын сүлжээний АН3 болон АН4 авто замд орчин үеийн дэвшилтэт тоноглол, төлбөр хураах системийг нэвтрүүлэх, олон улсын авто замын дагуу жолооч, зорчигчдын ая тухтай амрах үйлчилгээний цогцолбор, тээврийн хэрэгслийн засвар үйлчилгээний төвүүдийг байгуулах боломж бүрдэнэ.




3.1.5 Монголын транзит тээврийн талаар баримталж буй бодлого

Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын 3.2.2.5-д “Гадаад худалдааны дамжин өнгөрөх тээврийн нөхцөлөөс хэт хараат байдлыг бууруулж, далайд гарцгүй орны хувьд тээврийн салбарт хөрш орнуудтай хоёр болон гурван талын урт хугацааны, харилцан ашигтай хэлэлцээр байгуулна. Эскпортын бүтээгдэхүүнийг дэлхийн зах зээлд гаргах далайн боомтуудтай болох, боомт хүртэл тээвэрлэлтийг оновчтой зохион байгуулах, Монгол Улсын нутгаар дамжин өнгөрөх тээврийн эргэлтийг нэмэгдүүлэх нөхцөлийг бүрдүүлнэ” гэж заасан байдаг.

Далайд гарцгүй орны хувьд дээрх зорилтыг хэрэгжүүлэх яриа хэлэлцээг хөрш орнуудтай 2009 оноос эхлүүлэн идэвхтэй хийж ирсэн бөгөөд БНХАУ-ын Засгийн газартай 2014 онд “Төмөр замын дамжин өнгөрөх тээврийн хамтын ажиллагааны тухай” хэлэлцээрийг байгуулж, шинээр төмөр замын 4 боомт нээх, эдгээр хилийн боомтоор дамжуулан гуравдагч оронд бүтээгдэхүүнээ төмөр замаар дамжуулан экспортлох квот, тэдгээрт тээврийн хөнгөлөлттэй тариф зэрэг нөхцөлүүдийг тохирсон бол 2018 онд “Төмөр замаар дамжин өнгөрөх ачаа тээвэрлэх нөхцөлийн тухай Монгол Улс, ОХУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээр”-ийг байгуулж мөрдөгдөж эхэлсэн.

Зураг 3. 4 Транзит тээврийн коридорууд ба гадна холболтууд



Эх сурвалж: Жайка, Үндэсний цогц төлөвлөгөө-2021

Дээрх хэлэлцээрүүдийн хүрээнд Монгол улс транзит тээврийн 3 коридорыг бий болгож олон улсад зарласан. Үүнд:

Зүүн Коридор: Эрэнцав – Бичигт чиглэлийнх, энэ чиглэлд зөвхөн Төмөр замын тээвэр төлөвлөгдсөн. Одоогоор энд Эрэнцав – Чойбалсан чиглэлийн 210 км төмөр зам байна. нэмж Чойбалсан-Хөөт-Бичигт/Нөмрөг чиглэлд 1400 км зам барих шаардлагатай,



Баруун Коридор:	Алтанбулаг – Замын Үүд чиглэлийнх, энэ чиглэлд Автозамын ба Төмөр замын тээвэр төлөвлөгдсөн. Энд одоогоор зөвхөн автозамын АН-4 сүлжээ баригдаж байгаа ба төмөр замын сүлжээ байхгүй байна. Энэ чиглэлд Арцсуурь – Бургастай чиглэлийн 850 км төмөр замын сүлжээ, Улаанбайшинт–Ярантай чиглэлийн 725 км автозамын сүлжээ барих шаардлагатай,
Хойд Коридор:	Арцсуурь-Дархан чиглэлийн 800 км, энэ чиглэлд зөвхөн Төмөр замын тээвэр төлөвлөгдсөн. Үүнээс одоогоор Дархан-Эрдэнэтийн 20 км төмөр зам байгаа ба Эрдэнэт-Арцсуурь чиглэлийн 780 км төмөр зам шинээр барих шаардлагатай,
Төв коридор:	Алтанбулаг/Хиагт – Замын Үүд чиглэлийнх, энэ чиглэлд Автозамын ба Төмөр замын тээвэр төлөвлөгдсөн. Одоогоор энд Хиагт – Замын Үүд чиглэлийн төмөр замын УБТЗ-ын 1100 км төмөр зам, Алтанбулаг–Замын Үүд чиглэлийн АН-3 автозамын сүлжээ байна. Шинээр тус коридорт туслах чиглэлээр Сайншанд-Ханги чиглэлийн 281 км төмөр замын сүлжээ төлөвлөгдсөн,

Төмөр замын транзит тээвэр, авто замын транзит тээвэр, тэдгээрийн хооронд ачаалал хуваарилсан, транзит ачаа тээврийн талаар баримталж буй одоо хүчин төгөлдөр нэгдсэн бодлогын баримт бичиг үгүй байгаа өнөөгийн нөхцөлд бид транзит тээврийн талаар зөвхөн таамаглал дэвшүүлэх боломжтой байна. Транзит тээврийн талаар баримталж буй бодлогуудыг дээрх бүх нөхцөл байдлуудаас авч үзэн төв, баруун ба зүүн коридоруудын хөгжил, нэн ялангуяа Шинэ Зуунмод хот орчмоор дамжин өнгөрөх тээврийн ачааллыг харвал:


- Төв коридор нь ОХУ-аас чиглэлтэй тээврийн ачааллаа Хойд коридор болон Алтанбулаг чиглэлээс авах ба Дархан-Улаанбаатар-Сайншанд чиглэлд сүлжээний ачаалал 100 саяд хүрэх хэтийн төлөвлөгөөтэй,
- Баруун ба Зүүн коридорууд нь бүхэлдээ нурмаг ачаа болон овор ихтэй задгай ачааг тээвэрлэх буюу үйлдвэрлэлийн түүхий эдийг тээвэрлэх бөгөөд түүхий эд нийлүүлэгч нь ОХУ болон Монгол байх тул тус 2 коридорын ачааллыг бүхэлдээ урагш чиглэлтэй гэж үзэж болно.
- Төв коридорын Дархан хүртэлх төмөр зам нь Хойд Коридороос 30 сая тн, Хиагт чиглэлээс 70 сая тн ачаалал авах ба Сайншанд Хүртэл 100 сая тн ачаалалтай байхаар тооцогдох боломжтой,
- ОХУ-ын Тувагийн Элегест ордын транзит тээврийн 47 сая тн нүүрсний ачааллыг $\frac{1}{3}$ хувиар Хойд ба Баруун коридорт хувааж ачаалал өгнө гэж тооцож байна. Ингэснээр Хойд коридор нийтдээ 30 сая тн ачааны урсгалтай болох ба үүнээс урагш чиглэлд 28 сая нь нүүрс (Элегест 16 сая тн, Овоот орд 12 сая тн) 1 сая нь бусад ачаа, 1 сая нь буцах урсгал байна. Өөрөөр хэлбэл Хойд урсгал нь урагш чиглэлд 29 сая тн ачаа, буцах чиглэлдээ 1 сая тн ачааны тээвэртэй байна.
- Энэхүү 28 сая тн-ын нүүрс нь урагш хил нэвтрэхдээ Сайншанд-Ханги чиглэлд явна. Сайншанд-Ханги чиглэл нь одоогоор дотоодын ба транзит 19.7 сая тн-ын



урагш чиглэлийн ачаа, буцах чиглэлд 1.5 сая тн-ын ачаа авах ба үүн дээр нэмэгдэж 28 сая тн-ын хойд урсгалын нүүрсний тээвэр нэмэгдэнэ.

- Ингэснээр Төв коридорын салаа болох Сайншанд-Ханги чиглэлийн ачааны тээвэр 50 сая тн болох ба үүний 28 сая нь хойд урсгалаас, 20 сая нь төв урсгал ба дотоодоос 2 сая нь буцах урсгалаас ачаагаа авна.
- Баруун коридор нь Тувагийн 3 том нүүрсний уурхайн тээвэрлэлтийг транзитаар тээвэрлэх ба ачаалал нь 50 сая тн байна. Үүнээс нүүрсний транзит нь 35 сая тн (31 сая тн нь *Элегест орд*) байж дотоодын тээвэр 15 сая тн байх төлөвтэй байна. Харин зүүн коридорын хувьд одоогоор төсөөлгүй байгаа ба баруун коридортой ижил хүчин чадалтай байж ОХУ-ын транзит ачааллыг хуваалцана гэж үзэж байна.
- БНХАУ нь транзит тээврээр Европтой холбогдох чингэлэг ачааны хэмжээг Монголоор дамжуулахыг 1 сая TEU буюу 20 сая тн байхаар тооцож байна. Энэ ачаалал 100% Төв коридороор, Замын-Үүд-Сүхбаатар чиглэлээр дамжина гэж үзэж байна.
- Төв коридор нь 2019 оны байдлаар транзит тээврийн 4.2 сая тн-ыг хасвал 11.5 сая тн-ын экспортын, 3 сая тн-ын импортын, нийт 14.5 сая тн-ын дотоодын ачаа Шинэ Зуунмод орчмоор дамжиж байна. Мөн төв коридор нь орон нутгийн ачааны ачаалал 11 сая тн байгаа ба төв коридорын нийт тээвэрлэх хүчин чадал 25 сая тн-ын тээвэрлэх нийт хүчин чадалтай байна.
- Цаашдаа Төв коридор дахь транзит тээвэрт 50 сая тн, дотоодын тээвэр 50 сая тн тус тус болж хэтдээ төв коридор нь 100 сая тн тээх хүчин чадалтай болох ба хойноос урагш чиглэлийн тээвэрлэх ачаалал 60%, урдаас хойш чиглэх ачаалал 40% байхаар байна.
- Мөн төв коридорын дотоодын тээвэрт (*нийт ачааллын 50%*) экспорт-25%, импорт-10%, орон нутаг-15% байх бол, транзит тээвэрт орос-хятадын хооронд 30% (*оросоос хятад руу-25%, хятадаас орос руу 5%*), хятад-европын хооронд 20% тус тус байх хандлагатай байна.
- Бүхэлдээ төмөр замын 3 коридор нь 200 сая тн ачааг тээвэрлэх хүчин чадалтай болох ба үүний 100 сая тн нь төв коридорт, 50 сая тн нь баруун коридорт, 50 сая тн нь зүүн коридорт байх хэтийн төлөвтэй ба транзит тээвэр нь 150 сая тн, дотоодын тээвэр 50 сая тн болох боломжтой
- АН-3 автозамын ачаалал хоногт 11 тн жинтэй 33,000 автомашин (бүх жин нь 300 мянган тн) нэвтрүүлэх хүчин чадалтай баригдаж байгаа ба тус замаар 2040 онд 5 сая тн транзит тээвэр хийгдэх чиг хандлагатай байна. Тус автотээвэр нь зөвхөн Монгол болон ОХУ-ын сибирь ба БНХАУ-ын Өвөрмонголын хоорондын тээвэр байх тул хязгаарлагдмал зориулалтаар ашиглагдана.

Зураг 3. 5 Монголын транзит тээврийн бодлого



Эх сурвалж: Зам тээврийн яам ба Тооцоолсноор

Эдгээр тээврийн замууд нэвтэрвэл транзит тээврийн хүчин чадал 200-300 сая тн-д хүрэх боломжтой болно. Мөн түүнчлэн Монголын нутаг дэвсгэрийн 80% нь төмөр замын сүлжээнд холбогдож тус бүс нутгууд дахь эдийн засгийн үйл ажиллагаа хурдсаж хүн амын амьжиргаа, нийгмийн нөхцөл эрс сайжирна.

3.2 МОНГОЛЫН УЛСЫН ЛОГИСТИК ХӨГЖЛИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

3.2.1 МУ-ын ачаа тээвэр, логистикийн хөгжил

Монгол Улс эдийн засгийн төвлөрсөн төлөвлөгөөт харилцаанаас зах зээлийн харилцаанд шилжих болсноор төрийн өмчийн тээвэр, хангамжийн бааз буюу бараа, түүхий эдийн нийлүүлэлт, тээвэрлэлт, түгээлтийн төвлөрсөн систем задарсан.

Зураг 3. 6 МУ-ын тээвэр, логистик газрын зураг



Зах зээлийн шаардлагаар тээвэр зуучийн үйлчилгээ үүсэж эдүгээ худалдаанд оролцогчдын итгэмжилснээр ачаа тээвэрлэлт, хүргэлтийг зохион байгуулдаг үйлчилгээний нэг томоохон салбар болон хөгжөөд байна. Гэхдээ манай орны тээвэр, логистикийн үйлчилгээний өнөөгийн түвшинг бусад орнуудынхтай харьцуулбал хоцрогдсон хуучин арга, технологид суурилсан байна.

Дэлхийн банк нь ОУ-ын худалдааны үндсэн дэд бүтэц болох логистикийг зөв хөгжүүлснээр ачаа тээвэр, агуулах, хил гаалийн үзлэг, төлбөр тооцооны асуудлуудыг шийдвэрлэх тэргүүлэх ач холбогдолтой гэж үздэг бөгөөд 2007 оноос эхлэн 2 жилд нэг удаа LPI судалгааг гаргадаг болсон. Судалгааны зорилго нь ОУ-ын худалдааны салбарт тулгарч байгаа логистикийн саад бэрхшээлүүдийг ойлгон шийдвэрлэхэд улс орны шийдвэр гаргагчид болон бизнес эрхлэгч нарт туслахад оршдог.

Хүснэгт 3. 8 Монгол улсын Логистикийн гүйцэтгэлийн индекс /LPI/, 2018 он*

Country	Year	LPI Rank	LPI Score	Customs	Infrastructure	International shipments	Logistics competence	Tracking & tracing	Timeliness
Mongolia	2018	130	2.37	2.22	2.10	2.49	2.21	2.10	3.06

* Тайлбар: 2018 оноос хойш 2020 онд гарах ёстой байсан тайлан цар тахлын улмаас гараагүй

Зураг 3. 7 Логистикийн гүйцэтгэлийн индекс /LPI/-ээр байр эзлүүлсэн байдал, 2018 он



2018 2016 2014 2012 2010 2007



Дэлхий банк LPI-ийг хамгийн сүүлд 2018 онд хийсэн байгаа бөгөөд 160 орныг тээвэр логистикийн үйлчилгээний хөгжлийн түвшингээр (дэд бүтэц, гаалийн хяналтын орчинг оруулан) нь харьцуулахад Монгол улс 2.37 оноотойгоор 130 дүгээрт жагссан нь 2016 онд 2.51 оноотой байж 108 дахь байранд байсныг бодвол илүүтэй муудсан байна.

Олон улсын өнөөгийн жишгээс үзвэл, тээвэр логистикийн салбар хөгжлийн 4PL түвшинд хүрч худалдаа, тээвэр, тээвэр зууч, логистикийн үйлчилгээ нь интеграцлагдсан, нэмүү өртөг үүсгэдэг нэгдмэл сүлжээ болон хөгжиж байна. Хувийн хэвшилд суурилсан эдийн засгийн бүтцийн төлөвшил гүнзгийрэхийн хирээр худалдаа, хөрөнгө оруулалт, хамтын ажиллагаа өргөжиж, бизнесийн хөгжлийн олон улсын нийтлэг жишгийг дагах зайлшгүй шаардлага гарч ирж байна.

Хүснэгт 3. 9 Дэлхийн бүс нутгуудийн Логистикийн гүйцэтгэлийн индекс /LPI/-ээр байр эзлүүлсэн байдал, 2018 он

Country	Year	LPI Rank	LPI Score	Customs	Infrastructure	International shipments	Logistics competence	Tracking & tracing	Timeliness
Germany	2018	1	4.20	4.09	4.37	3.86	4.31	4.24	4.39
Region: Europe & Central Asia	2018		3.24	3.04	3.13	3.14	3.21	3.27	3.65
Region: East Asia & Pacific	2018		3.15	3.01	3.05	3.03	3.13	3.18	3.49
Region: Middle East & North Africa	2018		2.78	2.54	2.76	2.73	2.68	2.79	3.19
Region: Latin America & Caribbean	2018		2.66	2.47	2.47	2.69	2.59	2.68	3.05
Region: South Asia	2018		2.51	2.32	2.33	2.48	2.45	2.56	2.90



Region: Sub-Saharan Africa	2018	2.45	2.27	2.20	2.52	2.39	2.50	2.77
----------------------------	------	------	------	------	------	------	------	------

Манай улсын хувьд дэд бүтцийн хөгжил сул, олон улсын тээвэрлэлт хийхэд далайд гарцгүй тул өртөг өндөр, ажиллагаа ихтэй, үүнээс гадна логистикийн мэргэжилтэн дутмаг, логистикийн чиглэлээр нэгдсэн мэдээлэл, хууль эрх зүйн орчин бүрдээгүй, ачаа, барааг тээврийн замд нь хянахад сүүлийн үеийн техник технологиор бүрэн хангагдаж чадаагүй болон гадаад улс орнуудтай нэгдсэн нэг логистикийн сүлжээнд орж чадаагүй зэрэг шалтгаанууд нөлөөлж байна. Монгол банкны валют, эдийн засгийн газрын боловсруулсан бодлогын саналын судалгаанд манай улсын логистикийн зардлын дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь даруй 30 хувьд хүрчхээд байгаа талаар дурдсан байдаг.

Хүснэгт 3. 10 2018 оны логистикийн гүйцэтгэлийн индекс

Эзлэж буй байр	Улс орнууд	LPI	Гаалийн үйлчилгээ	Дэд бүтцийн хүртээмж	ОУ-ын тээвэр	Логистикийн үйлчилгээ, өрсөлдөх чадвар	Тээврийн замналын сонголт	Нийлүүлэлтийн хамрах хугацаа
1.	ХБНГУ	4.20	4.09	4.37	3.86	4.31	4.24	4.39
12.	БНХАУ	3.92	3.81	3.97	3.77	3.93	3.92	4.14
75.	ОХУ	2.76	2.42	2.78	2.64	2.75	2.65	3.31
-	Ботсвана	-	-	-	-	-	-	-
130.	Монгол	2.37	2.22	2.10	2.49	2.21	2.10	3.06

Эх сурвалж: <https://lpi.worldbank.org/international/global/2018>

Дээрх хүснэгтээс харахад БНХАУ LPI-ийн бүхий л гүйцэтгэлээр Монгол улс болон ОХУ-аас дээгүүр үзүүлэлттэй байна. Өөрөөр хэлбэл гааль, хилийн хяналтын үйл ажиллагаа, дэд бүтэц, тээвэрлэлт, логистикийн чадавхын хувьд өндөр үзүүлэлттэй байхад ОХУ ч мөн адил манай улсаас дэд бүтэц, логистикийн чадавх, ачаа тээврийн мэдээллийн үйл ажиллагаа, цаг хугацааны хувьд үзүүлэлтээрээ дээгүүр байна. Дэлхийн эдийн засгийн форумын тэргүүлэх мэргэжилтнүүд 2018 оны Дэлхийн эдийн засгийн худалдааны логистик тайландаа ирээдүйн 8 төрлийн логистикийн чиг хандлагыг тодорхойлсон байна⁸. Үүнд:

1. Логистикийн ур чадварын дутагдал
2. Дэлхийн хэмжээний өртгийн гинжин хэлхээг дахин бүтээх
3. Нийлүүлэлтийн эрсдэл ба сэргэлт (тэсвэртэй байдал)
4. Нийлүүлэлтийн гинжин хэлхээ дижитал хувиргах
5. Нийлүүлэлтийн гинжин хэлхээний тогтвортой байдал
6. Цахим худалдааны (E-commerce) жолоодлогын эрэлтийн гинжин хэлхээ
7. Логистикийн үл хөдлөх хөрөнгө ба дэд бүтэц
8. Хамтын ажиллагааны бизнес модел

Далайд гарцгүй манай улсын хувьд хэдийгээр логистикийн салбарын үзүүлэлтээр Африкийн далайд гарцгүй орнуудын түвшинд байгаа ч нэг ялгаатай зүйл нь гадаад худалдааны голлох түнш, хөрш орон БНХАУ нь логистикийн салбарын үзүүлэлтээр дэлхийд

⁸ <https://openknowledge.worldbank.org/bitstream/handle/10986/29971/LPI2018.pdf>, сүүлд нэвтэрсэн огноо 24.10.2019



Итали, Өмнөд Африк, Португал, Малайз, Турк улсуудтай нэг түвшинд буюу дэлхийд 26-д эрэмбэлэгдэж байгаа юм. Энэ нь хэрвээ бид дотооддоо тээвэр, логистикийн салбараа хөгжүүлж чадвал, мөн тэр түвшинд ойртох боломж байгааг илэрхийлж байна. Үүнийг хөгжүүлэхийн тулд логистикийн гүйцэтгэлийн индексийн 6 үзүүлэлт тус бүрийг сайжруулах юм. Эдгээр нь:

1. Логистик үйлчилгээний чанар, өрсөлдөх чанар
2. Гурван талт логистикийн үйлчилгээ
3. Агуулахын технологиуд /кросс докинг, логистик төв/
4. Мэдээлэл, харилцаа холбооны технологиуд
5. Чадварлаг боловсон хүчний сургалт
6. Логистик үйлчилгээний төрөлжүүлэлт, хөгжүүлэлт

Монгол Улсын онцлогт тохирсон үзүүлэлтээс дурдвал дараах 3 үзүүлэлт байна. Үүнд:

1. Далайн боомт хүртэлх тээвэр, логистикийн коридорын зохион байгуулалт /хөрш оронтой байгуулсан дамжин өнгөрөх хэлэлцээр/
2. “Хилийн менежмент” /тухайн хилийн боомт дээр хөрш орны ижил төстэй байгууллагуудтай ижил төстэй үйл ажиллагаа нэгтгэн жигдрүүлэх/
3. УБ хотоос орон нутагт бараа, үйлчилгээ хүргэх тээвэр, логистикийн үйлчилгээний чанар /хугацаа, технологийн тээвэрлэлт, үнэ/

Эдийн засгийн өсөлт хөгжил хурдсаж, зах зээлийн эрэлт, орлого нэмэгдсэнээр уул уурхай, дотоодын үйлдвэрлэл, дэд бүтэц, барилга зэрэг бүтээн байгуулалтын олон төслүүд хэрэгжиж, тэр хэмжээгээрээ тээвэрлэлт, логистикийн үйлчилгээний эрэлт нэмэгдсээр байна. Монголд 3 талт болон 4 талт логистикийг ашиглаж буй туршлагаас авч үзвэл:

- ✗ Аж үйлдвэрийн төслүүд нь цаг хугацаа, зардал, нөөцийн хуваарилалт болон олон өндөр эрсдэлүүдийн дунд ажилладаг.
- ✗ Логистик зохион байгуулалт нь төслийг амжилттай хэрэгжүүлэхэд маш өндөр нөлөөтэй.
- ✗ Логистикийг буруу зохион байгуулбал маш их зардалтай, эрсдэлтэй, цаг хугацааны хоцрогдол, үйл ажиллагаа болон санхүүгийн хувьд төсөөлшгүй их эрсдэл дагуулах эрсдэлтэй байдаг.
- ✗ Аливаа төсөл үйл ажиллагааг 3 талт болон 4 талт логистикийг ашиглан зохион байгуулснаар бүх логистик арга хэмжээг бүхэлд нь мэргэжлийн хүмүүсээр хийлгэж, хамгийн ашигтай нөөцийн хуваарилалт хийх боломжтой болдог.
- ✗ 3 талт болон 4 талт логистикийг ашигласнаар өндөр ашигтай, эрсдэл багатай, хүн нөөцийн бага зардлаар, цаг хугацаандаа өндөр бүтээмжтэй байх давуу талтай.



- Дэлхий даяар төслийн менежментийг амжилттай зохион байгуулахад 3 талт болон 4 талт логистикийг алхам бүрт ашиглаж өндөр үр дүн гарган ажилласаар байна

3.2.2 Тээврийн нэгдсэн үзүүлэлт

Нийт ачаа тээврийн бүтэц

Манай улс 2021 онд бүх төрлийн тээврээр 49.2 сая тонн ачаа тээвэрлэж, ачаа эргэлт 20,675 сая тонн километрт хүрэв. Тээсэн ачаа нь Ковид-19 цар тахал гарахаас өмнөх 2019 онтой харьцуулахад 29% орчим буурсан ба 2021 онд тээсэн ачааны 63.4 хувь нь төмөр замын тээвэр, 36.5 хувь нь авто тээвэр, 0.01 хувь нь агаарын тээврээр тээж өмнөх жилтэй харьцуулахад авто тээвэр буурсан, төмөр зам ба агаарын тээвэр өссөн үзүүлэлттэй байна.

Зураг 3. 8 Тээврийн нэгдсэн үзүүлэлт



Эх сурвалж: ҮСХ, www.1212.mn

Аливаа тээврийн үйлчилгээ өөр өөрийн гэсэн сул болон давуу талтай байдаг бөгөөд төмөр замын тээвэр нь бага зардлаар олон тооны зорчигч, их хэмжээний ачааг холын зайд тээвэрлэхэд тохиромжтой байхад агаарын тээвэр нь богино хугацаанд өндөр зардалтайгаар, хязгаарлагдмал тээвэрлэлтийг гүйцэтгэдэг. Харин авто тээврийн үйлчилгээ хаалганаас хаалганд хүргэх, богино болон дундын зайд үйлчилгээ үзүүлэхэд илүү тохиромжтой байсаар байна.

Хүснэгт 3. 11 Тээвэрлэлтийн бүтэц, тээврийн төрлөөр

	2010	2011	2012	2013	2014	2015	2016	2017	2018	2019	2020	2021
Төмөр замын	57.1	41.8	40.4	49.7	47.3	59.5	49.5	42.2	38	40.8	49.5	63.5
Авто	42.9	58.1	59.6	50.3	52.7	40.5	50.5	57.8	62	59.2	30.4	36.5
Агаар	0.01	0.01	0.01	0.01	0.01	0.01	0.01	0.01	0.01	0.01	0.002	0.001

Эх сурвалж: ҮСХ, www.1212.mn



Хөрөнгө оруулалт

Тээврийн салбарт 2020 онд гадаадын болон дотоодын эх үүсвэрээс 297.4 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтыг хийжээ. Энэ нь нийт хөрөнгө оруулалтын 1.9 хувийг эзэлж байгаа бөгөөд өмнөх оноос 1.6 пунктээр буурсан байна.

Хүснэгт 3. 12 Хөрөнгө оруулалтын салбарын бүтэц, хувиар


Бүтэц %	2016	2017	2018	2019	2020
Бүгд	100	100	100	100	100
Тээврийн үйл ажиллагаа	2.3	2.1	2.3	3.4	1.9
Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур	1.2	0.9	1	0.8	0.4
Уул уурхай, олборлолт	16.6	43.4	41.9	48.6	40.9
Боловсруулах үйлдвэрлэл	6.7	1.9	9	3.8	2.7
Барилга	20.6	9.2	8.3	6.9	7.0
Бусад	52.7	42.5	37.6	36.5	47.1

Эх сурвалж: МУ-ын тээвэр салбар-2020

Сүүлийн 10 жилийн байдлаар тээвэр ба агуулахын салбарт 2019 онд 522.8 тэрбум төгрөг, 2012 онд 510.5 тэрбум төгрөг, 2011 онд 280.1 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийсэн нь хамгийн их хөрөнгө оруулалт хийсэн жилүүд байна.

Хөрөнгө оруулалтыг технологийн бүтэц талаас нь авч үзвэл 2020 онд 1985.1 тэрбум төгрөгийн тээврийн хэрэгслийн хөрөнгө оруулалт оруулж, энэ нь өнгөрсөн оноос 29.3 хувиар буурсан үзүүлэлт болж байна. Тээврийн хэрэгслээр хийгдсэн хөрөнгө оруулалтын дийлэнх нь уул уурхай, газар тариалан, барилгын салбарт өндөр хувийг эзэлж байна.

Зураг 3. 9 Тээврийн хэрэгслийн хөрөнгө оруулалт, дүнд эзлэх хувиар



Эх сурвалж: МУ-ын тээвэр салбар-2020



Хүснэгт 3. 13 Бүх төрлийн тээврийн үндсэн үзүүлэлт, улсын дүн, жилээр

Үзүүлэлт	2010	2011	2012	2013	2014	2015	2016	2017	2018	2019	2020	2021
Тээсэн ачаа, мянган тонн	29,415.91	44,085.95	50,644.29	42,361.41	44,636.18	32,197.30	40,400.20	53,983.40	67,802.88	68,997.51	60,297.70	49,238
төмөр замын	16,804.03	18,447.74	20,445.19	21,035.47	21,118.59	19,150.80	19,989.10	22,765.10	25,763.30	28,143.00	29,840.10	31,261.36
авто	12,610.23	25,635.28	30,195.09	21,321.86	23,514.15	13,043.70	20,406.20	31,212.90	42,033.78	40,848.75	30,454.90	17,970.30
агаарын	1.64	2.93	4.01	4.08	3.44	2.80	4.90	5.37	5.75	5.76	2.70	6.43
усан замын												
Ачаа эргэлт, сая тонн км	12,124.83	16,336.73	15,656.36	14,641.92	17,419.52	13,844.30	16,619.40	19,167.80	21,969.51	23,601.78	23,861.00	20,675
төмөр замын	10,286.70	11,418.75	12,142.74	12,076.53	12,473.69	11,462.60	12,371.00	13,493.30	15,315.30	17,384.10	19,167.60	18,345.08
авто	1,833.95	4,910.29	3,503.88	2,555.79	4,936.43	2,374.00	4,236.20	5,661.30	6,640.61	6,203.78	4,685.30	2,313.92
агаарын	4.17	7.69	9.74	9.59	9.40	7.70	12.20	13.20	13.60	13.90	8.10	15.56
усан замын												
Зорчигчдын тоо, сая хүн	250.66	296.18	317.97	307.94	344.18	260.30	264.40	216.10	197.01	173.02	126.52	107.11
төмөр замын	3.52	3.83	4.00	3.76	3.31	2.80	2.70	2.63	2.60	2.95	1.97	0.35
авто	246.74	291.76	313.16	303.38	340.15	256.50	260.70	212.20	193.00	168.44	124.10	106.53
агаарын	0.40	0.57	0.77	0.78	0.68	1.00	1.00	1.25	1.40	1.62	0.45	0.20
усан замын	0.01	0.01	0.04	0.03	0.04	0.10	-	0.02	0.01	0.01	-	0.02
Зорчигч эргэлт, сая хүн км	3,607.51	4,695.44	4,972.41	4,604.23	5,235.44	4,931.60	4,988.50	5,434.69	6,598.08	7,146.18	3,416.87	1,563.44
төмөр замын	1,220.03	1,399.69	1,485.40	1,394.44	1,194.49	996.70	955.50	973.20	993.70	1,111.50	579.30	90.66
авто	1,480.20	2,321.60	2,263.11	1,897.47	2,793.04	1,940.50	1,959.90	2,040.90	2,919.90	2,925.09	2,178.00	1,023.01
агаарын	907.24	973.90	1,223.13	1,311.81	1,247.08	1,993.50	2,072.40	2,420.20	2,684.20	3,109.40	659.57	449.37
усан замын	0.04	0.25	0.76	0.51	0.82	0.90	0.70	0.39	0.28	0.19	-	0.40
Тээврийн нийт орлого, тэрбум ₮	593.60	854.79	1,041.15	1,045.01	1,038.34	987.90	1,191.50	1,422.20	1,754.40	2,003.52	1,498.58	1,380.71
төмөр замын	306.92	390.89	416.52	421.42	427.86	387.90	436.90	530.00	616.02	708.62	770.10	766.34
авто	172.19	299.31	417.55	376.15	363.75	345.10	467.20	506.40	695.86	796.06	564.38	413.90
агаарын	114.48	164.46	206.91	247.29	246.20	254.30	287.30	385.50	442.30	498.68	164.10	200.06
усан замын	0.01	0.13	0.16	0.15	0.53	0.60	0.20	0.30	0.20	0.16	-	0.41

Эх сурвалж: YCX, www.1212.mn




Салбарын орлого

Тээврийн салбарын нийт орлого 2019 онд 2 их наяд төгрөг, 2020 онд 1.5 их наяд төгрөг, 2021 онд 1.4 их наяд төгрөг тус тус болсон ба цар тахлын улмаас жилдээ 10 гаруй хувиар өсдөг байсан тээврийн салбарын орлого 31% буурсан үзүүлэлттэй байна. Салбарын нийт орлогын 56% нь төмөр замын, 30% нь авто тээврийн 14% нь агаарын тээврийн орлого байсан.

Тээврийн салбарын орлого буурахад автотээврийн салбарын орлого 48% буурсан, агаарын тээврийн орлого 60% тус тус буурснаас болсон.

Зураг 3. 10 Тээврийн салбарын орлого, тээврийн төрлөөр, тэрбум төгрөг




Эх сурвалж: ҮСХ, www.1212.mn

Зорчигчид

2021 онд тээвэрлэсэн нийт зорчигчийн 99%-ийг автотээврээр тээвэрлэсэн нь 2019 оныхоос 2 пунктээр өссөн. Цар тахлын нөлөөгөөр төмөр замын ба агаарын тээврийн зорчигчид эрс буурсан.

Зураг 3. 11 Нийт зорчигчид, тээврийн төрлөөр



Эх сурвалж: ҮСХ, www.1212.mn



Ажлын байр ба ажиллагсад

Тээвэр, логистикийн салбарт 2021 оны байдлаар 2.1 мянган аж ахуйн нэгж үйл ажиллагаа явуулж 67193 ажилтан ажиллаж байна. Нийт ажил олгогчдын 84% нь 1-9 ажилтантай жижиг аж ахуйн нэгжүүд байна. Үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдийн хувьд эдгээр жижиг компаниуд илүү ихээр бий болж байна.

Хүснэгт 3. 14 Логистикийн салбарын үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж байгууллагууд

Үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж байгууллагууд	Ажилчдын тооны бүлэг	2019	2020	2021
МУ-д үйл ажиллагаа явуулж буй ААНБ	Бүгд	94,425	95,950	96,336
Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа эрхлэгчид	Бүгд	1,652	1,895	2,101
	1-9 ажилтантай	1,361	1,546	1,768
	10-19 ажилтантай	98	100	102
	20-49 ажилтантай	98	103	101
	50+ ажилтантай	95	146	130

Эх сурвалж: ҮСХ, www.1212.mn

Хүснэгт 3. 15 Логистикийн салбарын ажилчид

Ажиллах хүчин	2019	2020	2021	Эзлэх хувь
Улсын дүн	61,123	66,541	67,193	100%
Баруун бүс	5,865	3,951	12,533	19%
Хангайн бүс	7,034	5,642	7,981	12%
Төвийн бүс	13,415	10,517	13,318	20%
Зүүн бүс	1,446	4,852	2,984	4%
Улаанбаатар	33,363	41,579	30,377	45%

Эх сурвалж: ҮСХ, www.1212.mn

Баруун бүсэд логистикийн салбарын ажиллагсдын 19% байгаа нь Улаанбаатар болон Төвийн бүсийн дараа орох дундаж үзүүлэлт юм.

3.2.3 Монгол Улсын тээврийн сүлжээ, бараа бүтээгдэхүүний нийлүүлэлтийн гинжин хэлхээ

Үндэсний тээвэр, логистикийн сүлжээний судалгаа

Монголын логистикийн холбоо 2018 онд Зам, тээвэр хөгжлийн яамны захиалгаар “**Үндэсний тээвэр логистикийн сүлжээ байгуулах бодлогын судалгааг**” боловсруулан логистикийн сүлжээний зураглалыг бэлэн болгосон байна. Уг судалгаанд төлөвлөж буй логистик төв, терминалын байршил, хөрөнгө оруулалт ангилан жагсаасан бөгөөд Увс аймагт махны хөргөлттэй агуулах, хүнсний ногооны зоорь, зорчигч үйлчилгээний цогцолбор, барилгын материалын терминал байгуулахаар төлөвлөжээ.

Зураг 3. 12 Үндэсний тээвэр логистикийн сүлжээ 2018 он



Эх сурвалж: <http://nda.gov.mn/backend/files/i2rHHsC31S41XKb.pdf>


Монгол Улсын тээврийн сүлжээ, бараа бүтээгдэхүүний нийлүүлэлтийн гинжин хэлхээ

Хэрэглээний бараа бүтээгдэхүүнээ голчлон импортолдог манай улсын хувьд гадаад худалдаа, тээвэр, логистикийн асуудал ихээхэн чухал юм. Одоогийн байдлаар гадаад худалдаа, тээврийн үйл ажиллагаанд төмөр замыг дагасан ганц босоо тэнхлэг голлох үүргийг гүйцэтгэж байгаа билээ. Энэхүү босоо тэнхлэгийг дагасан импортын нийлүүлэлтийн гинжин хэлхээнд Улаанбаатар хот гол байр суурийг эзэлж байна. Учир нь импортын бараа бүтээгдэхүүн Улаанбаатар хотод бууж тэндээсээ бусад аймгууд руу тээвэрлэгдэж байна.

Зураг 3.13 Монгол Улсын импортын нийлүүлэлтийн гинжин хэлхээ

Эх сурвалж: Азийн хөгжлийн банк

Дээрх үйл явц ерөнхийдөө хялбар харагдах хэдий ч нарийвчлан судалбал нийлүүлэлтийн гинжин сүлжээнд бүтээмж багатай шат дамжлага олон байна. Бараа бүтээгдэхүүний тээвэрлэлт, зардал тухайн бүтээгдэхүүний зах зээлийн үнэд шууд шингэх тул хэрэглэгчдийн өдөр тутмын амьжиргаанд нөлөөлнө.





Тээвэрлэлтийн хугацаа урт, хүлээн авагчид хүрэх хуваарь тодорхойгүй байгаагаас хэрэглэгчийн төлөх үнэ өсөх сөрөг үр дагавартай.

Тяньжинь боомтоос Улаанбаатар хот руу төмөр замаар чингэлэг тээвэрлэхэд нийт 1,700 км-ийг 10-15 хоногт туулна. Үүнтэй харьцуулахад, Антверп эсхүл Роттердам боомтоос Москва хот руу төмөр замаар чингэлэг тээвэрлэхэд 2,500 км зам туулах хэдий ч ердөө 7-8 хоног шаардагдаж байна.⁹ Импортолсон болон дотоодод үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүнийг хэрэглэгчид хүргэх дотоод тээвэр, логистикийн хувьд олон улсад логистикийн 5, 6PL сүлжээгээр үйл ажиллагаа явуулж байгаа бол Монгол Улсад одоогийн байдлаар үйлдвэрлэгчээс худалдааны газрууд руу бараа бүтээгдэхүүнийг шууд тээвэрлэх 2PL систем болон үйлдвэрлэгчээс бараа бүтээгдэхүүнийг аваад сав, баглаа боодлыг хийгээд, агуулахад хадгалаад, тээвэрлэн худалдааны газруудад хүргэх 3PL систем үйлчилж байна.

Логистикийн гинжин хэлхээг, шат дамжлага нэмэгдэхийн хэрээр, нийлүүлэлтийн хугацаа уртсаж хэрэглэгчид үнэ нэмэгдэж байдаг. Иймд аль болохоор бараа нийлүүлэх шат дамжлагыг бууруулан иргэдэд хүргэх нь хамгийн чухал болно. Үүнийг бид бүхэн маш сайн мэдэж ойлгож байдаг. Тухайлбал махыг малчнаас шууд авах, ногоог ногоочдоос шууд авахад мах ногоо шинэ, цэвэр бөгөөд зах зээл болон дэлгүүрийн үнээс хамаагүй хямд байдаг. Энэ давуу байдлыг ашиглан зарим аж ахуйн нэгж, жижиглэнгийн дэлгүүр болох Э-Март хамгийн хямд төмс, байцааг худалдаалж, Талын Монгол брэнд малчны хотноос махыг хүргэж эхэлсэн хамгийн хямдаар шинээр нь махыг хүргэж өгч байна. Намар Улаанбаатар хотод сүү цагаан идээний болон ногооны зах зохион байгуулдаг нь ногоочид ногоогоо хямд үнээр борлуулах, иргэд хүссэн ногоогоо шат дамжлагагүй шинэ ногоо хамгийн хямдаар худалдан авах боломжтой болдог.

Импортын барааны хувьд логистикийн нэгдсэн төв байгуулснаар тээвэрлэлтийн гинжин сүлжээг бууруулснаар, шат дамжлага, хугацаа буурч зардлыг бууруулах болно. Чингэлгийг ачиж буулгах давтамж цөөрөхөөс гадна нийт үйл ажиллагааны бүтээмж сайжирч, сул зогсолтыг бууруулах тул тээвэр, логистикийн дэд бүтцийн хүчин чадлын ашиглалт нэмэгдэнэ. Ачаа тээврийн урсгалыг нэг цэгт төвлөрүүлэх нь чингэлгийн ашиглалтыг сайжруулж, цуглуулбар ачааг цөөлөх ач холбогдолтой. Логистикийн төв чингэлэг ачиж буулгах давтамж цөөрөх тул өртөг зардал буурахаас гадна эцсийн хэрэглэгчид хүрэх хугацаа хэмнэгдэх, зардал буурна.


Логистикийн гинжин хэлхээ багасаж, бараа нийлүүлэлт хурдсахын хэрээр эдийн засгийн гүйлгээний урсгал, шилжилтийг дэмжиж байдаг. Бараа эргэлтийн хурдан болж, хэмжээ нэмэгдэх нь үйлдвэр, аж ахуй нэгж, иргэдийн бүхий л бараа, үйлчилгээний худалдаанд хамгийн чухал үйл ажиллагаа юм. Энэ нь цаашлаад макро эдийн засгийн талаасаа хэрэглэгчид очих бүтээгдэхүүний өргөн хэрэглээний барааны үнэ тогтвортой байлгах, бууруулах, бараа эргэлт нэмэгдэхийн хэрээр бизнесийн ашгийг өсгөж дээшлүүлж, татварын орлогыг тогтвортой байлгах, нэмэгдүүлэх ач холбогдолтой юм.

Иймээс логистикийн системийг оновчтой төлөвлөх, тээвэр логистикийн төв бий болгох, логистикийн үйл ажиллагааны үр ашгийг дээшлүүлэх нь бүхэл эдийн засгийн хувьд маш өндөр ач холбогдолтой юм. Логистикийн төв нь чингэлгийн нийлүүлэлтийн гинжин сүлжээнд ямар үр нөлөө гарч болохыг харуулав. Бараа бүтээгдэхүүний нийлүүлэлтийн гинжин хэлхээний чухал хэсэг болох түүхий эдийн нийлүүлэлтийн гинжин хэлхээг махны түүхий эд болон хүнсний ногооны сүлжээг жишээ болгон доорх зургуудад үзүүлэв.

⁹ Саад тотгорыг арилгах нь: Монгол Улсын тээвэр, логистикийн салбарын хөгжлийн тухай, 2018 он




Зураг 3. 14 Монгол Улсын тээвэр, логистикийн сүлжээний зураглал



Эх сурвалж: Нью Урбанизм ХХК

Зураг 3. 15 Махны түүхий эдийн нийлүүлэлтийн гинжин хэлхээ



Эх сурвалж: Нью Урбанизм ХХК


Тогтсон логистикийн сүлжээгүй Монгол улсад ХАА-н гаралтай бүтээгдэхүүний үнэнд тээврийн зардал төдийгүй бүтээгдэхүүн бэлтгэн нийлүүлэлтийн зардлын эзлэх хувь хэмжээ маш их байдаг. Түүнээс гадна, зуучлагч компанийн зардал, алсын зайнаас тээвэрлэгдэх боловсруулаагүй бүтээгдэхүүн муудаж хаягдал бүтээгдэхүүн болох гэх зэргийн зардал ч ордог. Ялангуяа, боловсруулаагүй бүтээгдэхүүний тухайд авч үзвэл, ердийн температураар тээвэрлэх үед ууршилтаас үүдэх нэгж хүндийн жинд ногдох борлуулалтын үнийн өсөлтийн асуудал байдаг. Тиймээс Монгол орныг бүхэлд нь хамрах тээвэрлэлтийн систем (хөргүүртэй тээвэр орно)-ийг бий болгох ажлыг түргэвчлэх хэрэгтэй.

Тухайлбал, тусдаа салангид байгаа бараа бүтээгдэхүүнийг бэлтгэн нийлүүлэлтийн газруудыг нэгдсэн төвд төвлөрүүлж, хадгалалтын зоорь бүхий бүтээгдэхүүний хаб төвийг орон нутаг тус бүрт байгуулж, улмаар (бүтээгдэхүүний төрлөөс шалтгаална) нийт тээврийн зардлыг хамгийн бага түвшинд байлгах газарт логистик төвийг байгуулах шаардлагатай. Улмаар дээр дурдсан бүтээгдэхүүн бэлтгэн нийлүүлэлтийн хаб төв, логистик төвтэй болон



хэрэглээний бүс болон хилийн экспорт, импортын тулгуур төвтэй холбох тээврийн системийг байгуулж, хөгжүүлэх нь зүйтэй гэж үзжээ.¹⁰

Зураг 3. 16 Хүнсний ногооны өртгийн сүлжээний зураглал¹¹



Эх сурвалж: Нью Урбанизм ХХК

Ачаа тээвэрлэлтийн тухайд, Монгол улс дотооддоо төвлөрсөн логистикийн систем байхгүй ба ачааны машинд тавих хяналт сул байгаагаас үүдэн, хөдлөх ба хүрэх газрын мэдээлэл бүхий ачаа тээврийн талаарх ерөнхий мэдээлэл байхгүй байгааг юун түрүүнд дурдах нь зүйтэй. Улмаар, даац хэтрүүлсэн ачааны машинд авах арга хэмжээ сул, ачааны машины жолоочийн хөдөлмөрийн аюулгүй байдал, даатгалын тогтолцоо, зам тээврийн аюулгүй байдлын хяналт шалгалтын тогтолцоогүй, нэгдсэн хууль эрхзүйн орчин бүрдээгүй, хэрэгжилт хангалтгүй байгаа гэх зэрэг шийдвэрлэхүйц асуудлууд байна.


Макро эдийн засгийн бодлогоор улсын төсөв, санхүүгийн тогтолцоо тогтворжихын зэрэгцээ хэрэглээ, хөрөнгө оруулалт өргөжиж, зам тээвэр, эрчим хүч зэрэг дэд бүтцийг бий болгосноор аж үйлдвэрийн төвлөрөл, логистикийн үндэс суурийг бий болгоно. Ийм үндэс суурийг ашиглан боловсруулах үйлдвэрийг хөгжүүлэх зэргээр аж үйлдвэрийг төрөлжүүлж, нэмүү өртгийг бий болгон, уул уурхай болон бусад салбарын экспортыг нэмэгдүүлж, аялал жуулчлалыг хөгжүүлэх зэргээр аж үйлдвэрийн голлох салбаруудын өсөлтийг дэмжих нь Монгол улсын тогтвортой, тасралтгүй хөгжлийн хувилбар юм.¹²

Зураг 3. 17 Ачаа тээвэрлэлтийн үндсэн зураглал

¹⁰ ЖАЙКА, “Монгол улсын бүсчилсэн хөгжлийн нэгдсэн судалгаа”, 2016 он

¹¹ АХБ, “Монгол Улсын хүнсний ногооны үйлдвэрлэлийн өртгийн сүлжээ”, 2020 он

¹² ЖАЙКА, “Монгол улсын бүсчилсэн хөгжлийн нэгдсэн судалгаа”, 2016 он




Эх
сурвалж: Нью Урбанизм ХХК

Монгол Улсын логистикийн сүлжээнд Улаанбаатар хотын гүйцэтгэж буй үүрэг

Улаанбаатар, Эрдэнэт, Дархан хотууд болон тэдгээрийн ойр орчмын бүс нутаг бол Монгол Улсын хүн амын харьцангуй нягтрал ихтэй газар нутаг юм. Эдгээр бүсэд хүн амын нягтралаас улбаалж дотоодын ачаа тээврийн хөдөлгөөн ихээхэн эрчтэй явагддаг. Улаанбаатар хот бүх ачаа тээврийн урсгалын зангилаа төв хэвээр байна. Монгол Улсад үйлдвэрлэгдсэн бараа бүтээгдэхүүн тус хот руу бүх чиглэлээс нь орж ирдэг ба үүнд мах, сүү, үр тариа, хүнсний ногоо ихэнхдээ баруун хойд, баруун болон зүүн чиглэлээс тээвэрлэгдэн ирдэг байна.


Үйлдвэрлэлийн байгууллага, агуулах, захуудын ихээхэн хэсэг нь Улаанбаатар хотын төвд байрладаг. Хотын он удаан түүхэн хөгжлийн явцад орон сууц болон аж ахуйн нэгжүүд хотын төвийн дүүргүүдэд төвлөрсөн тул бүх бараа бүтээгдэхүүн болон түүхий эд хотын төвийн эдгээр байршил руу тээвэрлэгдэж, улмаар хотын бүх дүүргүүдээр таран байршсан хүнс, барааны зах болон бусад хэрэглэгчдийн гар дээр очихоор эргэн түгээгддэг. Ачаа тээврийн урсгал ийм мөн чанартай тул бараа бүтээгдэхүүний хот доторх хөдөлгөөн ихээр хийгдэж, хотын замын ачаалал, бохирдлын асуудлуудыг даамжруулж байна.

Зураг 3. 18 Улаанбаатар хот руу чиглэсэн бараа бүтээгдэхүүний урсгал



Эх сурвалж: Азийн хөгжлийн банк

Зураг 3. 19 Улаанбаатар хот дахь тээвэрлэлт, түгээлтийн урсгалууд



Эх сурвалж: Азийн хөгжлийн банк

Хот руу орж ирсэн бараа бүтээгдэхүүний ихэнхийг нь хотын төвийн хэсэгт байрлах агуулах, үйлдвэрлэлийн нэгжүүд рүү тээвэрлэж байна. Боловсруулалт, савлалт хийгдсэн барааг хот даяар дахин түгээдэг, үүнийг ихэнхдээ импортлогчид эсхүл боловсруулагч ба үйлдвэрлэгчид өөрийн эзэмшлийн бага оврын ачааны машинаар гүйцэтгэж байна. Улаанбаатар хотод ашиглагддаг түгээлтийн ачааны машины багтаамж дунджаар 2.5-аас 5 тонн хооронд хэлбэлздэг хэдий ч бага оврын буюу 2.5 тонны ачааны машин илүү түгээмэл байдаг байна. Үйлдвэрлэгчид болон сүү, сүүн бүтээгдэхүүн, мах, махан бүтээгдэхүүн, гурил, хувцас, цахилгаан бараа гэх мэт хэрэглээний бараа бүтээгдэхүүний импортлогчид өөрсдийн түгээлтийн машинаар барааг агуулахаасаа супермаркет, дэлгүүрүүдэд түгээж, зарим эцсийн хэрэглэгчдэд шууд хүргэдэг. Үүний улмаас, түгээлтийн бага оврын ачааны машинууд хотын замаар зорчигч тээвэртэй зэрэгцэн явж, түгжрэлийг нэмэгдүүлж байна.¹³

¹³ АХБ, “Саад тотгорыг арилгах нь: Монгол Улсын тээвэр, логикийн салбарын хөгжлийн тухай”, 2018 он




3.3 МУ-ЫН ХУДАЛДААНЫ САЛБАРЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

3.3.1 Гадаад худалдаа

Нийт бараа эргэлт


2021 онд Монгол улс дэлхийн 159 оронтой худалдаа хийж гадаад худалдааны нийт бараа эргэлт 16086.6 сая ам.доллар болж 2020 оны гүйцэтгэлээс 3211.4 сая ам.доллар буюу 24.9 хувиар өсжээ. Экспортын дүн импортын дүнгээс 2395.7 сая ам.доллараар давж, гадаад худалдааны баланс эерэг гарлаа.

Зураг 3. 20 Гадаад худалдааны эргэлт



Эх сурвалж: Гаалийн статистик-2021

Зураг 3. 21 Монгол улсын гадаад худалдааны бараа эргэлт, ерөнхий тойм



Эх сурвалж: Нью Урбанизм ХХК



Импорт

2021 онд импортоор нийт 6845.5 сая ам.долларын бараа, түүхий эд оруулсан нь 2020 оны гүйцэтгэлээс 1546.5 сая ам.доллараар буюу 29.2 хувиар өссөн байна.

Импортоор нийлүүлэгдсэн барааны 95.8 хувийг валютын төлбөртэй худалдаа, 1.4 хувийг гадаадын зээлийн хөрөнгөөр нийлүүлсэн бараа, 0.6 хувийг гадаадын тусламжийн бараа, 1.9 хувийг гадаадын хөрөнгө оруулалтаар нийлүүлсэн бараа, 0.04 хувийг боловсруулалтын бараа эзэлж байна.

Импортоор нийлүүлэгдсэн барааны нийт дүнд машин механик тоног төхөөрөмж ба эд анги, цахилгаан хэрэгсэл, тэдгээрийн сэлбэг 1248.7 сая ам.доллар буюу 18.2 хувь; эрдэс бүтээгдэхүүн 1338.6 сая ам.доллар буюу 19.6 хувь /үүний дотор нефтийн бүтээгдэхүүн 1131.8 сая ам.доллар буюу 84.6 хувь/; мал амьтан, ургамлын гаралтай бүтээгдэхүүн, хүнсний зүйл 962.8 сая ам.доллар буюу 14.1 хувь; авто агаарын тээврийн хэрэгсэл тэдгээрийн эд анги 1228.4 сая ам.доллар буюу 17.9 хувь; хуванцар болон хуванцар эдлэл, хаймар түүгээр хийсэн эдлэл 252.2 сая ам.доллар буюу 3.7 хувь; үндсэн төмөрлөг болон түүгээр хийсэн бүтээгдэхүүн 567.2 сая ам.доллар буюу 8.3 хувь; химийн болон түүнтэй холбоотой үйлдвэрийн бүтээгдэхүүн 589.3 сая ам. доллар буюу 8.6 хувийг тус тус эзэлж, эдгээр бүтээгдэхүүн нийт дүнгийн 90.4 хувийг эзэлж байна.

Хүснэгт 3. 16 Импортын гүйцэтгэл, мян. ам.доллар

Барааны нэр	Импорт / Import		Өөрчлөлт		Бүтэц
	2020 он	2021 он	мян.\$	%	
01 Амьд мал, амьтад, мал амьтдын гаралтай бүтээгдэхүүн	77,696	121,479	43,782	56%	1.8%
02 Ургамлын гаралтай бүтээгдэхүүн	120,176	187,635	67,459	56%	2.7%
03 Мал амьтны болон ургамлын гаралтай тос, өөх	35,801	46,490	10,689	30%	0.7%
04 Хүнсний бэлэн бүтээгдэхүүн	434,368	607,217	172,849	40%	8.9%
05 Эрдэс бүтээгдэхүүн	1,007,248	1,338,591	331,344	33%	19.6%
06 Химийн болон түүнтэй холбоотой үйлдвэрийн бүтээгдэхүүн	370,772	589,268	218,496	59%	8.6%
07 Хуванцар болон түүгээр хийсэн зүйлс; хаймар болон түүгээр хийсэн зүйлс	223,142	252,173	29,031	13%	3.7%
08 Арьс ширэн түүхий эд болон боловсруулсан арьс, шир, ангийн үс, эдгээрээр хийсэн эдлэл	5,030	6,449	1,419	28%	0.1%
09 Мод, модон эдлэл	43,385	61,884	18,499	43%	0.9%
10 Цаас болон картон, тэдгээрээр хийсэн зүйлс	58,051	64,329	6,278	11%	0.9%
11 Нэхмэлийн материал болон нэхмэл эдлэл	85,791	103,763	17,972	21%	1.5%
12 Гутал, малгай, төрөл бүрийн бусад зүйл	17,894	24,591	6,697	37%	0.4%
13 Чулуу, гөлтгөнө, шөрмөсөн чулуу, гялтгануур болон тэдгээртэй төстэй материалаар хийсэн бүтээгдэхүүн	165,825	159,159	(6,666)	-4%	2.3%
14 Сувд, үнэт ба хагас үнэт чулуу, үнэт металл, гоёлын зүйлс, зоос	13,389	7,172	(6,217)	-46%	0.1%
15 Үндсэн төмөрлөг болон түүгээр хийсэн бүтээгдэхүүн	535,699	567,179	31,480	6%	8.3%



16 Машин, механик тоног төхөөрөмж ба эд анги, цахилгаан хэрэгсэл, тэдгээрийн сэлбэг	1,060,598	1,248,712	188,113	18%	18.2%
17 Авто, агаарын ба усан замын тээврийн хэрэгсэл, тэдгээрийн эд, анги	849,845	1,228,411	378,566	45%	17.9%
18 Хараа зүй, гэрэл зураг, хэмжүүр, хяналт, эмнэлгийн багаж хэрэгсэл, цаг, хөгжмийн зэмсэг эдгээрийн эд анги	103,842	127,183	23,340	22%	1.9%
19 Зэвсэг, галт хэрэгсэл; тэдгээрийн эд анги болон тоног хэрэгсэл	10,962	3,208	(7,754)	-71%	0.0%
20 Аж үйлдвэрийн төрөл бүрийн бараа	79,349	100,404	21,054	27%	1.5%
21 Урлагийн бүтээл, цуглуулга хийх, зориулалтын зүйлс ба эртний үнэт дурсгалын зүйлс	49	157	109	223%	0.0%
Бүгд	5,298,913	6,845,453	1,546,540	29%	100.0%

Эх сурвалж: ГЕГ, www.gaali.mn

Хүснэгтэд харуулсан 21 төрлийн гол нэрийн бүтээгдэхүүнээс 3 төрлийн бүтээгдэхүүний импорт буурчээ.

Экспорт

Экспортод 9241.1 сая ам.долларын бараа, түүхий эд гаргасан нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 22.0 хувиар өссөн байна. Экспортын өөрчлөлтийг БТКУС-ийн барааны хэсгээр авч үзвэл ургамлын гаралтай бүтээгдэхүүний бүлэгт багтах барааны экспорт 78.3 сая ам.доллар буюу 709.8 хувиар; эрдэс бүтээгдэхүүний экспорт 2254.4 сая ам.доллараар буюу 42.9 хувиар гэх мэт 12 хэсгийн барааны экспорт өсөж бусад 9 хэсгийн барааны экспорт буурсан байна. Монгол улс дэлхийн 64 оронд бараа экспортолсноос БНХАУ-д 82.6 хувь, Швейцар-д 9.4 хувь, Сингапурт 2.8 хувь, БНСУ-д 2.4 хувь тус тус ногдож нийт экспортын 97.2 хувийг дээрх орнууд эзэлж байна.

Хүснэгт 3. 17 Экспортын гүйцэтгэл, мян. ам.доллар

Барааны нэр	Экспорт / Export		Өөрчлөлт		Бүтэц
	2020 он	2021 он	мян.\$	%	
01 Амьд мал, амьтад, мал амьтдын гаралтай бүтээгдэхүүн	52,915.3	42,266.5	(10,649)	-20%	0.5%
02 Ургамлын гаралтай бүтээгдэхүүн	11,029.2	89,311.8	78,283	710%	1.0%
03 Мал амьтны болон ургамлын гаралтай тос, өөх	620.5	976.4	356	57%	0.0%
04 Хүнсний бэлэн бүтээгдэхүүн	70,206.0	47,076.1	(23,130)	-33%	0.5%
05 Эрдэс бүтээгдэхүүн	5,256,037.3	7,510,437.7	2,254,400	43%	81.3%
06 Химийн болон түүнтэй холбоотой үйлдвэрийн бүтээгдэхүүн	575.4	588.0	13	2%	0.0%
07 Хуванцар болон түүгээр хийсэн зүйлс; хаймар болон түүгээр хийсэн зүйлс	630.9	1,180.0	549	87%	0.0%



08 Арьс ширэн түүхий эд болон боловсруулсан арьс, шир, ангийн үс, эдгээрээр хийсэн эдлэл	7,433.7	6,478.4	(955)	-13%	0.1%
09 Мод, модон эдлэл	305.9	117.7	(188)	-62%	0.0%
10 Цаас болон картон, тэдгээрээр хийсэн зүйлс	47.2	32.0	(15)	-32%	0.0%
11 Нэхмэлийн материал болон нэхмэл эдлэл	279,484.6	370,657.9	91,173	33%	4.0%
12 Гутал, малгай, төрөл бүрийн бусад зүйл	1,869.8	2,257.1	387	21%	0.0%
13 Чулуу, гөлтгөнө, шөрмөсөн чулуу, гялтгануур болон тэдгээртэй төстэй материалаар хийсэн бүтээгдэхүүн	140.6	26.5	(114)	-81%	0.0%
14 Сувд, үнэт ба хагас үнэт чулуу, үнэт металл, гоёлын зүйлс, зоос	1,789,935.1	1,025,376.6	(764,559)	-43%	11.1%
15 Үндсэн төмөрлөг болон түүгээр хийсэн бүтээгдэхүүн	66,621.0	97,068.5	30,448	46%	1.1%
16 Машин, механик тоног төхөөрөмж ба эд анги, цахилгаан хэрэгсэл, тэдгээрийн сэлбэг	31,103.6	17,646.3	(13,457)	-43%	0.2%
17 Авто, агаарын ба усан замын тээврийн хэрэгсэл, тэдгээрийн эд, анги	4,234.7	25,954.6	21,720	513%	0.3%
18 Хараа зүй, гэрэл зураг, хэмжүүр, хяналт, эмнэлгийн багаж хэрэгсэл, цаг, хөгжмийн зэмсэг эдгээрийн эд анги	1,408.4	971.3	(437)	-31%	0.0%
19 Зэвсэг, галт хэрэгсэл; тэдгээрийн эд анги болон тоног хэрэгсэл	0.0	1.6	2	#DIV/0!	0.0%
20 Аж үйлдвэрийн төрөл бүрийн бараа	1,706.2	2,668.8	963	56%	0.0%
21 Урлагийн бүтээл, цуглуулга хийх, зориулалтын зүйлс ба эртний үнэт дурсгалын зүйлс	5.7	29.5	24	420%	0.0%
Бүгд	7,576,310.9	9,241,123.2	1,664,812	22%	100.0%

Эх сурвалж: ГЕГ, www.gaali.mn

Тээврийн төрлөөр

Импортын барааны 55% нь төмөр замаар, 35% нь авто замаар тээвэрлэгдсэн бол экспортын барааны хувьд 35% нь төмөр замаар, 53% нь авто замаар тус тус тээвэрлэгдэж байна. Агаарын тээвэр нь үнэ ихтэй, онцгой ачааны тээвэрлэлтэд /алт гэх мэт/ ашиглагдаж байна.

Хүснэгт 3. 18 Гадаад худалдааны бараа эргэлт, тээврийн төрлөөр, сая ам.доллар

код	Тээврийн төрөл	Импорт, үнийн дүн сая.ам.дол		Экспорт, үнийн дүн сая.ам.дол	
		2020 он	2021 он	2020 он	2021 он
20	Төмөр зам	2,623	3,795	2,070	3,193
30	Авто зам	2,323	2,401	3,671	4,914
40	Агаар	205	477	1,835	1,134
51	Шуудан илгээмж	0	0	0	0
52	Буухиа шуудан	0	0	0	0
60	Холимог тээвэр	0	0	-	-



70	Хөдөлгөөнт бус тээвэр	147	172	1	0
90	Бусад тээврийн хэрэгсэл	1	0	-	-
Дүн		5,299	6,845	7,576	9,241

Эх сурвалж: ГЕГ, www.gaali.mn


3.3.2 Дотоод худалдаа

Худалдааны салбарын борлуулалтын орлого 2021 онд 27.8 их наяд төгрөг болж, өмнөх оноос 5.7 их наяд төгрөг буюу 26.0 хувиар өслөө. Үүнд хүнсний бүтээгдэхүүн, шатахууны бөөний болон жижиглэн худалдаа, төлбөр эсвэл гэрээний үндсэн дээр хийгдэх бөөний худалдаа, эм, гоо сайхан, ариун цэврийн барааны жижиглэн худалдаа тус тус өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Худалдааны салбарын 2021 оны борлуулалтын орлогын 38.5 хувь нь бөөний худалдаа, 61.5 хувь жижиглэн жижиглэн худалдааны салбарт ногдож байна. Жижиглэн худалдааны борлуулалтын орлого 2021 онд 17.1 их наяд төгрөг болж, өмнөх оноос 3.3 (24.2%) их наяд төгрөг, бөөний худалдааны борлуулалтын орлого 10.7 их наяд төгрөг болж, өмнөх оноос 2.4 (29.0%) их наяд төгрөгөөр тус тус өссөн.

Худалдааны салбарын борлуулалтын орлогын 83.8 хувь нь Улаанбаатар хотод ногдож байна. Улаанбаатар хотын худалдааны салбарын борлуулалтын орлого 2021 онд 23.3 их наяд төгрөг болж, өмнөх оноос 4.8 (26.2%) их наяд төгрөгөөр өслөө. Худалдааны салбарын борлуулалтын орлого аймгуудад 7.7-55.2 хувиар өссөн байна.

Зураг 3. 22 Худалдааны борлуулалт, тэрбум төгрөг



Улсын хэмжээнд худалдааны салбарт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллага 2021 онд 36950 болж, өмнөх оноос -1597 буюу 4.1 хувиар буурсан дүнтэй байна. Үүнд, Коронавирус цар тахлын үеийн хөл хорионы нөхцөл голлон нөлөөлсөн.


Хүснэгт 3. 19 Худалдааны салбарт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллагын тоо



Үзүүлэлт	2015	2016	2017	2018	2019	2020	2021
БҮГД	64301	72182	78585	85749	94425	95950	96336
Худалдааны салбарын ААНБ-ын тоо	24194	27744	30510	33930	37706	38547	36950
Худалдааны салбарын ААНБ-ын эзлэх хувь	37.6	38.4	38.8	39.6	39.9	40.2	38.4

Эх сурвалж: ҮСХ, www.1212.mn

Зураг 3. 23 Монгол улсын дотоодын бараа бүтээгдэхүүний нийлүүлэлт



Эх сурвалж: Нью Урбанизм ХХК

3.3.3 Боомтын статистик

Улаанбаатар хотод төмөр замаар тээвэрлэгдэн ирж буй ачааны нарийвчилсан тоо хэмжээг гаргахад гаалийн статистикаас Улаанбаатарын гаалиар нэвтэрч буй ачааны хэмжээг ачааны төрлөөр нь тооцож гаргасан. Ингэхдээ хэвийн байх үеийн буюу 2019 оны мэдээлэлд голчлон анхаарал хандуулсан ба 2020 онд зарим боомтууд ажиллаагүй, үе үе хаагдаж байсан болон бүхэлдээ манай гадаад худалдаа доголдолтой байсан юм.

Цар тахлын өмнөх үеийн буюу 2019 оны голлох боомтын ачаа нэвтрэлтийг харахад:

- » Импортын ачаа 4.7 сая тн , үүнээс уул уурхайн ачаа 44%, уул уурхайн бус ачаа 56%,
- » Экспортын ачаа 48.6 сая тн , үүнээс уул уурхайн ачаа 99.6%, уул уурхайн бус ачаа 0.4%,
- » Улаанбаатар хот дахь ачаа 2.6 сая тн, үүний 51% нь уул уурхайн буюу нефьтийн бүтээгдэхүүн, үлдсэн нь өргөн хэрэглээний бараа аж үйлдвэрийн түүхий эд, тоног төхөөрөмж автомашин байсан,
- » Улаанбаатар хотод бууж буй ачаа нь УБ хотын терминалиудын хүчин чадалтай дүйж байгаа ба энэ нь УБ хот доторх логистикууд бүрэн хүчин чадлаараа ажилладаг гэж үзэхэд хүргэж байна,



- » Улаанбаатар хот дахь УБТЗ-аар тээвэрлэж буй импортын ачааны 51% нь уул уурхайн ачаа, 49% нь уул уурхайн бус ачаа байна,
- » Мөн Улаанбаатар хот дахь УБТЗ-ын тээвэрлэж буй экспортын ачааны 83% нь уул уурхайн ачаа, 17% нь уул уурхайн бус ачаа байна,
- » Замын Үүдээр 1.6 сая тн ачаа нэвтэрсний дийлэнх нь авто тээврийнх байсан ба энэ нь вагоны олноо муутайгаас авто тээврээр ачаа тээвэрлэх хандлагыг харуулж байна,


Зураг 3. 24 Хилийн боомтуудаар нэвтэрсэн ачаа (импорт+экспорт) – 2019 онд



Эх

сурвалж: ГЕГ

Зураг 3. 25 Улсын хилээр орсон тээврийн хэрэгслийн тоо 2019 оны байдлаар



Эх сурвалж: Нью Урбанизм ХХК



Хүснэгт 3. 20 Ачаа тээвэр, боомтоор, тн

Код	Боомтоорх ачаа нэвтрэлт	2019			2020			Импорт бүтэц, %		Экспорт бүтэц, %	
		Импорт	Экспорт	Нийт	Импорт	Экспорт	Нийт	2019	2020	2019	2020
1	Баян-Өлгий	88,851	1,058	89,909	82,049	548	82,597	1.9%	2%	0.0%	0.0%
2	Бичигт	19,415	675,234	694,649	1,342	317,758	319,101	0.4%	0%	1.4%	0.8%
3	Гашуунсухайт	160,105	21,407,095	21,567,200	194,236	15,503,344	15,697,580	3.4%	4%	44.0%	38.7%
4	Говь Алтай	1,856	1,176,658	1,178,514		97,620	97,620	0.0%	0%	2.4%	0.2%
5	Дархан-Уул	126,112	5,465,786	5,591,898	192,113	6,451,382	6,643,495	2.7%	4%	11.2%	16.1%
6	Дорнод	35,917	516,074	551,990	55,779	370,171	425,950	0.8%	1%	1.1%	0.9%
7	Завхан	243	146	389	77	-	77	0.0%	0%	0.0%	0.0%
8	Замын -Үүд	1,221,307	422,690	1,643,997	1,516,277	220,421	1,736,698	26.0%	30%	0.9%	0.6%
9	Орхон	135,524	701,870	837,394	132,429	667,100	799,530	2.9%	3%	1.4%	1.7%
10	Сайншанд	202,207	4,205,868	4,408,075	224,397	4,469,707	4,694,104	4.3%	4%	8.7%	11.2%
11	Сэлэнгэ	236,847	17,406	254,253	253,160	27,020	280,181	5.0%	5%	0.0%	0.1%
12	Увс	28,833	700	29,533	28,998	238	29,236	0.6%	1%	0.0%	0.0%
13	Ховд	12,960	1,341,220	1,354,180	3,361	793,868	797,229	0.3%	0%	2.8%	2.0%
14	Хөвсгөл	459		459	62	-	62	0.0%	0%	0.0%	0.0%
15	Шивээхүрэн	13,573	12,425,803	12,439,376	4,783	10,800,106	10,804,889	0.3%	0%	25.6%	27.0%
16	Улаанбаатар	2,415,794	240,761	2,656,555	2,443,839	317,211	2,761,050	51.4%	48%	0.5%	0.8%
	Бүгд	4,700,001	48,598,368	53,298,369	5,132,903	40,036,495	45,169,398	100.0%	100%	100.0%	100.0%
	Уул уурхайн ачаа	2,060,888	48,385,325	50,446,212	2,177,825	39,891,973	42,069,798	43.8%	42%	99.6%	99.6%
	Уул уурхайн бус ачаа	2,639,114	213,044	2,852,157	2,955,078	144,521	3,099,599	56.2%	58%	0.4%	0.4%

Хүснэгт 3. 21 Импортын ачаа тээвэр, бүтээгдэхүүний төрлөөр, тн: 2010-2020 онд

Код	Импортын ачаа, тн	2010	2011	2012	2013	2014	2015	2016	2017	2018	2019	2020
1	Амьд мал, амьтад, мал амьтдын гаралтай бүтээгдэхүүн	6,658	20,796	26,324	28,603	28,610	22,855	23,511	31,435	37,666	38,491	42,302
2	Ургамлын гаралтай бүтээгдэхүүн	65,455	210,280	209,673	162,246	212,240	197,836	348,983	187,157	442,035	208,913	338,770
3	Мал амьтны болон ургамлын гаралтай тос, өөх	10,809	25,374	25,311	27,637	27,887	27,163	28,644	30,020	34,145	30,463	36,461
4	Хүнсний бэлэн бүтээгдэхүүн	87,758	210,921	237,981	246,060	236,156	240,108	220,696	236,869	293,940	253,015	248,847
5	Эрдэс бүтээгдэхүүн	677,450	1,947,567	2,528,401	2,964,757	3,054,998	2,268,154	1,485,430	1,631,772	1,801,873	2,060,888	2,177,825
6	Химийн болон түүнтэй холбоотой үйлдвэрийн бүтээгдэхүүн	75,301	199,166	245,042	263,991	243,170	227,036	202,100	265,521	299,579	341,889	339,914
7	Хуванцар болон түүгээр хийсэн зүйлс; хаймар болон түүгээр хийсэн зүйлс	19,804	66,332	73,403	96,001	74,767	57,383	60,050	89,485	90,880	102,113	94,304
8	Арьс ширэн түүхий эд болон боловсруулсан арьс, шир, ангийн үс, эдгээрээр хийсэн эдлэл	63	248	284	351	763	248	363	470	747	702	432
9	Мод, модон эдлэл	22,418	71,369	81,842	101,489	115,012	81,500	75,316	93,262	99,885	119,399	117,147
10	Цаас болон картон, тэдгээрээр хийсэн зүйлс	11,067	32,844	35,737	34,591	36,055	32,833	33,978	37,576	42,416	40,758	41,325



11	Нэхмэлийн материал болон нэхмэл эдлэл	7,133	15,336	14,433	15,247	16,347	13,278	16,901	20,194	26,375	23,933	20,941
12	Гутал, малгай, төрөл бүрийн бусад зүйл	369	865	953	810	771	568	725	822	1,035	894	1,008
13	Чулуу, гөлтгөнө, шөрмөсөн чулуу, гялтгануур болон тэдгээртэй төстэй материалаар хийсэн бүтээгдэхүүн	100,635	307,974	414,070	466,070	441,175	315,109	213,341	197,777	317,721	419,787	615,116
14	Сувд, үнэт ба хагас үнэт чулуу, үнэт металл, гоёлын зүйлс, зоос	8	6	21	10	6	6	6	10	6	7	5
15	Үндсэн төмөрлөг болон түүгээр хийсэн бүтээгдэхүүн	70,624	417,771	443,300	492,409	530,905	385,753	231,538	316,776	459,855	559,406	601,378
16	Машин, механик тоног төхөөрөмж ба эд анги, цахилгаан хэрэгсэл, тэдгээрийн сэлбэг	45,019	182,501	192,806	162,740	129,247	95,988	71,242	118,948	158,877	159,436	122,562
17	Авто, агаарын ба усан замын тээврийн хэрэгсэл, тэдгээрийн эд, анги	84,104	323,148	239,652	173,687	135,514	101,337	114,348	215,541	307,678	300,528	302,969
18	Хараа зүй, гэрэл зураг, хэмжүүр, хяналт, эмнэлгийн багаж хэрэгсэл, цаг, хөгжмийн зэмсэг эдгээрийн эд анги	391	1,421	1,851	1,745	1,554	1,304	1,365	1,280	1,778	1,897	1,845
19	Зэвсэг, галт хэрэгсэл; тэдгээрийн эд анги болон тоног хэрэгсэл	128	418	34	30	10	7	14	13	32	24	202
20	Аж үйлдвэрийн төрөл бүрийн бараа	17,147	43,415	50,160	46,428	40,938	31,259	31,619	43,899	46,534	37,422	29,511
21	Урлагийн бүтээл, цуглуулга хийх, зориулалтын зүйлс ба эртний үнэт дурсгалын зүйлс	13	65	118	21	81	29	12	19	32	36	39
	Бүгд	1,302,356	4,077,814	4,821,398	5,284,924	5,326,208	4,099,755	3,160,183	3,518,846	4,463,090	4,700,001	5,132,903
	УУ	677,450	1,947,567	2,528,401	2,964,757	3,054,998	2,268,154	1,485,430	1,631,772	1,801,873	2,060,888	2,177,825
	УУБус	624,905	2,130,247	2,292,997	2,320,168	2,271,210	1,831,601	1,674,754	1,887,074	2,661,217	2,639,113	2,955,078

Хүснэгт 3. 22 Экспортын ачаа тээвэр, бүтээгдэхүүний төрлөөр, тн: 2010-2020 онд

Код	Экспортын бүтээгдэхүүн төрөл, тн	2010	2011	2012	2013	2014	2015	2016	2017	2018	2019	2020
1	Амьд мал, амьтад, мал амьтдын гаралтай бүтээгдэхүүн	22,519	15,697	8,142	5,126	3,719	9,248	13,591	32,441	47,559	44,772	24,421
2	Ургамлын гаралтай бүтээгдэхүүн	158	15,062	14,907	36,859	49,689	59,086	118,807	142,769	29,203	42,549	28,398
3	Мал амьтны болон ургамлын гаралтай тос, өөх	0	2	52	2	0	10	734	569	949	1,748	1,288
4	Хүнсний бэлэн бүтээгдэхүүн	1,281	12,955	8,384	34,159	41,146	22,250	26,098	29,734	62,215	47,241	41,921
5	Эрдэс бүтээгдэхүүн	11,378,051	28,699,508	29,043,404	26,918,181	28,602,819	22,566,327	35,071,631	42,619,991	46,745,370	48,385,325	39,891,973
6	Химийн болон түүнтэй холбоотой үйлдвэрийн бүтээгдэхүүн	19	42	50	299	216	36	758	821	1,251	1,795	306
7	Хуванцар болон түүгээр хийсэн зүйлс; хаймар болон түүгээр хийсэн зүйлс	2,865	6,694	5,895	7,448	6,964	7,071	6,861	5,525	607	2,597	110
8	Арьс ширэн түүхий эд болон боловсруулсан арьс, шир, ангийн үс, эдгээрээр хийсэн эдлэл	4,367	23,774	14,470	14,844	13,790	13,051	13,901	13,917	11,140	15,888	10,490
9	Мод, модон эдлэл	726	880	1,201	983	2,141	1,046	1,090	1,495	724	1,809	625
10	Цаас болон картон, тэдгээрээр хийсэн зүйлс	1,153	1,719	155	352	8	14	48	19	24	15	23
11	Нэхмэлийн материал болон нэхмэл эдлэл	4,226	16,302	11,676	10,106	16,041	20,374	23,288	26,589	23,673	26,095	19,267
12	Гутал, малгай, төрөл бүрийн бусад зүйл	13	76	34	20	29	24	40	72	64	183	49



13	Чулуу, гөлтгөнө, шөрмөсөн чулуу, гялтгануур болон тэдгээртэй төстэй материалаар хийсэн бүтээгдэхүүн	49	11	4	601	11	7	11	11	19	28	22
14	Сувд, үнэт ба хагас үнэт чулуу, үнэт металл, гоёлын зүйлс, зоос	2	13	3	4	1	3	10	4	16	77	10
15	Үндсэн төмөрлөг болон түүгээр хийсэн бүтээгдэхүүн	5,176	8,259	6,270	6,386	10,286	16,097	20,408	24,731	20,920	19,153	14,978
16	Машин, механик тоног төхөөрөмж ба эд анги, цахилгаан хэрэгсэл, тэдгээрийн сэлбэг	2,642	2,364	994	4,317	9,817	4,708	4,617	1,821	2,681	4,085	1,727
17	Авто, агаарын ба усан замын тээврийн хэрэгсэл, тэдгээрийн эд, анги	391	1,515	639	1,201	859	1,627	2,737	822	2,185	3,903	246
18	Хараа зүй, гэрэл зураг, хэмжүүр, хяналт, эмнэлгийн багаж хэрэгсэл, цаг, хөгжмийн зэмсэг эдгээрийн эд анги	151	11	2	4	13	4	6	4	19	16	13
19	Зэвсэг, галт хэрэгсэл; тэдгээрийн эд анги болон тоног хэрэгсэл		0	0		0			0		0	
20	Аж үйлдвэрийн төрөл бүрийн бараа	2,265	1,055	728	897	431	435	509	717	640	1,085	626
21	Урлагийн бүтээл, цуглуулга хийх, зориулалтын зүйлс ба эртний үнэт дурсгалын зүйлс		2	2	10	2	1	3	11	2	6	1
	Бүгд	11,426,063	28,805,941	29,117,014	27,041,798	28,757,981	22,721,418	35,305,149	42,902,064	46,949,259	48,598,368	40,036,495
	- УУ	11,378,051	28,699,508	29,043,404	26,918,181	28,602,819	22,566,327	35,071,631	42,619,991	46,745,370	48,385,325	39,891,973
	- УУБус	48,012	106,432	73,609	123,617	155,163	155,091	233,518	282,073	203,890	213,043	144,521

Хүснэгт 3. 23 1 тн ачааны дундаж үнэлгээ: 2010-2020 онд

1 тн ачаа үнэлгээ	2010	2011	2012	2013	2014	2015	2016	2017	2018	2019	2020
Импортын 1 тн ачааны дундаж үнэлгээ	1,203	1,617	1,393	1,201	989	926	1,042	1,231	1,314	1,299	1,032
- УУ	557	654	621	586	482	413	480	605	736	665	463
- УУБус	1,902	2,497	2,244	1,987	1,670	1,561	1,541	1,773	1,705	1,794	1,452
Экспортын 1 тн ачааны дундаж үнэлгээ	121	167	151	151	187	187	118	131	146	148	149
- УУ	102	150	135	130	168	163	99	116	130	132	132
- УУБус	4,680	4,867	6,454	4,821	3,712	3,676	2,886	2,382	3,909	3,916	4,844



3.4 АВТО ТЭЭВРИЙН СТАТИСТИК


3.4.1 Дэд бүтэц ба орлого

Дэд бүтэц

Монгол Улсын Авто замын тухай хуулийн 4.1.22, 14.1**–т заасны дагуу Монгол Улсын нутаг дэвсгэр дэх үндэсний авто замын сүлжээ нь олон улс, улс, нийслэл, орон нутгийн чанартай болон тусгай зориулалтын авто замаас бүрдэнэ.

Үндэсний авто замын сүлжээний нийт урт 2021 оны жилийн эцсээр 111,916.7 км байгаагийн 99,891.2 км нь буюу 89.2% нь ердийн хөрсөн, 12,025.5 км буюу 10.8% нь сайжруулсан зам байна. Нийт сайжруулсан замын 10,243.8 км буюу 85.1%-ийг хатуу хучилттай, 1176.79 км буюу 9.8%-ийг хайрган хучилттай, 604.9 км буюу 5.1%-ийг сайжруулсан хөрсөн зам эзэлж байна.


Зураг 3. 26 Монгол улсын автозамын сүлжээ



Эх сурвалж: Зам тээврийн хөгжлийн яам, Монгол улсын тээврийн салбар-2021

Монгол Улсын авто замын нийт сүлжээнд олон улсын болон улсын чанартай зам 14918.7 км буюу 13.3%, орон нутгийн чанартай зам 96,125.3 км буюу 85.9%, уул уурхайн буюу тусгай зориулалттай зам 898.4 км буюу 0,8%-ийг эзэлж байна. Хатуу хучилттай замын 7,744.7 км буюу 75.6% нь улсын чанартай, 1,598.78 км буюу 15.6% нь орон нутгийн чанартай, 898.4 км буюу 8.8% нь уул уурхайн (тусгай) зориулалттай зам байна.


Зураг 3. 27 Сайжруулсан замын урт, км



Эх сурвалж: ҮСХ, www.1212.mn




Хатуу хучилттай авто замыг хучилтын төрлөөр авч үзвэл 9,927.4 км буюу 97%-ийг асфальт бетон, 205.2 км буюу 2%-ийг хөнгөвчилсөн хучилттай, харин цемент бетон зам 111.16 км буюу 1%-ийг эзэлж байна.



Зураг 3. 28 Хатуу хучилттай авто замын бүтэц

Зураг 3. 29 Хатуу хучилттай авто замын хучилтын төрөл



Эх сурвалж: Зам тээврийнхөгжлийн яам, Монгол улсын тээврийн салбар-2021

2021 оны жилийн эцсийн байдлаар Монгол Улсын гүүрний тоо, хэмжээ 370 буюу 15,989.4 у/м болж, өмнөх оны мөн үеэс 4 буюу 532.6 у/м(+7.64%)-аар өссөн байна. 2021 оны жилийн эцсийн байдлаар нийт 90.7 км зам шинээр ашиглалтад орж, өмнөх оны мөн үеэс 253.3 км буюу -73.6%-иар буурсан байна. Харин 4 буюу 1181.5 у/м төмөр бетон гүүр шинээр ашиглалтад орж, өмнөх оны мөн үеэс 532.6 у/м буюу 82.1%-иар өссөн байна.

Авто замын салбарт 2021 онд нийт 90.7 км хатуу хучилттай авто замыг ашиглалтад оруулсан бол 2016-2021 онд нийт 2208.03 км хатуу хучилттай авто замыг барьж ашиглалтад оруулаад байна. Улсын чанартай 14,918.7 км авто замын 7,744.7 км буюу 51.9 хувь нь хатуу хучилттай авто замаар ашиглагдаж байна.

Зураг 3. 30 Авто замын сүлжээ



Эх сурвалж: Нью Урбанизм ХХК

2021 оны жилийн эцсийн байдлаар авто замын тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгж байгууллагын тоо нийт 465 болж, өмнөх оны мөн үеэс 28 буюу -5.7%-иар буурсан.



Хүснэгт 3. 24 Авто тээврийн үндсэн үзүүлэлт

Үзүүлэлт	2010	2011	2012	2013	2014	2015	2016	2017	2018	2019	2020	2021
Тээсэн ачаа, мянган тонн	12,610.23	25,635.28	30,195.09	21,321.86	23,514.19	13,043.70	20,406.20	31,212.90	42,033.78	40,848.80	30,455.00	17,970.3
Ачаа эргэлт, сая тонн километр	1,833.95	4,910.30	3,503.90	2,555.80	4,936.43	2,374.00	4,236.20	5,661.30	6,640.61	6,203.80	4,685.30	2,313.92
Зорчигчид, сая хүн	246.70	291.80	313.20	303.40	340.10	256.50	260.70	212.20	193.00	168.44	124.09	106.5
Зорчигч эргэлт, сая хүн километр	1,480.18	2,321.60	2,263.11	1,897.47	2,793.04	1,940.50	1,959.90	2,040.90	2,919.90	2,925.10	2,178.00	1,023.01
Шилжүүлсэн сая тонн километр	2,426.02	5,576.96	5,366.20	5,007.49	6,053.65	3,150.17	5,020.17	6,477.60	7,808.68	7,373.60	5,556.50	2,723.28
Тээврийн орлого, оны үнээр, сая төг	172,190.77	299,307.76	417,552.45	367,200.08	363,751.75	345,052.90	467,169.90	506,434.60	695,858.41	796,055.40	564,388.20	413,900
Сайжруулсан зам	6,734.38	7,633.49	7,652.89	8,875.62	9,428.20	9,812.12	10,126.03	10,355.20	10,835.00	11,619.1	11,963.8	
- хатуу хучилттай	3,015.60	4,063.51	4,082.91	5,838.21	6,461.05	7,125.30	7,456.61	8,431.40	9,023.00	9,806.3	10,151	
- хайрган хучилттай	2,071.58	1,959.23	1,959.23	1,864.81	1,782.50	1,715.62	1,696.82	1,308.90	1,207.90	1,207.9	1,207.9	
- сайжруулсан хөрсөн зам	1,647.20	1,610.75	1,610.75	1,172.60	1,184.70	971.20	972.60	614.90	604.90	604.9	604.9	

Эх сурвалж: ҮСХ, www.1212.mn

Хүснэгт 3. 25 Ашиглалтад орсон зам, гүүр /оноор/

Он	Шинээр ашиглалтад орсон гүүрийн урт у/м	Шинээр ашиглалтад орсон замын урт км
2016	199.52	199.52
2017	145.65	441.59
2018	489.8	383.72
2019	202.4	748.5
2020	643.65	344
2021	1181.5	90.7
Нийт	2862.52	2208.03


Эх сурвалж: Зам тээврийн хөгжлийн яам, Монгол улсын тээврийн салбар-2021



Орлого

Авто тээврийн салбарын орлого 2020 онд 564 тэрбум төгрөг болж өмнөх оноос 29% буурсан ба жилдээ 10 гаруй хувь өсөлттэй байсан салбарын орлого нь цар тахлын нөлөөллөөс болж тасалдсан байна.

Зураг 3. 31 Авто тээврийн салбарын орлого




Эх сурвалж: ҮСХ, www.1212.mn

3.4.2 Зорчигчид ба ачаа тээвэр

Зорчигчид

Автотээврийн салбар 2021 онд давхардсан тоогоор 106 сая хүн зорчигч тээвэрлэж, зорчигч эргэлт 1023 сая хүн.км болж, Ковид-19 цар тахал гарахаас өмнөх үеэс буюу 2019 оныхоос зорчигчийн тоо 62 сая хүн буюу 37%-иар буурч, зорчигч эргэлт 1902 сая хүн.км буюу 35%-иар буурсан байна.

Зураг 3. 32 Авто зорчигчийн үзүүлэлт




Эх сурвалж: ҮСХ, www.1212.mn



Ачаа тээвэр

Авто тээвэрээр 2021 онд 17.9 сая тн ачаа тээвэрлэж Ковид-19 цар тахлын өмнөх 2019 онтой харьцуулахад 56% буурсан үзүүлэлттэй байлаа. Түүнчлэн Автотээврийн ачаа эргэлт 2021 онд 2,314 сая км/тн болж 2019 оноосоо 63% тус тус буусан.

Зураг 3.33 Авто тээврийн ачаа тээвэр




Эх сурвалж: ҮСХ, www.1212.mn

Ачааны автомашин

Логистикийн үйл ажиллагаанд ашиглагдах ачааны автомашины тоо хэмжээ 2021 онд улсын хэмжээнд 225.5 мянган ширхэг байгаа ба үүний 38.7% буюу 87.4 мянга нь нийслэл хотноо, 61.3% буюу 138.1 мянга нь орон нутагт харьяалагдаж байна.

Зураг 3.34 Ачааны автомашины тоо



Эх сурвалж: ҮСХ, www.1212.mn

2021 онд 385 сая ам.долларын үнэлгээ бүхий 26,526 ширхэг ачааны автомашин орж ирсэн ба 1 ачааны автомашины импортын үнэ 14.5 мянган ам.доллар байна.

Ачааны автомашиныг голчлон БНСУ (56.5%), БНХАУ (16.2%) улсуудаас тус тус нийлүүлж байна.



3.5 УВС АЙМГИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН НӨХЦӨЛ

3.5.1 Хүн ам, өрх

2020 оны байдлаар Увс аймаг нь 21,874 өрхийн 83,524 хүн ам оршин сууж байна. Сүүлийн 10 жилийн хугацааны хүн амын өсөлтийн хурд нь 1.3% байна. Энэ нь баруун бүсийн дунджаас 0.6%-иар, улсын дунджаас 0.4%-иар бага байна. Нийт хүн амын 37% нь суурин газарт, 63% нь хөдөөд амьдарч байна. Мөн өрхийн дундаж хүн амын 3.82 байгаа юм.

Хүснэгт 3. 26 Увс аймгийн хүн ам, 10 жилээр

№	Үзүүлэлт	2011	2012	2013	2014	2015	2016	2017	2018	2019	2020
1	Хүн ам	73,824	73,824	73,972	75,792	80,763	81,278	82,688	84,309	83,223	83,524
2	Өрх	19,799	19,845	20,248	20,719	21,212	21,494	21,796	22,047	21,646	21,874
3	Өрхийн дундаж	3.73	3.72	3.65	3.66	3.81	3.78	3.79	3.82	3.84	3.82

Эх сурвалж: 1212.mn

2020 оны байдлаар Увс аймгийн хүн амын механик өсөлт 1,746 байгаа бөгөөд сүүлийн 10 жилийн өсөлтийн үзүүлэлтээс харахад 2014 онд хамгийн өндөр буюу 1,820 байсан бол 2015 онд буурч 1,517 болсон бол 2016 оноос өссөн байна.

Хүснэгт 3. 27 Увс аймгийн хүн амын ердийн өсөлт, 10 жилээр

№	Үзүүлэлт	2011	2012	2013	2014	2015	2016	2017	2018	2019	2020
1	Төрөлт	2,028	2,053	1,999	2,267	2,012	2,135	2,125	2,128	2,187	2,202
2	Нас баралт	520	330	456	447	495	487	472	456	468	456
3	Механик өсөлт	1,508	1,723	1,543	1,820	1,517	1,648	1,653	1,672	1,719	1,746

Эх сурвалж: 1212.tn

3.5.2 Хөдөлмөр эрхлэлт

2020 оны байдлаар Увс аймагт нийт хүн амын 65.7% буюу 54,893 нийт эдийн засгийн идэвхтэй хүн ам байна. Эдгээрийн 58% буюу 31,827 нь ажиллах хүч байгаагийн 95.8 хувь буюу 30,485 ажиллагсад байна. Энэ баруун бүсийн ажиллагсдын 2.5 хувь, улсын нийт ажиллагсдын 20 хувь юм. Түүнчлэн нийт 23,066 ажиллах хүчнээс гадуурх хүн ам байна.

Хүснэгт 3. 28 Увс аймгийн хөдөлмөр эрхлэлтийн байдал

№	Үзүүлэлт	Хөдөлмөр эрхлэлтийн байдал
1	Ажиллах хүч	31,827
1.1	Үүнээс:	Ажил эрхэлж буй
1.2		Ажилгүйчүүд
2	Ажиллах хүчнээс гадуурх хүн ам	23,066
2.1	Үүнээс:	Сургуульд сурдаг
2.2		Тэтгэвэр
2.3		Хөдөлмөр эрхлэх чадваргүй
2.4		Гэрийн ажилтай
2.5		Тохирох ажил олдохгүй байгаа
2.6		Ажиллах сонирхолгүй
2.7		Бусад


Эх сурвалж: Хүн ам, орон сууцны 2020 оны улсын ээлжит тооллогын Увс аймгийн нэгдсэн дүн

Нийт ажил эрхэлж буй хүн амын 3.6% нь боловсролгүй; 15.2% нь бага; 22.4% нь суурь; 21.2% нь бүрэн дунд; 6.8% нь техникийн болон мэргэжлийн; 3.6% нь тусгай мэргэжлийн



дунд; 0.5% нь дипломын дээд; 24.6% нь бакалавр; 2.2% нь магистр; 0.02% нь доктор түвшний боловсролтой байна.

Зураг 3. 35 Ажилд эрхэлж буй хүн амын боловсролын түвшин



Эх сурвалж: Хүн ам, орон сууцны 2020 оны улсын ээлжит тооллогын Увс аймгийн нэгдсэн дүн

3.5.3 Аж үйлдвэр

Увс аймагт нийт 1,180 жижиг дунд үйлдвэр, 2,000 ажилтантайгаар үйл ажиллагаа явуулж байгаагийн 51.2 хувь буюу 604 жижиг дунд үйлдвэр, 1,507 ажилтантайгаар Улаангомд үйл ажиллагаагаа явуулж байна. Улаангомд үйл ажиллагаа явуулж буй үйлдвэрүүд дараах үйл ажиллагааны чиглэлтэй. Үүнд:

- Агуулах болон тээврийн туслах үйл ажиллагаа тоо – 1
- Арьс, арьсан бүтээгдэхүүн үйлдвэрлэл – 8
- Барилга угсралт, барилгын тусгай үйл ажиллагаа – 41
- Газар тариалан, мал аж ахуйн үйлдвэрлэл, ан агнуур – 81
- Газрын тээвэр болон хийн хоолойн тээвэр – 10
- Машин, мотоциклээс бусад барааны бөөний худалдаа – 47
- Машин, мотоциклээс бусад барааны жижиглэн худалдаа – 194
- Машин, тоног төхөөрөмжийн угсралт, суурилуулалт – 1
- Моторт тээврийн хэрэгсэл, мотоциклийн бөөний, жижиглэн худалдаа – 5
- Нэхмэлийн үйлдвэрлэл – 5
- Резинэн болон хуванцар бүтээгдэхүүний үйлдвэрлэл – 2
- Тавилга үйлдвэрлэл – 6
- Тавилгаас бусад мод болон модон бүтээгдэхүүний үйлдвэрлэл – 5
- Төмөрлөг бус эрдэс бодисоор хийсэн эдлэл үйлдвэрлэл – 6



- Хоол ундаар үйлчлэх үйл ажиллагаа - 12
- Хувцас үйлдвэрлэл - 6
- Хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэл - 42

Увс аймгийн аж үйлдвэрийн салбарын нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн сүүлийн 10 жилийн үзүүлэлтийг салбараар нь авч үзвэл эрчим хүч түгээлт, ус хангамж 22.6%; уул уурхайн олборлолт 14; Боловсруулах үйлдвэр 8%-иар тус тус өссөн үзүүлэлтэй байгаа бөгөөд гол нэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн сүүлийн 10 жилийн үзүүлэлтийг авч үзвэл хувцас 27%; гутал 21.6%; жимсний сироп, чанамал 20%; барилгын материал 19%; мод, модон бүтээгдэхүүн 13.7%; талх, нарийн боов 9%; чацарганы тос 8%-иар өссөн үзүүлэлт харагдаж байна.

Аймгийн хэмжээнд 2015-2019 онд Экспортын хэмжээ 44%- иар өссөн бөгөөд экспортын гол бүтээгдэхүүн нь үхэр, хонины мах, эсгий, цай, хивс байна.

Аж үйлдвэрийн салбарын сүүлийн 30 буюу 1990 - 2020 оны нийт бүтээгдэхүүнийг тоймлон үзэхэд хүнсний үйлдвэрлэл, гурил, гурилан бүтээгдэхүүн, тэжээл, барилгын материалын үйлдвэрлэл томоохон үүрэг гүйцэтгэж байсан байна. Тухайлбал 1990 онд гурил 10163 тн, нарийн боов 596 тн, ундаа 171 тн, гоймон 213 тн, чацарганы тос 1800 кг, иоджуулсан давс 652 тн, тараг 719 мян.л, арвайн гурил 551 тн, хивэг 3015 тн, саван 57 тн зэрэг ихээхэн бүтээгдэхүүн үйлдвэрлэж байсан байна. Үүний цаана олон ажлын байр болон аймгийн болон улсын хэрэгцээний хангалт болохоор байна. Тухайн үед үйлдвэрлэж байсан эдгээр бүтээгдэхүүнээс заримыг нь одоо огт үйлдвэрлэхгүй байгаа. Гурил үйлдвэрлэл, арвайн гурил, хивэг үйлдвэрлэлээр аймгийн хэрэгцээг бүрэн хангах боломжтой байна.

Хүснэгт 3. 29 Аж үйлдвэрийн салбарын нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэлт, оны үнээр

Салбарын ангилал	1990	1995	2000	2005	2010	2015	2016	2017	2018	2019	2020	2020 2019
	2005 оны зэр үнээр	оны үнээр	2005 оны зэр үнээр			оны үнээр						хувь
Хэмжих нэгж	сая.төг											хувь
Бүгд	16717.5	1721.6	4527.6	2606.4	5784.9	13060.2	12134.4	13636.8	19090.3	20754.2	20136.8	97.0
1 Эрчим хүч түгээлт усан хангамж	9496.4	564	741.3	830.6	1145.3	4052.5	5355.4	5507.4	7625.1	7981.2	8825.2	110.6
үүнээс: дулаан	1652.3	-	540.7	715	1070.5	3904.2	5196.9	5213.1	7270.7	7643.1	8215.0	107.5
цахилгаан	7844.1	564	169.1	49.8	-	-	-	-	-	-	-	-
усан хангамж, хог зайгуулалт	-	-	31.5	65.8	74.8	148.3	158.5	294.3	354.4	338.1	610.2	180.5
2 Уул уурхайн олборлолт	1467.9	64.1	3275.2	828.9	696.7	1647.1	1526.7	2758.0	1270.3	2032.6	2581.4	127.0
үүнээс: алт	-	-	2987.1	551.2	314.0	-	-	1254.2	-	509.1	1050	206.2
нүүрс	1467.9	-	288.1	277.7	381.8	1641.6	1526.7	1503.0	1270.3	1523.5	1531.4	100.5
давс	-	-	-	-	-	5.5	-	-	-	-	-	-
3 Боловсруулах үйлдвэр	4925.3	1093.5	511.10	946.9	3942.9	7360.6	5252.3	5371.4	10194.9	10740.4	8730.2	81.3
3а Хүнс ундааны үйлдвэрлэл	-	-	400.2	703.5	3333.1	6215.1	4252.6	4088.5	8068.1	8346.8	5968.6	71.5
үүнээс: мах махан бүтээгдэхүүн	-	-	1.5	-	1124.8	4440.8	2181.4	1199.2	-	-	-	-
сүү сүүн бүтээгдэхүүн	287.6	-	-	2.8	0.5	22.0	26.8	44.5	-	-	-	-
гурил гурилан бүтээгдэхүүн	3177.4	-	49.1	79.6	251.1	932.2	1650.0	1880.0	-	-	-	-
ундаа архи	457.8	-	344.1	618.2	1906.7	754.4	337.0	872.7	-	-	-	-
хүнсний бусад бүтээгдэхүүн	1002.4	-	5.5	2.8	50.1	65.7	57.4	92.1	-	-	-	-
3б бусад боловсруулах үйлдвэрлэл	-	-	110.9	243.4	609.7	1145.5	999.7	1159.2	2126.9	2393.6	2761.6	115.4
Үүнээс: хувцас үйлдвэрлэл	67.5	-	4.40	11.8	6.9	13.8	23.0	52.9	101.7	85.7	79.5	92.8
Мод модон бүтээгдэхүүний үйлдвэрлэл	1.4	-	3.9	25.6	52.5	58.1	27.3	20.2	678.4	99.2	190.0	191.5
барилгын материалын үйлдвэрлэл	754.4	-	-	21.2	282.5	706.8	319.0	404.6	464.2	1411.7	1684.1	119.3
арьс шир гутлын үйлдвэрлэл	-	-	-	-	30.9	183.7	251.4	225.8	235.2	261.6	219.8	84.0
өлөн боловсруулалт	-	-	-	-	215.4	97.8	302.4	455.7	550.8	389.1	404.9	104.1
бусад боловсруулах үйлдвэрлэл	-	-	102.6	184.8	21.6	85.3	76.6	123.2	96.6	146.3	183.3	125.3
Борлуулалтын орлого /оны үнээр/	100.2*	1670.5	3969	2801.5	11975.5	10424.8	12231.3	14304.9	21609.0	22176.0	25090.4	113.1
Ажиллагсдын тоо, хүн	2301	998	617	480	607.0	929.0	802.0	839.0	782	907.0	790.0	87.1

* оны үнээр

Эх

сурвалж: Увс аймгийн Статистикийн хэлтэс

Сүүлийн жилүүдэд буюу 2015-2020 онуудад хувцас үйлдвэрлэл, арьс шир, гутал үйлдвэрлэл, өлөн боловсруулалт, модон эдлэл үйлдвэрлэл, бусад боловсруулах



үйлдвэрлэл хурдацтай хөгжиж байна. Эдгээр нь ихэвчлэн өрхийн болон жижиг дунд үйлдвэрлэлээр явагдаж байна.

Хүснэгт 3. 30 Аж үйлдвэрийн салбарын гол нэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлт

№	Гол нэрийн бүтээгдэхүүн	хэмжих нэгж	1990	1995	2000	2005	2010	2015	2016	2017	2018	2019	2020	2020
														2019
1	Дулаан	МГкал	120.4	34	40	52.1	78	145.5	165	176.9	227.8	251.8	254.9	101.2
2	цахилгаан	мян.квт	26689.6	8145.2	575.3	-	-	-	-	-	-	-	-	-
3	нүүрс	мян.тн	213	57.8	41.8	40.3	55.4	90.6	88.6	72.6	44.7	63.6	62.5	98.3
4	алт	кг	-	1.4	319.7	-	-	-	-	13.8	-	6.3	8.1	128.6
5	гурил	тн	10163.3	6897.9	92.3	32.9	894.1	315.2	3785.4	1278.7	354.84	1749	243.5	13.9
6	нарийн боов	тн	596.3	28.5	36.6	80.9	182.6	260.6	239.7	255.9	258.9	308.8	309.7	100.3
7	хэвийн боов	тн	-	-	-	-	-	-	-	7.1	17.3	7.1	18.3	257.7
8	архи	мян.л	142	46.1	113.7	200	613.9	41.2	5.5	41.7	39.8	39.5	105.9	268.1
9	ундаа	тн	171.2	52.7	22.6	118.7	146.6	-	-	-	-	-	-	-
10	гоймон	тн	213.4	15.4	-	-	14	4	3	0.5	0.7	-	-	-
11	жимсний шүүс, сироп	мян.л	6.8	0.4	2.5	3.2	16.9	79	58.6	82.0	77.4	88.8	75.6	85.1
12	чацарганы тос	кг	1800	22	111.2	83.3	186.4	236.5	238.3	367.9	375.0	257	313	121.8
13	варень	тн	3.2	0.6	-	-	1	0.8	0.8	1.4	1	1.7	0.4	23.5
14	иоджуулсан давс	тн	652.5	1016.9	132	188.9	56	0	2	-	-	6	6.5	108.3
15	талх	тн	756.8	2.4	9.9	6.6	109	177.9	117.3	109.0	128.0	121.7	139.0	114.2
16	хэрчсэн гурил	тн	-	-	-	-	39	4.1	0.1	3.5	5.0	1.7	0.9	52.9
17	тараг	мян.л	719	-	-	-	0	2.1	5.3	6.1	1.5	26.6	13.4	50.4
18	сүү	мян.л	-	-	-	-	-	-	-	-	-	80.6	63.2	78.4
19	ерем зөөхий	тн	-	-	-	-	-	-	-	-	-	0.9	0.4	44.4
20	шар тос	тн	-	-	-	-	-	-	-	-	-	0.7	1.2	171.4
21	ааруул	тн	-	-	-	-	-	-	-	-	-	0.4	2.2	550.0
22	бяслаг	тн	-	-	-	-	-	-	-	-	-	0.7	1.5	214.3
23	нэрмэл архи	мян.л	-	-	-	-	-	-	-	-	-	0.3	1.1	366.7
24	зайрмаг	мян.ш	-	-	-	32	6.7	68.0	64.0	111.0	22.0	-	-	-
25	мах бэлтгэл	тн	-	-	-	-	1112.3	1700	706	334.5	1396	1329	587	44.2
26	хиам	тн	-	2.3	1	-	6	6.7	2.6	5.7	3.6	4.6	3.1	67.4
27	ногооны консерв	тн	-	-	-	-	-	0	0	1.1	1.1	0.8	1.1	137.5
28	бялуу	тн	-	-	-	-	-	5.7	9.3	16.1	10.3	6.7	9.5	141.8
29	арвайн гурил	тн	551.1	280.8	-	-	-	4.2	0.4	4.8	6.5	8.6	9.9	115.1
30	чихэр	тн	30	2.7	0.2	-	-	-	-	-	-	-	-	-
31	цэвэр ус	мян.л	-	-	-	-	15	-	-	118.6	192.5	469.1	623.5	132.9
32	Цай	кг	-	-	-	-	-	-	-	918	860	450	500	111.1
33	бууз, банш	тн	-	-	-	-	-	-	-	0.3	-	1	1.5	150.0
34	өлөн гэдэс	мян.гогцоо	-	-	67.7	104.5	94.7	46.9	130	117.5	152.3	102.5	93.3	91.0
35	цэвэр ус түгээлт	мян.м3	-	-	356.2	456.2	518.5	642.6	685.0	395.2	391.3	435.2	440.1	101.1
36	дээл	ш	-	330	5	38	147	143	119	391	577	324	211	65.1
37	эм хослол	ш	-	-	109	34	40	14	4	36	13	23	16	69.6
38	костюм лиджак	ш	-	-	4	7	14	0	41	33	24	33	8	24.2
39	ажлын хувцас	ш	-	-	50	-	156	35	45	63	144	388	225	58.0
40	сурагч форм	ш	-	-	-	-	22	300	20	20	177	50	143	286.0
41	пальто	ш	-	-	-	4	11	10	31	55	96	46	56	124.4
42	булгар	мян.м2	-	-	-	-	1.6	0.4	2	0.4	0.2	0.4	0.7	175.0
43	шөврө	мян.м2	-	-	-	-	1.2	0.3	1.3	3.9	0.3	0.3	0.9	300.0
44	жөх шир	тн	-	-	-	-	0.9	0.6	1.6	2.2	1.65	2.5	2.4	98.0
45	гутал	хос	-	1980	131	470	979	4908	5208	4769	5078	4887	3900	81.0
46	хивээг	тн	3015.5	1726.1	17.4	13.5	408	202.8	935.3	1147.3	143.1	574.8	63.3	11.0
47	тавилга	ш	-	-	-	-	-	26	5	30	81	57	328	575.4
48	морин хуур	ш	-	-	-	-	-	19	24	112	29	-	60	-
49	платье	ш	-	-	-	-	-	65	50	79	33	61	-	-
50	хангааз	ш	-	-	-	-	-	100	10	-	-	-	71	-
51	өмд	ш	-	-	-	-	-	0	10	-	21	33	-	-
52	сандаг	ш	-	-	-	-	-	44	45	52	4	54	40	74.1
53	ширээ	ш	-	-	-	-	-	12	0	14	18	31	57	183.9
54	эсгий	мян.м	-	1.7	1	1	2.5	3.6	-	4.5	4.29	6.8	8.5	125.0
55	аяны уут, хөнгөл	ш	-	-	-	-	90	90	-	6	320	465	165	35.5
56	хөөсөнцөр хавтан	м3	-	-	-	-	-	-	-	-	82.8	1202	430	35.8
57	вакуум цонх	м2	-	-	-	-	125.3	-	-	-	-	-	170	-
58	тоосго	мян.ш	4017.3	-	0	-	1528	2900	700	1400	2920	1400	3700	264.3
59	дээврийн хавтан	мян.м2	-	-	-	-	3303.3	-	-	-	-	0.5	1.5	300.0
60	бетон зуурмаг	м3	4377.9	-	9.6	-	-	-	-	607	7058.3	6313.4	4134.4	65.5
61	замын хашлага	м2	-	-	-	-	728	-	-	-	-	-	625	-
62	төмөр хаалга	м2	-	-	-	-	-	-	-	-	24	84	10	11.9
63	стикер хэвлэл	мян.м2	-	-	-	-	-	0.1	-	-	3.8	-	-	-
64	машин суудлын бүрээс	ш	-	-	-	-	-	-	-	112	244	227	157	69.2
65	машин хучлага	ш	-	-	-	-	-	-	-	10	24	12	0	0.0
66	сандлын бүрээс	ш	-	-	-	-	-	-	-	112	49	60	366	610.0
67	хүснэгт маягт	мхдх	952.5	180.2	28.8	-	-	-	-	-	-	-	-	-
68	гэрийн бүрээс	ш	-	83	21	-	127	68	-	2	2	71	51	71.8
69	гэрийн хөшиг	ш	-	-	24	-	-	-	-	-	-	-	-	-
70	лаа	мян.ш	-	2.5	6	-	-	-	-	-	-	-	-	0.3
71	сонин	мян.ш	885.1	62.5	-	-	-	-	-	-	-	-	-	-
72	Хог зайлуулалт	м3	-	-	-	-	-	-	-	-	-	27429.6	20885.4	78.1
73	гар урлалын зүйл	ш	-	-	-	-	-	-	-	-	8500	760	420	55.3
74	саван	тн	57.6	-	-	-	-	-	-	-	-	-	-	0.4

Эх

сурвалж: Увс аймгийн Статистикийн хэлтэс

Аж үйлдвэрийн салбарт энэ онд оны үнээр 20.1 тэрбум төгрөгийн нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэж 25.1 тэрбум төгрөгийн борлуулалт хийсэн нь өнгөрсөн оны мөн үеэс үйлдвэрлэлт 3.3 хувиар буурч, бүтээгдэхүүний борлуулалт 13.1 хувиар өссөн байна. Нийт үйлдвэрлэлтийн 43.8 хувийг дулаан түгээлт, усан хангамж, хог зайлуулалт, 43.4 хувийг



боловсруулах салбарын үйлдвэрлэл, 12.8 хувийг уул уурхайн олборлолт эзэлж байна. Өнгөрсөн оны мөн үеэс уул уурхайн олборлолт 27.0, дулаан усан хангамж 10.6 хувиар өсөж, боловсруулах салбарын үйлдвэрлэл 18.7 хувиар буурсан байна.

3.5.4 Хөдөө аж ахуй

Мал аж ахуй

Увс аймаг нь 2020 оны байдлаар улсын нийт мал сүргийн 5.1%, баруун бүсийн мал сүргийн 21.5% буюу 3.4 толгой мал сүрэгтэй байна. Тус аймгийн мал сүргийн тоо сүүлийн 10 жилийн байдлаар тогтвортой өссөн үзүүлэлттэй байгаа юм.

Хүснэгт 3. 31 Увс аймгийн нийт малын тоо, төрлөөр /мян/

Малын төрөл		2011 он	2012 он	2013 он	2014 он	2015 он	2016 он	2017 он	2018 он	2019 он	2020 он
Бүгд	Тоо	1,831.8	2,030.7	2,225.1	2,561.3	2,729.1	2,784.1	3,129.9	3,175.3	3,279.6	3,409.3
	Өсөлтийн коэф		9.8%	8.7%	13.1%	6.1%	2.0%	11.0%	1.4%	3.2%	3.8%
Адуу	Тоо	64.0	70.4	77.0	88.4	98.0	105.7	119.5	123.8	130.7	139.3
	Өсөлтийн коэф		9.2%	8.5%	13.0%	9.8%	7.2%	11.6%	3.5%	5.3%	6.2%
Үхэр	Тоо	95.7	108.0	122.6	145.4	156.8	161.1	176.9	182.9	195.7	211.5
	Өсөлтийн коэф		11.5%	11.9%	15.7%	7.3%	2.6%	8.9%	3.3%	6.5%	7.5%
Тэмээ	Тоо	15.5	16.9	17.9	19.5	20.5	21.9	23.5	25.2	25.6	25.5
	Өсөлтийн коэф		8.7%	5.4%	8.3%	5.0%	6.3%	6.8%	6.5%	1.9%	-0.5%
Хонь	Тоо	851.5	976.0	1,081.3	1,260.5	1,337.0	1,376.5	1,552.1	1,568.0	1,604.8	1,622.7
	Өсөлтийн коэф		12.8%	9.7%	14.2%	5.7%	2.9%	11.3%	1.0%	2.3%	1.1%
Ямаа	Тоо	805.3	859.3	926.4	1,047.4	1,116.7	1,119.0	1,257.9	1,275.5	1,322.8	1,410.3
	Өсөлтийн коэф		6.3%	7.2%	11.6%	6.2%	0.2%	11.0%	1.4%	3.6%	6.2%

Эх сурвалж: 1212.мн

Хүснэгт 3. 32 Бүх малын тоо, сумаар



Сум	1990	1995	2000	2005	2010	2015	2016	2017	2018	2019	2020	2020 2019
Хэмжих нэгж	толгой											хувь
Бүгд	1666649	1754225	1579318	2021258	1619312	2729106	2784140	3129884	3175275	3279600	3409252	104.0
Баруунтуруун	41457	54779	35228	33434	32028	59192	61350	68543	73395	78072	86398	110.7
Бөхмөрөн	62682	68685	64620	66554	77402	114644	119109	134496	141223	140469	147539	105.0
Давст	62043	42567	39883	69777	62587	77378	72623	83229	89915	98507	94868	96.3
Завхан	62911	98900	73101	70162	47731	104137	105835	126456	124820	130855	148688	113.6
Зүүнговь	81471	67290	80250	101264	52517	117101	112273	123834	132295	142496	149770	105.1
Зүүнхангай	95860	103847	88658	107063	80946	145355	147950	163671	160708	178428	186342	104.4
Малчин	109870	111299	96442	112876	93855	145523	151592	161823	166560	174287	178296	102.3
Наранбулаг	114896	114393	107551	149962	106163	210075	215143	240149	248373	233055	250108	107.3
Өлгий	92205	113387	81118	81201	49665	111457	112008	131493	129895	115024	135372	117.7
Өмнөговь	130421	138820	87312	137308	87039	192716	196153	227931	233152	211186	237376	112.4
Өндөрхангай	96208	98661	93178	129445	101726	190081	174858	215201	201874	236586	247302	104.5
Сагил	71919	80684	74208	119315	101456	145918	148399	166887	178769	187033	191729	102.5
Тариалан	124982	102901	95001	130461	66092	126293	136328	154027	159269	150192	153206	102.0
Түргэн	59137	61174	67751	82089	63914	111111	125654	136743	143959	144623	137920	95.4
Тэс	136029	126053	159224	200399	211757	284860	268454	285349	265896	287902	279836	97.2
Ховд	83099	86663	70609	79809	78023	132532	138555	157549	161617	162956	167996	103.1
Хяргас	104453	100057	89482	123601	103483	166793	178308	194584	194326	208440	208630	100.1
Цагаанхайрхан	75806	73620	89914	105009	85547	141810	153152	171506	169080	183347	185229	101.0
Улаангом	47011	102238	85788	121529	117381	152130	166396	186413	200149	216142	222647	103.0
Хархираа	14189	8207										

Эх
сурвалж: 1212.mn

2020 оны эцэст 3409.3 мянган толгой мал үүний дотор 25.5 мянган тэмээ, 139.3 мянган адуу, 211.5 мянган үхэр, 1622.7 мянган хонь, 1410.3 мянган ямаатай болж тэмээ 0.1 (0.6%) мянга буурч, адуу 8.7 (6.6%) мянга, үхэр 15.8 (8.1%) мянга, хонь 17.9 (1.1%) мянга, ямаа 87.4 (3.7%) мянган толгойгоор дөрвөн төрөлдөө өсч, өнгөрсөн оноос нийт малын тоо 129.7 (4.0%) мянган толгойгоор нэмэгдсэн байна.

Хүснэгт 3. 33 Үхрийн тоо, сумаар

Сум	1990	1995	2000	2005	2010	2015	2016	2017	2018	2019	2020	2020 2019
Хэмжих нэгж	толгой											хувь
Бүгд	162289	181900	105737	108892	84378	156818	161046	176866	182922	195711	211498	108.1
Баруунтуруун	8537	9107	5086	3763	3539	7328	7686	8331	8768	9743	10860	111.5
Бөхмөрөн	5149	6311	4307	3728	3911	5691	5975	6859	7179	7217	7935	109.9
Давст	7449	5109	3433	3924	3460	5232	5073	5856	6550	7253	7859	108.4
Завхан	1607	3193	566	884	427	1114	1253	1527	1609	1494	1629	109.0
Зүүнговь	9268	9761	8716	8108	4750	10809	10050	10883	12068	13126	14397	109.7
Зүүнхангай	9395	12436	5258	4860	3606	7754	7928	8887	9136	10358	11562	111.6
Малчин	7466	10151	4108	4868	3603	6539	6808	7013	6715	7273	7992	109.9
Наранбулаг	6616	7093	2555	4488	2756	6225	6650	7090	6919	6641	7618	114.7
Өлгий	4328	5787	1395	2179	905	2442	2535	3009	2882	2793	3276	117.3
Өмнөговь	8224	9692	3116	5107	2639	7426	7898	8883	8843	8561	9284	108.4
Өндөрхангай	10827	12342	6359	6824	5197	11104	11038	12743	12635	14211	15631	110.0
Сагил	7238	8895	5266	5839	4934	10345	9714	11177	11969	12460	13304	106.8
Тариалан	11190	9120	4724	4876	1983	4953	5013	5943	6148	6148	6805	110.7
Түргэн	7195	7294	4567	3644	2148	6483	7020	7187	7832	7889	7613	96.5
Тэс	19836	22538	22507	21126	19373	27235	27095	28525	29101	32226	33337	103.4
Ховд	8130	7227	4387	4157	3442	6520	6959	7964	8447	8974	9595	106.9
Хяргас	7676	8805	4010	4039	2876	6330	6788	7125	6508	7172	7776	108.4
Цагаанхайрхан	6904	6252	4510	2871	1838	4051	4503	5062	5231	5865	6341	108.1
Улаангом	12939	19077	10867	13607	12991	19237	21060	22802	24382	26307	28684	109.0
Хархираа	2315	1710										

Эх
сурвалж: 1212.mn

Хүснэгт 3. 34 Хонины тоо толгой, сумаар



Сум	1990	1995	2000	2005	2010	2015	2016	2017	2018	2019	2020	2020 2019
Хэмжих нэгж	толгой											хувь
Бүгд	1020210	945733	858613	987682	776925	1337011	1376483	1552090	1567962	1604786	1622664	101.1
Баруунтуруун	28107	34585	18536	11994	11787	21744	22587	24880	26 664	27165	29750	109.5
Бөхмөрөн	36969	34085	31383	26725	31120	49703	52541	59876	62 645	61780	63980	103.6
Давст	33719	20646	20261	31979	28340	36124	34730	39671	42 180	46124	43699	94.7
Завхан	25561	39627	29290	19629	13453	32426	33958	40464	41 407	43239	49134	113.6
Зүүнговь	56779	42188	50580	58485	28551	61663	60832	68257	72 352	75661	77719	102.7
Зүүнхангай	60050	57710	52777	57307	40258	76330	78083	87638	86 472	94422	95928	101.6
Малчин	75369	68302	57390	61029	53482	88760	93956	100955	104 503	108723	109231	100.5
Наранбулаг	67830	56933	56802	71976	51992	107280	112506	124564	131 261	123570	128400	103.9
Өлгий	51337	54310	40145	30467	16498	40539	41543	48759	49 207	41532	47407	114.1
Өмнөговь	82593	78507	48237	68157	38638	89059	93624	109059	113 708	100664	108284	107.6
Өндөрхангай	57806	49642	47570	60140	45146	88398	79836	99886	93 836	109173	113451	103.9
Сагил	43635	42014	39515	57689	49996	71909	73038	83156	87 632	90567	93305	103.0
Тариалан	82809	61740	57193	73750	37119	68251	75228	86270	89 665	86637	84909	98.0
Түргэн	35543	33942	37849	44190	34044	58749	66814	74836	77 228	78315	74244	94.8
Тэс	88039	72170	93794	120066	127490	175507	162967	170699	152 319	159090	150250	94.4
Ховд	42880	39262	29321	24065	21204	39590	42633	49906	49 555	50333	49929	99.2
Хяргас	66566	60420	54287	67721	56729	96212	102883	115837	116 111	122986	120978	98.4
Цагаанхайрхан	47368	37194	45268	47429	36673	64061	70279	77713	75 720	81323	80216	98.6
Улаангом	27750	58880	48415	54884	54405	70706	78445	89664	95 497	103482	101850	98.4
Хархираа	9500	3576										

Эх сурвалж: 1212.mn

Хүснэгт 3. 35 Тэжээвэр амьтдын тоо, төрлөөр

№	Үзүүлэлт	2011	2012	2013	2014	2015	2016	2017	2018	2019	2020
		ОН	ОН	ОН	ОН	ОН	ОН	ОН	ОН	ОН	ОН
1	Тахиа	1580	190	210	250	120	140	40	200	220	277
	Өсөлтийн коэф		-88.0%	10.5%	19.0%	-52.0%	16.7%	-71.4%	400.0%	10.0%	25.9%
1.1	Өндөг- лөгч	1160	60	130	210	110	120	40	170	140	122
	Өсөлтийн коэф		-94.8%	116.7%	61.5%	-47.6%	9.1%	-66.7%	325.0%	-17.6%	-12.9%
2	Гахай	59	115	279	414	173	135	77	161	188	210
	Өсөлтийн коэф		94.9%	142.6%	48.4%	-58.2%	-22.0%	-43.0%	109.1%	16.8%	11.7%
2.1	Мэгж	36	17	65	110	85	75	30	68	78	130
	Өсөлтийн коэф		-52.8%	282.4%	69.2%	-22.7%	-11.8%	-60.0%	126.7%	14.7%	66.7%

Эх сурвалж: 1212.mn

Хүснэгт 3. 36 Тэжээвэр амьтдын тоо, сумаар

Сум	Гахай						Шувуу					
	2015	2016	2017	2018	2019	2020	2015	2016	2017	2018	2019	2020
Дүн	0.173	0.135	0.073	0.161	0.178	0.205	0.122	0.136	0.042	0.161	0.148	0.207
Улаангом	0.126	0.101	0.054	0.142	0.16	0.183	0.023	0.034	0	0.048	0.06	0.085
Баруунтуруун			0.011	0.019	0.018	0.022		0.038	0	0		0.014
Өндөрхангай	0.041	0.024	0.008				0.075	0.03	0.015			
Хяргас	0.006	0.01										
Зүүнговь												0.02
Сагил							0.024	0.034	0	0.042	0.032	0.032
Ховд									0.027	0.071	0.056	0.056
Цагаанхайрхан										0.039	0.07	0.07
Зөгийн бүл	138	65	42	85	65	104						

Эх
сурвалж: 1212.mn



Увс аймагт 2020 оны байдлаар нийт 277 тахиа байгаагийн хувь нь буюу 122 өндөглөгч тахиа, нийт 210 гахай байгаагийн хувь нь буюу 130 мэж байна. Сүүлийн 10 жилийн байдлаар тахианы тоо 82.5 хувиар, гахайны тоо 261 хувиар өссөн үзүүлэлттэй байгаа юм. Аймгийн нийт хүн амын мах махан бүтээгдэхүүний жилийн хэрэгцээ нь 5,7 мян/тн бөгөөд жилд дунджаар 17,0-18,0 мян/ тн мах бэлтгэж, аймгийнхаа хэрэгцээг бүрэн хангаж, үлдэгдлийг нь дотоод гадаадын зах зээлд нийлүүлж байна. Эргэлтэнд орсон малын сүргийн эзлэх хэмжээ нь хонь-21,1%, ямаа-16,%, үхэр-11, %, адуу-5,1%, тэмээ-4,8% байгаа бөгөөд нийт мал сүргийн 17,9 хувийг эзэлж байна.

Цаашид махны нөөцийг тодорхой хэмжээгээр нэмэгдүүлж болох бөгөөд дотоодын махны хэрэгцээнд 276,6 мян/толгой мал, арилжааны болон төвийн бүсийн хүн амын хэрэгцээнд 213,1 мян/толгой мал буюу нийт 4,7 мян/тонн махыг бэлтгэн нийлүүлэх бүрэн боломж байна. Хэрэглэгчийн эрэлт хэрэгцээ хангагдахын тулд хүнсний бүтээгдэхүүний хадгалалт, тээвэрлэлт болон ачилт буулгалтын явц чанарын тодорхой түвшинд хийгдэх шаардлагатай. Ингэснээр, хорогдол болон бохирдох магадлалыг хамгийн бага түвшинд байлгах, хэрэглэгчдийн эрүүл мэндэд эрсдэл учрахаас сэргийлэх ач холбогдолтой.

Увс аймгийн хэмжээнд логистик төв байхгүй улмаас дээр дурдсанчлан мах үйлдвэрлэлийн хэмжээ хязгаарлагдмал байна. Тухайлбал экспортын гол нэрийн бараа болох мах бэлтгэлийг нэмэгдүүлэх ихээхэн боломжтой хэдий ч , ихээхэн хэмжээгээр нөөцлөх агуулах байхгүй байна. Аймгийн хэмжээнд байгаа сургууль, цэцэрлэг, зоогийн газар зэрэг олон нийтийн байгууллагуудыг төмс, хүнсний ногоо, махаар тогтмол хангах хэрэгтэй байдаг.

Газар тариалан

Аймгийн хэмжээнд 2020 оны байдлаар улсын нийт газар тариалангийн талбайн 6%, баруун бүсийн нийт газар тариалангийн талбайн 80.5% буюу 35,968.5 газар тариалан эрхэлжээ. Нийт газар тариалангийн талбайн 48.2%-д нь үр тариа; 45.8%-д нь буудай; 0.5%-д нь төмс; 0.5%-д нь хүнсний ногоо; 5.1%-д нь таримал тэжээл тус тус тариалжээ. Сүүлийн 10 жилийн хугацаанд аймгийн газар тариалан эрхлэлтийн үзүүлэлтийг авч үзвэл 2011-2014 онд өссөн, 2014-2017 онд буурсан, 2017-2020 онд өссөн үзүүлэлттэй байгаа юм.

Хүснэгт 3. 37 Газар тариалан (га)

№	Үзүүлэлт	2011 он	2012 он	2013 он	2014 он	2015 он	2016 он	2017 он	2018 он	2019 он	2020 он
1	Үр тариа	6,518.2	8,443.0	10,276.5	8,308.6	5,951.3	5,195.3	9,235.2	14,580.0	16,548.0	25,983.7
2	Буудай	6,123.5	8,341.0	10,037.0	8,095.8	5,707.8	4,694.0	8,786.9	14,155.0	15,981.5	24,697.0
3	Төмс	234.4	276.1	238.3	153.7	215.5	248.6	273.6	265.8	259.0	250.1
4	Хүнсний ногоо	175.4	208.2	231.0	192.2	222.9	273.2	274.4	275.1	272.5	277.1
5	Таримал тэжээл	609.6	681.3	454.0	1,177.4	1,664.5	1,980.0	1,891.8	2,367.5	2,907.5	2,737.1
НИЙТ		13,661.1	13,661.1	17,949.6	21,236.8	17,927.7	13,762.0	12,391.1	20,461.9	31,643.4	35,968.5

Эх сурвалж: 1212.mn

Хүснэгт 3. 38 Хураан авсан төмс, сумаар



Сум	1990	1995	2000	2005	2010	2015	2016	2017	2018	2019	2020	2020 2019
Хэмжих нэгж	ТОНН											хувь
БҮГД	3391.4	655.8	1715.4	1921.1	2194.6	2768.5	3191.5	3220.5	2814.3	2664.0	2787.2	104.6
Баруунтуруун	731	87	64.6	248	300	300.0	262.6	250.0	360.0	307	275	89.6
Бөхмөрөн	5		15.6	24	18	25.0	39.0	30.0	30.0	30	21	70.0
Давст	128.9	30.4	33.2	11.3	22.8	9.9	18.0	7.3	4.5	5.4	5.71	105.7
Завхан					0.4	0.0	0.9		0.0	0.16	0.4	250.0
Зүүнговь	105	28.8	6.4	17.1	31	18.5	11.4	15.0	16.0	14.5	29	200.0
Зүүнхангай	103	25	1.5	10	10.5	0.0	0.0					
Малчин	66.7	15	10	25	26	2.0	14.5	9.5	14.6	8.7	10.96	126.0
Наранбулаг	200	30.7		21	115.7	86.6	46.0	9.7	73.0	73.1	46	62.9
Өлгий	162.2	6.4	16.1	12.4	32	10.0	10.0	3.0	2.0	1.1	6.6	600.0
Өмнөговь	75.4	8	4.4	29.5	28	73.1	71.2	106.5	78.1	42.4	51	120.3
Өндөрхангай		5		8	15	4.0	0.9	1.3	4.8	12	2	16.7
Сагил	7		27.5	35.2	54.2	22.0	85.2	80.5	69.9	85.05	70.7	83.1
Тариалан	110	162.4	524	215.6	173	144.3	382.0	510.0	397.8	210	210.5	100.2
Түргэн	38.2	3.5	1.4	28.7	34.1	33.7	31.0	36.0	120.2	30	31.6	105.3
Тэс	20		1.6		14.1	5.1	25.5	22.0	28.0	25	13	52.0
Ховд	80	5	3.2	18.6	28	2.3		4.5	6.0	1.8	25.5	1416.7
Хяргас	55	35	39.2	12.3	22.6	44.0	55.0	61.0	34.5	37.7	21.51	57.1
Цагаанхайрхан	47.5	20	40	36.2	36	20.0	18.7	26.0	2.0	13	13.73	105.6
Улаангом	544.5	193.6	926.7	1168.2	1233.2	1968.0	2119.5	2048.2	1573.0	1767.1	1953	110.5
Хархираа	912											

Эх сурвалж: 1212.mn

1990 онд аймгийн хэмжээнд нийт 3391.4 тн төмс хурааж авч байсан. Үүнд Баруунтуруун, Давст, Наранбулаг, Өлгий зэрэг сумууд одоогийнхоор 2-3 дахин их төмс хураан авч байсан байна. Харин Улаангом, Тариалан зэрэг сумд төмс тариалалт, хураалт тогтвортой өссөн байна. 2020 оны байдлаар аймгийн хэмжээнд нийт 2787.2 тн төмс хураан авсан, үүний 1953 тн Улаангом хураан авсан байна. Сумд хураан авсан төмсөө өөрсдийн нүхэн зооринд хадгалж байна. Улаангомд төмс хадгалах зорь хангалттай хэмжээнд байж чадахгүй байна.

Хүснэгт 3. 39 Хураан авсан хүнсний ногоо, сумаар

Сум	1990	1995	2000	2005	2010	2015	2016	2017	2018	2019	2020	2020 2019
Хэмжих нэгж	ТОНН											хувь
БҮГД	1757.8	427.7	1030	1316.3	1865.8	2655.5	3404.7	3114.9	2907.0	2433.7	2637.9	108.4
Баруунтуруун	401.2	6.1	96	189.1	288	239.00	390.6	305.5	290	228.0	221.6	97.2
Бөхмөрөн			4.1	4.2	10	16.00	21.0	16.4	23.25	21.0	18.0	85.7
Давст	127.8		20.9	17.7	11.1	6.00	15.9	5.9	13.19	6.7	6.2	92.5
Завхан					0.3	3.00	1.1	0.0	0.9	0.7	1.6	247.0
Зүүнговь	19.8	1.1	4.9	7.7	23	5.07	4.0	11.0	11.8	11.5	21.6	187.8
Зүүнхангай				5	13	0.00	0.0					
Малчин	50	6	11	10.7	22.5	2.00	14.4	1.5	11	8.8	12.1	137.7
Наранбулаг	126.2	17.6		29	74.9	92.00	101.6	10.8	79.4	83.4	46.2	55.4
Өлгий	21.7	1	20.6	2	12	3.60	3.1	1.9	2.1	0.5	7.1	1420.0
Өмнөговь	35.4	1.5	1.8	11	23.4	78.50	62.3	116.4	162.29	26.6	43.8	164.7
Өндөрхангай				5	7.5	1.40	0.3	0.5	7.3	10.5		0.0
Сагил			12	11.5	35.4	21.85	46.4	40.9	68.96	82.0	50.7	61.8
Тариалан	141.8	39.7	199	114.7	165	205.60	503.3	581.0	527.2	366.1	474.9	129.7
Түргэн	25.5		1	30.6	42.8	23.77	27.0	22.1	293.81	24.6	41.0	166.5
Тэс	43.7		0.3		4.5	7.70	19.5	22.6	26.4	23.2	17.8	76.7
Ховд				6	25	6.40		4.5	8.5	0.9	9.4	1037.8
Хяргас	37.8	5	13.6	6.4	15	32.00	37.3	37.3	20.985	40.1	16.0	39.8
Цагаанхайрхан	17	8	21	7.5	10.6	12.00	11.2	18.0	4.4	10.2	32.8	323.1
Улаангом	440.6	341.7	623.8	858.2	1081.8	1899.6	2145.7	1918.7	1355.491	1489.0	1617.1	108.6
Хархираа	269.3											

Эх
сурвалж: 1212.mn



Увс аймгийн хэмжээнд хүнсний ногооны тариалалт, ургац хураалт тогтвортой өсөж байна. 1990 онд аймгийн хэмжээнд 1757.8 тн хүнсний ногоо хураан авч байсан бол 2020 онд 2637.9 тн хүнсний ногоо хураан авсан. Баруунтуруун, Наранбулаг, Тариалан, Улаангом сумууд дийлэнх хүнсний ногоо хураан авч байна. 2020 онд Улаангом сум 1617 тн хүнсний ногоо хураан авсан байна.

Жимс, жимсгэний тариалалт

2016 оны судалгаагаар 600 гаруй га-д 346 тариалагч чацаргана тариалагдсан байна. Үүнээс 463 га талбай, 217 тариалагч нь Улаангом суманд байна. Жилд 550-950 тн жимс хураан авч 250-300 тн-ыг боловсруулан үлдсэн жимсийг нь гадны хүмүүс, компанид нийлүүлж байна.

Хүснэгт 3. 40 Жимс жимсгэнэ тариалсан талбай, төрлөөр (га)

№	Үзүүлэлт	2011 он	2012 он	2013 он	2014 он	2015 он	2016 он	2017 он	2018 он	2019 он	2020 он
1	Чацаргана	505.3	365.2	399.5	313.5	416.1	295.1	428.1	557.8	552.8	609.3
2	Ранетка	-	-	-	0.1	0.1	-	-	-	-	-
3	үхрийн нүд	39.5	42.8	79.1	32.0	50.7	39.9	75.5	61.7	61.9	66.4
4	Бөөрөлзгөнө	-	-	-	-	-	-	-	-	-	-
5	Гүзээлзгэнэ	-	-	-	0.03	0.03	-	-	-	-	-
6	Бусад	-	-	-	0.02	-	-	-	-	-	-
Нийт		544.8	408.0	478.6	345.5	466.9	335.0	503.6	619.5	614.7	675.7

Эх сурвалж: 1212.mn

Чацарганы жимсийг боловсруулдаг бүртгэгдсэн 35 ААН үйл ажиллагаа явуулж байгаагаас үйлдвэрийн дамжлагатай Увс хүнс ХК, Ус-Эрдэнэ ХХК байх бөгөөд бусад нь жижиг оврын шахагч, тос ялгагч ашиглан гар аргаар боловсруулан гадна дотны зах зээлд нийлүүлж байна.

Хүснэгт 3. 41 Хураан авсан жимс жимсгэнэ, улс, аймаг, жилээр

Жимс жимсгэнэ	2000	2015	2016	2017	2018	2019	2020
ТОНН							
Жимс, жимсгэнэ, бүгд	578.2	1418	1632.7	1488.6	1701.3	1784.3	1600.2
Увс аймгийн дүн	159.8	822.8	818.4	844.8	932.4	945	848
Үүнээс : Улсын, дүн		1225.1	1371.8	1189.1	1397.1	1512.5	1331
Чацаргана аймгийн дүн		753.1	710.6	737.2	792.8	810.2	711.5

Увс аймаг нь 2020 оны байдлаар 675.7 га талбайд жимс жимсгэнэ тариалсны 90.2 хувь буюу 609.3 га талбайд чацаргана, 9.8 хувь буюу 66.4 га талбайд үхрийн нүд тарьжээ. Тус аймгийн чацаргана тариалалт нь улсын 20 хувь; баруун бүсийн 73.3 хувийг эзэлж байгаа бөгөөд үхрийн тариалалт нь улсын 38 хувь, баруун бүсийн 75.8 хувийг эзэлж байна.

3.5.5 Худалдаа, үйлчилгээ

Бөөний болон жижиглэн худалдааны салбарын нийт борлуулалт 2020 онд 24.9 тэрбум төгрөг болж өнгөрсөн оны мөн үеэс 10.7 тэрбум буюу 8.0 хувиар өссөн байна.

Хүснэгт 3. 42 Худалдааны салбарын борлуулалт, бүс, аймаг, нийслэлээр



Аймаг	2012	2013	2014	2015	2016	2017	2018	2019	2020	2020 2019
хэмжих нэгж	Тэрбум төгрөг									Хувь
Улсын дүн	9,003.9	12,065.8	12,804.3	13,526.6	13,199.2	14,892.8	20,706.0	23,646.9	22,033.6	93.2
Баруун бүс	124.7	137.2	156.2	148.6	225.8	328.4	449.8	514.6	534.3	103.8
Баян-Өлгий	34.1	34.3	34.4	37.1	89.9	80.3	112.7	132.1	140.5	106.4
Говь-Алтай	24.1	30.5	19.4	17.2	30.2	37.9	49.7	54.4	57.0	104.8
Завхан	18.9	20.7	22.4	18.5	22.2	45.0	65.4	75.0	83.9	111.9
Увс	27.1	27.3	56.2	49.1	54.9	99.1	131.4	133.5	144.2	108.0
Ховд	20.5	24.4	23.8	26.7	28.6	66.1	90.6	119.6	108.7	90.9

Зочид буудлын салбарын нийт орлого 2020 онд 210.2 сая төгрөг болж өнгөрсөн олны мөн үеэс 136.8 сая төгрөг буюу 39.4 хувиар буурсан байна. Нийтийн хоолны салбарын орлого 2020 онд 720.4 сая төгрөг болж өнгөрсөн оны мөн үеэс 54.2 сая төгрөг буюу 7.0 хувиар буурсан байна.

Хүснэгт 3. 43 Зочид буудлын салбарын орлого, бүс, аймаг, нийслэлээр

Аймаг	2012	2014	2015	2016	2017	2018	2019	2020	2020 2019
хэмжих нэгж	Сая төгрөг								Хувь
Улсын дүн	110,237.9	122,117.1	134,240.5	143,323.5	157,957.9	215,698.2	297,833.6	131,394.3	44.1
Баруун бүс	646.7	824.	531.5	929.6	1,693.3	1,161.5	2,540.6	1,514.4	59.6
Баян-Өлгий	240.	259.1	106.5	96.3	137.9	150.6	276.4	233.4	84.4
Говь-Алтай	19.3	73.4	38.3	228.4	374.7	222.7	291.2	288.2	99.0
Завхан	128.3	247.4	183.5	366.2	376.7	349.4	404.	268.7	66.5
Увс	58.1	63.	62.9	53.3	87.1	104.6	347.	210.2	60.6
Ховд	201.	181.1	140.4	185.4	717.	334.2	1,222.	513.9	42.1

Хүснэгт 3. 44 Нийтийн хоолны салбарын орлого, бүс, аймаг, нийслэлээр

Аймаг	2013	2014	2015	2016	2017	2018	2019	2020	2020 2019
хэмжих нэгж	Сая төгрөг								Хувь
Улсын дүн	192,290.	201,462.	205,548.1	249,051.4	321,431.9	402,601.7	484,966.3	451,181.8	93.0
Баруун бүс	2,322.	2,294.2	1,625.72	2,422.5	2,178.	3,374.5	4,812.2	5,289.1	109.9
Баян-Өлгий	427.	533.	517.48	676.8	858.6	1,065.6	1,355.4	1,201.2	88.6
Говь-Алтай	246.	230.2	272.16	542.5	424.9	573.8	747.2	1,317.2	176.3
Завхан	80.	123.1	223.65	421.1	356.	709.5	765.6	1,317.2	172.0
Увс	1,288.	1,071.9	251.58	328.8	239.3	479.5	774.6	720.4	93.0
Ховд	281.	336.	360.85	453.3	299.1	546.1	1,166.8	893.7	76.6

3.6 УВС АЙМГИЙН ЛОГИСТИКИЙН ӨНӨӨГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

3.6.1 Увс аймгийн авто зам, ачаа тээврийн одоогийн байдал

Аймаг хоорондын тээврийн одоогийн байдал

Увс аймгийн Улаангом суманд 1924 онд худалдааны трест байгуулагдаж байсан байна. Тус трест нь 1970 оны байдлаар 1648м² барааны агуулах, 40м² түүхий эдийн агуулахтай, нийт 240 ажиллагчидтай байжээ. Тус трест нь 1970 онд гэхэд 14413.4 мян.төг-ийн барааны гүйлгээ хийсэн бөгөөд тус оны жилийн эцсийн байдлаар 1812.6 мян.төг-ийн үндсэн хөрөнгөтэй байжээ. 1990 оны шилжилтийн үеийн дараа тус трестийн үйл ажиллагаа зогссон. Сүүлийн жилүүдэд авто замын дэд бүтэц, уул уурхайн тээвэрлэлтийн өсөлтийг дагаад авто тээврийн салбарын эдийн засгийн үзүүлэлт тогтмол нэмэгдэж байна.

Увс аймаг авто замын 2 үндсэн тэнхлэгтэй. Үүнд:

- Баруунаас зүүн чиглэлийн зам нь Улаангомоос Наранбулаг сумаар дамжин Улаанбаатарын чиглэлд тавьсан хатуу хучилттай зам бөгөөд Ханхөхийн нурууны өврөөр, Хяргас нуурын араар явж, Увс аймгийн баруун талыг хоорондоо



холбоогүй хоёр хэсэг болгон тусгаарладаг. Тус зам Улаангом хүртэл хатуу хучилттай, ашиглалтын нөхцөл байдал сайн,

- Хойноос урагш чиглэлийн зам ОХУ-тай хиллэж буй улсын хилийн Боршоо боомтоос Улаангом, Наранбулаг, Өлгий, Мянгад сумдаар дамжин Ховд аймгийн төв (цааш Булган сум, БНХАУ-тай хиллэж буй улсын хилийн Ярантайн боомт) хүрнэ. Тус зам Боршоогоос Наранбулаг хүртэл хатуу хучилттай, Наранбулагаас Өлгий, Мянгад сумд хүртэл хатуу хучилтгүй, сайжруулсан шороон зам, Мянгадаас Ховд хот хүртэл хатуу хучилтай.¹⁴

Увс аймгийн төв Улаангом сум нь Улаанбаатар хотоос 1456 км-т орших бөгөөд хатуу хучилттай авто замаар холбогдсон.

Аймаг хоорондын ачаа тээвэрлэлтийн хэмжээг тодорхойлсон албан ёсны мэдээлэл одоогоор байхгүй байна. Харин Зам, тээвэр хөгжлийн төвийн улирал бүр нэг удаа явуулдаг авто замын хөдөлгөөний эрчмийн тооллогоор хөдөлгөөнд оролцсон ачааны машины тоог гаргах боломжтой байна. Гэвч уг мэдээллээр хэдий хэмжээний, ямар ачааг тээвэрлэсэн талаарх мэдээллийг гаргаагүй байна.

Аймаг хоорондын ачааны тоо хэмжээ болон тээвэрлэдэг ачааны тоо хэмжээг тодорхойлох өөр нэгэн боломж нь 2020-2021 онд ковидын хөл хорионы дэглэмийн үед ачаа тээврийн машинуудад өгч байсан QR кодын зөвшөөрлөөр аймаг хоорондын ачаа тээвэрлэлтийн мэдээлэл байсан. Гэсэн хэдий ч тус мэдээллийн өгөгдлүүдийг бүрэн бөглөөгүй, бараа бүтээгдэхүүнийг нэр төрлөөр нарийн ангилж гаргаагүй гэх мэт сул талууд байна. Ямар барааг хаанаас хаашаа тээсэн мэдээлэл гарсан байна түүнийг дэлгэрэнгүй оруулах

Мөн бид Увс аймагт холбогдох талуудтай хийсэн уулзалтаар Увс аймаг бусад аймгуудтай дараах ачаа барааг зөөдөг гэсэн мэдээллийг авсан.

Хүснэгт: Увс аймгийн ачаа тээвэр, 2020.12-р сараас 2021.06-р сард QR кодоор тээвэрлэж байх үеийн нөхцөлөөр


№	Хүнсний бүтээгдэхүүний нэр төрөл	Увсаас гарч байгаа ачааны хэмжээ /тн/	Увс руу орж байгаа ачааны хэмжээ /тн/
1	Мах, махан бүтээгдэхүүн	6916	89
2	Сүү, сүүн бүтээгдэхүүн	19.6	-
3	Гурил	100	4334
4	Гурилан бүтээгдэхүүн	56	-
5	Төрөл бүрийн будаа	3576	40
7	Хүнсний ногоо	-	25
8	Жимс, жимсгэнэ, бүтээгдэхүүн	109	5
9	Давс	1686	-
10	Арьс, шир, ноос, ноолуур	1158	6
11	Өвс, тэжээл	7628	676
12	Ахуйн бараа	-	15
13	Барилгын материал	-	6298
14	Тавилга	-	84
15	Ундаа, ус, архи	-	50
16	Тоног төхөөрөмж	-	123
17	Хүнс	-	9582

¹⁴ АХБ, Аймаг, сумын төвийн бүсчилсэн хөгжлийн хөрөнгө оруулалтын хөтөлбөр, 2019 он



18	Цахилгаан бараа	-	27
19	Эм	-	211
НИЙТ		21248.6	21565

Зураг 3. 36 Баруун бүсийн улсын чанартай авто замын сүлжээ



Эх сурвалж: Нью Урбанизм ХХК

Зорчигч тээвэр


Зорчигч тээврийн үйл ажиллагаа эрхлэгч аж ахуй нэгжүүд 115.8 мянган зорчигч тээвэрлэжээ. Зорчигчдын тоог 2016 онтой харьцуулахад 41.8 мянган хүнээр буюу 51.2 хувиар өсжээ. 2020 онд зорчигч тээврийн үйл ажиллагаа эрхэлж буй аж ахуйн нэгж байгууллага, иргэд 64.6 мянган зорчигч тээвэрлэж 80269.7 мян.хүн.км-ийн зорчигч эргэлт хийснийг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад зорчигчдын тоо 44.2 хувиар, зорчигч эргэлт нь 49.6 хувиар тус тус буурсан байна.

Ачаа тээвэр

Авто тээврээр тээсэн ачаа 2019 онд 39.7 сая тонн болж, 2018 оноос тээсэн ачаа 1.2 сая тонн буюу 2.8 хувиар буурч, 2016 оноос 20.4 сая тонн буюу 2.0 дахин, 2010 оноос 28.2 сая тонн буюу 3.2 дахин өссөн байна.

2020 оны байдлаар Увс аймгийн хэмжээнд тээвэр, агуулахын салбарт 732 хүн ажиллаж байгаа бөгөөд ачааны 2928 машин байна. Дээрх статистикуудыг харьцуулан үзэхэд хэдийгээр ажиллах хүч 1970-аад оныхоос 5 дахин, ачааны машины тоо 12 дахин нэмэгдсэн ч тээсэн ачааны хэмжээ 4 дахин, ачаа эргэлт 3.5 дахин бага байна. Энэ нь тээврийн салбарын үйл ажиллагаа социализмын үеийн чадамж, хөдөлмөрийн бүтээмжид хүрэхгүй байгааг харуулж байна.

Зураг 3. 37 Увс аймгийн бараа эргэлт, 2019 оны байдлаар, мян.тн-оор



Эх сурвалж: Нью Урбанизм ХХК

2020 онд тээврийн үйл ажиллагаа эрхлэгч ААНБ-ууд 43.6 мян.тн ачаа тээвэрлэж, 10943.0 мян.тн.км ачаа эргэлт хийжээ.

Хүснэгт 3. 45 Увс аймгийн ачаа, зорчигч эргэлт

Үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	1990	1995	2000	2005	2010	2015	2016	2017	2018	2019	2020	2020 2019 хувь
Ачаа эргэлт	мян.тн. км	51164.5	1433.1	1800	1827.2	13875.6	28345.5	28814.4	23129.0	29719.0	10822.1	10943.0	101.1
Тээсэн ачаа	мян.тн	234.3	318.2	5.5	5.0	69.3	58.3	56.2	41.2	125.4	39.7	43.6	109.8
Зорчигч эргэлт	мян.хүн.км	8889.8	5354.1	4630	52881.2	12878.8	36096.1	51426.7	53984.2	80174.0	159278.0	80269.7	50.4
Зорчигчид	мян.хүн	3.5	55.2	0.5	0.5	35.3	58.3	74.0	66.1	76.6	115.8	64.6	55.8

Эх сурвалж: Увс аймгийн Статистикийн хэлтэс

Тээврийн хэрэгслийн тоо

2020 оны байдлаар Аймгийн авто тээврийн төвд бүртгэлтэй оношилгоонд хамрагдсан тээврийн хэрэгслийн тоо 10193 байгаа ба төрлөөр авч үзвэл 6958 суудлын, 2705 ачааны, 373 автобус, 55 зүтгүүр, 28 цистерн, 74 тусгай зориулалтын автомашин байна.

Хүснэгт 3. 46 Увс аймгийн техникийн хяналтын үзлэгийн дүн, давхардсан тоогоор

Салбар: PC045 (Увс)

2021-01-01-ээс 2021-12-15 хүртэл

Үзлэгийн төв	ТХ төрлөөр - Автомашин							ТХ төрлөөр - Бусад				БҮГД ДҮН	Хөдөлгүүрийн төрлөөр					Насжилтаар			
	Суудал	Ачаа	Зүт гүүр	Авто бус	Цис терн	Тусг ай	Дүн	Меха низм	Чир гүүл	Мото цикл	Дүн		Бензи н	Дизел ь	Хий	Цахи л гаан	Хосол сон	0-3 жил	4-6 жил	7-9 жил	10 ба дээш
PC045 (Увс)	7 234	2 574	62	421	25	84	10 400	37	131	903	1 071	11 471	6 271	3 234	50	1 785	739	306	894	9 532	
НИЙТ ДҮН:	7 234	2 574	62	421	25	84	10 400	37	131	903	1 071	11 471	6 271	3 234	50	1 785	739	306	894	9 532	

Эх сурвалж: Увс аймгийн Авто тээврийн үндэсний төв

Хүснэгт 3. 47 Оношилгоонд орсон авто тээврийн хэрэгслийн нийт тоо, сумаар



Сумууд	2010	2011	2012	2013	2014	2015	2016	2017	2018	2019	2020	2020 2019
Хэмжих нэгж	тоогоор											хувь
Бүгд	4394	4501	7790	7706	8555	8753	8974	8745	9452	8946	10241	114.5
Баруунтуруун	145	126	241	256	290	283	313	278	316	296	354	119.6
Бөхмөрөн	102	75	99	129	178	177	172	171	169	185	237	128.1
Давст	107	96	183	200	202	164	184	189	166	165	199	120.6
Завхан	92	67	75	136	136	129	129	156	184	159	191	120.1
Зүүнговь	125	108	206	242	242	238	260	249	220	239	306	128.0
Зүүнхангай	160	102	93	120	193	177	172	171	234	223	265	118.8
Малчин	114	122	1551	192	238	200	250	232	197	178	264	148.3
Наранбулаг	135	145	235	309	359	359	415	410	349	353	425	120.4
Өлгий	115	88	161	198	206	217	246	257	230	226	278	123.0
Өмнөговь	152	126	233	438	385	415	449	480	412	407	487	119.7
Өндөрхангай	171	137	226	284	224	188	232	167	332	280	359	128.2
Сагил	149	124	204	253	268	266	281	277	266	293	343	117.1
Тариалан	151	142	399	449	461	477	476	536	350	288	399	138.5
Түргэн	128	106	195	250	279	264	336	284	247	200	265	132.5
Тэс	185	126	271	307	335	284	245	246	288	296	388	131.1
Ховд	98	83	136	166	192	172	192	262	255	250	301	120.4
Хяргас	158	147	184	248	255	220	213	217	239	224	270	120.5
Цагаанхайрхан	113	80	104	137	108	122	135	132	146	184	188	102.2
Улаангом	1994	2501	2994	3392	4004	4401	4274	4031	4852	4500	4722	104.9

Эх сурвалж: Увс аймгийн Статистикийн хэлтэс

2021 оны 12 сарын 14-ны байдлаар аймгийн хэмжээнд техникийн хяналтын үзлэг оношилгоонд хамрагдсан нийт 10400 тээврийн хэрэгсэл байгаагаас суудлын автомашин 7234, ачааны автомашин 2574, зүтгүүр 62, автобус 421, цистерн 25, тусгай зориулалтын 84 автомашин байна.

Авто засвар, сэлбэгийн худалдаа

Улаангом суманд 27 иргэн, аж ахуйн нэгжийн нийт 67 ажилтантай автомашины засвар, техник үйлчилгээ, 14 иргэн, аж ахуйн нэгж автомашины сэлбэг, дугуйн худалдаа явуулж байна. Эдгээр засвар үйлчилгээ хийх газрууд нь бүгд суудлын автомашин хүлээн авч, техник үзлэг хийх, дугуй, тос солих, бусад механик засварын үйлчилгээ хийж байна.

Судалгааны явцад Улаангом болон бусад суманд том оврын ачааны автомашинд засвар үйлчилгээ хийх авто засварын газрууд байхгүй бөгөөд жолооч нар машины жижиг эвдрэлийг өөрсдөө засах, тос солих бусад техник үйлчилгээг Улаанбаатар хотод хийлгэдэг байна.

3.6.2 Увс аймгийн хилийн боомтын одоогийн байдал

Монгол улсын хилийн боомтууд

Монгол Улсын хэмжээнд хилийн боомтын асуудлаар хөрш орнуудтай байгуулсан хэлэлцээр, Засгийн газрын тогтоолын дагуу нийт 46 боомттой байхаар тусгасан. Үүнд:

- ОХУ-тай хиллэдэг хэсэгт 29;
- БНХАУ-тай хиллэдэг хэсэгт 13;
- Агаарын замын боомт 4



Үүнээс олон улсын ажиллагаатай 14, хоёр талын байнгын ажиллагаатай 11, хоёр талын түр буюу улирлын ажиллагаатай 14, дамжин өнгөрөх 7 боомт байхаар заагдсанаас авто замын 39, төмөр замын 3, агаарын замын 4 боомт байна. Эдгээр боомтуудаас Монгол-Оросын хил байрлах 19 боомтын дэд бүтэц бүрдээгүйн улмаас 1994 оноос хойш ажиллаагүй байна.

Монгол-Оросын хилийн боомтууд:


- Олон улсын зорчигч, ачаа тээврийн харилцааны зориулалттай байнгын ажиллагаатай Сүхбаатар-Наушки, Алтанбулаг-Хиагт, Цагааннуур-Ташанта, Эрээнцав-Соловьевск, Боршоо-Хандгайт;
- Хоёр талын зорчигч, ачаа тээврийн зориулалттай байнгын ажиллагаатай Тэс-Шарсуурь, Арцсуурь-Цагаантолгой, Ханх-Монд, Бага-Илэнх-Айнек, Зэлтэр-Желтура, Агацын гол-Алтан, Ульхан-Дээд Ульхан, Эрээнцав-Соловьевск /төмөр зам/;
- Түр буюу улирлын ажиллагаатай Баянзүрх-Тарис, Шишгэд гол-Ушь Бэлдир, Хээгт-Санага, Хонгор овоо-Боций, Цагаан-Арал-Наушки, Хутаг-Өндөр-Киран, Хүдэр-Цагаанчулуутай, Тогтор-Өвөртогтор, Ямалхын гол-Новый Дурулгүй;
- Дамжин өнгөрөх Асгатын гол-Аспайт, Бөхмөрөн-Кызылхая, Харигийн гол-Мугур Аксы, Тээл-Хандгайт, Тээл-Торгалыг, Давст-Сарыг Холь, Тэс-Сарыг Холь гэсэн 7 бүгд 29 боомт байдгаас Булган, Завхан, Хэнтий аймаг тус бүрт 1, Баян-Өлгий аймагт 2, Хөвсгөлд 4, Дорнод аймагт 5, Сэлэнгэ аймагт 7, Увс аймагт 8 байрладаг.

Боршоо хилийн шалган нэвтрүүлэх боомт

Увс аймгийн Давст сумын нутаг дэвсгэрт Хандгайт голын сав газрын урд Боршоо хилийн шалган нэвтрүүлэх боомт байрладаг. Тус боомтоор өдөрт 80-120 тээврийн хэрэгсэл, 250-350 иргэн дамжин өнгөрдөг бөгөөд амралтын өдөр 450 орчим хүн нэвтэрдэг байна.

Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлж буй “Гаалийн шинэчлэл”-ийн хүрээнд Азийн хөгжлийн банкны 27,2 тэрбум төгрөгийн нэн хөнгөлөлттэй зээлийн санхүүжилтээр “Боршоо” боомтыг олон улсын жишигт нийцүүлэн өргөтгөн шинэчилж эхэлсэн.

Зураг 3. 38 Боршоо хилийн боомтоор нэвтэрсэн тээврийн хэрэгсэл, зорчигчдын тоо



Эх сурвалж: Увс аймгийн Статистикийн хэлтэс

Боомтын зорчигч тээврийн хэсэгт 21 ширхэг барилга байгууламж, иж бүрэн шугам сүлжээ, дэд бүтэц, зам талбай, ногоон байгууламж, зорчигч тээврийн хэрэгслийг түргэн шуурхай нэвтрүүлэх орчин үеийн дэвшилтэт технологи бүхий гарцуудыг шинээр ашиглалтад орно. Зорчигч тээврийн цогцолборт хүлээлгийн болон үйлчилгээний танхимуудыг цогцоор нь байгуулна. Боршоо боомтыг шинэлэн өргөтсөнөөр өдөрт нэвтрэх зорчигчийн тоо 4,8 дахин, ачааны автомашины тоо 3 дахин, суудлын автомашины тоо 6,7 дахин нэмэгдэж иргэд, аж ахуй нэгжид түргэн шуурхай, чирэгдэлгүй үйлчлэх боломж нөхцөл бүрдэн цаашлаад гадаад худалдааны эргэлт мөн хэмжээгээр нэмэгдэнэ.

Боршоо боомт нь мянганы замын Боршоо-Ярант чиглэлийн босоо тэнхлэгийн замын дагуу байрлалтай. ОХУ-Монгол Улс-БНХАУ-ын Шинжаан Уйгарын худалдаа, аялал жуулчлалын томоохон коридор үүсэх бүрэн боломжтой боомт юм.

Боршоо боомтоор нэг жилд орж байгаа болон гарч байгаа зорчигч, авто тээврийн хэрэгсэл тогтмол өсөж байна. 2019 онд суудлын автомашин 12529, ачааны автомашин 1569 орж ирсэн байна. Харин 2020 онд цар тахлаас үүдэн хил хаагдсан тул эрс буурсан.

Хүснэгт 3. 48 Увс аймгийн ачаа тээвэр, 2020.12-р сараас 2021.06-р сард QR кодоор тээвэрлэж байх үеийн нөхцөлөөр

№	Хүнсний бүтээгдэхүүний нэр төрөл	Увсаас гарч байгаа ачааны хэмжээ /тн/	Увс руу орж байгаа ачааны хэмжээ /тн/
1	Мах, махан бүтээгдэхүүн	6916	89
2	Сүү, сүүн бүтээгдэхүүн	19.6	-
3	Гурил	100	4334
4	Гурилан бүтээгдэхүүн	56	-
5	Төрөл бүрийн будаа	3576	40
7	Хүнсний ногоо	-	25
8	Жимс, жимсгэнэ, бүтээгдэхүүн	109	5
9	Давс	1686	-
10	Арьс, шир, ноос, ноолуур	1158	6
11	Өвс, тэжээл	7628	676
12	Ахуйн бараа	-	15



13	Барилгын материал	-	6298
14	Тавилга	-	84
15	Ундаа, ус, архи	-	50
16	Тоног төхөөрөмж	-	123
17	Хүнс	-	9582
18	Цахилгаан бараа	-	27
19	Эм	-	211
НИЙТ		21248.6	21565

Эх сурвалж: Увс аймгийн Авто тээврийн төв

Хүснэгт 3. 49 Боршоо хилийн боомтоор орж ирж байгаа барааны ангилал

	Түргэн муудах, эмзэг	Хөлдүү / Хөргүүр	Шингэн	Аюултай
мөнгөн дүн, сая.доллар	191.2	162.2	15.3	15427.3
Хэмжээ, тн	148.1	131.1	16.1	21759.4

3.6.3 Увс аймгийн гадаад худалдаа

2019 онд импорт 22651.1 мянган америк долларт хүрч 2018 оны мөн үеэс 5503.8 (19.5%) мянган америк доллараар өссөн байна. 2019 онд нийт экспорт 1938.1 мянган америк долларт хүрч 2018 оны мөн үеэс 1610.8 (5.9 дахин) мянган америк доллараар өссөн байна. Нийт экспортын хэмжээг 2016 онтой харьцуулбал 9.6 дахин өсөж, харин импортын хэмжээ 34.1 хувиар буурчээ.

2020 онд импорт 15991.6 мянган америк долларт хүрч 2019 оны мөн үеэс 6659.5 (29.4 %) мянган америк доллараар буурсан байна. 2020 оны эцэст нийт экспорт 957.7 мянган америк долларт хүрч 2019 оны мөн үеэс 980.4 (50.6 %) мянган америк доллараар буурсан байна¹⁵.

Хүснэгт 3. 50 Увс аймгийн гадаад худалдаа

Хүснэгт Экспорт, импорт

Үзүүлэлт	хэмжих нэгж	2000	2005	2010	2015	2016	2017	2018	2019	2020	2020 2019
Хэмжих нэгж											Хувь
Нийт экспорт	мян.ам.долл	325.3	242.9	2556.7	303.8	20.1	237.2	327.3	1938.1	957.7	49.4
Нийт импорт	мян.ам.долл	4083.9	6924.9	32420.4	28133.7	34372.7	22269.6	28154.9	22651.1	15991.6	70.6

Хүснэгт Экспортын гол нэрийн бараа, төрлөөр

Гол нэр төрөл	хэмжих нэгж	2000		2005		2010		2015		2016		2017		2018		2019		2020		Хувь
		Тоо хэмжээ	үнийн дүн мян.ам.долл	Тоо хэмжээ	үнийн дүн мян.ам.долл	Тоо хэмжээ	үнийн дүн мян.ам.долл	Тоо хэмжээ	үнийн дүн мян.ам.долл	Тоо хэмжээ	үнийн дүн мян.ам.долл	Тоо хэмжээ	үнийн дүн мян.ам.долл	Тоо хэмжээ	үнийн дүн мян.ам.долл	Тоо хэмжээ	үнийн дүн мян.ам.долл	Тоо хэмжээ	үнийн дүн мян.ам.долл	
Бүгд		325.2		242.9		2556.7		303.8		20.1		237.2		327.3		1578.7		517.3		32.8
Авто машин, суудлын Чулуулгийн дээж	тн						0.4	0.0		0.4	0.2		0.5	0.0	1.0	0.2				0.0
Ухрийн мах	тн	131.1		26.9		195.4	394.3							40.0	105.0					
Бодын шир	ш	8170.0																		
Загас, хөлдөөсөн	тн	30.0		25.0						5.0	6.9									
Адууны мах	тн			412.2		1289.0	2161.4	156.0	297.8			136.4	204.9	100.0	150.0	60.0	194.2	20.0	50.0	
Шашины эд зүйлс	ш													512.0	0.7					
Хонины мах	тн													19.0	35.2	307.9	1375.6	118.0	466.4	38.3
Монгол гэр	ш			7.0		1.0	1.0	6.0	6.0	4.0	3.5	16.0	15.9	3.0	1.8	3.0	2.5			
Трактор	ш			9.0																
Хонины ноос	тн	205.1		126.5																
эспий	м2									60.0	0.9	80.0	1.9							
Цай, ногоон	тн									1.8	9.7	4.2	15.3	7.6	10.9	4.2	6.2	0.9	0.9	0.2

Эх сурвалж: 1212.mn

2019 онд адууны мах 60 тн, 194,2 мянган ам. доллар, хонины мах 307,9 тн, 1,3 сая ам. доллар, ямааны мах 95 тн, 332,7 мянган ам. доллар зэрэг голлох гол нэр төрлийн бараа

¹⁵ Увс аймгийн статистикийн эмхэтгэл



гаргасан байсан. 2020 онд цар тахлын улмаас экспортын хэмжээ 3 дахин буурч, адууны мах 20 тн, хонины мах 118.0 тн, ногоон зай 0.9 тн, нийт 517,3 мянган ам.долларын бараа гаргасан байна. Мах, махан бүтээгдэхүүн зонхилж гарсан байгаагаас харахад цаашид энэ чиглэлийн боловсруулах үйлдвэр байгуулж, олон нэр төрлийн бэлэн бүтээгдэхүүн үйлдвэрлэн экспортод гаргах боломж байна. Мөн бусад чиглэлийн монгол гэр, эсгий бүтээгдэхүүн, ноолууран хувцас, тэмээний ноосон бүтээгдэхүүн, нэхий дээл зэргийг олноор үйлдвэрлэн гаргах боломжтой байна.

Импортын гол нэрийн бараа, төрлөөр

Сүүлийн жилүүдийн импортын гол нэрийн барааны нэр төрлөөр судалж үзэхэд түлш шатахуун, цахилгаан эрчим хүч нэлээд хувийг эзэлж байна. Тухайлбал 2019 онд дизелийн түлш 8,2 сая ам доллар, авто бензин гэхэд 6,3 сая ам доллар, цахилгаан эрчим хүч 5,7 сая ам доллараар импортолсон байна. Цар тахлын үед буюу 2020 онд дизелийн түлш 5,6 сая ам.доллар, авто бензин 4,2 сая ам.доллараар импортолсон байна. Монгол улс дотоодоо цахилгаан эрчим хүчээр хангахын тулд Увс аймгийн Өмнөговь суманд, мөн Ховд аймагт Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц барихаар шийдвэрлэсэн байгаа. Газрын тос боловсруулах үйлдвэр Дорноговь аймгийн Алтанширээд байгуулахаар эхэлсэн. Эдгээр үйлдвэрүүд 2025 оноос эхлэн ашиглалтад ороход Монгол улсын гадаад худалдаанд ихээхэн өөрчлөлт орох болно. 2019 онд өргөн хэрэглээний бараа болох өндөг 631 тн, хөц будаа 127.5 тн, бэлэн гоймон 19 тн, жимс жимсгэнэ 60,5 тн хүүхдийн будаа 14,1 тн, шарсан төмс 240 тн, зөгийн бал зэргийг импортолсон байна. 2019 онд Барилгын материал болох банз 802 тн, өнгөлгөөний тоосго 717 тн, зоргодсон хавтан 1594 тн, хуванцар цонх 898 тн болон малын тэжээл болох овьёос 890 тн, хивэг 4287 тн зэргийг импортолсон байна.

Хүснэгт 3. 51 Увс аймгийн импортын гол нэрийн бараа

Гол нэр төрөл	Хэмжээ нэгж	2000		2005		2010		2015		2016		2017		2018		2019		2020		2020 2019	Хувь
		Тоо хэмжээ	Үнийн дүн мян.ам. долл.	Тоо хэмжээ	Үнийн дүн мян.ам. долл.	Тоо хэмжээ	Үнийн дүн мян.ам. долл.	Тоо хэмжээ	Үнийн дүн мян.ам. долл.	Тоо хэмжээ	Үнийн дүн мян.ам. долл.	Тоо хэмжээ	Үнийн дүн мян.ам. долл.	Тоо хэмжээ	Үнийн дүн мян.ам. долл.	Тоо хэмжээ	Үнийн дүн мян.ам. долл.	Тоо хэмжээ	Үнийн дүн мян.ам. долл.		
Бүгд		4083.9		6924.9		32420.4		28133.7		34372.7		22269.8		28154.9		21005.3		15487.3		73.7	
Цонх, хуванцар	ш							1350.0	143.7	330.0	32.0	236.0	22.4	351.0	32.4						
Авто бензин	т	6666.8		3241.5				17402.3	13116.3	20127.7	12389.5	15066.2	10069.1	11727.7	9170.9	6238	6370.5	9178	4275.1	99.4	
Автобус	ш					1	3.8														
Автомашин, суудлын	ш	204		7.0		2.0	120.0	26.0	248.8	1.0	7.6	6.0	4.4	6.0	34.0						
Автомашин, тусгай зориулалт	ш							1.0	2.3												
Ачааны авто, машин, чиргүүл	ш	123.0		30.0		3.0	4.0	9.0	81.1	4.0	25.4	1.0	0.5	4.0	19.5						
Банз	м3							1053.4	129.3	661.5	68.8	456.5	65.4	485.1	62.5						
Барааны саван	кг									30.0	0.1			25.9	0.1						
Бетонон хавтан	кг									67.9	4.5	24.7	2.8								
Битум	т							117.5	51.4	1115.6	388.9	35.3	9.0								
Будаг	т							0.9	1.2												
Бүрээс даавуун	м2							403.2	0.3												
Бөлдмөл шөлтий хоолны	кг									61.0	0.1	45.0	0.1	27.0	0.1						
Бөлдөц, хөнгөн цагаан	ш											93.0	14.9	1.0	4.2						
Бэлэн гоймон	т									0.5	0.7	0.0	0.1								
Бялуу	т									0.3	1.6	0.1	0.2	0.6	1.1	0.3	0.7	0.6	0.1	200	
Бяслаг	кг											9.4	0.0								
Ванн, хуванцар	ш													1.0	0.4						
Гоймон	т							1.3	0.6	1.9	1.0	1.5	1.1	7.7	3.6			21.6	12.5		
Гурвалжин будаа	т									1.6	0.9										
Гурил	т	3304.0		1654.0				2781.0	660.7	1743.8	424.5							75	16.9		
Гутал	хос							16.0	0.3	25.0	0.1										
Давс идэжүүлсэн	кг									50.0	0.0										
Дамжуурын тууз	ш							0.1	0.4												
Даралт хэмжигч	ш											2.0	0.0								
Даршилсан өргөст хэмж	кг									56.6	0.1	500.0	0.5								
Дивель тулш	т	1515.6		601.5				11480.7	8152.3	25825.2	15438.8	9996.4	6717.3	15628.6	12471.4	11265	8202.6	12351	5678.3	109.4	
Дулаан хэмжигч	ш											2.0	0.0								
Давсгар, химийн мяндсан	м2													80.0	0.2						
Давсгийн төмөр	т									7.3	4.4										
Еотон	т											0.1	0.1			0.1	0.1	0.5	0.5	500	
Жигнэмэг	т							1.4	2.6	3.4	5.6	1.3	2.2	1.5	2.3	3.6	5.2	2.6	4	72.2	
Жимс, Жимсгэнэ	т							83.6	88.9	50.6	55.4	23.6	37.2	20.5	32.6	60.5	87.7	18.8	22.8	31.1	
Жимсний нухаш	кг									25.4	0.2			0.0	0.1			2	1.8		
Жимсний чанамал	кг											302.0	0.4			0.9	0.7	1.4	3.4	155.6	
Зайрмаг	кг							0.9	3.4	1.3	3.5	0.3	1.1								
Замын хавтан, явган хүний	т							2.6	0.2												



Гол нэр төрөл	Хэмжээ нэгж	2000		2005		2010		2015		2016		2017		2018		2019		2020		2020 2019 хувь
		Тоо хэмжээ	Үнийн дүн мян.ам. долл.	Тоо хэмжээ	Үнийн дүн мян.ам. долл.	Тоо хэмжээ	Үнийн дүн мян.ам. долл.	Тоо хэмжээ	Үнийн дүн мян.ам. долл.	Тоо хэмжээ	Үнийн дүн мян.ам. долл.	Тоо хэмжээ	Үнийн дүн мян.ам. долл.	Тоо хэмжээ	Үнийн дүн мян.ам. долл.	Тоо хэмжээ	Үнийн дүн мян.ам. долл.	Тоо хэмжээ	Үнийн дүн мян.ам. долл.	
Зөлийн бал	т									6.3	7.1					5	6.7			0
Зүлжэй	м2							300.0	0.2											
Зуух, халаалтын	ш									2.0	11.9									
Июгурт	т									0.3	0.5									
Кабель	м													0.1	0.2	0.8	1.8	372	0.5	
Кетчуп	кг									270.0	0.3	0.3	0.4	25.0	0.1					
Кисаль	кг											6.6	0.0	0.2	0.4					
Майонез	кг							36.0	0.0											
Маргарин	т									5.1	3.0									
Мебель тавилга	ш					537	57.7	1050.0	87.7	317.0	20.5	216.0	23.0	581.0	42.8					
Мод хөрөөдөх машин	ш					4	16	3.0	6.5											
Модны нүүрс	кг									11.0	0.0									
Мотоцикл	ш			7.0																
Наатл, туузан	кг									58.0	0.1									
Насоо, төвөөс зугтагч үйлдлийн	ш									2.0	0.8									
Ногооны холимог	кг									24.0	0.0	30.7	0.1							
Ноос, хяргасан	т											42.0	7.8	114.7	20.0					
Нөөцшилсөн загас	т									0.0	0.0									
Овъёос	т					368.7	56.1	1985.0	210.1	1577.2	208.8	883.1	132.4	1155.9	185.5	890	118.3	2897.5	356.2	
Өндөг	мян.ш							216.4	17.6	749.9	55.3	948.6	72.9	741.6	51.7					
Өргөст хэмх	кг							0.3	0.3					0.5	0.5					
Өрмөнцөр	кг											25.0	0.1			1.2	0.7	51	0.1	4250
Өтгөрүүлсэн сүү	т									1.1	1.1	0.6	0.9	0.1	0.2	1.7	1.3	1.5	1.7	89.5
Поролон орны	т							0.6	0.9	44.0	0.0			84.0	0.3					
Пропан	м3											38.0	11.6							
Радилатор, ширмэн	т							18.9	21.1	2.5	2.2	6.0	6.7	1.3	4.8					
Сав суулга	ш													20	0.1					
Салхицуур	ш											20.0	0.1							
Сода	тн									0.6	0.3									
Суулгац	ш					5200	8.8													
Суултуур, 00 өрөөний	ш							20.0	1.1											
Сырок	т									0.4	1.1	0.1	0.4							
Тавцан хуванцар	ш											29.0	0.3	70.0	0.4					
Талх	тн											0.2	0.1	0.0	0.1					
Тогоо, халуун усны	ш											5.0	21.4							
Тоолуур	ш											40.0	0.4							
Тоолуур, цахилгааны	ш							50.0	0.6											

Эх сурвалж: 1212.mn

2020 онд нийт импортын бараа буурсан бөгөөд бялуу, гоймон, гурил, жигнэмэг, жимс жимсгэнэ, жимсний нухаш, жимсний чанамал, овъёос, өрмөнцөр, өтгөрүүлсэн сүү зэргийг бага хэмжээгээр импортолсон байна.

3.6.4 Увс аймгийн бараа бүтээгдэхүүний хэрэглээ, одоогийн нөөц

Увс аймгийн хүн амын одоогийн бараа бүтээгдэхүүний хэрэглээг дараах хувилбаруудаар тооцоолов. Үүнд:

1. Монгол улсын гаалиар орж ирж байгаа бүх төрлийн бараа бүтээгдэхүүний нэг хүнд ногдох хэмжээгээр
2. Увс аймгийн бүх сумдын хүнс, барааны дэлгүүрүүдэд худалдаалагдаж буй бараа бүтээгдэхүүний хэмжээгээр

Увс аймгийн бараа бүтээгдэхүүний одоогийн аймгийн нийт хэрэглээ болон сумдын хэрэглээг тодорхойлон, аймаг сум хоорондын ачаа тээвэрлэлтийн одоогийн байдлыг таамаглах, сумдад стандарт, хадгалалтын горим хангасан агуулахаас бараа бүтээгдэхүүнийг түгээхэд нийт хэдий хэмжээний агуулах шаардлагатай зэргийг тооцоолох зорилгоор Увс аймгийн 19 сумын хүнс, барааны дэлгүүр, агуулах, зоориос асуулга судалгаа авсан.

Увс аймгийн хэмжээнд 1990 онд 10136 тн гурил үйлдвэрлэж байсан бол 2020 онд нэг хоногт 4 аж ахуйн нэгж нийт 4.2 тн, жилдээ 243 тн гурил үйлдвэрлэж байна. Увс аймаг жилдээ 30.000 тн үр тариа хурааж авч байгаа боловч одоогийн байдлаар 243 тн гурил үйлдвэрлэж байна. Гурил үйлдвэрлэл, арвайн гурил, хивэг үйлдвэрлэлээр аймгийн хэрэгцээг бүрэн хангах боломжтой байна.



Улаангомын хэмжээнд 7 аж ахуйн нэгж талх, 13 аж ахуйн нэгж нарийн боов, бялуу нийт жилдээ 477 тн үйлдвэрлэж байна. Талх, нарийн боов, бялуу нь үйлдвэрлэгчээс өдөр бүр шууд хэрэглэгчид хүргэдэг учир агуулахад хадгалах шаардлага төдийлөн байхгүй.

Улаангомд 2020 онд нэг хоногт 4 аж ахуйн нэгж 4 тн цэвэр ус, 15 компани нийт 500 тн ундаа, шүүс, Увс хүнс ХХК 4 тн цагаан архи үйлдвэрлэж байна.

Улаангомд 2020 онд давс 6.5 тн, лаазалсан бүтээгдэхүүн 3.1 тн, арвайн гурил, 9.9 тн үйлдвэрлэсэн байна.

Сүү, сүүн бүтээгдэхүүн: 2018 оны байдлаар Монгол хүний сүү, сүүн бүтээгдэхүүний 1 сарын хэрэглээ 10.9 литр байна. Увс аймгийн хэмжээнд хоногт 1500 литр сүү боловсруулах, 100 кг хүүхдийн сүү, сүүн бүтээгдэхүүн боловсруулах хүчин чадал бүхий үйлдвэр төлөвлөсөн байна. Тус үйлдвэр шингэн сүүнээс гадна тараг, цөцгийн тос, өтгөн цөцгий, бяслаг, аарц зэрэг бүтээгдэхүүний цехүүдтэй байна. Одоогоор нийт 12 аж ахуйн нэгжийн хоногт 2.2 тн сүү, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэж байна. Сүүн бүтээгдэхүүн нь хадгалалт, тээвэрлэлтийн онцгой горим, хугацаа шаарддаг тул ихэвчлэн сүүний үйлдвэрээс шууд хэрэглэгчид очих нь илүү хурдан шуурхай, зардал багатай байдаг. Иймд сүүн бүтээгдэхүүн их хэмжээний агуулах шаардлагагүй.

2019 онд өргөн хэрэглээний бараа болох өндөг 631 тн, хөц будаа 127.5 тн, бэлэн гоймон 19 тн, жимс жимсгэнэ 60,5 тн хүүхдийн будаа 14,1 тн, шарсан төмс 240 тн, зөгийн бал зэргийг импортолсон байна. 2020 онд нийт импортын бараа буурсан бөгөөд бялуу, гоймон, гурил, жигнэмэг, жимс жимсгэнэ, жимсний нухаш, жимсний чанамал, овъёос, өрмөнцөр, өтгөрүүлсэн сүү зэргийг бага хэмжээгээр импортолсон байна.

Хил хаалттай цар тахлын хөл хорионы үед тусгай зөвшөөрөлөөр Увс аймаг руу нэвтэрч байх үед Улаанбаатараас гурил 4334 тн, савласан ус 623,5 мян.л, дарсан ногоо 1.1 тн, төрөл бүрийн будаа 40 тн, жимс 5 тн, ундаа, архи 50 тн, бусад хүнс 9582 тн оруулсан байна.

3.6.5 Увс аймгийн агуулахуудын одоо байгаа багтаамж, хүчин чадал

2019 онд адууны мах 60 тн, 194,2 мянган ам. доллар, хонины мах 307,9 тн, 1,3 сая ам. доллар, ямааны мах 95 тн, 332,7 мянган ам. долларын мах экспортод гаргасан. Одоогоор аймгийн хэмжээнд Мон Тува ХХК 500 тн, Увс Мах Маркет 350 тн, Гранд Мийт ХХК 300 тн, Бумномин ХХК 300 тн, Бадрангуй Кредит ХХК 100 тн буюу нийт 1550 тн махны агуулах ашиглагдаж байна. Аймгийн жилийн статистик эмхэтгэлд жилд 1329 тн мах, 4.6 тн хиам үйлдвэрлэж байна.

Улаангом хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд болон Их наяд хөтөлбөрийн арга хэмжээнд жилд 1000 тонн мах, 600 тонн махан бүтээгдэхүүн үйлдвэрлэх үйлдвэр байгуулагдах бөгөөд экспортод гаргахаар төлөвлөжээ.

Улаангом сумд төмс, хүнсний ногоог 54 хувь хүн, ах ахуйн нэгжийн нийт 1280 тн нүхэн зооринд хадгалж байна. 2020 онд жимсний шүүс 75 мян/л, чацарганы тос 313 кг, чанамал 0.4 тн үйлдвэрлэсэн байна.

Хүнсний ногооны төрөлжсөн агуулахыг байрлуулах шаардлагатай байна.



3.7 АВТО ЗАМЫН ХӨДӨЛГӨӨНИЙ МЭДЭЭЛЭЛ


3.7.1 Орон нутгийн авто замын хөдөлгөөн

Улаанбаатар хотын хөдөлгөөнийг оруулахгүйгээр, өндөр эрчимтэй замын тоонд А0401(CAREC 4В): Улаанбаатар-Дархан, А0301 (АН32): Улаанбаатар-Атар-Лүн, А0501 (АН32): Налайх-Багануур гээд Улаанбаатар хотод ойр замууд орж байна. CAREC 4В чиглэл, А0402 буюу Дархан-Алтанбулагийн чиглэлд өдөрт 700-1000 автомашин явж байгаа ба Улаанбаатар, Замын-Үүд хооронд А0101-А0102-А0103 чиглэлд одоогоор өдөрт 1000 автомашин явж байна.

Цаашид, хөдөлгөөн нэмэгдэж буй авто зам нь зөвхөн хот руу орох зам болон УБ-Дархан, УБ-Налайх, УБ-Атар чиглэлийн авто зам байна.

Одоогийн байдлаар, улсын чанартай авто замын үлдсэн хэсэгт хөдөлгөөний эрчмийн түвшин бага байна. Дархан, Эрдэнэт, Өндөрхаан гэх мэт хүн ам ихтэй төвүүд болон аялал жуулчлалын төв Хархорин чиглэлийн авто замаас бусад нь өдөрт 400-600 автомашины хөдөлгөөний эрчимтэй байна. Автомашины хөдөлгөөн нь улсын чанартай замыг сайжрахад нэмэгдэх хандлагатай байдаг ч үүнийг хөдөө орон нутгаас хот руу чиглэсэн нүүдэл, холын зайнд явах зэргээс бодит гэж авч үзэхгүй ба энэ тохиолдолд дотоодын агаарын тээврийн үйлчилгээг сайжруулах хэрэгтэй.

Зураг 3. 39 Авто замын хөдөлгөөний эрчим




Эх сурвалж: ЗТХЯ

Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 232 дугаар тушаалаар батлагдсан “Олон улс, улсын чанартай авто замд хөдөлгөөний эрчмийн тооллого хийх” шинэчилсэн журмын дагуу олон улс, улсын чанартай авто замуудад нэг, хоёр, гурав, дөрөвдүгээр улирал, наадмын оргил цагийн тооллогыг ажлын даалгаварт заасан нэр бүхий 58 цэгт заасан хугацаанд авто зам хариуцагч АЗЗА компаниуд, Зам тээврийн хөгжлийн төвийн харьяа ТАЦ-үүд, орон нутаг дахь ЗЦА, Хил хамгаалах ерөнхий газартай хамтран хийсэн байна.



Олон улс, улсын чанартай авто замын сүлжээнд хоногт явсан тээврийн хэрэгслийн төрөл, тэдгээрийн эзлэх хувийг сүүлийн 4 жилийн үзүүлэлттэй харьцуулан доорх хүснэгтээр харуулав.

Зураг 3. 40 Авто замын хөдөлгөөний эрчим, тээврийн хэрэгслийн төрлөөр




Эх сурвалж: ЗТХЯ

Графикаас харахад авто замын сүлжээнд суудлын автомашины эзлэх хувь 2016 оноос 10.8%-аар өссөн, 2017 оноос 0.4%, 2018 оноос 6.5%-аар өссөн, 2019 оноос 2.4%-аар буурсан үзүүлэлттэй, зорчигч тээврийн хэрэгслийн хувьд 2016 оноос 39%, 2017 оноос 31.4%, 2018 оноос 12%-аар буурсан, 2019 оноос 17.2%-аар буурсан, ачаа тээврийн хэрэгслийн хувьд 2016 оноос 6%-аар буурсан, 2017 оноос 15.2%, 2018 оноос 28.3%-аар өссөн, 2019 оноос 20%-аар тус тус өссөн үзүүлэлттэй байна.

2020 оны жилийн дундаж хоногийн хөдөлгөөний эрчим 1500-аас дээш гарсан цэгүүд:

- ✓ A0101 дугаартай Улаанбаатар-Чойр чиглэл-Хоолтын ТАЦ
- ✓ A0201, A25 дугаартай Улаанбаатар-Мандалговь, Зуунмод чиглэл-Өндөрдовын уулзварт
- ✓ A0203 дугаартай Цогтцэций-Гашуунсухайт чиглэл-Цагаан хадны орчим
- ✓ A0301 дугаартай Улаанбаатар-Арвайхээр чиглэл-Цанын бааз
- ✓ A0301 Улаанбаатар-Арвайхээр чиглэл-Лүнгээс хангайн даваа салдаг уулзвар
- ✓ A0301, A0601 Улаанбаатар-Арвайхээр, Хархорин чиглэл-Тарны гүүр
- ✓ A0401, A1001 дугаартай-Дархан, Эрдэнэтийн замын уулзварт
- ✓ A0501 дугаартай Улаанбаатар-Өндөрхаан чиглэл-Налайхын ТАЦ

Зураг 3. 41 Авто замын хөдөлгөөний эрчмийн тооллого хийсэн цэгүүд



Ховд, Баян-Өлгий аймгийн А0305 дугаартай Ховд-Өлгий, А1701 дугаартай Ховд-Улаангом чиглэлийн хатуу хучилттай авто замын уулзварт тоолохоор тооллогын цэгийн байрлалыг өөрчилсөн болно.

Зураг 3. 42 Баруун бүсийн хөдөлгөөний эрчмийн тооллогын цэг



А0401 дугаартай Улаанбаатар-Дархан чиглэлийн авто замын өргөтгөл, шинэчлэлийн ажилтай холбогдуулан Ажлын даалгаварт заасны дагуу Рашаантын ТАЦ, Бороо гоулдын уурхай салдаг уулзварт /УБ-аас 130км/ тооллого хийхгүй байхаар тогтсон.

Хүснэгт 3. 52 2020 онд зорчсон авто машины нэгтгэл



Д/д	ЗАМЫН ДУГААР	ТООЛЛОГО ХИЙСЭН ГАЗАР	ТООЛЛОГО ХИЙСЭН ЗАМЫН ЧИГЛЭЛ	I УЛИРАЛ	II УЛИРАЛ	III УЛИРАЛ	IV УЛИРАЛ	ОРГИЛ ЦАГ НААДАМ	ДУНДАЖ	ГҮЙЦЭТГЭГЧ БАЙГУУЛЛАГУУД
A01										
1	A0101	Хоолтын ТАЦ дээр	Улаанбаатар-Чойр Чойр-Улаанбаатар	1229	1740	2146	1935	2558	1763	"ЗТХГ" ТӨҮГ /камер/
2	A0101	УБ-Чойр орох ЗЦПост	Улаанбаатар-Чойр Чойр-Улаанбаатар	694	986	573	584	1197	709	"Саруул харгуй" ХХК
3	A0102	Чойроос Сайншанд чиглэл 10км-т	Чойр-Сайншанд Сайншанд-Чойр	456	636	340	307	791	435	
4	A0103	Замын-Үүдийн боомт	Замын үүд-Сайншанд Сайншанд-Замын үүд	680	903	809	821	193	803	Хил хамгаалах ерөнхий газар
A02										
5	A25	Зуунмод, Мандалговь замын уулзварт	Улаанбаатар-Зуунмод	1714	2322	4572	1428	1639	2509	"ЗТХГ" ТӨҮГ /хяналтын тооллого/
	A0201		Зуунмод-Улаанбаатар							
6	A0201	Мандалговийн ТАЦ	Улаанбаатар-Мандалговь	939	1047	3412	1036	1404	1609	
			Мандалговь-Улаанбаатар							
7	A0202	Мандалговийн төвөөс Даланзадгад чиглэлд 5км-т	Мандалговь-Улаанбаатар Улаанбаатар-Мандалговь	742	1182	1007	1011	1251	986	"ЗТХГ" ТӨҮГ /камер/
8	A0202	Мандалговийн төвөөс Даланзадгад чиглэлд 5км-т	Мандалговь-Даланзадгад	582	2108	842	943	1064	1119	"АЗММ" ХХК
	Даланзадгад-Мандалговь									
8	A0202	Цогт-Овоогоос ДЗ, Гашуунсухайт салах уулзварт	Мандалговь-Даланзадгад	532	281	344	387	520	386	"Даш зам" ХХК
	Даланзадгад-Мандалговь									
9	A0203	Цагаан хадны орчим	Гашуунсухайт	278	286	261	328	219	288	
	Мандалговь									
9	A0203	Цагаан хадны орчим	Цогтцэций-Гашуунсухайт Гашуунсухайт-Цогтцэций	358	2800	5412	4686	=	3314	Хил хамгаалах ерөнхий газар
A03										
10	A0301	Цанын бааз	Улаанбаатар-Арвайхээр Арвайхээр-Улаанбаатар	3546	5089	6097	4665	30367	4849	"Баянчандмань АЗЗА" ТӨХК
11	A0301	Лүнгээс цааш хангайн даваа руу салдаг хэсэгт	Улаанбаатар-Арвайхээр	1769	2696	3025	2788	18293	2570	"ЗТХГ" ТӨҮГ /хяналтын тооллого/
	A27		Арвайхээр-Улаанбаатар							
12	A0301	Арвайхээр, Хархорины уулзварт, Тарны гүүр орчим	Дашинчилэн-Лүн Лүн-Дашинчилэн	1125	1718	1630	1068	10629	1385	
	A0601		Улаанбаатар-Арвайхээр Арвайхээр-Улаанбаатар							
13	A0301	Онгийн голын ТАЦ	Эрдэнэсант-Хархорин Хархорин-Эрдэнэсант	609	1329	1308	1018	6404	1066	"Эрдэнэсант АЗЗА" ТӨХК
	A0301		Улаанбаатар-Арвайхээр Арвайхээр-Улаанбаатар							
14	A0302	Баянхонгор, Шивээ хүрэн салах уулзварт	Улаанбаатар-Арвайхээр Арвайхээр-Улаанбаатар	593	940	735	1039	2089	827	"ЗТХГ" ТӨҮГ /камер/
	A29		Баянхонгор-Арвайхээр Арвайхээр-Баянхонгор							
15	A0302	Баянхонгор, Шаргалжуурын рашааны замын уулзварт	Арвайхээр-Гучин Ус- Шивээхүрэн Шивээхүрэн-Гучин Ус- Арвайхээр	419	879	1067	712	1227	769	"Өвөрхангай АЗЗА" ТӨХК
	A26		Баянхонгор-Арвайхээр Арвайхээр-Баянхонгор							
16	A0303	Алтай, Тайшир, Дэлгэрийн замын уулзварт	Баянхонгор-Шаргалжуут Шаргалжуут-Баянхонгор	346	411	243	166	440	292	"Их богд зам" ХХК
	A1103		Баянхонгор-Алтай Алтай-Баянхонгор							
17	A0304	А0304, А1104 замын уулзварт	Улиастай-Алтай Алтай-Улиастай	194	155	198	168	380	179	"Говь-Алтай АЗЗА" ТӨХК
	A1104		Ховд-Алтай Алтай-Ховд							
18	A0304	А14, А0304 замын уулзварт	Бургастай-Алтай Алтай-Бургастай	126	202	187	108	172	156	"Говь-Алтай АЗЗА" ТӨХК
	A14		Ховд-Алтай Алтай-Ховд							
19	A0305	Ховдоос Өлгий, Улаангом салах уулзварт	Ховд-Булган-Ярантай Ярантай-Булган-Ховд	85	169	109	122	215	121	"Ховд АЗЗА" ТӨХК
	A1701		Ховд-Өлгий Өлгий-Ховд							
			Ховд-Улаангом Улаангом-Ховд	=	145	120	=	=	133	
				=	285	112	=	=	199	



Д/д	ЗАМЫН ДУГААР	ТООЛЛОГО ХИЙСЭН ГАЗАР	ТООЛЛОГО ХИЙСЭН ЗАМЫН ЧИГЛЭЛ	I УЛИРАЛ	II УЛИРАЛ	III УЛИРАЛ	IV УЛИРАЛ	ОРГИЛ ЦАГ НААДАМ	ДУНДАЖ	ГҮЙЦЭТГЭГЧ БАЙГУУЛЛАГУУД
20	A0305	Өлгийгөөс Ховд чиглэлд 5 км-т, самбарын хажууд	Ховд-Өлгий Өлгий-Ховд	=	187	310	=	=	249	"Жол" ХХК
21	A0306	Цагааннуур чиглэлд 5 км-т, самбарын хажууд	Өлгий-Цагааннуур-Улсын хил Улсын хил-Цагааннуур- Өлгий	171	217	117	146	=	163	
A04										
22	A0401	Дархан Эрдэнэтийн замын уулзварт	Улаанбаатар-Дархан	173	=	=	1544	=	859	"Дархан АЗЗА" ТӨЖК
	A1001		Дархан-Улаанбаатар	221	381	1058	1264	958	731	
			Эрдэнэт-Дархан							
			Дархан-Эрдэнэт							
A0402	Дулаанхааны 4 замын уулзвар, ТАЦ	Улаанбаатар-Эрдэнэт Эрдэнэт-Улаанбаатар	153	=	=	1071	1324	612		
23	A0402	Дархан-Сүхбаатар Сүхбаатар-Дархан	516	779	1032	766	1591	773	"ЗТХГ" ТӨҮГ /камер/	
24	A0403	Сүхбаатараас цааш 10 км-т	Сүхбаатар-Алтанбулаг Алтанбулаг-Сүхбаатар	739	1114	877	1008	1360	935	"Сэлэнгэ АЗЗА" ТӨЖК
A05										
25	A0501	Багануур, Тэрэлжийн замын уулзварт	Улаанбаатар-Өндөрхаан Өндөрхаан-Улаанбаатар	1937	4952	3055	2962	5107	3227	"Налайх АЗЗА" ТӨЖК
	A24		Тэрэлж-Улаанбаатар Улаанбаатар-Тэрэлж	1104	2967	2544	1297	2729	1978	
26	A0501	Хэрлэнгийн ТАЦ	Улаанбаатар-Өндөрхаан Өндөрхаан-Улаанбаатар	1573	1377	1356	1095	4418	1350	"ЗТХГ" ТӨҮГ /камер/
27	A0502	Чойбалсан, Баруун-Уртын замын уулзварт	Чойбалсан-Өндөрхаан Өндөрхаан-Чойбалсан	299	664	325	231	612	380	"Харгуй" ТӨЖК
	A2001		Өндөрхаан-Баруун-Урт Баруун-Урт-Өндөрхаан	279	347	240	262	321	282	
28	A0502	Өндөрхаан, Баруун-Уртын замын уулзварт	Чойбалсан-Өндөрхаан Өндөрхаан-Чойбалсан	457	666	412	204	878	435	"Дорнод авто зам" ХХК
	A2201		Чойбалсан-Баруун-Урт Баруун-Урт-Чойбалсан	87	98	138	153	139	119	
29	A0503	Хэрлэнгийн доод гүүр /Сумбэр чиглэл/	Чойбалсан-Халх гол Халх гол-Чойбалсан	=	347	276	=	=	312	
A06										
30	A0601	Элсэнтасархай, Хархорин Хужиртын замын уулзварт	Элсэнтасархай-Хархорин Хархорин-Элсэнтасархай	575	1145	1164	958	7776	961	"Хархорин АЗЗА" ТӨЖК
	A08		Элсэнтасархай-Хужирт Хужирт-Элсэнтасархай Хархорин-Хужирт /А08/ Хужирт-Хархорин /А08/	86	139	126	143	762	124	
31	A0602	Орхоны төмөрбетон гүүр	Цэцэрлэг-Хархорин Хархорин-Цэцэрлэг	677	1469	1380	1140	6554	1167	"Хархорин АЗЗА" ТӨЖК
32	A0602	Цэнхэрийн төмөрбетон гүүр	Хархорин-Цэцэрлэг Цэцэрлэг-Хархорин	470	1018	871	736	2079	774	"Архангай АЗЗА" ТӨЖК
33	A0603	Ганц модны ТАЦ	Цэцэрлэг-Тосонцэнгэл Тосонцэнгэл-Цэцэрлэг	520	1684	857	799	4858	965	
34	A0603	Солонготын даваа	Тосонцэнгэл-Цэцэрлэг Цэцэрлэг-Тосонцэнгэл	=	414	-	=	=	414	
36	A0604	Нөмрөг-Баянтэс, Нөмрөг- Улаангом замын уулзварт	Нөмрөг-Баянтэс-Улсын хил Улсын хил-Нөмрөг-Баянтэс	34	62	-	28	=	41	"Завхан АЗЗА" ТӨЖК
	A18		Нөмрөг-Улаангом Улаангом-Нөмрөг	74	232	-	82	=	129	
A07										
37	A07	Улаангом чиглэлд 5 км-т, самбарын хажууд	Өлгий-Улаангом Улаангом-Өлгий	=	123	108	=	=	116	"Жол" ХХК
38	A07	Улаандавааны зам салах уулзварт /А1702, А07 замын уулзварт	Улаангом-Өлгий Өлгий-Улаангом	52	162	126	128	126	117	"Увс АЗЗА" ТӨЖК
	A1702		Улаангом-Хандгайт Хандгайт-Улаангом	84	205	179	130	140	150	
A09										
39	A0902	Булганаас Мөрөн, Тэшиг салах замын уулзварт	Булган-Мөрөн Мөрөн-Булган	249	514	469	399	3066	408	"Булган АЗЗА" ТӨЖК
	A13		Булган-Тэшиг Тэшиг-Булган	16	30	41	31	237	30	



Д/д	ЗАМЫН ДУГААР	ТООЛЛОГО ХИЙСЭН ГАЗАР	ТООЛЛОГО ХИЙСЭН ЗАМЫН ЧИГЛЭЛ	I УЛИРАЛ	II УЛИРАЛ	III УЛИРАЛ	IV УЛИРАЛ	ОРГИЛ ЦАГ НААДАМ	ДУНДАЖ	ГҮЙЦЭТГЭГЧ БАЙГУУЛЛАГУУД
40	A0902	Мөрөнгөөс Булган чиглэлд 10 км-т	Булган-Мөрөн Мөрөн-Булган	227	485	478	447	2762	409	"Хөвсгөл АЗЗА" ТӨЖ
A10										
41	A1001	Хангалын гүүрийн ТАЦ	Эрдэнэт-Дархан Дархан-Эрдэнэт	502	1343	799	1958	2111	1151	"ЗТХТ" ТӨҮГ /камер/
42	A1002	Зоон даваан дээр	Эрдэнэт-Булган Булган-Эрдэнэт	638	1484	978	875	3557	994	"Булган АЗЗА" ТӨЖ
A11										
43	A1101	Ханхаас улсын хил чиглэлд 5 км	Хатгал-Ханх-Улсын хил Улсын хил-Ханх-Хатгал	0	0	0	0	0	0	Хил хамгаалах ерөнхий газар
44	A1101	Хатгал, Ханхын замын уулзварт	Мөрөн-Хатгал	=	90	22	=	-	56	"Хөвсгөл зам" ХХК
			Хатгал-Мөрөн Мөрөн-Ханх Ханх-Мөрөн	=	73	27	=	-	50	
45	A1102	Хилэнтийн гүүр	Мөрөн-Улиастай	120	230	123	122	464	149	"Хөвсгөл АЗЗА" ТӨЖ
	Улиастай-Мөрөн Мөрөн-Тариат Тариат-Мөрөн		116	125	102	106	517	112		
46	A1102	Загастайн даваа	Мөрөн-Улиастай Улиастай-Мөрөн	=	243	235	-	=	239	"Пирамид проект" ХХК
47	A1103	Төмөртэйн голын гүүр	Улиастай-Алтай	=	63	79	-	=	71	
	A12		Алтай-Улиастай Улиастай-Баянхонгор Баянхонгор-Улиастай	=	0	0	-	=	0	
48	A1104	Бургастайн хилийн боомт	Алтай-Бургастай Бургастай-Алтай	=	78	=	0	=	78	Хил хамгаалах ерөнхий газар
A15										
49	A15	Сагсай голын төмөр бетон гүүр	Даян-Өлгий Өлгий-Даян	=	221	125	=	=	173	"Жол" ХХК
A17										
50	A1701	Улаангомоос Наранбулаг, Өлгий сум салах замын уулзварт	Ховд-Улаангом	=	59	84	=	=	72	"Увс АЗЗА" ТӨЖ
	A18		Улаангом-Ховд Наранбулаг, Сонгино- Улаангом Улаангом-Наранбулаг, Сонгино	=	239	277	=	=	258	
51	A1701	Мянгадын гүүр	Улиастай-Ховд	=	150	120	=	=	135	"Ховд АЗЗА" ТӨЖ
	A16		Ховд-Улиастай Ховд-Улаангом Улаангом-Ховд	=	157	133	=	=	145	
A19										
52	A19	Чингисээс Норовлингийн чиглэлд	Чингис-Норовлин Норовлин-Чингис	=	371	399	=	=	385	"Харгуй" ТӨЖ
A20										
53	A2001	Баруун-Урт ТАЦ	Чингис-Баруун-Урт Баруун-Урт-Чингис	191	287	270	291	480	260	"ЗТХТ" ТӨҮГ /камер/
54	A2002	Аймгийн төвөөс Бичигт чиглэлд	Баруун-Урт-Бичигт Бичигт-Баруун-Урт	75	38	137	280	=	133	Хил хамгаалах ерөнхий газар
A21										
55	A21	Нефт баазын урд талд	Чойбалсан-Баян-Уул Баян-Уул-Чойбалсан	56	115	191	126	=	122	"Дорнод авто зам" ХХК
A22										
56	A2201	Аймгийн төвөөс 5 км-т Төмөртэй хатагд	Баруун-Урт-Чойбалсан Чойбалсан-Баруун-Урт	=	119	115	=	77	117	"Талын зам" ТӨЖ
57	A2202	Эрэнцав, Хавирга чиглэлийн замын уулзварт	Хавирга-Чойбалсан	0	0	0	0	=	0	Хил хамгаалах ерөнхий газар
	A23		Чойбалсан-Хавирга Чойбалсан-Эрэнцав Эрэнцав-Чойбалсан	0	0	0	0	=	0	
A27										
58	A0901	Харбухын гүүр	Дашинчилэн-Булган Булган-Дашинчилэн	111	543	310	139	4239	276	"Хөвчийн зам" ХХК
	A27		Дашинчилэн-Ихтамир Ихтамир-Дашинчилэн	129	266	178	133	1302	177	



Д/д	ЗАМЫН ДУГААР	ТООЛЛОГО ХИЙСЭН ГАЗАР	ТООЛЛОГО ХИЙСЭН ЗАМЫН ЧИГЛЭЛ	I УЛИРАЛ	II УЛИРАЛ	III УЛИРАЛ	IV УЛИРАЛ	ОРГИЛ ЦАГ НААДАМ	ДУНДАЖ	ГҮЙЦЭТГЭГЧ БАЙГУУЛЛАГУУД
A28										
59	A28	Хархориноос Хөшөөцайдам чиглэлд	Хархорин-Хөшөө цайдам Хөшөө цайдам-Хархорин	=	450	385	=	907	418	Хархорин А33А" ТӨХК
НИЙТ				31299	58676	59275	48292	154820		

Жич: Хөдөлгөөний эрчмийн тооллогын жилийн дунджийг 4 улирлын дүнгээр гаргасан болно.

= Тооллого хийгдэхгүй цэг

- Тооллого хийгээгүй цэг

Эх сурвалж: Зам, тээвэр хөгжлийн төв


3.7.2 Олон улсын авто замын хөдөлгөөн

Олон улс, улсын чанартай авто замуудад хийгддэг хөдөлгөөний эрчмийн тооллого, судалгааны ажлын хүрээнд энэ оны 1, 4-р улирлын тооллогыг 43 цэгт, 2-р улирлын тооллогыг 58 цэгт, 3-р улирлын тооллогыг 55 цэгт, наадмын оргил цагийн тооллогыг 40 цэгт 24/48 цагаар хийж гүйцэтгэн, тооллогын үр дүнг нэгтгэн боловсруулсан байна.

Тооллогыг 43 цэгт зам хариуцагч А33А компаниудтай хамтран, 10 цэгт ТАЦ-ээ түшиглэн, 2 цэгт орон нутаг дахь ЗЦА-ны хяналтын камерын бичлэг ашиглан, 6 (11) цэгт Хил хамгаалах ерөнхий газраас ирүүлсэн мэдээллийг ашиглан тооллогыг зохион байгууллаа.

Дэлхий нийтэд тархаад байгаа шинэ коронавирусын халдварын улмаас Монгол улсын Засгийн газрын шийдвэрээр Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх тухай шийдвэр гарсан. БНХАУ, ОХУ-тай хиллэдэг хилийн боомтуудаар зорчих иргэдийг хилээр нэвтрүүлэхгүй байх, зарим хилийн боомтуудыг түр хаах, /Уул уурхайн тээвэрлэлт хийгддэг боомтуудаар зөвхөн ачаа тээврийн хэрэгсэл зорчихыг зөвшөөрсөн./ зэргээр тээврийн хэрэгслийн хөдөлгөөнд хязгаарлалт хийсэнтэй холбоотойгоор хөдөлгөөний эрчим өнгөрсөн онуудаас бага байлаа.

Зураг 3. 43 Боомтуудаар нэвтэрсэн тээврийн хэрэгсэл



Эх сурвалж. Зам, тээврийн хөгжлийн төв



БҮЛЭГ 4. ҮНЭЛГЭЭ, ДҮГНЭЛТ

Бүлгийн дэд агуулга:

- ✂ SWOT шинжилгээ
- ✂ PEASTLE шинжилгээ
- ✂ Авто тээврийн хэтийн төлөвийг үнэлэх нь
- ✂ Монгол улсад тээвэр, логистикийн салбарыг хөгжүүлэхэд цаашид авах арга хэмжээний санал

4.1 SWOT ШИНЖИЛГЭЭ

Увс аймгийн Улаангом хотод бий болох Баруун бүсийн Логистик төв нь Баруун 5 аймгийн хувьд хамгийн том Орон нутгийн логистик төв болж хөгжихтэй холбоотойгоор тус төвийн SWOT шинжилгээ нь дараах байдалтай гарч байна.

<p>Давуу тал</p> <p>S</p>	<ul style="list-style-type: none"> • Баруун коридорын дагуу байршиж байгаа ба Баруун бүсийг товарийн эрэлтээр хангах боломжтой, • Транзит тээвэр ба гадаад худалдааны эргэлт сайжирна, • Хөрөнгө оруулалт, санхүүжилт олох боломжтой, • Байнгын найдвартай эрэлт үүсгэх Улаангом хотоос 10 км зайд буй, • Ажиллах хүчний нөөц хангалттай, • Суурьшил явагдаагүй, газар чөлөөлөлтийн зардал байхгүй, • Төлөвлөлтийн шийдлээс хамаарч тус төвд шилжин ирэх бизнес нэгжүүд ихтэй, • Цахилгааны ба мэдээлэл холбооны сүлжээнд холбогдоход саад бэрхшээлгүй, • Барааг урт хугацаанд хадгалахад шаардлагатай талбайн нөөц ихтэй, • Увс аймгийн авто замын зангилаа дагаж байрлах тул нөлөөллийн томоохон бүсэд хамаарна, • Улсын болон орон нутгийн чанартай авто замуудтай холбогдсон, • Увс аймаг, Баруун бүсийн хүн амын тоо, товарын хэрэгцээ нэмэгдэж байна, • Сул чөлөөтэй газар тул дэд бүтцийн бүтээн байгуулалт хийх нөөц талбай ихтэй,
<p>Сул тал</p> <p>W</p>	<ul style="list-style-type: none"> • Төлөвлөгдөх газар нь бүхэлдээ дэд бүтцийн хангамжгүй тул дэд бүтцээ шинээр байгуулах шаардлагатай, • Логистик төв орчимд ажилчид, оршин суугчид амьдрах таатай орчин бүрээгүй, • Ажиллах хүчний гэр бүлийн нийгмийн дэд бүтцийг ямар нэг байдлаар нэмэлт хөрөнгө оруулалтаар шийдэх шаардлагатай, • Логистик төв нь зөвхөн авто замаар ачааг хүлээн авах, хүлээлгэж өгөх нөхцөлтэй тул тээвэрлэлтийн зардал харьцангуй өндөр бөгөөд энэ сул талаа нөхөхийн тулд бусад боломжуудыг санал болгох шаардлагатай,



	<ul style="list-style-type: none"> Төрөл бүрийн агуулах болон зоорийн эзэмшигчдийг нэг дор төвлөрүүлэх тул ухуулга сурталчилгаа, таниулах ажил хийх шаардлагатай,
<p>Боломж</p> <p>О</p>	<ul style="list-style-type: none"> Тээвэр логистикийн салбарт хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг татах, Жижиг дунд үйлдвэрүүдийн бараа бүтээгдэхүүний нэгдсэн стандарт, түгээлт, хангамж зэрэг 4PL үйлчилгээг гүйцэтгэж том зах зээлд чиглэсэн эксбоомтын нийлүүлэлтийн сүлжээний бүс нутгийн логистик зангилааг бий болгох, Логистик төвийг дагасан үйлдвэрлэл, дамжин өнгөрөх худалдаа, Увс аймагт нэмүү өртөг шингээсэн бүтээгдэхүүний борлуулалт, логистик төвийн үйлдвэрлэлийг дэмжих орчныг бүрдүүлснээр бусад салбарууд дахь хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, Улаангом хотоос холгүй байрших тул бөөний худалдаа, логистик дагасан үйлчилгээ, бусад бизнесийн орчинг дэмжих, Ажиллах хүч болон бүс нутгийн эдийн засгийг өсгөх, Баруун бүсийн товарын эргэлтийг нэмэгдүүлэх,
<p>Эрсдэл</p> <p>Т</p>	<ul style="list-style-type: none"> Логистикийг байгуулах санхүүжилт олдохгүй байх, Дэд бүтцийн барилга байгууламж баригдахгүй удаашрах, Улаангом хот дахь агуулах, зоорийн аж ахуй эрхлэгчид нүүн шилжиж ирэхгүй байх, дургүйцэх, Тээвэр логистикийн салбараас бусад салбартай холбогдох байдал, Барилгажилт үүссэнээр хүрээлэн буй орчны бохирдол ихсэх, Барилгажилт эрчимтэй явагдсанаар төвлөрөл үүсэх,

SO	Стратеги + +	WO	Стратеги +-
	<ul style="list-style-type: none"> Улаангом хотын төвлөрлийг хөгжлийн бодлоготой уялдуулж нутаг дэвсгэрт байрлах бусад суурингийн эдийн засгийн чадавхыг үндэслэн олон төвт байдлаар хөгжүүлэх Тухайн газрын нөөцөд үндэслэн бие даасан эх үүсвэрийг төлөвлөх, Баруун бүсийн гол худалдаа, логистикийн суурин болох, Тээврийн зангилааг дагасан аялал жуулчлалын таталцлыг нэмэгдүүлэх төлөвлөлт, уялдаа холбоог гаргах Экологийн тэнцвэрт байдал, нөхөн сэргээлтийн менежментийг нэмэгдүүлэх, 		<ul style="list-style-type: none"> Улаангом хотын гол худалдааны бүс тул нутаг дэвсгэрийн даацаас хамааран газар ашиглалтын төлөвлөгөөг мөрдөх, Байгалийн төвөгтэй нөхцөлтэй бүс нутгийн унаган байдлаар хадгалах, хамгаалах Дэвшилтэд технологийг ашиглан инженерийн шугам сүлжээг хийх
ST	Стратеги +-	WT	Стратеги - -
	<ul style="list-style-type: none"> Тухайн бүс нутгийн газрын эрх зүйн байдал, харилцан хамаарлыг үндэслэн логистик бүсийг төлөвлөх Эдийн засгийн хөндлөн тэнхлэгтэй уялдах байдал болон холбогдох арга замыг нэвтрүүлэх, 		<ul style="list-style-type: none"> Ажлын зургийн үе шатанд барилга байгууламжид газар хөдлөлт, хөрсний судалгааг хийх, Ногоон болон хамгаалалтын бүсийг ихээр төлөвлөх, Санхүүжилтийг үе шаттай, төр хувийн хэвшил хосолсон байдлаар шийдвэрлэх,



- Суурьшил болон тээвэр логистикийн бүсийн харилцан хамаарал, нөлөөлөлд анхаарах,

4.2 PEASTLE ШИНЖИЛГЭЭ

Увс аймгийн Улаангом хотод бий болох Баруун бүсийн Логистик төв нь Баруун 5 аймгийн хувьд хамгийн том Орон нутгийн логистик төв болж хөгжихтэй холбоотойгоор тус төвийн PEASTLE шинжилгээ нь дараах байдалтай гарч байна.

	Боломжууд	Бэрхшээлүүд
P		
Улс төрийн хүчин зүйлс	<ul style="list-style-type: none"> ▪ Монгол улсын эдийн засгийн гол тэнхлэгүүд болон тэдгээрийн харилцан хамаарлын асуудлууд судлагдаж байна 	<ul style="list-style-type: none"> ▪ Сонгууль болон улс төрийн холбоотой ашиг сонирхлын зөрчилдөөн үүсэх
E		
Эдийн засгийн хүчин зүйлс	<ul style="list-style-type: none"> • Арилжааны банкнуудын хүү багасах хандлагатай • Тээвэр логистикийн салбарын урсгал зардал багасах 	<ul style="list-style-type: none"> • Газрын үнэ өсөх • Хэт төвлөрөл үүсэх
S		
Нийгмийн хүчин зүйлс	<ul style="list-style-type: none"> • Ажлын байр нэмэгдэх • Орон сууцны эрэлт өсөх, • Цар тахлын сөрөг нөлөөлөл багасах, 	<ul style="list-style-type: none"> ▪ Хот байгууллын хэрэгжилтэд замбараагүй байдал үүсэх, ▪ Орон нутгийн иргэдтэй үл ойлголцох,
T		
Технологийн хүчин зүйлс	<ul style="list-style-type: none"> ▪ Байгаль орчинд ээлтэй орчин үеийн технологид суурилсан инженерийн дэд бүтцийн шийдлийг нэвтрүүлэх 	<ul style="list-style-type: none"> ▪ Инженер геологийн нөхцөлийг нарийвчлан судлах,
L		
Хууль, эрх зүйн хүчин зүйлс	<ul style="list-style-type: none"> • Хуурай боомтод тавигдах хууль эрх зүйн орчныг сайжруулах • Логистик төвд тавигдах шаардлагыг мөрдөх, 	<ul style="list-style-type: none"> • Хөгжлийн бодлогын улс төр, бизнесээс хараат бус байх нөхцөл шаардлагын хэрэгжилт хангагдахгүй байх
E		
Байгаль орчин хүрээлэн буй орчны хүчин зүйлс	<ul style="list-style-type: none"> ▪ Хүрээлэн буй орчныг тогтвортой хөгжүүлэх зарчмыг баримтлах 	<ul style="list-style-type: none"> ▪ Байгалийн нөхөн сэргээлт хийхэд хяналт тавих

4.3 АВТО ТЭЭВРИЙН ХЭТИЙН ТӨЛӨВИЙГ ҮНЭЛЭХ НЬ

- Тээврийн хэрэгслийн тоо, хөдөлгөөний эрчим



Суудлын автомашин, автобус, ачааны автомашины тоо нь Үндэсний нийт бүтээгдэхүүн, нэг хүнд ногдох орлогоос хамааран нэмэгдсээр байх болно. Улаанбаатар хотын ойролцоох автозам, CAREC корридорын 4А, 4В болон 4С чиглэлийн авто замын хөдөлгөөн нэмэгдэх бөгөөд Улаанбаатар хотын ойр замын хэсгээс бусад нь замын хүчин чадлыг нэмэгдүүлэх хэмжээнд хүрэхгүй.

Шинэ сэргэлтийн бодлогын хүрээнд авто замын боомтуудын хүчин чадал дээшилж, зарим боомтууд олон улсын шинж чанартай болсон, улсын ачаа тээвэр логистикийн бодлогыг идэвхжүүлж байна. Улаанбаатар хоттой бүх аймгийн төв хатуу хучилттай авто замаар холбогдсон мөн айл өрх бүр автомашинтай болсон байна.

Эндээс дүгнэхэд улсын болон орон нутгийн авто замын хөдөлгөөний эрчим нь тасралтгүй нэмэгдэх болно.

- **Улсын чанартай авто замын сүлжээ**

Бүх аймгийн төвүүдийг Улаанбаатар хоттой хатуу хучилттай авто замаар холбох, CAREC корридорын 4А болон 4С чиглэлийн замын барилгын ажлыг дуусгах одоогийн хөтөлбөрийг хэрэгжүүлж дууссаны дараа улсын чанартай авто замын сүлжээг хөгжүүлэх томоохон хэсгийн ажил дуусна. Тэр үед тэргүүлэх ач холбогдолд 1) УБ хотын ойролцоох хөдөлгөөний эрчим өндөр авто замыг сайжруулах, 2) нийт сүлжээний засвар арчлалтыг хийх ажлыг авч үзнэ. Цаашид, бага хөдөлгөөний эрчимтэй улсын чанартай авто замын барилгын ажлыг 10 жил, түүнээс илүү хугацаанд эхлүүлж болох юм.

- **Орон нутгийн авто замын сүлжээ**

Аймгуудын орон нутгийн замын сүлжээг сайжруулах нь шаардлагатай үйлчилгээг хөдөө, орон нутгийн ард, иргэдэд хүрэх боломжийг нэмэгдүүлэхэд чухал юм. Энэ нь төлөвлөлтийг сайн гаргаж, тэргүүлэх ач холбогдлыг тодорхойлж, хямд өртгөөр зам барих аргыг нэвтрүүлснээр үр дүнд хүрч чадна.

- **Авто тээвэр**

Автомашины тоо нэмэгдсэнээр, техникийн дүрэм, журам (автомашины утаа, ачааны машины овор, хэмжээ, жин, жолоочийн сургалт, үнэмлэх гэх мэтэд хамаатай), бусад заавал мөрдөх журмыг сайжруулах нь чухал. Олон улсын гэрээ, хэлэлцээрээр хилийн боомтын болон транзит тээврийн үйл ажиллагааг хөнгөвчлөх, ялангуяа ачаа тээврийн ажиллагааг хөнгөвчлөх талаар оруулж өгөх хэрэгтэй. Дүрэм, журмыг сайжруулах, мөрдүүлэх ажлын зардал нь авто замын дэд бүтцийн хөрөнгө оруулалттай харьцуулахад харьцангуй бага юм.

- **Авто замын хөдөлгөөний аюулгүй байдал**

Автомашины тоо, хөдөлгөөний эрчим нэмэгдэж байгаа нь авто замын ослоос нас барах, хүнд бэртэх үзүүлэлтийг нэмэгдүүлэхэд нөлөөлөх ба энэ үзүүлэлт нь хөгжилтэй орнуудтай харьцуулахад өндөр байна. Сөрөг арга хэмжээ авах нарийн төлөвлөгөөг боловсруулж, дэд бүтцийг хөгжүүлэх, жолооч сургах, нийтийн боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээнд олон талыг оролцуулах хэрэгтэй.



4.4 МОНГОЛ УЛСАД ТЭЭВЭР, ЛОГИСТИКИЙН САЛБАРЫГ ХӨГЖҮҮЛЭХЭД ЦААШИД АВАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ САНАЛ

Монгол Улсад тээвэр, логистикийн салбарыг хөгжүүлэхэд дараах арга хэмжээ авах боломжтой байна гэж үзэж байна. Үүнд:

1. Хэдийгээр гадаад орчиндоо тээврийн гарц сүлжээг ярьж байгаа ч дотоодын салбар хооронд нэгтгэж гадаад сүлжээг нутаг дэвсгэрийн хувьд хэрхэн зохион байгуулах асуудал орхигдож байна.
2. Үүнд үндэслэл суурь нь болох бодлого сул тодорхойлогдсон байна. Чөлөөт бүсийг үйлдвэржилтийн бодлоготой уях чиглэлээр ярилцахад салбаруудын төлөөлөл өөр өөр байр суурьтай байна. Зарим төлөөлөл үйлдвэржилт Монгол улсад байж чадахгүй, зөвхөн тээвэрлэж өгсөн үйлчилгээнээс мөнгөжнө гэж байр суурийг илэрхийлж байгаа нь дотооддоо бэлтгэл бүрэн хангагдаагүй, зорилго тодорхойлогдоогүй байна. Иймд дотооддоо эдийн засгийн салбаруудыг хөгжүүлэх нэгдсэн бодлого, үндсэн чиглэл гараагүйгээс тэдгээрийг хэрэгжүүлэхэд дэмжих салбарын буюу дэд бүтэц, тээвэр логистикийн стратеги тодорхойлогдох боломжгүй байна. Улмаар эдгээрийн өгөөжийг нэмэгдүүлэхэд салбар хоорондын сүлжээний гол цэг болох тусгай үүргийн бүсүүдийг газар орон зайн хувьд оновчтой байршуулж, хөгжүүлэх хэрэгцээ шаардлага байгааг Хүн ам нутагшилт суурьшил, нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөгөөр тодорхойлох
3. Улмаар салбарын бодлогуудыг уялдаатайгаар тодорхойлох суурь өгөгдөлтэй болохын тулд гадаад болон дотоод зах зээлийн судалгаа хийж байх институцтай болох, хэдий хэмжээний ачааг хаанаас хаа хүртэл тээвэрлэх хэрэгцээг тооцох, таамаглал боловсруулах боломжийг бүрдүүлж үүнээс хамаарч тээврийн салбар түүний дэд бүтцийг бий болгох стратегитай болох
4. Дотоодын худалдаа үйлдвэрлэлийн салбарын бодлого тодорхойлж тээврийн эрэлтийг үе шаттайгаар өсгөж, стратегийн байгууламжуудыг өсөлтөд нийцүүлэн байгуулах
5. Тээвэр логистикийн мэргэжлийн боловсон хүчнийг бэлтгэж, техник технологийн тусламжтайгаар аюулгүй тээврийн сүлжээ, үйлчилгээг байгуулах.
6. Дээрх бодлого нөхцөлүүдийг газар орон зайн хувьд хамгийн үр ашигтай байх цэгт эдийн засгийн коридор, эх газрын боомт, чөлөөт бүс болон боомтын төсөл хөтөлбөрүүд нэгдсэн бодлогоор зангидагдаж хэрэгжүүлэх.
7. Төрөөс логистикийн талаар баримтлах бодлогыг боловсруулах, логистикийн эрх зүйн орчинг бий болгох;
8. Логистикийн төвүүд нь олон улсын болон дотоодын сүлжээнээсээ хамаараад хүчин чадал нь өөр өөр байдаг тул тусгай бүсүүдийн статусыг тодорхойлж, логистик төвүүдийг уялдуулан байгуулах;
9. Логистикийн төвийн бизнес төлөвлөгөөний менежмент, түүний зохион байгуулалттай холбоотой хөрөнгө оруулалт, хөгжлийн төлөвлөгөөг боловсруулах;



БҮЛЭГ 5. ТӨЛӨВЛӨЛТИЙН ШИЙДЭЛ

Бүлгийн дэд агуулга:

- ✎ Бүс орчмын хөгжлийн зорилтууд
- ✎ Увс аймгийн ачаа тээвэрлэлт, хадгалалтын хэтийн төлөв
- ✎ Баруун бүсийн Логистик төв байгуулах үзэл баримтлал, шийдэл
- ✎ Бизнесийн үйл ажиллагаа


5.1 БҮС ОРЧМЫН ХӨГЖЛИЙН ЗОРИЛТУУД

5.1.1 Увс аймгийн хөгжлийн зорилтууд

Увс аймгийн хөгжлийн хэтийн зорилт 2019-2028

Увс аймаг Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хуульд нийцүүлэн аймгийнхаа 10 жилийн хугацаанд баримтлах хөгжлийн бодлогыг боловсруулсан байна. Тус хөгжлийн бодлогод “Уламжлалт ахуйгаа дээдэлсэн өндөр технологи бүхий хөдөө аж ахуй - аялал жуулчлалын хөгжлийн төв болох” алсын хараагаа үндсэн чиглэл болгон, “Гэр бүл төвтэй, бүтээлч, оюунлаг иргэдийнхээ эрүүл, аюулгүй орчинд амьдрах боломжийг бүрдүүлж, байгаль экологид ээлтэй, дэвшилтэт технологид суурилсан зохистой хэрэглээ, аж ахуйн үйл ажиллагааг дэмжиж, ухаалаг засаглал, тогтвортой хөгжил бүхий өрсөлдөх чадвараар тэргүүлсэн аймаг болно” гэсэн эрхэм зорилго тавьжээ. Тус бодлогын баримт бичигт Увс аймгийн эдийн засгийн орон зайн бүсчлэлийг гаргасан байна.

Зураг 5. 1 Увс аймгийн эдийн засгийн орон зайн бүсчлэл



Эх сурвалж: Увс аймгийн хөгжлийн хэтийн зорилт 2019-2028



Үүнд авто зам түшиглэсэн нэмүү өртгийн коридорт тулгуурлан Увс аймгийн эдийн засгийн орон зайн бүсчлэлийг дараах байдлаар дүрсэлжээ.

1. Улаангом болон хөгжлийн төвийн таталцлын тойрогт (60 гаруй км-ын) багтах суурин газрууд: Төв – суурин бодлогын хүрээнд дагуул суурин төвүүдэд боловсруулах үйлдвэрүүд, аялал жуулчлалын нэгдсэн сүлжээ, тээвэр логистикийн үндсэн сүлжээ, төв байрлах
2. Баруун хэсгийн аж үйлдвэрлэлийн бүс: Нөөцийн давуулаг тал дээр суурилсан Эрчим хүчний нэгдсэн сүлжээ, сэргээгдэх эрчим хүчний үйлдвэрлэл, эрчим хүчний логистикийн төв байрших
3. Хойд хэсгийн аялал жуулчлал, боловсруулах үйлдвэрийн орон зай: Давс, чацарганын үйлдвэрлэл, байгалийн аялал жуулчлал дагасан уламжлалт аж ахуйн аялал жуулчлал
4. Зүүн хэсгийн газар тариалангийн бүс: Газар тариалангийн бүсэд суурилсан жижиг, дунд үйлдвэрлэлийн төвлөрлийн орон зай

Түүнчлэн энэхүү баримт бичигт тээвэр, логистикийг хөгжүүлэх талаар дарааг зорилтуудыг хэрэгжүүлэхээр тусгагджээ. Үүнд:

- 7.3. Эдийн засгийн үр ашигтай, аюулгүй, хүртээмжтэй зам, тээвэр, логистикийн сүлжээг хөгжүүлэх
- 2.1.5. Хүнсний сүлжээний бүх шатанд түүхий эд, бүтээгдэхүүнийг технологийн дагуу хадгалах, тээвэрлэх стандартыг мөрдүүлж, аюулгүй байдлыг хангах, олон нийтийн оролцоо бүхий хяналтыг сайжруулах
- 6.2.6. Арьс шир, малын гаралтай дайвар бүтээгдэхүүн, ноос ноолуур боловсруулах жижиг дунд үйлдвэр байгуулах замаар малын түүхий эдийн боловсруулалт, хадгалалтыг сайжруулах, зах зээлд нийлүүлэх нэмүү өртгийн сүлжээг бүрдүүлж, хөрөнгө оруулалтаар дэмжих, түүхий эдийн бэлтгэл, тээвэрлэлтийг боловсронгуй болгож, бусад бүсийн үйлдвэрт тогтвортой нийлүүлэх
- 7.3.1. Боршоо боомтыг түшиглэн олон улсын транзит коридор болох баруун бүсийн тээвэр, логистикийн төв байгуулах
- 7.5.10. Хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэлд олон улсын стандартад нийцсэн боловсруулалт, сав, баглаа, боодол, хадгалалт, тээвэрлэлтийн технологи нэвтрүүлэх, стандарт мөрдүүлэх замаар бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэх

Дээрх зорилтуудыг хэрэгжүүлснээр 2028 он гэхэд дараах үр дүнд хүрнэ гэж төлөвлөжээ.

- Хоол, хүнсний бүтээгдэхүүний хадгалалт, тээвэрлэлтийн стандартын шаардлагын түвшинг 68%-иас 75.9%-д хүргэх
- Эдийн засгийн үр ашигтай, аюулгүй, хүртээмжтэй зам, тээвэр, логистикийн сүлжээг хөгжүүлэх хүрээнд ачаа эргэлийг 23.1 сая.тн.км-ээс 48.8 сая.тн.км-т хүргэх, тээсэн ачааг 41.2 мян.тн-оос 70.6 мян.тн-д хүргэх



Увс аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл

Зорилт 4.2. Аймгийн эдийн засгийн бүтцийг шинэчлэн тогтоож хүнд, хөнгөн үйлдвэрлэлийг хөгжүүлнэ:

- 4.2.1. Иргэдийг чанартай, эрүүл хүнсний бүтээгдэхүүнээр хангах, олон улсын чанар, стандартыг нэвтрүүлсэн, өрсөлдөх чадвартай брэнд бүтээгдэхүүнийг үйлдвэрлэж, хоршооны хөгжлийг дэмжих, орон нутагт шинэ ажлын байр бий болгох зорилго бүхий хөдөө аж ахуйн “ШИНЭ ХӨДӨӨ-УВС”, “УВС-АГРО” хөдөө аж ахуй, үйлдвэрлэлийн цогцолбор төслийг хэрэгжүүлнэ.
- 4.2.2. Аймгийн онцлог бүхий аялал жуулчлалыг хөгжүүлж, олон улсын аялал жуулчлалын зах зээлд өрсөлдөх чадварыг дээшлүүлнэ.
- 4.2.3. Баруун бүсийн тээвэр, логистикийн төвийг байгуулна.
- 4.2.4. Орон нутгийн хот, суурин газарт цахилгаан, дулаан, сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрийг нэмэгдүүлнэ.
- 4.2.5. Хариуцлагатай уул уурхайг дэмжиж, аймгийн нөөц баялагт тулгуурлан /нүүрс, давс, төмрийн хүдэр, барилгын материал/ боловсруулах үйлдвэрлэлийг хөгжүүлэхийг дэмжинэ

Зорилт 4.4. Хөрш болон бусад орнуудын эдийн засгийн хамтын ажиллагаа чөлөөт худалдааг аймгийн онцлогт нийцүүлэн хөгжүүлнэ.

- 4.4.1. ОХУ болон БНХАУ-ыг холбосон эдийн засгийн коридорыг хөгжүүлэх санал санаачилгыг дэмжинэ.
- 4.4.2. Гуравдагч орнуудтай худалдаа, эдийн засаг, нийгэм, соёлын харилцааг өргөжүүлнэ.

Зорилт 4.5. Бичил, жижиг, дунд үйлдвэрлэлийг инновацад тулгуурлан хөгжүүлж, бүтээмжийг нэмэгдүүлнэ:

- 4.5.1. Судалгаа, шинжилгээ, шинэ санаа, оюуны бүтээл, нөөц, брэндэд тулгуурласан, зах зээлд өрсөлдөхүйц бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг хөгжүүлнэ.
- 4.5.2. Бичил, жижиг, дунд үйлдвэрлэлийн бэлтгэн нийлүүлэлт, борлуулалтын тогтолцоог кластерын зарчмаар хөгжүүлэх нөхцөлийг бүрдүүлнэ.

Зорилт 8.1. Эдийн засгийн тэргүүлэх бүс нутаг, салбаруудыг дэд бүтцээр холбоно:

- 8.1.1. Байгаль орчинд ээлтэй, эрэлтэд нийцсэн, тогтвортой, хүртээмжтэй, аюулгүй тээврийн үйлчилгээг хөгжүүлж, авто замын сүлжээ, тээвэр логистикийн тогтолцоог хэрэгжүүлнэ.
- 8.1.2. “Боршоо” боомтын цогцолбор байгуулж, тоног төхөөрөмжид шинэчлэлт хийх, олон улсын стандартад нийцүүлэн, нэвтрэх чадварыг нэмэгдүүлнэ.
- 8.1.4. Засгийн газрын “Бүсчилсэн хөгжлийн хөрөнгө оруулалтын хөтөлбөр”-ийн хүрээнд бүсийн болон хил залгаа аймгуудтай хамтран ажиллах чиглэлээ тодорхойлж, төслийг хэрэгжүүлж эхэлнэ.



- 8.1.6. Увс-Ховд аймаг чиглэлийн хатуу хучилттай авто замыг барьж, баруун бүсийн А-07, А-1702, А-18 замын дагуух сумдыг улсын чанартай автозамтай үе шаттай холбох ажлын эхлүүлнэ.

Зорилт 8.2. Үндэсний онцлог бүхий, байгаль орчинд ээлтэй, нутгийн иргэдэд түшиглэсэн тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлнэ:

- 8.2.1. Аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээ, чанар, стандартыг сайжруулж, өрсөлдөх чадварыг дээшлүүлэн жуулчдын тоог нэмэгдүүлнэ.

Зорилт 8.3. Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн нөөц ашиглалт, эдийн засгийн эргэлтийг эрчимжүүлж, тооноос чанар, бүтээмжид шилжүүлнэ:

- 8.3.1. Үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээний хөгжлийг дэмжих, гол нэрийн хүнсний бүтээгдэхүүний хэрэгцээг дотоодын болон орон нутгийн үйлдвэрлэлээр тогтвортой хангах, төрийн худалдан авах ажиллагаагаар дамжуулан дэмжинэ.
- 8.3.2. Мал, амьтны эрүүл мэндийг хамгаалах, мал, амьтны гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлагыг хангах, мал эмнэлгийн үржлийн нэгжүүдэд хийх хяналтыг сайжруулж, мал, махны экспортын хэмжээг нэмэгдүүлнэ.
- 8.3.6. Хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд бүтээгдэхүүний чанарт анхаарах, бэлтгэн нийлүүлэлтийн тогтолцоо, тээвэр, борлуулалтын сүлжээг хөгжүүлж, хоршоодын хөгжлийг дэмжинэ.
- 8.3.7. Тариалангийн эргэлтийн талбайн ашиглалтыг сайжруулж, усалгаатай тариалангийн талбайг нэмэгдүүлэх, үр тариа болон голлох нэр төрлийн таримлаар дотоодын хэрэгцээг хангах, бусад ашигт таримлын үйлдвэрлэл болон хүлэмж, зорь агуулахыг нэмэгдүүлнэ.
- 8.3.11. Дундын хоршооны үйл ажиллагааг дэмжиж, хөдөө аж ахуйд технологи суурьтай инновацийг нэвтрүүлж, экспортын бүтээгдэхүүний хэмжээг нэмэгдүүлнэ.
- 8.3.13. Чацаргана, жимс жимсгэний үйлдвэрийн кластерыг дэмжиж, бүтээгдэхүүний борлуулалтын сүлжээ, үр сортын шинэчлэлийг тууштай дэмжинэ.

Увс аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр

Зорилт 3.1. Аймгийн эдийн засгийн бүтцийг шинэчлэн тогтоож, ХАА-н боловсруулах болон хүнд, хөнгөн үйлдвэрлэлийг хөгжүүлнэ:

- 3.1.1. Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлд технологи суурьтай инновацийг нэвтрүүлж, бүс нутгийн нөөц баялагт түшиглэсэн төр-хувийн хэвшлийн түншлэл, олон улсын байгууллага, олон нийтийн оролцоот хоршооны менежментийг нэвтрүүлэх замаар эдийн засгийн өгөөж, өрхийн орлого, бүтээмж, үнэ цэнэ, баталгаатай ажлын байрыг нэмэгдүүлэх зорилго бүхий “ШИНЭ ХӨДӨӨ-УВС” төслийг хэрэгжүүлэх



- 3.1.2. Бүс ба орон нутгийн иргэдийг чанартай экологийн цэвэр хүнсний бүтээгдэхүүнээр хангах, олон улсын чанар, стандартыг нэвтрүүлсэн, өрсөлдөх чадвартай брэнд бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх, эдийн засгийн хөгжлийг дэмжих, орон нутагт шинэ ажлын байр бий болгох хөдөө аж ахуйн “УВС-АГРО” Хөдөө аж ахуй, үйлдвэрлэлийн цогцолбор төслийг хэрэгжүүлэх
- 3.1.3. Аймгийн хадлан тариалангийн эргэлтийн талбайг нэмэгдүүлж, тэжээлийн голлох ургамлууд болох царгас, овьёос, эрдэнэ шиш, гурвалжин будаа тариалж, Баруунтуруун, Тариалан, Улаангом сумуудад “ГУРИЛ-ТЭЖЭЭЛИЙН ҮЙЛДВЭР” байгуулж, аймгийнхаа болон баруун бүсийн хэрэгцээг хангах
- 3.1.5. Жуулчдын урсгал, экспортын хэмжээг нэмэгдүүлж, Боршоо олон улсын боомтын "Шалган нэвтрүүлэх цогцолбор"-ын шинэчлэлийг хэрэгжүүлэх
- 3.1.6. Аймагт “Баруун бүсийн тээвэр логистикийн төв” байгуулах
- 3.1.7. “Дэглий цагаан” нисэх буудлын хүчин чадлыг нэмэгдүүлж, олон улсын зэрэглэлтэй болгох, зарим сумдад ерөнхий зориулалтын нисэхийг хөгжүүлэх
- 3.1.8. Цахилгаан эрчим хүчийг дотооддоо үйлдвэрлэх хөрөнгө оруулалтын 60 МВт-ын цахилгаан станц барих төслийн ажлыг эхлүүлэх

Зорилт 3.3. Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн нөөц ашиглалт, эдийн засгийн эргэлтийг эрчимжүүлж, тооноос чанар, бүтээмжид шилжүүлнэ:

- 3.3.3. Тариалангийн эргэлтийн талбайн ашиглалтыг сайжруулж, тариалангийн бүс нутгийг тогтоох, усалгаатай тариалангийн талбайг нэмэгдүүлэх, үр тариа болон голлох нэр төрлийн хүнсний ногоо, чацаргана, жимс жимсгэнэ, тэжээлийн ургамлын нутагших чадвартай үр, сортыг бодлогоор хөгжүүлж дотоодын болон бүсийн хэрэгцээг хангах, зэрлэг чацарганыг хамгаалах, бусад ашигт таримлын үйлдвэрлэл, өвөл зуны хүлэмж, зоорь агуулахыг нэмэгдүүлэх
- 3.3.4. Дундын хоршоодыг чадавхжуулан, хөдөө аж ахуйн бүтээмж үр ашгийг нэмэгдүүлж, байгальд ээлтэй дэвшилтэт технологид суурилсан шинэ ажил, үйлчилгээг дэмжин хөгжүүлэх, техник хангамжийг нэмэгдүүлэх
- 3.3.5. Өртгийн сүлжээ, кластерт холбогдсон бизнес болон ЖДҮ-ийг бодлогоор дэмжих
- 3.3.7. Ноос, ноолуур боловсруулах үйлдвэрийг барих санаачилгыг дэмжих, малын түүхий эдийг худалдан борлуулах нэг цэгийн үйлчилгээг бий болгох

Зорилт 6.1. Эдийн засгийн бүсчлэлийг хөгжүүлж, орон нутаг, салбаруудыг дэд бүтцээр холбоно.

- 6.1.3. Увс-Агро цогцолбор, Аялал жуулчлалын отоглох цэгүүд, баазын цахилгаан хангамжийг шийдвэрлэх
- 6.1.6. Улаангомьн төв цэвэрлэх байгууламжийг шинэчилж, аймгийн төвийн бохирын шугамыг өргөтгөх, сумдын төвд бага оврын цэвэрлэх байгууламж байгуулах ажлыг үе шаттай хэрэгжүүлж эхлэх



- 6.1.9. Увс-Ховд аймаг, Улаангом-Увс нуур, Улаангом-Баруунтуруун, Улаангом зарим сум чиглэлийн хатуу хучилттай авто замыг барих, баруун бүсийн А-07, А-1702, А-18 замын дагуух сумдыг улсын чанартай автозамтай үе шаттай холбох ажлыг эхлүүлэх, зарим чиглэлийн авто замд их засвар хийх
- 6.1.10. Улаангом доторх хатуу хучилттай авто, явган, дугуйн замыг өргөтгөн, бүх багуудыг холбосон сүлжээг байгуулах, аймгийн төв болон сумдын гэр хороолол, гудамж талбайн гэрэлтүүлэг, ногоон байгууламжийг өргөтгөх, ашиглалтын менежментийг сайжруулах

Азийн хөгжлийн банкны “Аймаг, сум хөгжүүлэх хөрөнгө оруулалтын хөтөлбөр”

“Аймаг, сум хөгжүүлэх хөрөнгө оруулалтын хөтөлбөр”-ийн хүрээнд баруун бүсийн аймгийн төвүүдийн дэд бүтцийг сайжруулах, агро-үйлдвэрлэлийн байгууламжийг сайжруулах ажлуудыг хэрэгжүүлэх юм. Тус хөтөлбөрийн хүрээнд Увс аймгийн Улаангом суманд агропарк байгуулахаар төлөвлөгдөж байгаа бөгөөд тус парк нь хорио цээрийн бүс, мал төхөөрөх үйлдвэр, лаборатори болон мал эмнэлгийн үйлчилгээ, судалгаа шинжилгээний төв, бизнес төв, хөдөө аж ахуйн боловсруулах үйлдвэрүүдээс бүрдэх юм.

Зураг 5.2 Улаангом дахь агропаркийн байршил

Эх сурвалж: “Аймаг, сум хөгжүүлэх хөрөнгө оруулалтын хөтөлбөр”

Улаангомдын Хорио цээрийн бүс дэх малын тэжээлийн цэг нь 1000 толгой мал багтаах хүчин чадалтай бөгөөд малын гоц халдварт өвчин гарсан тохиолдолд юм уу экспортын хэрэгцээнд зориулан хоёроос гурван долоо хоног тусгаарлах боломжтой. Бод, бог малд шаардагдах талбайн хэмжээ дунджаар нэг малд 10м² байх тул бүсийн болон тэжээлийн талбай нийтдээ 1га болно. Үүн дээр нэмж хяналт шалгалтын хэсэг, лабораторийн байрт 0.5га, малын хашаа саравчинд 0.5га, өвс, тэжээл хадгалах хашаанд 0.5га, мал төхөөрөх хэсэгт 0.5га, талбайд хөдөө аж ахуйн техник хэрэгслийн зогсоолын талбайд 0.5га-г тус тус гаргана гэж төлөвлөжээ.



“Их наяд” хөтөлбөр

Увс аймгийн хөгжлийн хэтийн төлөвийг Увс аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2015 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн 9/03 дугаар тогтоолоор батлагдсан “Их наяд Увс 2020” хөтөлбөр гаргасан. “Их наяд Увс” хөтөлбөр нь дотроо 5 дэд төсөлтэй. Үүнийг товчлон авахад:

- ✓ Мах тарья



- ✓ Чацаргана
- ✓ Хуурай газрын далай-Увс нуур
- ✓ Цахилгаанжуулалт
- ✓ Санхүүч Увс

Тус хөтөлбөр хэрэгжсэнээр доорх үр дүнд хүрэхээр тусгасан байна. Үүнд:

- Түүхий эдүүдээ дотооддоо үйлдвэрлэх боломжууд бий болно.
- Чацарганы үйлдвэрлэлд шинэчлэл хийнэ.
- Махны үйлдвэрлэл сайтар хөгжинө.
- Малын гаралтай түүхий эд боловсруулах үйлдвэрүүд байгуулагдана.
- Оёдол нэхмэл арьс ширний үйлдвэрүүд байгуулагдана.
- Малын тэжээлийн үйлдвэр, барилгын материалын үйлдвэрүүд шинэ шатанд гарна.
- Чацарганы логистик сүлжээ бий болгох:
- Хүйтэн хэлхээний агуулахын аж ахуй
- Хүйтэн хэлхээний тээвэр байгуулах гэсэн олон арван зорилтууд хэрэгжиж, ажлын байраа дагаад ажиллах хүчний тоо нэмэгдэнэ.

Үйлдвэрлэлийн салбар 20 дахин өснө:

- Малын тоо 2,5 сая, 5,000 малчин өрх байх бөгөөд тариалангийн талбай 50,000 га талбайг ашиглана.
- Загас агнуур, зөгийн аж ахуй болон бусад аж ахуйнууд хөгжсөн байна.

Хөдөө аж ахуйн нэмүү өртөг 4 дахин өснө:

- Баруун бүсийн худалдааны төв
- Санхүүгийн үйлчилгээний өндөр хөгжил
- Аялал жуулчлалын салбарын хөгжлийг дагаж зочид буудал, зоогийн газар,
- тээврийн үйлчилгээ сайтар хөгжинө.

Үйлчилгээний салбар 4.3 дахин өснө:

- Баруун бүсийн худалдааны төв
- Санхүүгийн үйлчилгээний өндөр хөгжил
- Аялал жуулчлалын салбарын хөгжлийг дагаж зочид буудал, зоогийн газар,
- тээврийн үйлчилгээ сайтар хөгжинө.



Хөдөө аж ахуйн салбарын гол бүтээгдэхүүнүүд:

- Өнөөгийн дотоодын үхрийн махны хэрэглээний 40%; хонины махны хэрэглээний 15%-ийг дангаар нийлүүлэгч; Махны үйлдвэрлэлийн загвар аймаг
- 62 мянган тонн бэлтгэсэн сүү, 210 тн ямааны ноолуур, 1000 тн ноос, 60000 арьс,
- 11000 тн үр тариа, 12 тн төмс, төмсний үр, 13500 тн гурвалжин будаа, 7500 тн эрдэнэшиш, 120000 тн царгас

Аж үйлдвэрийн салбарын гол бүтээгдэхүүнүүд:

- 30 тн чацарганы тос, 21 тн хуурайшуулсан чацаргана үйлдвэрлэж ОУ-д экспортлогч
- 350,000 ширхэг оёмол хувцас ба гутал үйлдвэрлэл
- 5000 тн малын тэжээлийн үйлдвэрлэл
- 10,000 мкв барилгын материалын үйлдвэрлэл,
- ОХУ-д жилд 200 тн хиаман бүтээгдэхүүн экспортлох
- Жилд ашиглалтад орох орон сууцны тоо 200 айл
- Худалдааны нийт эргэлт 2 их наяд
- Гадаадын 15,000; дотоодын 45,000 жуулчин жилд хүлээн авна.
- 120,000 зорчигч тээвэр, 150,000 тн ачаа тээвэр
- 950,0 тэрбумын зээлийн өрийн үлдэгдэл
- 400,000 тэрбум төгрөгийн иргэдийн хадгаламж

Хүснэгт 5.1 Хүнсний үйлдвэрийн хүчин чадал

№	Объектууд	Хэмжих нэгж	Хүчин чадал	Тайлбар
Хүнсний үйлдвэр				
1	Махны үйлдвэр	тн/жил	1000	Жилд 1000 тн мах, 600 тн махан бүтээгдэхүүн
2	Чацарганы тос боловсруулах үйлдвэр	тн/жил	30	
3	Сүүний үйлдвэр	л/хон	800-1500	
4	Хүүхдийн сүү, тэжээлийн үйлдвэр	кг/хон	50-100	
5	Ундаа, цэвэр усны үйлдвэр	л/хон	2000	

Эх сурвалж: "Их наяд" хөтөлбөр



5.1.2 Улаангом хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө


Ерөнхий төлөвлөгөөний концепци

Увс аймгийн төв Улаангом хотын сумын төвийн хөгжлийн хэтийн төлөвийг Нэкст Степ Инженеринг ХХК 2018 онд “Улаангом хотын 2030 оны хөгжлийн ерөнхий төлөвлөгөө”-нд тусгасан төлөвлөлтийн шийдэлд тусгасан байдаг.

Улаангом хотын 2030 оны төлөвлөлтийн үндсэн шийдэл нь:

Орон нутгийн нөөц баялагтаа тулгуурлан үйлдвэрлэл, үйлчилгээ дэд бүтэц хөгжүүлсэн аймгийн засаг захиргаа, соёл, шинжлэх ухаан, мэдээлэл технологи, нийгмийн үйлчилгээний төв хот байхаар авч үзэж, хүн ам эрүүл аюулгүй орчинд амьдрах нөхцлийг бүрдүүлэхэд чиглэгдэнэ гэж заасан байдаг.

Зураг 5.3 Улаангом хотын хөгжлийн тэргүүлэх чиглэл



Төлөвлөлтөөр орон сууцны хангамжийг 2030 он гэхэд нийт өрхийн 55%-ийг буюу 6332 өрхийг хангахаар тооцсон байна. Улаангом хотын хөгжлийг хангах зорилтуудыг дараах байдлаар томъёолсон.

Хүснэгт 5.2 Улаангом хотын хөгжлийн зорилтууд

Аймгаа хангах чадвартай үйлдвэрийн хот	<ul style="list-style-type: none"> ✓ Мал аж ахуйн түүхий эдэд тулгуурлан боловсруулах аж үйлдвэр барих ✓ Барилгын материалын үйлдвэр хөгжүүлж, аймагтаа төдийгүй бүс нутаг чиглэсэн үйл ажиллагаа явуулах, ✓ Гадны хөрөнгө оруулалтыг татаж, аж үйлдвэрийн цогцолбор бий болгосноор ажилгүйдэл, ядуурлыг бууруулах,
Аялал жуулчлал, амралт зугаалгын сэтгэл татам хот:	<ul style="list-style-type: none"> ✓ Аялагч, жуулчдыг татах зорилгоор зам тээвэр, харилцаа холбооны найдвартай сүлжээ бүхий хот болох, ✓ Нисэх онгоцны буудлын зэрэглэлийг нэмэгдүүлж, дэд бүтцийг хөгжүүлэх замаар аялал жуулчлалын хотыг бий болгох, ✓ Орон нутгийн иргэд, оршин суугчдын чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх ногоон байгууламж, хөшөө дурсгал бүхий цэцэрлэгт хүрээлэн, үзмэрийн газрууд бүхий хотыг хөгжүүлэх,




<p>Иргэдийн амьдрах таатай ирээдүйг төлөвлөсөн хот:</p>	<ul style="list-style-type: none"> ✓ Нийслэлээс алслагдсан баруун бүсийг Орос улстай холбосон “бизнес, худалдаа, ложистик”-ын төв хот болох, ✓ Аймгийнхаа хүн амыг мэргэжлийн сургууль, нарийн мэргэжлийн эмчилгээ, оношилгоо болон бусад үйлчилгээгээр хангасан нийгмийн үйлчилгээний хот, ✓ Хүн амын амьдрах таатай орчин бүхий орон сууцны хорооллыг барьж байгуулахаас гадна гэр хорооллын иргэдийн санаачилга, оролцоонд тулгуурлан дахин төлөвлөх, шинээр хотхон, хороолол байгуулах замаар орон нутагт бүтээн байгуулалтыг өрнүүлэх, ✓ Хүн амын аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор зам талбай, тохижилт, инженерийн бэлтгэл арга хэмжээний асуудлыг шийдсэн тохилог хот болох, ✓ Бүтээн байгуулалтын ажлыг дулаан хангамж, ус хангамж, ариутгах татуурга, цахилгаан хангамж, холбоо мэдээллийн сүлжээний эх үүсвэрээр хангасан орчин үеийн хот байгуулах,
<p>Байгальд ээлтэй хот</p>	<ul style="list-style-type: none"> ✓ Усны нөөцөө ашиглан жимс, жимсгэнэ тариалахын зэрэгцээ ногоон болон цэнхэр сүлжээг бий болгож, хүн амын тав тухтай амьдрах орчныг бүрдүүлэх, ✓ Цэцэрлэгт хүрээлэн байгуулах, ✓ “Хөдөө ба хот”, “хөгжил ба уламжлал”-ын хоорондын зохицолдоог хангасан хот болох,

Зураг 5.4 Улаангом сумын хэтийн төлөв-2030







Төлөвлөгдсөн бүсчлэл



Төлөвлөгдсөн авто замын сүлжээ



Ерөнхий төлөвлөгөө





Хүн ам өрхийн хэтийн төлөв

Увс аймгийн хүн ам өрхийн тооцоог гүйцэтгэгч компанийн зүгээс боловсрууллаа. Ингэхэд Ингэхэд аймгийн хүн ам 2030 онд 98 мянга, 2040 онд 112 мянгад хүрэхээр байгаа ба өрхийн тоо 2030 онд 25 мянга, 2040 онд 27 мянгад тус тус хүрэхээр тооцогдлоо.

Хүснэгт 5.3 Увс аймгийн сумдын хүн амын хэтийн төлөв

№	Сумын нэр	2010	2021	2010-2021 оны өсөлтийн хурд	2030	2040
1	Баруунтуруун	2668	2,802	0.5%	2,930	3,058
2	Бөхмөрөн	2098	2,294	0.8%	2,489	2,684
3	Давст	1713	1,592	-0.6%	1,490	1,388
4	Завхан	1727	1,913	1.0%	2,100	2,288
5	Зүүнговь	2509	2,895	1.4%	3,300	3,705
6	Зүүнхангай	2247	2,409	0.7%	2,567	2,725
7	Малчин	2292	2,472	0.7%	2,648	2,825
8	Наранбулаг	4331	4,400	0.1%	4,464	4,527
9	Өлгий	2046	2,493	2.0%	2,988	3,483
10	Өмнөговь	4049	4,772	1.6%	5,547	6,321
11	Өндөрхангай	3149	3,238	0.3%	3,321	3,404
12	Сагил	2239	2,507	1.1%	2,780	3,053
13	Тариалан	3682	4,067	1.0%	4,454	4,840
14	Түргэн	1985	2,100	0.5%	2,211	2,321
15	Тэс	5035	5,211	0.3%	5,377	5,542
16	Ховд	2091	2,555	2.0%	3,070	3,586
17	Хяргас	2470	2,564	0.3%	2,653	2,741
18	Цагаанхайрхан	1945	2,118	0.8%	2,289	2,461
19	Улаангом	24530	32,912	3.1%	43,136	53,360
	НИЙТ	72806	85,314	1.6%	98,638	111,963

Эх сурвалж: Нью Урбанизм ХХК

Хүснэгт 5.4 Увс аймгийн сумдын өрхийн хэтийн төлөв

№	Сумын нэр	2010	2021	2010-2021 оны өсөлтийн хурд	2030	2040
1	Баруунтуруун	746	762	0.2%	777	792
2	Бөхмөрөн	562	571	0.1%	579	588
3	Давст	437	424	-0.3%	413	401
4	Завхан	499	520	0.4%	540	560
5	Зүүнговь	675	722	0.6%	768	813
6	Зүүнхангай	656	647	-0.1%	639	631
7	Малчин	637	655	0.3%	672	689
8	Наранбулаг	1042	1052	0.1%	1,061	1,070
9	Өлгий	531	620	1.5%	714	809
10	Өмнөговь	1035	1154	1.0%	1,275	1,395
11	Өндөрхангай	924	908	-0.2%	894	879
12	Сагил	632	609	-0.3%	589	569
13	Тариалан	896	966	0.7%	1,035	1,103
14	Түргэн	532	618	1.5%	709	800
15	Тэс	1299	1308	0.1%	1,316	1,324
16	Ховд	627	691	0.9%	755	819
17	Хяргас	651	636	-0.2%	623	609
18	Цагаанхайрхан	581	596	0.2%	610	624
19	Улаангом	6770	8856	2.8%	11,337	13,817
	НИЙТ	19732	22315	1.2%	24,971	27,626

Эх сурвалж: Нью Урбанизм ХХК



5.2 УВС АЙМГИЙН АЧАА ТЭЭВЭРЛЭЛТ, ХАДГАЛАЛТЫН ХЭТИЙН ТӨЛӨВ

5.2.1 Хүн амын хэтийн төлөв, хүнсний бараа бүтээгдэхүүний хэрэгцээ

Монгол улсын үндэсний статистикийн эмхэтгэлээс үзэхэд хүн амын хүнсний хэрэглээ нь хүн амын дунд махны хэрэглээ хот 24 %, хөдөө 22%, ойролцоо боловч, сүүний хэрэглээ хот 21%, хөдөө 41 %, үр тариа хот 36%, хөдөө 28%, ногооны хэрэглээ хот 19%, хөдөө 9% байна. Энэ мэдээж хөдөөний хүмүүс ногоо бага идэж байгаа нь хүний амьдралын хэвшилтэй ойлгож болох ч, нөгөө талаас хүртээмж хангамжийн асуудал бас байдаг. Эрүүл амьдралын хэвшил болох мах, үр тариа, төмс ногоо, сүүний зохистой хэрэглээг бий болгохын тулд хүртээмж, тогтвортой үнээр тогтмол хангах шаардлагатай.

Зураг 5. 5 Монгол Улсын хот хөдөөгийн хүнсний хэрэгцээний бүтэц



Монголчуудын хүнсний хэрэглээний төрөл зүйл хэт тэнцвэргүй бөгөөд бусад оронтой харьцуулахад зүрх судасны эмгэг, цус харвалт, 2-р хэлбэрийн чихрийн шижин болон хорт хавдар зэрэг халдварт бус өвчлөлд өртөх эрсдэл маш өндөр байна.

✓ **Махны хэрэглээ**

Аймгийн болон Сумын иргэд өвөл өөрсдийн хэрэглээний махыг ихэвчлэн өөрсдийн мал, махнаас хангаж байдаг. Тэдний хувьд мах худалдан авах ойлголт байхгүй гэж болно. Увс аймгийн сургууль, цэцэрлэг, эмнэлэг болон зоогийн газар зэрэг нийтийн хэрэглээг тогтмол өргөн хэрэглээний бараагаар хангах шаардлагатай байдаг. Аймгийн нийт хүн амын мах махан бүтээгдэхүүний жилийн хэрэгцээ нь 5,7 мян/тн бөгөөд жилд дунджаар 17,0-18,0 мян/тн мах бэлтгэж, аймгийнхаа хэрэгцээг бүрэн хангаж, үлдэгдлийг нь дотоод гадаадын зах зээлд нийлүүлж байна. Эргэлтэд орсон малын сүргийн эзлэх хэмжээ нь хонь-21,1%, ямаа-16,%, үхэр-11, %, адуу-5,1%, тэмээ-4,8% байгаа бөгөөд нийт мал сүргийн 17,9 хувийг эзэлж байна. Дотоодын махны хэрэгцээнд 276,6 мян/толгой мал, арилжааны болон төвийн бүсийн хүн амын хэрэгцээнд 213,1 мян/толгой мал буюу нийт 4,7 мян/тонн махыг бэлтгэн нийлүүлэх бүрэн боломж байна.¹⁶

¹⁶ Шинэ хөдөө – Увс төсөл



Аймгийн махны одоо байгаа хэрэглээг тогтоож, хэтийн хэрэгцээг тодорхойлох дараах байдлаар тооцож болно.

✓ **Жишсэн хүн амын жилийн хүнсний хэрэгцээ**

Жишсэн нэг хүний хоногийн хүнсний хэрэгцээ гэж бодисын үндсэн солилцоо, бие мах бодийн эрхтэн тогтолцооны хэвийн үйл ажиллагаа, эд эсийн нөхөн төлжилт, илч зарцуулалтыг нөхөхөд нэг хоногт шаардагдах илчлэг, шимт бодисуудын хэмжээ, тэдгээрийг хангах хүнсний бүтээгдэхүүний хэмжээг ойлгоно.

Үндэсний статистикийн газраас Увс аймгийн хүн амын тоог 2020 онд 84294 хүн ам байсан, 2035 онд 88485 хүн амтай, 2045 онд 98472 хүн амтай байхаар тооцсон байна. Хүн амын өсөлтийн тооцоололд үндэслэн ЭМЯ-наас гаргасан нормчлолын дагуу нэг хүний жилийн хүнсний хэрэгцээний жишсэн хэрэглээг дараах байдлаар тооцов.

Хүснэгт 5.5 Увс аймгийн хүн амын жишсэн хүнсний хэрэгцээ 2035 он

№	Хүнсний бүтээгдэхүүний нэр төрөл	Жишсэн нэг хүний жилийн хүнсний хэрэгцээ / кг /	Жишсэн хүн амын хүнсний хэрэгцээ / мян.тн /
1	Мах, махан бүтээгдэхүүн	73	6 459
2	Төмс	51,0	4 512
3	Хүнсний ногоо	73	6 459
4	Жимс, жимсгэнэ	65,7	5 813

Эх үүсвэр: ЭМЯ

Увс аймгийн хүн амын хэрэгцээнд нэг жилд мах, махан бүтээгдэхүүн 6456 тн, төмсний хэрэгцээ 4512 тн, хүнсний ногоо 6459 тн, жимс, жимсгэнэ 5813 тн шаардлагатай болохоор байна.

5.2.2 МАА, ГТ, барилгын материал, аж үйлдвэрийн бараа бүтээгдэхүүний хэрэгцээ

Увс аймгийн бараа бүтээгдэхүүний хэрэгцээг тодорхойлсноор одоогийн хэрэглээ хэд дахин өсөх, тэр хэрэгцээг хангахын тулд одоо байгаа үйлдвэрлэлийн хүчин чадал, ачаа эргэлтийг хэд дахин өсгөх шаардлагатайг тооцоолох боломжтой болно. Увс аймгийн бараа бүтээгдэхүүний хэрэгцээг дараах үндсэн ангиллаар хувааж тооцоолов. Үүнд:

- ХАА-н бүтээгдэхүүн
- Хүнсний бүтээгдэхүүн
- Ахуйн бараа бүтээгдэхүүн
- Барилгын материал – Барилгын материалын хэрэгцээг тооцоходоо 1м2 барилгад дунджаар 2.4тн тоосго, 3.5 тн бетон орохоор тооцоолов.
- Тавилга – Тавилгыг нэг өрх 5 жилд нэг удаа тавилгаа солихоор, мөн шинээр нэмэгдэж буй өрх бүрт ногдохоор тооцоолов.
- Ноос, ноолуур – Хивсийг өрхөд 2 байхаар тооцоолов.
- Бөс бараа, хувцас – 1 хүнд ногдохоор тооцох
- Цахилгаан бараа



- Арьс шир
- Өвс тэжээл

5.2.3 Хүнсний ногооны хэрэгцээ

Олон нийтийн байгууллага, ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, үйлчилгээний газруудыг эрүүл ахуй, хүнсний аюулгүй байдлыг бүрэн хангасан мах, махан бүтээгдэхүүн, төмс, хүнсний ногоо, жимс, жимсгэнээр найдвартай, тогтвортой ханган нийлүүлэх бүрэн боломжтой гэж үзэж байна.

Хүснэгт 5. 6 Улаангом хотын төрийн болон зарим үйлчилгээний газрын төмс, хүнсний ногооны хэрэгцээ

№	Байгууллага	Тоо	Ажиллах хоног	Өдөрт хэрэглэх төмс, хүнсний ногооны хэмжээ /кг/	Жилд шаардлагатай төмс, хүнсний ногооны хэмжээ /тн/
1	Цэцэрлэг	34	170	71,6	413,8
2	Ерөнхий боловсролын сургууль	30	165	71,6	354,4
3	Эмнэлэг	24	264	113,6	719,8
4	Цэргийн анги	3	365	155,5	170,3
5	Ресторан, зоогийн газар	30	280	117,1	983,6
	Нийт				2642,0

Эх үүсвэр: ҮСХ, "МХШТФХ" ТББ-ын судалгаа

5.2.4 Үйлдвэрлэлийн хэтийн зорилго

Увс аймгийн үйлдвэрлэлийн хэтийн зорилго:

- Доорх төслүүдийн хүрээнд жил бий болох ачааны хэмжээ, Үүнд:
- Гурил тэжээлийн үйлдвэр, Баруунтуруун: 24 мян.тн гурил, 6 мян.тн хивэг,
- ЦУГ, Улаангом: 50 мян.хос гутал
- Тэжээлийн үйлдвэр, Улаангом: 8 мян.тн тэжээл,
- Давс, Давст: 5000 тн давс,
- Чацаргана, Улаангом: 2000 тн бэлэн бүтээгдэхүүн,
- УВС: 1 тэрбум төгрөгийн борлуулалт, нэр бүхий бүтээгдэхүүн,
- Төмрийн хүдэр, Наранбулаг: 500 мян.тн хорголж, Ховд аймгийн хилийн боомт руу
- Мах боловсруулах үйлдвэр, Улаангом: 6 мян.тн мах УБ руу,
- Хурга төлөг бордох аж ахуй, Баруунтуруун: 1000 тн хурга, төлөгний мах буюу 65 мянган толгой хурга, 1000 толгой бяруу, шүдлэн нийлүүлэх, УБ болон экспорт

5.2.5 Гадаад худалдааны хэтийн төлөв

Монгол улс дотоодоо цахилгаан эрчим хүчээр хангахын тулд Увс аймгийн Өмнөговь суманд, мөн Ховд аймагт Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц барихаар шийдвэрлэсэн



байгаа. Газрын тос боловсруулах үйлдвэр Дорноговь аймгийн Алтанширээд байгуулахаар эхэлсэн. Эдгээр үйлдвэрүүд 2025 оноос эхлэн ашиглалтад ороход Монгол улсын гадаад худалдаанд ихээхэн өөрчлөлт орох болно.

5.2.6 Агуулахын багтаамж, хүчин чадлын хэрэгцээ

Увс аймгийн бараа хадгалалтын хэрэгцээ буюу логистикийн төвд байгуулах агуулахын багтаамж, хүчин чадлын хэрэгцээг тооцож гаргалаа.

- **Төмс, хүнсний ногооны хэрэглээ зоорь, агуулах**

Эхний ээлжид төмс хадгалах зоорийн төлөвлөж буй багтаамжаас хамааран жилд 2000 тн төмс, 1800 тн хүнсний ногоо, 200 тн жимс, жимсгэнийг нөөцлөн хадгалж, зах зээлд нийлүүлэх боломж бий болно.

- ✓ 2000 тонн төмсний багтаамжийг тооцвол. 2000 тонн = 2 000 000 кг
- ✓ 1кг/м³ -д 750кг төмс багтана.
- ✓ 2 000 000 кг /750 кг/м³ = 2666,6 м³

Зоорь агуулахын багтаамж нь хадгалах ногооны багтаамжаас 20-30 хувь илүү байдаг. Учир нь агаарын сэлгэлт хийх орон зайг үлдээх шаардлагатай.

Жишээ: 2000 тонн төмсний зоорийн багтаамжийг тооцоход, 2000 тонн төмс 2666,6 м³ эзлэхүүнтэй. Зоорийн багтаамж нь үүнээс 30 хувиар илүү байх ёстой.

$$V_{\text{зоорь}} = V_{\text{төмс}} + V_{\text{төмс}} * 30\%/100\%$$

$$V_{\text{зоорь}} = 2666,6 \text{ м}^3 + 2666,6 \text{ м}^3 * 30\%/100\% = 2666,6 \text{ м}^3 + 799,9 \text{ м}^3 = 3466,5 \text{ м}^3$$

$$V_{\text{зоорь}} = 3466,5 \text{ м}^3$$

Хүснэгт 5. 7 Зоорийн багтаамж

	Бүтээгдэхүүний нэр	Хувийн жин, кг/м ³	Багтаамж /тн/	Багтаамж эзлэхүүн м ³
1	Төмс	750	2000	3466
2	Хүнсний ногоо	550	1800	4726
3	Жимс, жимсгэнэ		200	

Гаднаас хүйтэн агаарыг оруулж халуун агаарыг гадагшлуулах замаар хөргөдөг. Мөн агаарыг халааж дулаанаар үлээлгэдэг. Байгалийн аргаар эсвэл тоног төхөөрөмж /сэнс, компрессор/ ашиглах аргыг хэрэглэдэг.

Жишээ нь: 1000 тонн төмсний зооринд гаргах/оруулах нээлхийний талбай 9м² байхаар 1000 тонн сонгинод 13м² байхаар тус тус тооцно. Төмсийг агааржуулахад эсэргүүцэл нь 150Па байдаг. 80-100 м³/цаг/м³ агаар шаардлагатай. Сонгино агааржуулахад эсэргүүцэл нь 250 Па байдаг. Хэрэв сонгиныг талбай дээр урьдчилан хатаагаагүй бол 100-120 м³/цаг/м³ агаар шаардлагатай. Талбай дээр урьдчилан хатаасан бол 80 м³/цаг/м³ агаар шаардлагатай. Манжинг агааржуулахад эсэргүүцэл нь 150Па байдаг. 60 м³/цаг/м³ агаар шаардлагатай.

- **Зоорь, агуулахын хэрэгцээ**



Улаангом Логистик төвд эхний ээлжид шинээр 1800 тн махны хөргөгчтэй агуулах, 200 тн махан бүтээгдэхүүн болон сүүн бүтээгдэхүүний хөргүүртэй агуулах төлөвлөж байна. Мах, махан бүтээгдэхүүний төрөлжсөн агуулахыг 2000 тонн багтаамжтайгаар төлөвлөж байна.

Төмс, хүнсний ногооны агуулах, тус бүр 2000 тн багтаамжтай 2 агуулах, нийт 4000 тн багтаамжтай агуулах шаардлагатай байна. Хүнсний өргөн хэрэглээ, гурил будаа, нөөшилсөн хүнсэнд зориулж 1000 тн багтаамжтай агуулах төлөвлөж байна. Цаашид өргөжүүлээд агуулахын багтаамж хүчин чадлыг нэмэгдүүлэх боломжтой юм.

Хүснэгт 5. 8 Зоорь, агуулахын хэрэгцээ

№	Нэрс	Тоо	Багтаамж /тн/	Нийт багтаамж /тн/	Нэгж үнэлгээ /нэгж сая.төг/	Нийт үнэ /сая.төг/	Хэрэгжих хугацаа
1	Махны хөргөлттэй зоорь, агуулах						
	Улаангом	1	2000	2000	3 420	34 200	2024
2	Хүнсний ногооны зоорь, агуулах						
	Улаангом	2	2000	4000	3 420	34 200	2024
3	Хүнсний өргөн хэрэглээ, нөөшилсөн бүтээгдэхүүн, гурил, будааны агуулах						
	Улаангом	1	1000	1000			
	Хөдөө аж ахуйн салбарын агуулах						
1	Улаангом	1	2000	2000			
	Аж үйлдвэрийн салбарын агуулах						
2	Улаангом	1	1000	1000			

5.3 БАРУУН БҮСИЙН ЛОГИСТИК ТӨВ БАЙГУУЛАХ ҮЗЭЛ БАРИМТЛАЛ, ШИЙДЭЛ

5.3.1 Үндэслэл ба хэрэгцээ шаардлага

Улс орон бүр хөгжлийн үе шатыг дамжиж, хөгжилд тэмүүлж байна. Манай улс ч импортлогч орноос, үйлдвэрлэгч болон экспортлогч орон болох засгийн газар, бүх аймаг, сумууд зорилт тавьж бүхий л шатанд ажиллаж байна. Өрх бүр үйлдвэрлэгч, өөрийн газартаа хэрэгцээний төмс, ногоо тарьж, малчид ноос, ноолуур, мах үйлдвэрлэгч болж, өрхийн үйлдвэрлэлээс жижиг дунд үйлдвэрлэл рүү шилжиж, жижиг дунд үйлдвэрлэлээс өөрийн үйлдвэрлэлийн байртай болж, эдийн засгийн өсөлтийг даган томрох болно. Үйлдвэрлэлийн өсөлтөд хамгийн чухал нь үйлдвэрийн логистик, тээврийн логистик болон агуулахын логистик чухал түлхэц болно.


Монгол улс 2022 оноос Таван Толгой - Гашуун Сухайт төмөр зам ашиглалтад орж, экспортын хэмжээ нэмэгдэх болно. Увс аймгийн Өмнөговь сумын нутагт болон Ховдын Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц ашиглалтад орсноор баруун аймгууд эрчим хүч, Алтанширээт суманд баригдсан газрын тосны үйлдвэр тус тус ашиглалтад орсноор Монгол улс эрчим хүч, бензин импортлохгүй байх болно. Цаашлаад Оюу толгой болон бусад уурхайн ажиллагаа ойрын 3-4 жилд экспортын хэмжээ нэмэгдэх болно. Гадаад худалдааны төлбөрийн тэнцэл ашигтай болж, эдийн засгийн тэлэлт нэмэгдэж, дотоодын үйлдвэрийг дэмжих бодлогоор үйлдвэрүүдийн ажиллагаа жигдрэх болно.




Увс аймгийн Их наяд хөтөлбөрт, үйлдвэрлэлийн салбар 20 дахин, хөдөө аж ахуйн нэмүү өртөг 4 дахин, худалдаа үйлчилгээ 4.3 дахин өсөхөөр байна. Боршоо боомтыг шинэчилж өргөтсөнөөр өдөрт нэвтрэх зорчигчийн тоо 4,8 дахин, ачааны автомашины тоо 3 дахин, суудлын автомашины тоо 6.7 дахин нэмэгдэж, гадаад худалдааны эргэлт мөн хэмжээгээр нэмэгдэх болно.

Дээр дурдсан эдийн засгийн өсөлтийг даган Увс аймагт үйлдвэрлэсэн бараа материал, мах, махан бүтээгдэхүүн, чацаргана, оёмол хувцас ба гутал үйлдвэрлэл, ноос, ноолуур, арьс шир болон аймгийн иргэдийн хэрэгцээний төмс, хүнсний ногоо өргөн хэрэглээний барааны бүтээгдэхүүний агуулах зайлшгүй шаардлагатай болно.

Зураг 5.6 Увс аймагт бүтээгдэхүүн импортлох логистик үйл ажиллагааны схем



Зураг 5.7 Увс аймгаас бүтээгдэхүүн экспортлох логистик үйл ажиллагааны схем



Улаангом хотод Улаанбаатар хотоос ирэх болон Боршоо боомтоос ирэх авто замуудын нэгдэл дээр нэгдсэн терминал, логистик төвийг байгуулан, үйл ажиллагаа нь баруун бүсийн болон аймгийн хэрэгцээг хангах, уялдуулах мэдээлэл, харилцаа холбооны технологид суурилсан дэд бүтцийг байгуулна.



Улаанбаатар хотоос болон хилээр импортоор ирэх ачаа бараа шууд логистик төвд хуваарилагдсаны дараа хотын нэгдсэн түгээлтийн сувгаар бусад аймаг болон сумуудад жижиглэнгийн сүлжээгээр тараагдана. Эдгээр үйл ажиллагааг логистик төвөөс тухайн бараанд олгогдсон зураасан кодын тусламжтайгаар цахим сүлжээгээр дамжигдан хянах ба уг хяналтын тогтолцоо нь зөвхөн барааны чанараас гадна гаргуулахад байгаа нөөцийн мэдээллүүдийг агуулснаар зах зээлд нийлүүлэгдэх тухайн барааны үнэ ханш тогтвортой байх нөхцөлийг бүрдүүлдэг.

Логистик төв нь хүнсний бараа, өргөн хэрэглээний бараа, аж үйлдвэрлэлийн бараа болон хотын үйлдвэрүүдэд шаардлагатай түүхий эд, хагас боловсруулсан бүтээгдэхүүний төрөлжсөн агуулахуудын цогцолборыг байна. Улаангом логистик төвийн хажууд үйлдвэрийн бөөний дэлгүүрүүд байрлах бөгөөд хэрэглэгчид бөөний үнээр бараа худалдан авах нээлттэй тогтолцооны болно. Мөн тэнд үйлдвэрлэгч, худалдан авагч нарт зориулсан үзэсгэлэн худалдаа явуулах үзэсгэлэнгийн танхим байгуулах болно. Ингэснээр жижиглэн худалдааны сүлжээн дэх хэт ашгийн хойноос хөөцөлдөх явдлыг тодорхой түвшинд хязгаарлаж, үйлдвэрлэгч нарыг худалдан авагч нартай шууд холбох боломжтой болгоно.

Логистик төвд төрөл бүрийн шинжилгээний лаборатори байрлах тул агуулахад байгаа бараа бүтээгдэхүүний чанарт өдөр бүр илгээгдэх үед нь шалгалт хийн кодонд оруулах тул хүнсний болон бусад өргөн хэрэглээний барааны чанар, аюулгүй байдал, хадгалалтын горим хяналт тавих боломжтой болно.

Улаангом логистик төв агуулахын үйл ажиллагаа сүлжээ дэлгүүрүүд, үйлдвэрүүдийн хооронд цахим бүртгэлийн систем ажилласнаар тухайн барааны зах зээлийн үнийг тогтвортой барих зорилгоор нөөц бүрдүүлэлт, үйлдвэрлэх захиалга, бүрдүүлэлт хийгдсэнээр оролцогч талууд зардал хэмнэх боломж бүрдэнэ.

Төрийн зүгээс зах зээлд эргэлдэх бараа бүтээгдэхүүний үнийн зохицуулалтыг логистик төвүүдээр дамжуулан импортоор орж ирэх барааны нөөцийн хамгийн бага хэмжээг тогтоох боломж бүрдэнэ. Логистик тогтолцоо бий болсноор хотод үйлдвэрлэгдэх бараа бүтээгдэхүүн, хот руу ирэх импортын барааг бага оврын тээврийн байгууллагуудаар гүйцэтгүүлснээр дараах давуу тал бий болдог. Үүнд:

- Үйлдвэрлэгчид болон худалдааны байгууллагууд тээвэр логистикийн зардлаа бууруулдаг. Учир нь компани бүр өөрийн дэргэд байсан автобаазаа татан буулгах боломж бүрдэнэ. Нөгөө талаас логистикийн тээврийн компани бий болсноор ажлын байр нэмэгдүүлнэ.
- Хот доторх ачааны тээврийн хэрэгслийн тоо буурснаар хотын тээврийн ачаалал, агаар, орчны бохирдол, дуу чимээ буурна.
- Мэдээлэл үнэн гарснаар статистикийн тоо үзүүлэлт сайжирч Засгийн газрын бодлого хэрэгжилтэд сайнаар нөлөөлнө.
- Тухайн логистик тогтолцоогоор хүнсний бараа, өргөн хэрэглээний бараа, аж үйлдвэрлэлийн бараа болон нөгөө талаас тухайн үйлдвэрүүдэд шаардлагатай түүхий эд, хагас боловсруулсан бүтээгдэхүүн тухайн бараа бүтээгдэхүүний онцлогт тохируулан стандартын тээвэрлэлт хийгдэнэ.

Нэг талаас Улаангом хот дотор буй тархай бутархай олон жижиг агуулахыг нэгтгэн зориулалтын нэгдсэн төв байгуулах замаар Увс аймаг, баруун бүсийн ард иргэдийн тээвэр



логистикийн зардлыг бууруулах хэрэгцээ шаардлага, нөгөө талаас бөөний худалдаа эрхлэгчдийг дэмжих замаар ажлын байр бий болох, Увс аймгийн үйлдвэрлэгчдийн бараа бүтээгдэхүүнийг тогтвортой тээвэрлэх дэд бүтцийн эрэлт хэрэгцээн дээр энэхүү төсөл үндэслэгдэж байна.

5.3.2 Зорилго, хамрах хүрээ ба тавигдах шаардлага

Зорилго

Увс аймаг, Баруун бүсийн худалдаа тээврийн дэд бүтцийг сайжруулан өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, тээвэр, Логистикийн үйлчилгээний үргүй зардлыг бууруулан эдийн засаг, бизнесийн өсөлтөд эерэг нөлөө үзүүлэхэд оршино.

Үр дүнд нь Увс аймгийн ачаа тээвэр Логистикийн салбарт олон улсын тэргүүний техник технологийг нутагшин нэвтэрч, хот төлөвлөлт, хотын доторх ачаа барааны урсгалыг дэлхийн томоохон хотуудын жишгээр хотын гадна зохион байгуулж бизнесийн хөгжлийг дэмжих боломж бүрдэнэ.

Түүнчлэн одоогийн хот доторх логистик төвүүдийг дагасан агуулахын аж ахуйнуудыг Улаангом хотоос гадагш гаргаж хадгалалтын зардлыг бууруулах ба Улаанбаатар хот болон Баруун бүс, бусад аймаг орон нутаг руу чиглэсэн барааны урсгалыг Улаангом хотын гадна талд зохион байгуулах боломжтой болно.

Стратегийн Зорилт 1:

Увс аймаг, Улаангом хотын нийгэм, эдийн засгийн бодлогод нийцсэн иргэдийг эрүүл ахуйн шаардлага хангасан хүнсний өргөн хэрэглээний бүтээгдэхүүнээр хангах, хөдөө аж ахуйн болон аж үйлдвэрлэл, бараа материалын урсгалыг оновчлон цэгцэлж, хүн амын ажиллаж, амьдрах, амрах ая тухтай байдлыг бий болгоно.

Стратегийн Зорилт 2:

Увс аймаг, Улаангом хотын газарзүйн байршил, зам тээврийн сүлжээ, сумдын хэрэгцээг харгалзан хотын логистик төв болгоно.

Логистик төвийн цогцолбор байгууламжийн салшгүй хэсэг бол ачаа тээврийн үйл ажиллагаа бөгөөд ачааг хүлээн авах, барааг агуулах, агуулахад байгаа барааг тээвэрлэлтэд бэлтгэх үйл ажиллагаа юм. Цогцолборын чухал хэсэгт ачаа бараа буулгасан болон ачаа хүлээх тээврийн хэрэгсэл зогсох, тэдгээрийг дараагийн аялалд гарахад бэлтгэх техник үйлчилгээ үзүүлэх, засвар үйлчилгээ үзүүлэх авто парк төлөвлөх шаардлагатай.

Өвөл зуны аль ч улиралд засвар үйлчилгээг цаг тухайд хийж гүйцэтгэж, тээврийн хэрэгслийн бүрэн бүтэн байдлыг хангаж, алсын тээвэрт гарахад бэлэн байлгах болно. Энэ үед жолооч нарын хооллож, унтах, амралт чөлөөт цагаа өнгөрөөх орчинг бүрдүүлсэн амрах байр, зочид буудал байх болно. Аймгийн хэмжээнд ачаа тээврийн 60 зүтгүүр байгаа бөгөөд 10 зүтгүүр хоноглох дулаан гараж, автомашины ил зогсоол зэргийг хангалттай хэмжээгээр төлөвлөж өгнө.

Хамрах хүрээ



Тус Логистик төв нь зөвхөн УБ хот, Шинэ Зуунмод хотын нутаг дэвсгэрт болон Зуунмод хот, Сэргэлэн сум, Төв аймгийн нутаг дэвсгэрт байршиж буй үйлдвэрүүдэд шаардлагатай бараа, түүхий эдийг татан авахаас гадна тэдгээр үйлдвэрийн бараа бүтээгдэхүүнийг экспортод гаргахад гол дамжлага болно. Түүнчлэн худалдааны бүс рүү импортын бараа бүтээгдэхүүнээр хангах болно.

Хэтийн төлөв

Тус төлөвлөгдөж буй логистик төв нь хэтдээ 1 сая тн ачаа эргэлтийг боловсруулах хүчин чадалтай болно. Түүний хөгжлийн хувилбар нь ачаа эргэлтийн хэмжээг нь тодорхойлно.

Тавигдах шаардлага

Логистик төвийг төлөвлөхөд дараах шаардлагыг хангасан байх ёстой. Үүнд:

- » Увс аймгийн ачаа эргэлттэй уялдсан байх,
- » Баруун бүсийн ачааны эрэлтийг харгалзсан байх,
- » Улаанбаатар хотоос бараа татдаг орон нутгийн ачаа эргэлтийг харгалзсан байх,
- » Хот байгуулалтын норм дүрмийг бүх талаар хангасан байх,
- » Агуулах, зоорийн стандарт, холбогдох норм дүрмийг хангасан байх,

5.3.3 Үндсэн шийдэл

Суурь нөхцөл

Логистик бүсийн дэд бүтэц, техник технологийн хүчин чадлын талаарх сонголт хийх, хөрөнгө оруулалтын хэмжээг тооцох, хүний нөөцийг төлөвлөхөд шийдвэрлэх нөлөө үзүүлэх хүчин зүйл нь зах зээлийн бодит эрэлт юм.

Зураг 5. 8 Баруун бүсийн логистик төвийн суурь нөхцөл





Ачааг тээвэрлэх нөхцөл, шинж чанараас нь хамааруулан:

- ✗ Хөргүүртэй агуулах, зоорь шаардах түргэн муудах хүнсний бүтээгдэхүүн ачаа,
- ✗ Хадгалалтын хэвийн горим шаардагдах төрөл бүрийн ачаа,
- ✗ Тавилга эд хогшил, тоног төхөөрөмж, эд анги гэх мэт овор ихтэй ачаа,
- ✗ Дахин савлагдаж баглаа боодолтой бүтээгдэхүүн болох задгай ачаа гэж ангилсан,

Тээвэрлэлтийн нөхцөл:

- ✗ Автомашинаар задгай тээвэрлэх,
- ✗ Автомашинаар чингэлэгтэй тээвэрлэх,
- ✗ Автомашинаар хөргүүртэй тээвэрлэх,
- ✗ Автомашинаар битүү тээвэрлэх,

Бүтэц

Логистик парк нь гаалийн тусгай бүстэй байх ба энэ бүсэд гаалийн баталгаат агуулах, агуулахаас агуулахад шилжүүлэх хяналттай агуулахууд байх бөгөөд агуулах, талбай нь үндэсний болон олон улсын хяналтын шаардлага, стандартад нийцсэн мэдээлэл, бүртгэл, хяналтын тоног төхөөрөмжүүдтэй байна. Мөн мэргэжлийн хяналтын төвлөрсөн лаборатори байхаар тооцож байна.


Логистик төв нь 18.22 га талбайд үйл ажиллагаа явуулах ба дараах бүтэцтэй байна. Үүнд:

- Нэвтрэх хэсэг,
- Худалдаа үйлчилгээ, сервис бүс,
- Хүлээлгийн бүс,



- Задгай агуулахын бүс
- Агуулахын бүс,
- Нөөц агуулахын бүс,
- Дэд бүтцийн бүс,
- Гарах хэсэг,

Зураг 5.9 Баруун бүсийн логистик төвийн дотоод зохион байгуулалт, бүтэц



5.3.4 Логистикийн төв байгуулснаар бий болох үр дүн

Увс аймгийн хүн амыг мах сүү, төмс хүнсний ногоо, жимс, жимсгэнэ, хүнсний болон бусад импортын бараа бүтээгдэхүүнээр найдвартай хангах зорилгоор байгуулах логистикийн төв, түгээлтийн төвүүд, мах, хүнсний ногооны томоохон орчин үеийн нөөцийн агуулахуудыг байгуулах хэрэгтэй байна. Улаангом хотод логистик төв байгуулж шинэ тогтолцоог бий болгож дараах үр дүнд хүрнэ. Үүнд:

- Улаангом хотод үйл ажиллагаа явуулж байгаа үйлдвэрлэл, худалдаа үйлчилгээний борлуулалтын сувгуудыг нэгтгэн нэг системд оруулж, хот дотор үйлчлэх түгээлтийн үйл ажиллагааг цэгцэлснээр нийлүүлэлтийн тээврийн хэрэгслийн тоо, зорчилтын хэмжээ буурна
- Аймгийн өргөн хэрэглээний барааны хангамжийн асуудлыг төрөлжсөн логистик тээврийн компаниуд гүйцэтгэснээр бизнес эрхлэгчдэд зардал бууруулж, ачаалал буурч ажлын шинэ байр бий болгоно.
- Өргөн хэрэглээний барааны үнийг тогтвортой байлгах, барааны хомсдолоос сэргийлэх нөөц бий болсноор төрөөс үнийн зохицуулалт хийх механизм бүрдэнэ.
- Хүнс болон өргөн хэрэглээний бараанд тавих эрүүл ахуйн хяналтыг агуулахад хийснээр бүтээгдэхүүний чанарын тогтолцоо бий болно.



- Улаангом хотын логистик төвийг даган өрхийн үйлдвэрлэл нэмэгдэх, жижиг дунд үйлдвэрлэл хөгжих боломж бүрдэнэ. Тухайлбал экспорт түшиглэн монгол гэр, эсгий, ноос ноолууран бүтээгдэхүүний үйлдвэрлэл нэмэгдэнэ.
- Тээврийн салбарын эрэлт нэмэгдсэнээр тээвэр төрөлжиж шинэ технологи нэвтрүүлж, ачаа тээвэр тогтсон цагт тогтмол явах, бараа найдвартай, даатгалтай явах, барааны мэдээлэл бодит цагаар хэрэглэгчид хүрэх болно.
- Мэдээллийн технологийн үйлчилгээнд шинэ дэвшилтэт технологи нэвтрүүлж, бараа материалын урсгал цахимжих болно.
- Барилгын материалын үнэ тогтвортой байж, хүртээмж, хангамж нэмэгдэнэ.
- Бараа бүтээгдэхүүнд зураасан кодын технологи нэвтэрснээр бүтээгдэхүүний хяналт сайжирч хуурамч бүтээгдэхүүн үйлдвэрлэл байхгүй болж, иргэдэд найдвартай баталгаажсан хүнсээр хангагдах болно.
- Бараа бүтээгдэхүүнд цахим хяналт, мэдээлэл хүргэлт сайжирснаар тоо баримтын чанар сайжирч, эдийн засгийн төлөвлөлт, статистик мэдээлэл тодорхой болно.
- Баруун бүс аймгийн хэмжээнд хүн амын өргөн хэрэглээний бүтээгдэхүүн тогтвортой үнээр хүргэгдэж, амьдралын чанар дээшлэх болно.
- Аймагт орлогын шинэ эх үүсвэр бий болж, аймгийн өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, хөрөнгө оруулалтын тааламжтай орчин бий болно.
- Аймгийн хэрэгцээг хангах хүнсний өргөн хэрэглээний болон бараа бүтээгдэхүүний нийлүүлэлт жилийн турш тогтвортой байж, үнэ буурснаар худалдан авалт тогтворжиж, иргэдийн хэрэглээ нэмэгдэнэ.
- Бараа бүтээгдэхүүний хадгалалтанд шинэ үйлчилгээ гарч, иргэд эрүүл ахуйн шаардлагад нийцсэн хүнсээр хангагдах болно.
- Онцгой байдлын үед аймгийн хэрэглээний нөөц бүрдэх, эмнэлэг, сургууль, цэцэрлэг, иргэдийн хэрэгцээг хангах болно.
- Бараа гүйлгээний эргэлт, ачаа тээвэрлэлт нэмэгдсэнээр аймгийн эдийн засгийн эргэлт нэмэгдэнэ, өрхийн үйлдвэрлэл - жижиг дунд үйлдвэрлэлд шинжинэ, үйлдвэрлэлийн үйл ажиллагаа тогтвортой болж, аймгаас гарах экспортын хэмжээ нэмэгдэх болно.
- Үйлдвэрлэл тогтворжсоноор хүн амын амжиргааны төвшин дээшилж, татварын орлого тогтвортой өсөлттэй байх болно.
- Хүн амыг эрүүл аюулгүй хүнсээр хангах төрийн бодлогыг төр хувийн хэвшил, худалдаа, үйлдвэрлэл, хөдөө аж ахуй, хоршоо, холбоод хамтран хийж үр дүнд хүрэх болно.
- Үйлдвэрлэл, ачаа тээвэр, түгээлт, худалдаа, борлуулалт, хэрэглээг нэгдсэн зохион байгуулалтад орж, цаашдын хөгжлийн статистик мэдээллийн том суурь болно.




Үүнээс гадна шууд бус үр дан эдийн засагт болон эрүүл мэндийн салбарт гарч ирнэ. Увс аймгийн хэмжээнд болон бусад аймаг, суманд өрхийн үйлдвэрлэл эрчимжиж бараа бүтээгдэхүүний борлуулалт тогтмол нэмэгдэх бөгөөд үүнийг дагаад улирлын чанартай ажилладаг үйлдвэрүүд жилийн турш тогтвортой ажиллах боломжтой болно.

Зарим улирлын чанартай байсан ажлын байрууд тогтмол ажиллах болон үүнийг даган жолооч нар тогтвортой ажиллах боломж бүрдэнэ. Хүн амыг тогтмол чанартай хүнсээр хангаж, жимс, жимсгэнэ, хүнсний ногооны хэрэглээ тогтмол болсноор хүн амын эрүүл амьдрах, өвчлөл буурна. Барилгын материалын хангамж нэмэгдсэнээр орон сууцны үнэ тогтвортой байж, хангамж сайжирна, иргэдийн хувийн орон сууцтай болох хандлага нэмэгдэнэ.

5.3.5 Ажиллах хүч, үйлчлүүлэгчийн тооцоо

Баруун бүсийн логистик төв нь нийтдээ 400 байнгын ажлын байрыг үүсгэх ба хоногт үйлчлүүлэх иргэдийн тоо 2000 байхаар тооцогдсон.

Зураг: Хүчин чадлын үзүүлэлт



5.4 БИЗНЕСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

5.4.1 Үндсэн үйл ажиллагаа

Логистикийн төвийн үйл ажиллагаа

Шинээр байгуулагдах логистикийн төвд дараах үндсэн үйл ажиллагаатай байх болно. Энэ нь олон улсад байдаг нийтлэг үйл ажиллагаа бөгөөд үндсэн 3 үйл ажиллагааны чиглэлд хувааж болно.

Зураг 5.10 Үйл ажиллагааны схем



- 1. Логистик төвийн чиг үүрэг:** Үйлдвэрлэгч, ханган нийлүүлэгчдээс тээвэрлэн ирсэн бараа, бүтээгдэхүүн хадгалах, бараа материалын менежмент, захиалгын удирдлага, ханган нийлүүлэгчээс ирсэн барааг зохион байгуулах, хэрэглэгчдэд шилжүүлэх, сав баглаа боодол, олон үйлчлүүлэгчийн захиалга авах.
- 2. Туслах чиг үүрэг:** Тээвэр зуучлал, гаалийн үйлчилгээ, даатгал, дахин тээвэрлэх боломжтой ачаа, барааг (экспортын савлагаа) сав баглаа боодол, тээвэрлэхэд бэлтгэх, чингэлэг, тавиур болон бусад тээврийн сав баглаа боодол түрээслэх, мэдээлэл, мэдээллийн технологийн үйлчилгээ, сурталчилгаа, маркетинг.
- 3. Нэмэлт чиг үүрэг:** тээврийн хэрэгслийн техникийн засвар үйлчилгээ, түлш, тос, дагалдах хэрэгслийн худалдаа, чингэлэг болон бусад сав баглаа боодлын засвар үйлчилгээ, зочид буудлын үйлчилгээ, нийтийн хоолны үйлчилгээ, банкны үйлчилгээ, нягтлан бодох бүртгэлийн үйлчилгээ, харилцаа холбооны үйлчилгээ, автомашины зогсоол.

Бүтээгдэхүүний тусгай хадгалалт

Хүнсний агуулахыг гурван төрөлд хувааж болно.

➤ Хуурай хүнс барааны агуулах

Хуурай агуулахад бүх төрлийн хуурай хүнс, гурил будаа, чихэр, нөөшилсөн хүнс болон шингэн хүнс, урт хугацаанд хадгалж болох хүнсний бүтээгдэхүүн хадгалах боломжтой. Мөн гэр ахуйн бараа болон аж үйлдвэрийн бараа, нэхмэл оёмол бэлэн хувцас, хивс, гутал, гэр ахуйн тавилга гэх зэрэг бүх төрлийн бараа бүтээгдэхүүн хадгалж болно.

Хуурай хадгалах байгууламж нь Монгол улсын MNS 5364 : 201, MNS ISO 22002-2:2020 зэрэг стандарт шаардлага, эрүүл ахуйн ерөнхий дүрэм журам хангасан, агааржуулалт сайтай, ердийн хуурай байх ёстой. Хоол хүнсний бүтээгдэхүүн нь нарны шууд тусгалд өртөхгүй байх ёстой бөгөөд температурыг +5 ° C-аас + 20 ° C хүртэл байна. Мөн агаарын чийгшил 70% байх хэрэгтэй. Бараа бүтээгдэхүүнүүд нь агуулахын хана, шал, таазнаас 15 см-ээс багагүй байх ёстой.



➤ **Хүйтэн агуулах**

Тухайн бүтээгдэхүүнийг хадгалахад үйлдвэрээс заасан температурт таарсан бүхий л төрлийн хүнсний бүтээгдэхүүн хадгална. Махан төрлийн хиам, зайдас, нухаш, царцаамаг, сүүн төрлийн тараг, сүү, цөцгий бяслаг гэх мэтийн бүтээгдэхүүн хадгалах боломжтой.

Хүйтэн агуулах нь -2°C -аас $+5^{\circ}\text{C}$ -ийн хооронд тогтмол температуртай байх ёстой. Хүйтэн агуулахын агаарын чийгшил 80-90% байна. Температурыг тогтмол хянаж, баримтжуулж байх ёстой. Шинээр ирсэн барааг хүйтэн дэлгүүрт хадгалахын өмнө температурт нөлөөлөхгүйн тулд хөргөх шаардлагатай бөгөөд хөргөсний дараа агуулахад хадгална. Мөн агуулахын хаалга богино хугацаанд нээгдэх хаагдах ёстой. Хүнсний бүтээгдэхүүн нь хөргөлтийн температураас хамаарч 1-3 хоног хадгалагддаг.

➤ **Хөлдөөгч агуулах**

Хөлдөөгч агуулахад гүний аргаар хөлдөөсөн махан төрлийн болон жимс, жимсгэнэ хүнсний ногоог хадгална. Хөлдөөх агуулахын өрөөний температур хамгийн багадаа -20°C байх бөгөөд энэ нь хөлдөөсөн барааны үндсэн температур -18°C -аас хэтрэхгүй байх нөхцөлийг бүрдүүлдэг. Хөлдөөсөн барааны хувьд хөлдөөх явц ямар ч үед тасалдаж болохгүй, тиймээс олон хяналтын цэгүүд байх шаардлагатай байдаг. Энд агааржуулалт, хуурайшилт, цэвэр байдал, температурын байнгын хяналт зэрэг нь гол үүрэг гүйцэтгэдэг. Гүн хөлдөөлтийн давуу тал нь бүтээгдэхүүнийг удаан хугацаагаар хадгалах боломжтой байдаг, учир нь энэ процесс нь хадгалах хугацааг ихээхэн нэмэгдүүлдэг.

Хүнсний логистикийн сул талуудын нэг нь тухайн бүтээгдэхүүнийг тээвэрлэлтэнд бэлтгэн цуглуулах үйл явц бөгөөд энэ нь илүү их цаг хугацаа, ажилтан шаарддаг тул өртөг нэмэгдэж байдаг. (цаг хугацаа / ажилтан / тоног төхөөрөмж).

Агуулахын температурыг тогтвортой хадгалах

Хоол хүнс хадгалах таван үндсэн зарчим байдаг.

1. Агуулахын температурыг тогтмол хянаж байх ёстой.

Агуулах бүрэн автомат системээр хянагдаж, температур зөвшөөрөгдөх хэмжээнээс буурсан тохиолдолд хяналтын төвд мэдэгдэж байх шаардлагатай.

2. Бүх төрлийн бараа бүтээгдэхүүн нь хана, газартай шууд харьцах ёсгүй.

Бараа бүтээгдэхүүнүүд нь агуулахын хана, шал, таазнаас 15 см-ээс багагүй байх ёстой.

3. Нянгаас хамгаалах зорилгоор зөвхөн өөрийн савыг ашиглаж болно.

Тухайн бүтээгдэхүүнийг хадгалахад заагдсан сав баглаа боодолд байх шаардлагатай.

4. Савлаагүй эсвэл түүхий хүнсний бүтээгдэхүүн, ялангуяа өөр өөр хоол хүнсийг тусад нь хадгалах ёстой.
5. Орж, гарч байгаа барааны чанарын хатуу хяналт



Хуваарилалтын стратеги /FIFO – First In – First Out/ - Эхлээд орж - эхлээд гаргана гэдэг нь түргэн мууддаг бараа нь хурдан эргэлт шаарддаг тул хүнсний логистикт ихэвчлэн ашиглагддаг.

Хүнсний логистикт янз бүрийн хөргөлтийн бүстэй хөргөгч тусгай тээврийн хэрэгсэл, чиргүүл, цистернтэй машин эсвэл тусгаарлагдсан температураа хадгалдаг хайрцагт бүтээгдэхүүнийг тээвэрлэн ашигладаг. Бүх машинууд температурын тогтмол хяналт, болон баримтжуулалтаар баталгаажих болно.

5.4.2 Хадгалалтын дэглэм ба онцгой горим

Хүнсний тохиромжтой хадгалалт

Хүнсний бүтээгдэхүүнээс хамааран үйлдвэрээс заасан температурын хяналттай хадгалалт, савлагаа шаардлагатай. Хөргөсөн болон гүн хөлдөөсөн барааны хувьд агуулах болон тээвэрлэх замд тохирох тусгаарлагч материал, хүйтэн савлагаатай байх шаардлагатай. Хэрэв хүйтэн хэлхээ тасарсан тохиолдолд буцаасан бүтээгдэхүүнийг дахин хадгалах боломжгүй. Бараа бүтээгдэхүүний буцаалтыг аль болох бууруулах, байхгүй болгох хэрэгтэй. Хүргэлт хурдан байх болон зориулалтын сав баглаа боодол, тогтмол температур хөргүүрт, тээвэрлэлтийн аюулгүй байдал сайн байх нь ихээхэн үр дүнтэй.

Хүнс тээвэрлэх - юуг анхаарах ёстой вэ?

Худалдааны түншүүд, гэрээт борлуулагч болон жижиглэн худалдааны салбараар дамжуулан бараа бүтээгдэхүүнийг бөөний худалдаачид болон хүнсний жижиглэнгийн худалдааны төв агуулах болон жижиг барааг ч эцсийн хэрэглэгч рүү шууд хүргэх хүртэл тээвэрлэлт зохион байгуулна: Борлуулалтын бүх сувгууд өөрсдийн логистикийн шаардлагыг хангасан байна.


Хамгийн тохиромжтой логистик үйлчилгээг хайж олоход интернэт өгөгдөлд суурилсан платформ шийдэл хамгийн чухал ач холбогдолтой.

Логистикийн шийдэл нь тээвэрлэлтээс эхлээд төрөл бүрийн борлуулалтын сувгууд, тусгай зориулалтын агуулах хүртэлх бүх үйл ажиллагааны үйл явцыг уян хатан байдлаар, бодит цаг хугацаанд төлөвлөх зураглах чадвартай байх ёстой.

5.4.3 Менежмент шийдэл

Логистик төв нь менежментийн хувьд төр хувийн хэвшлийн түншлэлийн үйл ажиллагаатай байна. Төрийн буюу орон нутгийн зүгээс бүтээн байгуулалтын ажлыг бүхэлд нь хийж гүйцэтгэн хувийн хэвшил нь түрээс төлөх зарчмаар ажиллана. Төслийн менежментийг логистикийн үйл ажиллагаа явуулагч болон бусад төрийн бус байгууллагуудтай хамтран хэрэгжүүлж болно.

Зураг 5. 11 Менежмент шийдэл




Логистикийн төвийн менежмент, үйл ажиллагаанд оролцох ТББ-ууд:

- Монголын авто тээвэрчдийн нэгдсэн холбооны Увс аймаг дахь салбар
- Ачаа тээвэр эрхлэгчдийн холбоо
- Худалдаа аж үйлдвэрийн танхим
- Шинэ Улаангом ОНӨААТҮГ
- Бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийн холбоо
- Худалдаа, эд хэрэглэгчдийн хоршоодын холбоо
- Жижиг дунд, үйлдвэрлэл эрхлэгчдийн холбоо
- “Хөдөө аж ахуй эрхлэгчдийн хоршоологчдын холбоо
- Жимс жимсгэний холбоо
- Арьс шир, гутал, эсгий, эсгий эдлэл, хөнгөн оёдлын холбоо, хоршоод
- Бусад

Төслийн үл хөдлөхийн менежментийг хэрэгжүүлж болох бүтцийн шийдлийг доор үзүүлж байна.

Зураг 5. 12 Үл хөдлөхийн менежмент бүтэц



Төсөл санаачлагч, хэрэгжүүлэгчид нь Урт хугацаанд Баруун бүсийн логистикийн үйл ажиллагааг сайжруулах, үнэ өртгийг бууруулах бодлого баримтлахын хүрээнд тус цогцолборыг удирдахдаа түрээсийн төлбөрийг уян хатан тогтоож орон нутгийн бизнес эрхлэгчидээ дэмжих бодлого баримтална.

Зураг 5.13 Орлоцогч талууд, менежмент, бодлого



5.4.4 Ажиллах хүчний тоо, цалингийн сан

Логистик төвийн төв оффис нь зөвхөн үл хөдлөхийн менежментийн үйл ажиллагаа явуулах бөгөөд 15 ажиллах хүчинтэйгээр сард 22.4 сая төгрөгний буюу жилд 268.8 сая төгрөгний цалингийн сантайгаар үйл ажиллагаагаа явуулна.


Хүснэгт-5.9: Ажиллах хүчин цалингийн сан

Д/д	Албан тушаал	Орон тоо	Нэгж цалин	Сарын цалингийн сан	Жилийн цалингийн сан
-----	--------------	----------	------------	---------------------	----------------------



Захиргаа удирдлагын хэлтэс -4					
1	Гүйцэтгэх захирал	1	2,500,000	2,500,000	30,000,000
2	Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны инженер	1	1,500,000	1,500,000	18,000,000
3	Гадаад харилцаа хамтын ажиллагааны мэргэжилтэн	1	1,500,000	1,500,000	18,000,000
4	Архив, бичиг хэргийн ажилтан	1	1,200,000	1,200,000	14,400,000
Санхүүгийн алба - 3					
5	Ерөнхий нягтлан бодогч	1	2,000,000	2,000,000	24,000,000
6	Тооцооны нягтлан бодогч	1	1,500,000	1,500,000	18,000,000
7	Нярав, хангамжийн ажилтан	1	1,200,000	1,200,000	14,400,000
Аж ахуйн хэлтэс -8					
8	Аж ахуйн албаны ахлах	1	2,000,000	2,000,000	24,000,000
9	Сантехникч	1	1,500,000	1,500,000	18,000,000
10	Цахилгаанчин	1	1,500,000	1,500,000	18,000,000
11	Үйлчлэгч	2	1,200,000	2,400,000	28,800,000
12	Харуул хамгаалалтын ажилтан	3	1,200,000	3,600,000	43,200,000
Нийт		15		22,400,000	268,800,000

Зураг 5. 14 Удирдлага зохион байгуулалтын бүтэц



БҮЛЭГ 6. АРХИТЕКТУР ТӨЛӨВЛӨЛТ

Бүлгийн дэд агуулга:

- ⌘ Архитектур-орон зайн төлөвлөлтийн концепц
- ⌘ Өндөржилт ба улаан шугам төлөвлөлт



- ⌘ Зам тээврийн сүлжээ төлөвлөлт
- ⌘ Барилга, байгууламжийн төлөвлөлт


6.1 АРХИТЕКТУР-ОРОН ЗАЙН ТӨЛӨВЛӨЛТИЙН КОНЦЕПЦ

6.1.1 Ерөнхий төлөвлөгөө

Орчны тойм

Төлөвлөж буй "Баруун бүсийн логистик төв" нь Увс аймаг, Тариалан сум, 3-р баг, Хойд Адарганд байрлана. Увс аймгийн төвөөс зүүн урагш хатуу хучилттай автозамаар 7.5км зайд, замаас баруун урагш 300м зайд байрлана. Байршлын хувьд Увс аймгийн Тариалан сум, 3-р баг, Адарганы нутаг дэвсгэрт байрлана. Тухайн төслийг Увс аймгийн ГХБХБГ-азрын албатай зөвшилцсөний дагуу замын орц гарц, зам талбай, тохижилтыг төлөвлөв.

Зураг 6.1 Орчны тойм



Төсөл хэрэгжих газрын ойр орчимд хүний үйл ажиллагаа болон байгалийн нөхцөлөөр үүссэн гуу, жалга, нүх байхгүй, бага зэрэг довонтой, тэгшивтэр гадаргатай байна. Тухайн газрын хөрс, ургамлан нөмрөгийн өнөөгийн байдал нь элэгдэл эвдрэлд ороогүй байгалийн унаган төрхөөрөө байна.

Ерөнхий төлөвлөгөө




Баруун бүсийн тээвэр логистикийн төв нь Увс, Улаангом, Тариалан сум дамжин: Увс аймаг болон баруун 5 аймаг, Улаанбаатар хот, ОХУ-аас дамжин өнгөрүүлэх бүх төрлийн импорт, экспортын тээвэрлэлтийн үйл ажиллагааг дэмжих зорилготой.

Баруун бүсийн тээвэр логистикийн төв нь 345.5 х 523.0 метр харьцаатай 18.22 га бүхий эдэлбэр газартай ба газар нутгийн багтаамж, хот байгуулалт, барилгын холбогдох норм дүрэмд үндэслэн 8 бүсчлэлд хувааж хөгжүүлэхээр төлөвлөсөн.

Шинээр төлөвлөж буй тус Баруун бүсийн тээвэр логистикийн төв нь нутаг дэвсгэрийн газрын гадаргуугийн налуу, хөрсний инженер геологийн нөхцөл, бусад хот төлөвлөлтөд нөлөөлөх байгаль экологийн нөхцөлтэй уялдуулан барилгажих боломжтой нутаг дэвсгэр 7.11 га буюу 39%, ногоон байгууламж 11.11 га буюу 61% байхаар тус тус төлөвлөгдсөн.

Зураг 6. 2 Ерөнхий төлөвлөгөө



Хүснэгт 6. 1 Ерөнхий төлөвлөгөөний хэмжээс

	Нэр төрөл	Хэмжих нэгж	Тоо хэмжээ
1	Нийт талбай	м2	182202
2	Барилгажих талбай	м2	4768
3	Гадна бараа буулгах талбай	м2	7500
4	Авто зам зогсоол /хашаан дотор/	м2	111093
5	Авто зам /хашааны гадна/	м2	11351
6	Явган зам талбай	м2	1536
7	Тохижилт ногоон байгууламж	м2	34463

Зураг 6. 3 Баруун логистик төвийн үзэгдэх байдал



6.1.2 Үүрэг зориулалтын бүсчлэл

Улаанбаатараас Улаангом орох зам дагуу замын баруун урд талд төв замаас 300м зайд доорх 8 бүсчлэлд хуваана. Үүнд:

1. Нэвтрэх хэсэг - 1.18 га,



2. Худалдаа үйлчилгээ сервисийн бүс - 1.68 га,
3. Хүлээлгийн бүс - 3.13 га,
4. Задгай агуулахын бүс - 2.88 га,
5. Агуулахын бүс - 1.71 га,
6. Нөөц агуулахын хэсэг - 6.82 га,
7. Дэд бүтцийн бүс - 0.55 га,
8. Гарах хэсэг - 0.20 га,

Зураг 6.4 Үүрэг зориулалтын бүсчлэл



6.1.3 Барилгажилт

Төлөвлөлтийн талбайд оффис, лабораторийн барилга, амрах болон үйлчилгээний байр, авто засварын төв, аж ахуйн агуулахын барилга, нийтийн бие засах газар, 19 ширхэг агуулахын барилга болон дагалдах инженер хангамжийн барилга байшингууд байрлана.

Төлөвлөлтийн 182202 м² нийт талбайгаас 27610 м² талбайг барилгажуулах бөгөөд үүнээс гадна бараа буулгах талбай 7500 м², авто зам, зогсоол хашаан дотор 111093 м², хашааны гадна 11351 м², явган зам талбай 1536 м² хийх бөгөөд 34463 м² талбайд тохижилт ногоон байгууламж хийхээр төлөвлөв.

Зураг 6.5 Барилгажилт





Хүснэгт 6. 2 Барилгажилтын хэмжээс

№	Барилга байгууламжын нэр	Тоо ширхэг, ш	Барилгын давхар, ш	Давхрын өндөр шалнаас шал, м	Хэмжээ, м /тэнхлэгээр/	Хэмжээ, м /гадна ханаар/	Барилгажих талбай, м2 /тэнхлэгээр/	Нийт барилга талбай, м2	Барилгын нийт ашигтай талбай, м2	Барилгын эзлэхүүн, м3	Хүчин чадал	Тайлбар	Ажилтан	
ЭХНИЙ ЭЭЛЖИЙН БАРИЛГА БАЙГУУЛАМЖ	1	Оффис, лабораторийн барилга	1	2 + 1 (зоорь)	3.30, 4.05	24x21	24.86x21.86	504	1512	1416.25	4283.35	-		55
	2	Хүнсний ногооны агуулах	1	1	8.1	42x24	43.01x25.16	1008	1008	1024.74	8299.54	1780 (тонн)	Жимс, жимсгэнэ, нарийн ногоо, бусад хүнсний ногоо	50
	3	Өргөн хэрэглээний дулаан агуулах	1	1	8.1	42x24	43.01x25.16	1008	1008	1019.16	8532.81	1780 (тонн)	Хүнсний өргөн хэрэглээний хуурай бүтээгдэхүүн, ахуйн хэрэглээний бүтээгдэхүүн	50
	4	Хөлдөөгч, хөргүүртэй агуулах	1	1	8.1	42x24	42.91x25.06	1008	1008	965.36	7713	695.59 (тонн)	Мах, махан бүтээгдэхүүний агуулах, хөргүүртэй ногооны агуулах, хөлдөөсөн хүнсний бүтээгдэхүүний агуулах, түргэн хөлдөөх өрөө	50
	5	Хөдөө аж ахуйн агуулах	1	1	8.1	42x24	42.91x25.06	1008	1008	1027.48	8309.49	1940 (тонн)	Арьс, шир, ноос ноолуур	50
	6	Уурын зуухны барилга	1	1	4.5	18x9	18.94x9.94	162	162	158.46	713.07	-	-	5
	7	Дэд өртөөний барилга	1	1	3.6	10x7	10.36x7.36	70	70	59.06	194.4	-	-	2



ДАРААГИЙН ЭЭЛЖ	8	Ажилчдын байр, худалдаа үйлчилгээний барилга	1	2	3	60x24	-	1296	1296	1603.67	5184		52
	9	Авто засварын төв	1	2	5.9	42x21	-	882	882	1059.22	5292		10
	10	Аж ахуйн барилга	1	1	3.6	36x12	-	432	432	398.76	1555		10
	11	Ачаа буулгах тавцан	5	1	-	61.2	-	61.2	61.2	82.95	-		20
	12	Авто пүү	7	1	-	21x3.5	-	73.5	73.5	-	-		1
	13	Нийтийн бие засах газар	2	1	2.8	7.1x7.1	-	50.41	50.41	31.9	19.88		1
	14	Агуулах	15	1	8.1	42x24	42.91x25.06	1008	1008	1024.74	8299.54	1780 (тонн)	40
	15	Харуулын байр	1	1	2.5	2x2	-	4	4	4	10	-	3
		НИЙТ					8,575	9,583	9,876	58,406	7875.59 (тонн)	400	



6.2 ӨНДӨРЖИЛТ БА УЛААН ШУГАМ ТӨЛӨВЛӨЛТ

Өндөржилт

Баруун бүсийн логистик төвийн ерөнхий төлөвлөгөөний талбайн барилгажилт болон зам талбайн тэнхлэгүүдийн огтлолцол дээр тэг тэнхлэг буюу координатын цэгүүд тэдгээрийн хоорондын зайн ажлын зурган дээр тодорхойлов.


Барилга байгууламжийн тэг тэнхлэгийг зураг төсөлд заасны дагуу геодезийн тэмдэглэгээ /улаан шугам/-тэй уялдуулан тухайн барилгын ажлын талбайд барилгын геодези, зураг зүйн ажил эрхлэх эрх бүхий хуулийн этгээд тогтооно.

Захын цэгийн байршлыг олохдоо геодезийн байнгын тэмдэгт буюу харьцуулан авах цэгээс хэмжилт авч улмаар дараагийн цэгүүдийн байршлыг нарийвчлалтай тогтоон гадаслана.

- Тодорхойлсон цэгүүдийг диагональдаж тэнхлэг хоорондын зай хэмжээг шалгах,
- Х,У тэнхлэгүүдийн огтлолцлын цэгт теодолитыг байрлуулж, Х тэнхлэгт 0,00-т тохируулан, У тэнхлэгийн дагуу 90 градус эргүүлэхэд геодезийн компанийн тодорхойлсон цэгтэй таарч байна,

Одоо байгаа газрыг замын налууд тааруулан талбайн тэгшилгээ хийгдэх бөгөөд нийт газрын тэгшилгээ хийгдэхэд 52513,94м³ шороог өндөрлөг газраас ухаж 47997,13м³ шороог нам дор газарт нэмж өнгө.

Зураг 6. 6 Өндөржилт




Улаан шугам



Авто замын болон цэвэрлэх байгууламжийн барилгажилтын Улаан шугамыг газар дээр нь буюу төлөвлөлтийн үед тодорхойлохдоо геодезийн сүлжээний байнгын цэг тэмдэгтүүдээс холболт хийж өгөгдсөн координат, холын зайгаар хийж гүйцэтгэсэн.

Зураг 6.7 Улаан шугам




6.3 ЗАМ ТЭЭВРИЙН СҮЛЖЭЭ ТӨЛӨВЛӨЛТ

Баруун бүсийн Логистик төвийн доторх замын сүлжээний төлөвлөлтийг “Хот тосгоны төлөвлөлт, барилгажилтын норм ба дүрэм БНБД 30.01.04”-н дагуу захиалагчийн саналтай уялдуулан төлөвлөв.

Гадна замын сүлжээг төлөвлөлтийн нутаг дэвсгэр болон Сумын төвийг чиглэсэн авто замтай харилцаа холбоотой хөгжүүлэх үндсэн дээр Улаангом сумыг 2030 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний архитектур орон зай төлөвлөлт, Сумын төвийн ирээдүйн хөгжилтэй уялдуулан тооцсон.

Зураг 6.8 Замын сүлжээ төлөвлөлт ба хөдөлгөөний схем



Логистик төвийн автомашины замын орц гарц нь тусдаа байрлана. Орц гарц тал тус бүр нь том тээврийн хэрэгслийн 2 эгнээ, бага оврын тээврийн хэрэгслийн 1 эгнээ нийт 3 эгнээ замтай. Талбайд оффис аж ахуйн хэсгийн зогсоол тусдаа, том тээврийн хэрэгслийн зогсоолыг тусдаа төлөвлөж өгсөн. Талбайн том прожектор гэрлүүд болон зам дагуу гудамжны гэрэлтүүлэг зэргийг төлөвлөж өгнө.

Төслийн талбайд хийгдэх авто зам, зогсоол ба явган замын төлөвлөлт нь:

- Авто зам, зогсоол хашаан дотор 111,093 м²,
- Авто зам, зогсоол хашааны гадна 11,351 м²,
- Явган зам талбай 1,536 м² тус тус төлөвлөгдсөн.

6.4 БАРИЛГА, БАЙГУУЛАМЖИЙН ТӨЛӨВЛӨЛТ

6.4.1 Оффис лабораторийн барилга

Тус оффис лабораторийн барилга нь логистик төвийн хашаан дотор зүүн хойд талд орж ирж байгаа орцны дагуу байрлалтай. Барилга нь 4 тусдаа орцтой. Оффис хэсгийн гол орц нь зүүн хойд болон баруун урд зүгт харсан байрлалтай. Лабораторийн хэсэг баруун талаас, гал тогоо нь зүүн урд зүгээс орох орцтой.


21.00 x 24.00 харьцаанд багтсан төмөр бетон араг бүтээц, дүүргэгч хана, хавтгай дээвэр бүхий 2 давхар, зоорийн давхраас бүрдсэн барилга юм. Барилгын үндсэн өндөр 3,82 м, дүүжин тааз хүртэлх цэвэр өндөр 3,0м байна. Барилга нь олон нийтийн үйлчилгээний болон лабораторийн зориулалттай байх БА БНБД 31-03-03-11 олон нийт иргэний барилга, БНБД



31-04-03 захиргаа ба аж ахуйн барилга БНБД 21-05-10 авто зогсоол, БНБД 21-02-02 барилга, байгууламжийн зураг төсөл зохиох галын аюулгүйн норм, БНБД 2.01-85 галын аюулгүйн дүрэм; үндсэн шаардлага, БД 22-101-07 газар хөдлөлтийн бүс нутагт барилга төлөвлөх барилгын норм ба дүрмийн шаардлагын дагуу боловсруулсан. Бүх давхарт галын кран байрлана.


Зоорийн -В1 давхарт нийт 8 машины гараж, дулааны болон цахилгааны техникийн ерөөнүүд байрлана. Нэг дүгээр давхарт диспетчер, үйлчилгээний заал, банкны салбар, эмчийн өрөө, 40 хүний суудалтай цайны газар, түүний дагалдах гал тогооны өрөө тасалгаанууд, сервер хяналтын өрөө, ариун цэврийн өрөө байрлана. Харин тусдаа орцтойгоор лабораторийн хэсэг орох бөгөөд нэг давхарт дээж хүлээн авах хэсэг нь байрлана.

Зураг 6. 9 *Оффис лабораторийн барилга*



Барилгын хоёрдугаар давхарт оффис талд уулзалтын өрөө, ТББ хоршоодын төлөөлөгчдийн өрөө, санхүү маркетингийн өрөө, захирал, нарийн бичгийн өрөө, ариун цэврийн өрөөнүүд байрлана. Харин лабораторийн хэсэгт ажилчдын хувцас солих өрөө, шинжээчдийн өрөө, дүш, лабораторийн 4 өрөө, дээж хадгалах өхөө, устгал, ариутгал, жингийн өрөө гэх зэрэг хамгийн анхан шатны лабораторийн зориулалттай өрөө тасалгаануудыг төлөвлөв. Жингийн өрөө нь гадны тоосжилтоос бүрэн хамгаалагдсан тусдаа вакум шилэн ханын цаана байрлана. Мэргэжлийн хяналтын байгууллагын хэрэгцээний дагуу лабораторийн өрөөний зохион байгуулалт, тоног төхөөрөмжийн урсгал, функцийг зурж тусгав.

Зураг 6. 10 *Оффис лабораторийн барилгын дотоод зохион байгуулалт*



Хана, гадна заслал

Зоорийн давхрын 200 мм цутгамал ханыг гадна талаас 150 мм XPS хөөсөн хавтангаар дулаалж ус чийгнээс хамгаалах түрхлэг түрхэж гадна талаар нь ус чийг болон хөрсний гэмтлээс хамгаалах PLANTER суурийн ус тусгаарлагч хийх, эсвэл нүхгүй цул тоосго өрөн давхар шавардан хар тос түрхэж хар цаасаар нааж өгнө. Хөрснөөс дээш гарах цоколын хэсэгт цайвар шаргал өнгийн хавтанцар нааж өгнө. Үндсэн давхрын давхрын ханыг 300 мм хөнгөн блокон хана дээр 150 мм чулуун хөвөн хавтангаар дулаалга хийж, ус чийг тусгаарлагчаар хамгаалан гадна талаар нь металл хавтан өнгөлгөөг технологийн дагуу хийнэ. Барилгын ханын дулаалгад хэрэглэх материал нь MNS1247;1998 стандартад нийцсэн байна.

Фасадны өнгө цагаан өнгийн метал хавтангаар, гол үүдний чимэглэл хэсгийг бор шаргал өнгийн керамик хавтангаар ялгаж өнгөлгөөг хийнэ. Дотор даацын бус хануудыг ерөхдөө газар хөдлөлийн бүс нутагт барилга төлөвлөх барилгын норм ба дүрэм - БНБД 22-01-01 болон түүний тайлбар БД22-101-07 гын дагуу даацын үндсэн каркас, цутгамал ханаас 2см-



с багагүй зайтай тусгаарлан хийх ба тус зайг уян чигжээсээр дүүргэнэ. Ариун цэврийн өрөөнд ХАС, ЦБУ - гын угсралт хийгдсэний дараа дотор давхар ханыг угсарна.

Зоорийн давхрын дотор хана тоосгон өрлөг 1-2 давхрын дотор ханууд нь ус чийгтэй газар 120 мм тоосгон хана, бусад газар гипс картонон хана хийнэ. Лабораторийн өрөөнүүдийн ханыг 2,4 м өндөртэй хүчил, шүлтэд тэсвэртэй керамик хавтангаар өнгөлнө. Өнгө нь цагаан өнгөтэй байна.

Хүснэгт 6.3 Оффис лабораторийн барилгын өрөөний зохион байгуулалт

ӨРӨӨНИЙ ТОДОРХОЙЛОЛТ						ӨРӨӨНИЙ ТОДОРХОЙЛОЛТ									
№	Өрөө нэвтрэх нэр	Шалны төрөл	Талбай /м ² /	Ханан периметр /м/	Ханан өндөр /м/	Ханан гадна талбай /м ² /	Ханан периметр /м/	Ханан өндөр /м/	Ханан гадна талбай /м ² /	Ханан периметр					
ЗООРИЙН ДАВХАР						2-Р ДАВХАР - ОФФИС									
1	Авны засвар	Этажис дэвсгэр	35188	109.24	3.07	335.37	Энгийн	1	Каридор	Плима	37.39	516.2	3.00	187.86	Энгийн
2	Агуулгах	Этажис дэвсгэр	6952	36.88	3.07	113.22	Энгийн	2	Цугааралтын өрөө - нам	Оффис - Фражи	16.70	16.70	3.00	50.28	Энгийн
3	Шав	Этажис дэвсгэр	15.25	16.96	3.07	52.07	Энгийн	3	Хурал, сургалтын өрөө	Оффис - Фражи	45.4.3	28.07	3.00	84.21	Энгийн
4	Цахилгааны техникний өрөө	Этажис дэвсгэр	5.64	9.54	3.07	29.79	Энгийн	4	Төв, харгалзан төлөвлөгөөний өрөө	Оффис - Фражи	36.44	24.25	3.00	72.78	Энгийн
5	Холбооны техникний өрөө	Этажис дэвсгэр	5.50	9.50	3.07	29.77	Энгийн	5	Бичиг, харгалзан төлөвлөгөөний өрөө	Оффис - Фражи	35.60	26.10	3.00	78.30	Энгийн
6	Дулааны техникний өрөө	Этажис дэвсгэр	36.00	24.12	3.07	74.05	Энгийн	6	АЦВ /УР/	Плима	2.68	6.68	3.00	20.04	Плима 1.2м
ДАВХРЫН АШИГТАЙ ТАЛБАЙ						ДАВХРЫН АШИГТАЙ ТАЛБАЙ									
ДАВХРЫН НИЙТИЙН ЗЭЭЖИЛЭЙН ТАЛБАЙ						ДАВХРЫН НИЙТИЙН ЗЭЭЖИЛЭЙН ТАЛБАЙ									
ДАВХРЫН АЖЛЭЙН ТАЛБАЙ						ДАВХРЫН АЖЛЭЙН ТАЛБАЙ									
ДАВХРЫН ТАЛБАЙ /лэнгилээр/						ДАВХРЫН ТАЛБАЙ /лэнгилээр/									
ДАВХРЫН ТАЛБАЙ /гайна жонсор/						ДАВХРЫН ТАЛБАЙ /гайна жонсор/									
ДАВХРЫН ЗЭЛЭХҮҮН						ДАВХРЫН ЗЭЛЭХҮҮН									
1-Р ДАВХАР - ОФФИС						2-Р ДАВХАР - ЛАБОРАТОРИ									
1	Ганц 1	Чулуу	6.56	10.64	3.00	21.92	Энгийн	13	Каридор 1	Плима	15.60	20.22	3.00	60.66	Энгийн
2	Ганц 2	Чулуу	6.53	10.64	3.00	21.92	Энгийн	14	Ажилчдын оффис	Хатуу хувцас	36.08	24.12	3.00	72.36	Энгийн
3	Каридор, шалны хангал	Чулуу	84.80	65.50	3.00	196.50	Энгийн	15	АЦВ	Плима	6.99	11.64	3.00	34.98	Плима 1.2м
4	Диспенсер, үйлчилгээний танхим	Чулуу	71.91	37.32	3.00	111.96	Энгийн	16	Дуг	Плима	3.59	7.96	3.00	23.88	Плима 2.4м
5	Үйлчилгээний зохио	Чулуу	67.12	36.58	3.00	109.74	Энгийн	17	Ажилчдын хувцас солих өрөө	Хатуу хувцас	10.10	14.44	3.00	43.38	Энгийн
6	Гал тусга	Плима	46.56	39.26	3.00	117.78	Энгийн	18	Усгалын өрөө	Плима	3.48	7.48	3.00	22.44	Плима 2.4м
7	Агуулгах 1	Плима	2.36	6.20	3.00	19.60	Энгийн	19	Дээж хадгалалт өрөө	Плима	10.09	12.96	3.00	39.70	Плима 2.4м
8	Агуулгах 2	Плима	4.38	8.90	3.00	26.70	Энгийн	20	Ариундал, хөндий цоонолын өрөө	Плима	7.76	11.76	3.00	34.80	Плима 2.4м
9	Хөс хөндийн өрөө	Плима	1.50	5.00	3.00	5.00	Энгийн	21	Агуулгах-цавдал багас	Плима	7.76	11.76	3.00	35.28	Плима 2.4м
10	Хувцас солих өрөө	Плима	2.98	6.98	3.00	20.94	Энгийн	22	Хөндийн өрөө	Плима	3.99	8.00	3.00	24.00	Энгийн
11	АЦВ /гал тусга/	Плима	3.20	7.16	3.00	21.68	Плима 2.4м	23	Каридор 2	Плима	19.69	26.76	3.00	80.28	Энгийн
12	АЦВ /г/	Плима	10.30	16.34	3.00	49.02	Плима 1.2м	24	Лаборатори-1	Плима	29.41	22.70	3.00	68.10	Плима 2.4м
13	АЦВ /г/	Плима	8.71	12.38	3.00	37.14	Плима 1.2м	25	Лаборатори-2	Плима	33.01	23.56	3.00	76.68	Плима 2.4м
14	Сейфер хөндийн өрөө	Чулуу	9.49	16.08	3.00	48.24	Энгийн	26	Лаборатори-3	Плима	16.72	18.10	3.00	54.30	Плима 2.4м
15	Энгийн өрөө	Чулуу	18.11	16.80	3.00	49.80	Энгийн	27	Лаборатори-4	Плима	16.72	18.10	3.00	54.30	Плима 2.4м
16	Бонжис салбар	Чулуу	25.16	23.50	3.00	70.50	Энгийн	ДАВХРЫН АШИГТАЙ ТАЛБАЙ							
17	Агуулгалтын ажигчдын оффис	Хойвондөр	32.33	23.46	3.00	70.38	Энгийн	ДАВХРЫН НИЙТИЙН ЗЭЭЖИЛЭЙН ТАЛБАЙ							
18	Ажилчдын хувцас солих өрөө	Хойвондөр	14.35	16.60	3.00	49.80	Энгийн	ДАВХРЫН АЖЛЭЙН ТАЛБАЙ							
1-Р ДАВХАР - ЛАБОРАТОРИ						2-Р ДАВХАР - ЛАБОРАТОРИ									
19	Ганц 4	Чулуу	3.62	7.94	3.00	23.82	Энгийн	ДАВХРЫН ТАЛБАЙ /лэнгилээр/							
20	Лаборатори - дээж хүлээн авах	Чулуу	11.06	13.40	3.00	40.20	Плима 2.4м	ДАВХРЫН ТАЛБАЙ /гайна жонсор/							
21	Лаборатори - хүлээлийн танхим	Чулуу	18.74	20.00	3.00	60.00	Энгийн	ДАВХРЫН ЗЭЛЭХҮҮН							
22	Лаборатори - шалны хангал	Чулуу	21.59	22.06	3.00	66.18	Энгийн	ЗООРИЙН ДАВХРЫН АШИГТАЙ ТАЛБАЙ							
ДАВХРЫН АШИГТАЙ ТАЛБАЙ						1-Р ДАВХРЫН АШИГТАЙ ТАЛБАЙ									
ДАВХРЫН НИЙТИЙН ЗЭЭЖИЛЭЙН ТАЛБАЙ						2-Р ДАВХРЫН АШИГТАЙ ТАЛБАЙ									
ДАВХРЫН АЖЛЭЙН ТАЛБАЙ						БАРИТЭГН НИЙТ АШИГТАЙ ТАЛБАЙ									
ДАВХРЫН ТАЛБАЙ /лэнгилээр/						БАРИТЭГН НИЙТ НИЙТИЙН ЗЭЭЖИЛЭЙН ТАЛБАЙ									
ДАВХРЫН ТАЛБАЙ /гайна жонсор/						БАРИТЭГН НИЙТ АЖЛЭЙН ТАЛБАЙ									
ДАВХРЫН ЗЭЛЭХҮҮН						ДАВХРЫН ЗЭЛЭХҮҮН									

Цонх

Цонх, шилэн хана нь хар саарал өнгийн 70 мм -с доошгүй зузаантай металл рамтай - 5-6 тасалгаатай (камертай) 3 давхар резинэн жийргэвчтэй байх бөгөөд тасалгаа завсар зориулалтын дулаан тусгаарлагч хатуу хуванцар хийж өгч гадна дуу болон дулаан тусгаарлалтыг нэмэгдүүлсэн технологитой байна. Өндөр чанартай нугас түгжээ хийх ба германы ROTO брендын бүтээгдэхүүн байвал сайн.

Том цонхны рам дотор даацыг хүчитгэсэн төмөр нэмэлт тулгууртай байна. Цонхны онгойлт түгжээг үйлдвэрийн технологийн дагуу цонхыг угааж арчих боломжтой онгойлттой байхаар хийнэ. Онгойдог хэсгүүдэд бүгдэд ялааны торон хамгаалалт хийж өгнө. Гадна шилэн хана нь дотор талд өрлөгтэй байх ба тухайн өрлөг болон баганын харалдаа байгаа шилэн ханын шилэн багц нь нэвт харагддаггүй материалтай байна. Шилэн хануудыг шилэн багц нь ганжуулсан хагарахдаа бутарч унадаг материалтай байна.

Цонхны гадна зэвэрдэггүй төмөр тавцан болон дотор цонхны вэцанг технологийн дагуу газар дээр нь хэмжээ авч захиалж хийж гүйцэтгэнэ. Цонхны дотор тавцан байгалийн чулуу байх бөгөөд өнгийг интерьерийн зургийн дагуу сонгоно.



Хаалга

Гадна шилэн хаалга нь олон нийтийн хэрэглээнд тэсвэртэй хар саарал өнгийн 70-100 мм - с доошгүй зузаантай металл рамтай, 3-4 тасалгаатай (камертай) 3 давхар резинэн жийргэвчтэй байх бөгөөд тасалгаа завсар зориулалтын дулаан тусгаарлагч хатуу хуванцар хийж өгч гадна дуу болон дулаан тусгаарлалтыг нэмэгдүүлсэн технологитой байна. Шилэн ханын багцад ганжуулсан шил хийх бөгөөд ба хагарахдаа бутарч унадаг байх шаардлагатай. Лабораторийн гадна хаалга нь үндсэн цоожноос гадна код болон картаар онгойх системтэй байна.

Техникийн ерөөний болон гал тогооны гадна хаалга нь маш сайн чанарын хамгаалалтын төмөр хаалга байх бөгөөд хаалганы түгжээ 3 тал руугаа түгжигддэг байна. Оффисын дотор модон хаалгуудыг зургийн дагуу битүү болон цонхтой самбартайгаар захиалж хийлгэнэ. Дотор хаалганы өнгийг цагаан байхаар сонгоно. Гаражинд байрлах хаалга болон гадна хаалгууд - галаас хамгаалах технологийн дагуу сайжруулсан гал эсэргүүцэх цагийг уртасгасан үзүүлэлттэй байх шаардлагатай.

Дээвэр

Гадуур ус зайлуулалт бүхий хавтгай дээвэртэй байна. Дээвэрт гадна төмөр шатаар дамжин гарна. Дээвэрт сүүлийн үеийн технологийн шинэ чанартай материалуудыг ашиглана. Дээврийн парапетийг тус зурагт үзүүлсний дагуу цутгаж хийнэ. Зурагт үзүүлсний дагуу ус урсах налуу, ус зайлуулах ховил, хаялга зэргийг өндөр чанар, технологийн дагуу хийж гүйцэтгэнэ.

Шал, тааз

Шалыг хэсэглэлийн дагуу хийж гүйцэтгэнэ. Нийтийн эзэмшлийн талбай, коридор шатны талбайд чулуун хавтан хийнэ. Ус чийгтэй өрөөнд ус тусгаарлагч түрхлэг түрхэж, нэмэлт ус тусгаарлагч материал дэвсэж өгнө. Зоорийн давхрын таазанд зурагт үзүүлсэн дуу болон дулаан тусгаарлах зорилгоор 100 мм зузаантай ерс хөөсөнцөр хавтан хийж доороос нь зориулалтын шавардлага өнгөлгөө хийнэ. Лабораторийн өрөөнүүдэд хүчил шүлт болон дулаан, даралтад тэсвэртэй, зурагддаггүй iso - шаардлага хангасан сайжруулсан керамик хавтан хийнэ. Инженер хангамжийн холболтын монтаж болон бусад шаардлагатай холболт угсрагдсаны дараа дүүжин таазыг хааж битүүлнэ. Тус дүүжин тааз нь хөнгөн цагаан төмөр каркас дээр ус чийгт тэсвэртэй акмигран хавтангаар хийнэ. Дүүжин таазны зам төмрийг угсрахдаа өрөө бүрд орох утас монтажтай уялдуулан хийх шаардлагатай. Гэрэлтүүлэг дүүжин таазны зам төмрийг дайрсан тохиолдолд тайрч 2 талд нь нэмэлт бэхэлгээ хийж өгнө.

Дотор заслал

Дотор заслыг захиалагчийн санал, хүсэлтийн дагуу стандартын дагуу чанарын өндөр түвшинд хийж гүйцэтгэнэ. Лабораторийн өрөөний хананд шалнаас 2400 мм өндөртэй керамик хавтан нааж өгнө. Ариун цэврийн өрөөний ханын плита 1200 мм, дүштэй 2400 өндөртэй наагдана. Шинжээчдийн өрөө болон үүдний өрөө, коридор ханыг угааж арчиж болдог эмульсэн будгаар 2 үе будаж өгнө.



Довжоо пандус

Гадна довжоо пандусыг сайтар нягтруулсан овойлт үүсгэдэггүй хөрсөн дээр зурагт үзүүлсний дагуу хийж гүйцэтгэнэ.

Зураг 6. 11 Оффис лабораторийн барилгын үзэгдэх байдал




6.4.2 Хүнсний ногооны агуулах

Тус хүнсний ногооны агуулахын барилга нь логистик төвийн хашаан дотор зүүн талд орж ирж байгаа орцны дагуу байрлалтай. Барилга нь урд зүгт харсан байрлалтай баруун урд зүгээс орох орцтой. 24.00 x 42.00 харьцаанд багтсан металл каркас араг бүтээц, сендвичэн хана, 2 талт налуу дээвэр бүхий 1 давхар, зоорьгүй барилга юм. Барилгын захын өндөр 7.0 м, голын цэвэр өндөр 8,1 м байна. / сендвич тааз хүртэл/ барилга нь агуулахын зориулалттай байх ба БНБД 31-19-10 агуулахын барилга, БНБД 21-02-02 барилга,



байгууламжийн зураг төсөл зохиох галын аюулгүйн норм , БНБД 2.01-85 галын аюулгүйн дүрэм; үндсэн шаардлага, БД 22-101-07 газар хөдлөлтийн бүс нутагт барилга төлөвлөх барилгын норм ба дүрмийн шаардлагын дагуу боловсруулсан. Барилгын үнэмлэхүй 0.00 түвшин = 989.50. Агуулах нь 151.80 м² сонгинолгийн агуулах, 42.40 м² нарийн ногоо, жимс, жимсгэний агуулах, 340.62 м² бусад ногооны агуулах /байцаа, лууван/, 328.76 м² төмсний агуулах гэсэн 4 хэсэг заалтай байна. Мөн тухайн агуулахыг хариуцан ажиллах ажилчдын өрөө байрлана.

Зураг 6. 12 Хүнсний ногооны агуулахын төлөвлөлт



Хана, гадна заслал

Суурийн ханыг гадна талаас 100 мм XPS хөөсөн хавтангаар дулаалж ус чийгээс хамгаалах түрхлэг түрхэж гадна талаар нь ус чийг болон хөрсний гэмтлээс хамгаалах GerPlanter суурийн ус тусгаарлагч хийж өгнө. Хөрснөөс дээш гарах цоколын хэсгийг шавардан хар саарал өнгийн гадна фасадны будгаар будах эсвэл хар саарал өнгийн зориулалтын шавардлагаар шавардаж өгнө. Үндсэн давхрын давхрын ханыг 200 мм шахалт сайтай EPS хөөсөндөр бүхий сендвич хавтангаар хийж, уулзвар, бүтцийг технологийн дагуу хийж гүйцэтгэнэ. Барилгын ханын дулаалгад хэрэглэх материал нь MNS 1247;1998 стандартад нийцсэн байна. Фасадны өнгө цайвар саарал өнгийн хавтангаар, гол үүдний хэсгийг хар саарал болон цэнхэр өнгийн хавтангаар ялгаж өнгөлгөөг хийнэ. Дотор хануудыг газар хөдлөлийн бүс нутагт барилга төлөвлөх барилгын норм ба дүрэм - БНБД 22-01-01 болон түүний тайлбар БД 22-101-07 гын дагуу даацын үндсэн каркас, цутгамал ханаас 2см-с багагүй зайтай тусгаарлан хийх ба тус зайг уян чигжээсээр дүүргэнэ.


Цонх

Цонх нь хар саарал өнгийн 70 мм -с доошгүй зузаантай металл рамтай - 3-7 тасалгаатай (камертай) 3 давхар резинэн жийргэвчтэй байх бөгөөд тасалгаа завсар зориулалтын дулаан тусгаарлагч хатуу хуванцар хийж өгч гадна дуу болон дулаан тусгаарлалтыг нэмэгдүүлсэн технологитой байна. Өндөр чанартай нугас түгжээ хийнэ. Том цонхны рам дотор даацыг хүчитгэсэн төмөр нэмэлт тулгууртай байна. Цонхны онгойлт түгжээг үйлдвэрийн технологийн дагуу цонхыг угааж арчих боломжтой онгойлттой байхаар хийнэ. Онгойдог хэсгүүдэд бүгдэд ялааны торон хамгаалалт хийж өгнө. Цонхны гадна, дотор



зэвэрдэггүй төмөр тавцан болон дотор цонхны тавцанг технологийн дагуу газар дээр нь хэмжээ авч захиалж хийж гүйцэтгэнэ.

Зураг 6. 13 Хүнсний ногооны агуулахын дотоод зохион байгуулалт



Хаалга

Агуулахын хаалга нь дээш сөхөгддөг дулаалгатай хаалга байх ба хаалга нь дээрээ шилэн цонхтой байна. Ажилчдын гадна хаалга нь маш сайн чанарын, дулаалгатай хамгаалалтын төмөр хаалга байх бөгөөд хаалганы түгжээ 3 тал руугаа түгжигддэг байна. Агуулахын хаалгууд - галаас хамгаалах технологийн дагуу сайжруулсан гал эсэргүүцэх цагийг уртасгасан үзүүлэлттэй байх шаардлагатай. Агуулахын хаалганы ирмэгээр анхааруулах тэмдэглэгээ бүхий хамгаалалтын булан төмөр хийж өгнө. Мөн мөргөхөөс хамгаалсан нэмэлт төмөр суурилуулж өгнө.

Дээвэр

Гадуур ус зайлуулалт бүхий 2 талт налуу дээвэртэй байна. Дээвэрт гадна төмөр шатаар дамжин гарна. Дээвэрт сүүлийн үеийн технологийн шинэ чанартай материалуудыг ашиглана. Зурагт үзүүлсний дагуу ус урсах налуу, ус зайлуулах ховил, хаялга зэргийг өндөр чанар, технологийн дагуу хийж гүйцэтгэнэ.

Шал, тааз, дотор засал

Шалыг хэсэглэлийн дагуу хийж гүйцэтгэнэ. Ажилчдын өрөөний халаах талбайг багасгахын тулд дүүжин тааз хийж өгнө. Сендвичэн ханын дотор тал нь хана тааз бүгд цагаан өнгөтэй байна.

Зураг 6. 14 Хүнсний ногооны агуулахын үзэгдэх байдал



Довжоо пандус

Гадна тавцан, пандусыг сайтар нягтруулсан овойлт үүсгэдэггүй хөрсөн дээр зурагт үзүүлсний дагуу хийж гүйцэтгэнэ. Гадна ачаа буулгах тавцанг ачаа ачдаг машины өндрөөс хамааруулан 900, 1200, 1400 м өндөртэй байхаар 3 янзын түвшинтэй байхаар хийж өгөв. Тавцангийн ирмэгээр анхааруулах тэмдэглэгээ бүхий хамгаалалтын булан төмөр хийж өгнө. Тавцангаас по-ачаа ачих машин буух гарах пандус хийж өгнө. Мөн тухайн агуулах нь техникийн өрөөтэй тул техникийн өрөө рүү гаднаасаа орох гадна довжоо хийж өгнө.

Хүснэгт 6. 4 Хүнсний ногооны агуулахын өрөөний зохион байгуулалт

№	Өрөө тасалгааны нэр	Шалны төрөл	Талбай /м2/
1	Хувцас солих өрөө	Эпокси будаг	11.93
2	Ажилчдын өрөө	Эпокси будаг	11.27
3	Үүдний хэсэг	Эпокси будаг	124.69
4	Сонгинологийн агуулах	Эпокси будаг	151.80
5	Нарийн ногоо, жимс, жимсгээний агуулах	Эпокси будаг	42.40
6	Бусад ногооны агуулах /байцаа, лүцван/	Эпокси будаг	340.62
7	Төмсний агуулах	Эпокси будаг	328.76
8	Техникийн өрөө	Эпокси будаг	13.27
ДАВХРЫН АШИГТАЙ ТАЛБАЙ			1024.74 м ²
ДАВХРЫН ТАЛБАЙ /тэнхлэгээр/			1008.00 м ²
ДАВХРЫН ТАЛБАЙ /гадна ханаар/			1082.13 м ²
ДАВХРЫН ЭЗЛЭХҮҮН			8,299.54 м ³


6.4.3 Өргөн хэрэглээний дулаан агуулах

Тус өргөн хэрэглээний дулаан агуулахын барилга нь логистик төвийн хашаан дотор зүүн талд орж ирж байгаа орцны дагуу байрлалтай. Барилга нь урд зүгт харсан байрлалтай баруун урд зүгээс орох орцтой. 24.00 x 42.00 харьцаанд багтсан метал каркас араг бүтээц, сендвичэн хана, 2 талт налуу дээвэр бүхий 1 давхар, зоорьгүй барилга юм. Барилгын захын өндөр 7,0 м, голын цэвэр өндөр 8,1 м байна. / сендвич тааз хүртэл/ барилга нь агуулахын зориулалттай байх ба БНБД 31-19-10 агуулахын барилга, БНБД 21-02-02 барилга, байгууламжийн зураг төсөл зохиох галын аюулгүйн норм , БНБД 2.01-85 галын аюулгүйн



дүрэм; үндсэн шаардлага, БД 22-101-07 газар хөдлөлтийн бүс нутагт барилга төлөвлөх барилгын норм ба дүрэм -н шаардлагын дагуу боловсруулсан. Барилгын үнэмлэхүй 0.00 түвшин = 990.10. Байгуулалтын зураг БА-02-р хуудаснаас өрөө тасалгааны өрлөгийн зай хэмжээ, инженер хангамжийн холболтод зориулан хучилт хананд гарах нүх М&Е -гын даалгаврын хэмжээг харна уу. Агуулах нь 167.14 м² агуулах /жижиг/, 331.90 м² агуулах /дунд/, 503.24 м² агуулах /том/ гэсэн 3 хэсэг заалтай байна. Мөн тухайн агуулахыг хариуцан ажиллах ажилчдын өрөө байрлана.


Зураг 6. 15 Өргөн хэрэглээний дулаан агуулахын төлөвлөлт



Хана, гадна заслал

Суурийн ханыг гадна талаас 100 мм XPS хөөсөн хавтангаар дулаалж ус чийгээс хамгаалах түрхлэг түрхэж гадна талаар нь ус чийг болон хөрсний гэмтлээс хамгаалах GerPlanter суурийн ус тусгаарлагч хийж өгнө. Хөрснөөс дээш гарах цоколын хэсгийг шавардан хар саарал өнгийн гадна фасадны будгаар будах эсвэл хар саарал өнгийн зориулалтын шавардлагаар шавардаж өгнө. Үндсэн давхрын давхрын ханыг 200 мм шахалт сайтай EPS хөөсөнцөр бүхий сендвич хавтангаар хийж, уулзвар, бүтцийг технологийн дагуу хийж гүйцэтгэнэ. Барилгын ханын дулаалгад хэрэглэх материал нь MNS 1247;1998 стандартад нийцсэн байна. Фасадны өнгө цайвар саарал өнгийн хавтангаар, гол үүдний хэсгийг хар саарал болон цэнхэр өнгийн хавтангаар ялгаж өнгөлгөөг хийнэ. Дотор хануудыг газар хөдлөлийн бүс нутагт барилга төлөвлөх барилгын норм ба дүрэм - БНБД 22-01-01 болон түүний тайлбар БД 22-101-07 гын дагуу даацын үндсэн каркас, цутгамал ханаас 2см-с багагүй зайтай тусгаарлан хийх ба тус зайг уян чигжээсээр дүүргэнэ.

Зураг 6. 16 Өргөн хэрэглээний дулаан агуулахын дотоод зохион байгуулалт



Цонх

Цонх нь хар саарал өнгийн 70 мм -с доошгүй зузаантай металл рамтай - 3-7 тасалгаатай (камертай) 3 давхар резинэн жийргэвчтэй байх бөгөөд тасалгаа завсар зориулалтын дулаан тусгаарлагч хатуу хуванцар хийж өгч гадна дуу болон дулаан тусгаарлалтыг нэмэгдүүлсэн технологитой байна. Өндөр чанартай нугас түгжээ хийнэ. Том цонхны рам дотор даацыг хүчитгэсэн төмөр нэмэлт тулгууртай байна. Цонхны онгойлт түгжээг үйлдвэрийн технологийн дагуу цонхыг угааж арчих боломжтой онгойлттой байхаар хийнэ. Онгойдог хэсгүүдэд бүгдэд ялааны торон хамгаалалт хийж өгнө. Цонхны гадна, дотор зэвэрдэггүй төмөр тавцан болон дотор цонхны тавцанг технологийн дагуу газар дээр нь хэмжээ авч захиалж хийж гүйцэтгэнэ.

Хаалга

Агуулахын хаалга нь дээш сөхөгддөг дулаалгатай хаалга байх ба хаалга нь дээрээ шилэн цонхтой байна. Ажилчдын гадна хаалга нь маш сайн чанарын, дулаалгатай хамгаалалтын төмөр хаалга байх бөгөөд хаалганы түгжээ 3 тал руугаа түгжигддэг байна. Агуулахын хаалгууд - галаас хамгаалах технологийн дагуу сайжруулсан гал эсэргүүцэх цагийг уртасгасан үзүүлэлттэй байх шаардлагатай. Агуулахын хаалганы ирмэгээр анхааруулах тэмдэглэгээ бүхий хамгаалалтын булан төмөр хийж өгнө. Мөн мөргөхөөс хамгаалсан нэмэлт төмөр суурилуулж өгнө.

Дээвэр

Гадуур ус зайлуулалт бүхий 2 талт налуу дээвэртэй байна. Дээвэрт гадна төмөр шатаар дамжин гарна. Дээвэрт сүүлийн үеийн технологийн шинэ чанартай материалуудыг ашиглана. Дээврийн хэсэглэл, уулзварыг ус урсах налуу, ус зайлуулах ховил, хаялга зэргийг өндөр чанар, технологийн дагуу хийж гүйцэтгэнэ.

Зураг 6. 17 Өргөн хэрэглээний дулаан агуулахын үзэгдэх байдал



Шал, тааз, дотор засал

Шалыг хэсэглэлийн дагуу хийж гүйцэтгэнэ. Ажилчдын өрөөний халаах талбайг багасгахын тулд дүүжин тааз хийж өгнө. Сендвичэн ханын дотор тал нь хана тааз бүгд цагаан өнгөтэй байна.

Довжоо пандус

Гадна тавцан, пандусыг сайтар нягтруулсан овойлт үүсгэдэггүй хөрсөн дээр зурагт үзүүлсний дагуу хийж гүйцэтгэнэ. Гадна ачаа буулгах тавцанг ачаа ачдаг машины өндрөөс хамааруулан 900, 1200, 1400 м өндөртэй байхаар 3 янзын түвшинтэй байхаар хийж өгөв. Тавцангийн ирмэгээр анхааруулах тэмдэглэгээ бүхий хамгаалалтын булан төмөр хийж өгнө. Тавцангаас по-ачаа ачих машин буух гарах пандус хийж өгнө. Мөн тухайн агуулах нь техникийн өрөөтэй тул техникийн өрөө рүү гаднаасаа орох гадна довжоо хийж өгнө.

Хүснэгт 6. 5 Өргөн хэрэглээний дулаан агуулахын өрөөний зохион байгуулалт

№	Өрөө масалгааны нэр	Шалны төрөл	Талбай /м ² /
1	Агуулах /дунд/	Эпокси будаг	331.90
2	Ажилчдын өрөө	Эпокси будаг	9.91
3	Агуулах /жижиг/	Эпокси будаг	165.92
4	Агуулах /том/	Эпокси будаг	502.54
5	Техникийн өрөө	Эпокси будаг	9.50
ДАВХРЫН АШИГТАЙ ТАЛБАЙ			1019.16 м ²
ДАВХРЫН ТАЛБАЙ /тэнхлэгээр/			1008.00 м ²
ДАВХРЫН ТАЛБАЙ /гадна ханаар/			1082.13 м ²
ДАВХРЫН ЭЗЛЭХҮҮН			8532.81 м ³




6.4.4 Хөлдөөгч хөргүүртэй агуулах

Тус хөлдөөгч, хөргүүртэй агуулахын барилга нь логистик төвийн хашаан дотор зүүн талд орж ирж байгаа орцны дагуу байрлалтай. Барилга нь урд зүгт харсан байрлалтай баруун урд зүгээс орох орцтой.

24.00 x 42.00 харьцаанд багтсан метал каркас араг бүтээц, сендвичэн хана, 2 талт налуу дээвэр бүхий 1 давхар, зоорьгүй барилга юм. Барилгын захын өндөр 7,0 м, голын цэвэр өндөр 8,1 м байна. /сендвич тааз хүртэл/ Барилга нь агуулахын зориулалттай байх ба БНБД 31-19-10 агуулахын барилга, БНБД 21-02-02 барилга, байгууламжийн зураг төсөл зохиох галын аюулгүйн норм, БНБД 2.01-85 галын аюулгүйн дүрэм; үндсэн шаардлага, БД 22-101-07 газар хөдлөлтийн бүс нутагт барилга төлөвлөх барилгын норм ба дүрэм -н шаардлагын дагуу боловсруулсан. Барилгын үнэмлэхүй 0.00 түвшин = 990.70. Байгуулалтын зураг БА-02-р хуудаснаас өрөө тасалгааны өрлөгийн зай хэмжээ, инженер хангамжийн холболтод зориулан хучилт хананд гарах нүх М&Е -гын даалгаврын хэмжээг харна уу. Агуулах нь 22.84 м² жимс, ногооны гүн хөлдөөх өрөө, 208 м² хөлдөөсөн нарийн ногоо, жимс, жимсгэний агуулах, 68.04 м² мах, махан бүтээгдэхүүний гүн хөлдөөх өрөө, 487.59 м² хөлдөөсөн мах, махан бүтээгдэхүүний агуулах гэсэн 4 заалтай байна. Мөн тухайн агуулахыг хариуцан ажиллах ажилчдын өрөө байрлана. MF/ABC5 маркийн хуурай галын унтраагуур төлөвлөв.

Зураг 6. 18 Хөлдөөгч хөргүүртэй агуулахын төлөвлөлт




Хана, гадна заслал

Суурийн ханыг гадна талаас 50 мм XPS хөөсөн хавтангаар дулаалж ус чийгээс хамгаалах түрхлэг түрхэж гадна талаар нь ус чийг болон хөрсний гэмтлээс хамгаалах GeoPlanter суурийн ус тусгаарлагч хийж өгнө. Хөрснөөс дээш гарах цоколын хэсгийг шавардан хар саарал өнгийн гадна фасадны будгаар будах эсвэл хар саарал өнгийн зориулалтын шавардлагаар шавардаж өгнө. Үндсэн давхрын давхрын ханыг 150 мм шахалт сайтай EPS хөөсөндөр бүхий сендвич хавтангаар хийж, уулзвар, бүтцийг технологийн дагуу хийж гүйцэтгэнэ. Барилгын ханын дулаалгад хэрэглэх материал нь MNS 1247:1998 стандартад нийцсэн байна. Фасадны өнгө цайвар саарал өнгийн хавтангаар, гол үүдний хэсгийг хар саарал болон цэнхэр өнгийн хавтангаар ялгаж өнгөлгөөг хийнэ. Дотор хануудыг газар



хөдлөлийн бүс нутагт барилга төлөвлөх барилгын норм ба дүрэм - БНБД 22-01-01 болон түүний тайлбар БД 22-101-07 гын дагуу даацын үндсэн каркас, цутгамал ханаас 2см-с багагүй зайтай тусгаарлан хийх ба тус зайг уян чигжээсээр дүүргэнэ.

Зураг 6. 19 Хөлдөөгч хөргүүртэй агуулахын дотоод зохион байгуулалт



Цонх

Цонх нь хар саарал өнгийн 70 мм -с доошгүй зузаантай металл рамтай - 3-7 тасалгаатай (камертай) 3 давхар резинэн жийргэвчтэй байх бөгөөд тасалгаа завсар зориулалтын дулаан тусгаарлагч хатуу хуванцар хийж өгч гадна дуу болон дулаан тусгаарлалтыг нэмэгдүүлсэн технологитой байна. Өндөр чанартай нугас түгжээ хийнэ. Том цонхны рам дотор даацыг хүчитгэсэн төмөр нэмэлт тулгууртай байна. Цонхны онгойлт түгжээг үйлдвэрийн технологийн дагуу цонхыг угааж арчих боломжтой онгойлттой байхаар хийнэ. Онгойдог хэсгүүдэд бүгдэд ялааны торон хамгаалалт хийж өгнө. Цонхны гадна, дотор зэвэрдэггүй төмөр тавцан болон дотор цонхны тавцанг технологийн дагуу газар дээр нь хэмжээ авч захиалж хийж гүйцэтгэнэ.

Хаалга

Агуулахын хаалга нь дээш сөхөгддөг дулаалгатай хаалга байх ба хаалга нь дээрээ шилэн цонхтой байна. Ажилчдын гадна хаалга нь маш сайн чанарын, дулаалгатай хамгаалалтын төмөр хаалга байх бөгөөд хаалганы түгжээ 3 тал руугаа түгжигддэг байна. Агуулахын хаалгууд - галаас хамгаалах технологийн дагуу сайжруулсан гал эсэргүүцэх цагийг уртасгасан үзүүлэлттэй байх шаардлагатай. Агуулахын хаалганы ирмэгээр анхааруулах тэмдэглэгээ бүхий хамгаалалтын булан төмөр хийж өгнө. Мөн мөргөхөөс хамгаалсан нэмэлт төмөр суурилуулж өгнө.



Хүснэгт 6. 6 Хөлдөөгч хөргүүртэй агуулахын өрөөний зохион байгуулалт

№	Өрөө тасалгааны нэр	Шалны төрөл	Талбай /м2/
1	Үүдний хэсэг	Эпокси будаг	120.62
2	Хувцас солих өрөө	Эпокси будаг	23.22
3	Ажилчдын өрөө	Эпокси будаг	11.69
4	Жимс, ногооны гүн хөлдөөх өрөө	Эпокси будаг	22.84
5	Чгаах, сэврээх, савлах, хэсэг	Эпокси будаг	23.36
6	Хөлдөөсөн нарийн ногоо, жимс, жимсгэний агуулах	Эпокси будаг	208.00
7	Хөлдөөсөн мах махан бүтээгдэхүүний агуулах	Эпокси будаг	487.59
8	Мах махан бүтээгдэхүүний гүн хөлдөөх өрөө	Эпокси будаг	68.04
БАРИЛГЫН АШИГТАЙ ТАЛБАЙ			965.36 м ²
БАРИЛГЫН ТАЛБАЙ /тэнхлэгээр/			1008.00 м ²
БАРИЛГЫН ТАЛБАЙ /гадна ханаар/			1075.32 м ²
БАРИЛГЫН ЭЗЛЭХҮҮН			7,713 м ³

Дээвэр

Гадуур ус зайлуулалт бүхий 2 талт налуу дээвэртэй байна. Дээвэрт гадна төмөр шатаар дамжин гарна. Дээвэрт сүүлийн үеийн технологийн шинэ чанартай материалуудыг ашиглана. Зурагт үзүүлсний дагуу ус урсах налуу, ус зайлуулах ховил, хаялга зэргийг өндөр чанар, технологийн дагуу хийж гүйцэтгэнэ.

Шал, тааз, дотор засал

Шалыг хэсэглэлийн дагуу хийж гүйцэтгэнэ. Ажилчдын өрөөний халаах талбайг багасгахын тулд дүүжин тааз хийж өгнө. Сендвичэн ханын дотор тал нь хана тааз бүгд цагаан өнгөтэй байна.

Довжоо пандус

Гадна тавцан, пандусыг сайтар нягтруулсан овойлт үүсгэдэггүй хөрсөн дээр зурагт үзүүлсний дагуу хийж гүйцэтгэнэ. Гадна ачаа буулгах тавцанг ачаа ачдаг машины өндрөөс хамааруулан 900, 1200, 1400 м өндөртэй байхаар 3 янзын түвшинтэй байхаар хийж өгөв. Тавцангийн ирмэгээр анхааруулах тэмдэглэгээ бүхий хамгаалалтын булан төмөр хийж өгнө. Тавцангаас по-ачаа ачих машин буух гарах пандус хийж өгнө.

Зураг 6. 20 Хөлдөөгч хөргүүртэй агуулахын үзэгдэх байдал



6.4.5 Хөдөө аж ахуйн агуулах


Тус хөдөө аж ахуйн агуулахын барилга нь логистик төвийн хашаан дотор зүүн талд орж ирж байгаа орцны дагуу байрлалтай. Барилга нь урд зүгт харсан байрлалтай баруун урд зүгээс орох орцтой. 24.00 х 42.00 харьцаанд багтсан металл каркас араг бүтээц, сендвичэн хана,



2 талт налуу дээвэр бүхий 1 давхар, зoorьгүй барилга юм. Барилгын захын өндөр 7,0 м, голын цэвэр өндөр 8,1 м байна. /сендвич тааз хүртэл/ барилга нь агуулахын зориулалттай байх ба БНБД 31-19-10 агуулахын барилга, БНБД 21-02-02 барилга, байгууламжийн зураг төсөл зохиох галын аюулгүйн норм , БНБД 2.01-85 галын аюулгүйн дүрэм; үндсэн шаардлага, БД 22-101-07 газар хөдлөлтийн бүс нутагт барилга төлөвлөх барилгын норм ба дүрэм -н шаардлагын дагуу боловсруулсан. Барилгын үнэмлэхүй 0.00 түвшин = 991.30.

Агуулах нь 503 м2 ноос ноолуурын агуулах, 514 м2 арьс ширний агуулах гэсэн 2 хэсэг заалтай байна. Агуулах бүр 2 хаалгатай байх ба энэ нь шаардлагатай бол агуулахыг төрөлжүүлэн хуваах үед тус бүр гаднаас орох хаалгатай байх давуу талтай. Мөн тухайн агуулахыг хариуцан ажиллах ажилчдын өрөө байрлана. MF/ABC5 маркийн хуурай галын унтраагуур төлөвлөв.

Зураг 6. 21 Хөдөө аж ахуйн агуулахын төлөвлөлт




Хана, гадна заслал

Суурийн ханыг гадна талаас 50 мм XPS хөөсөн хавтангаар дулаалж ус чийгээс хамгаалах түрхлэг түрхэж гадна талаар нь ус чийг болон хөрсний гэмтлээс хамгаалах GerPlanter суурийн ус тусгаарлагч хийж өгнө. Хөрснөөс дээш гарах цоколын хэсгийг шавардан хар саарал өнгийн гадна фасадны будгаар будах эсвэл хар саарал өнгийн зориулалтын



шавардлагаар шавардаж өгнө. Үндсэн давхрын давхрын ханыг 150 мм шахалт сайтай EPS хөөсөнцөр бүхий сендвич хавтангаар хийж, уулзвар, бүтцийг технологийн дагуу хийж гүйцэтгэнэ. Барилгын ханын дулаалгад хэрэглэх материал нь MNS 1247;1998 стандартад нийцсэн байна. Фасадны өнгө цайвар саарал өнгийн хавтангаар, гол үүдний хэсгийг хар саарал болон цэнхэр өнгийн хавтангаар ялгаж өнгөлгөөг хийнэ. Дотор хануудыг газар хөдлөлийн бүс нутагт барилга төлөвлөх барилгын норм ба дүрэм - БНБД 22-01-01 болон түүний тайлбар БД 22-101-07 гын дагуу даацын үндсэн каркас, цутгамал ханаас 2см-с багагүй зайтай тусгаарлан хийх ба тус зайг уян чигжээсээр дүүргэнэ.

Зураг 6. 22 Хөдөө аж ахуйн агуулахын дотоод зохион байгуулалт



Хүснэгт 6. 7 Хөдөө аж ахуйн агуулахын өрөөний зохион байгуулалт

№	Өрөө тасалгааны нэр	Шалны төрөл	Талбай /м ² /
1	Ноос ноолуурын агуулах	Эпокси будаг	503.22
2	Ажилчдын өрөө	Эпокси будаг	10.03
3	Арьс шийрний агуулах	Эпокси будаг	514.23
БАРИЛГЫН АШИГТАЙ ТАЛБАЙ			1027.48 м ²
БАРИЛГЫН ТАЛБАЙ /тэнхлэгээр/			1008.00 м ²
БАРИЛГЫН ТАЛБАЙ /гадна ханаар/			1075.32 м ²
БАРИЛГЫН ЭЗЛЭХҮҮН			8309.49 м ³

Цонх

Цонх нь хар саарал өнгийн 70 мм -с доошгүй зузаантай металл рамтай - 3-7 тасалгаатай (камертай) 3 давхар резинэн жийргэвчтэй байх бөгөөд тасалгаа завсар зориулалтын дулаан тусгаарлагч хатуу хуванцар хийж өгч гадна дуу болон дулаан тусгаарлалтыг нэмэгдүүлсэн технологитой байна. Өндөр чанартай нугас түгжээ хийнэ. Том цонхны рам дотор даацыг

хүчитгэсэн төмөр нэмэлт тулгууртай байна. Цонхны онгойлт түгжээг үйлдвэрийн технологийн дагуу цонхыг угааж арчих боломжтой онгойлттой байхаар хийнэ. Онгойдог хэсгүүдэд бүгдэд ялааны торон хамгаалалт хийж өгнө. Цонхны гадна, дотор зэвэрдэггүй төмөр тавцан болон дотор цонхны тавцанг технологийн дагуу газар дээр нь хэмжээ авч захиалж хийж гүйцэтгэнэ.

Хаалга

Агуулахын хаалга нь дээш сөхөгддөг дулаалгатай хаалга байх ба хаалга нь дээрээ шилэн цонхтой байна. Ажилчдын гадна хаалга нь маш сайн чанарын, дулаалгатай хамгаалалтын төмөр хаалга байх бөгөөд хаалганы түгжээ 3 тал руугаа түгжигддэг байна. Агуулахын



хаалгууд - галаас хамгаалах технологийн дагуу сайжруулсан гал эсэргүүцэх цагийг уртасгасан үзүүлэлттэй байх шаардлагатай. Агуулахын хаалганы ирмэгээр анхааруулах тэмдэглэгээ бүхий хамгаалалтын булан төмөр хийж өгнө. Мөн мөргөхөөс хамгаалсан нэмэлт төмөр суурилуулж өгнө.

Дээвэр

Гадуур ус зайлуулалт бүхий 2 талт налуу дээвэртэй байна. Дээвэрт гадна төмөр шатаар дамжин гарна. Дээвэрт сүүлийн үеийн технологийн шинэ чанартай материалуудыг ашиглана. Дээврийн хэсэглэл, уулзварыг ус урсах налуу, ус зайлуулах ховил, хаялга зэргийг өндөр чанар, технологийн дагуу хийж гүйцэтгэнэ.

Шал, тааз, дотор засал

Шалыг хэсэглэлийн дагуу хийж гүйцэтгэнэ. Ажилчдын өрөөний халаах талбайг багасгахын тулд дүүжин тааз хийж өгнө. Сендвичэн ханын дотор тал нь хана тааз бүгд цагаан өнгөтэй байна.

Довжоо пандус

Гадна тавцан, пандусыг сайтар нягтруулсан овойлт үүсгэдэггүй хөрсөн дээр зурагт үзүүлсний дагуу хийж гүйцэтгэнэ. Гадна ачаа буулгах тавцанг ачаа ачдаг машины өндрөөс хамааруулан 900, 1200, 1400 м өндөртэй байхаар 3 янзын түвшинтэй байхаар хийж өгөв. Тавцангийн ирмэгээр анхааруулах тэмдэглэгээ бүхий хамгаалалтын булан төмөр хийж өгнө. Тавцангаас по-ачаа ачих машин буух гарах пандус хийж өгнө.

Зураг 6. 23 Хөдөө аж ахуйн агуулахын үзэгдэх байдал



6.4.6 Уурын зуухны барилга


Тус уурын зуухны барилга нь логистик төвийн хашаан дотор хойд талд, орж ирж байгаа орцны хойд талд байрлана. Барилга нь урд зүгт харсан байрлалтай баруун урд зүгээс орох орцтой.



9.00x18.00м харьцаанд багтсан төмөр бетон каркас, дүүргэгч ханатай, гадна талдаа өнгөлгөөний тоосгоор өрөгдсөн 1 давхар хавтгай дээвэр бүхий барилга байна. Барилгын үнэмлэхүй нь 0,00 түвшин = 986,90. Цэвэр өндөр нь 4,50 м байна.

Барилгад сүүлийн үед хэрэглэж байгаа монгол улсын стандартад тохирсон материал, технологи ашиглана. Барилгын фасад нь хүрэн улаан өнгийн өнгөлгөөний керамик тоосгоор өрөгдөх бөгөөд керамик тоосго ба гулдмай. Техникийн шаардлага MNS 0138:2010 -ийн дагуу стандарт чанарын шаардлага хангасан байна. Бат бэхийн ангилал м200-м300, хүйтэн тэсвэрлэлтээр F100 марктай, дундаж нягт 1,4-2,0 хооронд байхаар сонгоно. Цоколыг хар саарал өнгийн шавардлагаар өнгөлөхөөр зурагт тусгав. Тус барилгад зуухны өрөө, насосны өрөө, галчийн амралтын өрөө, ариун цэврийн өрөө байрлана.

Зураг 6. 24 Уурын зуухны барилга



6.4.7 Дэд өртөөний барилга


Тус дэд өртөөний барилга нь логистик төвийн хашаан дотор зүүн хойд буланд, орж ирж байгаа замын хойд талд байрлана. Барилгын гол орц нь урд зүгт харсан байрлалтай.



7.00 x 10.00 харьцаанд багтсан 380мм даацын арматурласан тоосгон өрлөгтэй, гадна талдаа өнгөлгөөний тоосгоор өрөгдсөн 1 давхар хавтгай дээвэр бүхий барилга байна. Барилгын үнэмлэхүй 0,00 түвшин = 986,40. Цэвэр өндөр 3,6м байна.

Барилгад сүүлийн үед хэрэглэж бай монгол улсын стандартад тохирсон материал, технологи ашиглана. Барилгын фасад нь улаан хүрэн өнгийн өнгөлгөөний керамик тоосгоор өрөгдөх бөгөөд керамик тоосго ба гулдмай. Техникийн шаардлага mns 0138:2010 -ийн дагуу стандарт чанарын шаардлага хангасан байна. Бат бэхийн ангилал м200-м300, хүйтэн тэсвэрлэлтээр f100 марктай, дундаж нягт 1,4-2,0 хооронд байхаар сонгоно. Цоколыг хар саарал өнгийн шавардлагаар өнгөлөхөөр зурагт тусгав.

Зураг 6. 25 Дэд өртөөний барилга



БҮЛЭГ 7. ИНЖЕНЕРИЙН ДЭД БҮТЦИЙН ТӨЛӨВЛӨЛТ

Бүлгийн дэд агуулга:

- ✘ Инженерийн хангамжийн тодорхойлолт
- ✘ Цахилгаан хангамж
- ✘ Дулаан хангамж
- ✘ Усан хангамж, ариутгах татуурга



Холбоо мэдээллийн сүлжээ


7.1 ИНЖЕНЕРИЙН ХАНГАМЖИЙН ТОДОРХОЙЛОЛТ

Логистик төв нь инженерийн хангамжийн хувьд төвлөрсөн ба бие даасан холимог шийдэлтэй байна.

Зураг 7.1 Инженерийн хангамжийн шийдэл



Зураг 7.2 Инженерийн шугам сүлжээ нэгдсэн



7.2 ЦАХИЛГААН ХАНГАМЖ

Увс аймагт байгуулагдах Баруун бүсийн Логистик төвийн цахилгаан хангамжийн хэсгийг боловсруулахдаа хүн амын өсөлт эдийн засгийн хөгжилт, бүсчлэлийг харгалзан үзэж зохиосон архитектур орон зайн ерөнхий төлөвлөгөөний дагуу материал дараах норм дүрмийг ашиглан хийж гүйцэтгэсэн.

1. “Лэнд Тэст”ХХК-ийн боловсруулсан газрын зураглал М1:500
1. “Эл Эм Ланд”ХХК-ийн боловсруулсан инженер-геологийн хайгуул судалгааны дүгнэлт,



2. Увс аймагт байгуулагдах Логистик төвийн зураг төсөл боловсруулах ажлын даалгавар 2021 оны 05 сарын 05 өдөр №...../.....

Шинээр төлөвлөж буй Логистик төвийн талбайд одоогоор цахилгааны эх үүсвэр байхгүй.

Зураг 7.3 Гадна цахилгааны шугам



Гадна цахилгаан хангамжид 1 КТП, 6111 метр урттай гадна цахилаан, 3172 метр урттай гэрэлтүүлэг 101 ширхэг шонгийн хамт, цамхагт гэрэлтүүлэгч 6 ширхэг, Лед прожекторон гэрэлтүүлэгч 48 ширхэг тус тус төлөвлөгдсөн.

Хүснэгт 7.1 Цахилгааны төлөвлөлт, 1-р ээлж

Нэр төрөл	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Хэв маяг
Гадна цахилгаан			
КТП	ширхэг	1	
Хөнгөн цагаан голтой поливинилхлорид тусгаарлагчтай ган туузан хуягтай хүчний кабель	м	116	АББл 3x120
	м	1047	АВББ 3x95+1x50
	м	88	АВББ 3x50+1x35
	м	688	АВББ 3x35+1x16
Бүгд	м	1939	
Гадна гэрэлтүүлэг			
Хөнгөн цагаан голтой поливинилхлорид тусгаарлагчтай ган туузан хуягтай хүчний кабель	м	176	АВББ 4x10
	м	1579	АВББ 3x25+1x16
	м	172	АВББ 3x50+1x25
Гэрэлтүүлгийн шон - 9м өндөртэй ф133/ф76	ш	52	LPH-9м
Явган хүний замын гэрэлтүүлгийн шон L=3м	ш	15	CDS550

Зураг 7.4 Дотор цахилгааны шугам



Хүснэгт 7.2 Цахилгааны төлөвлөлт, 2-р ээлж

Нэр төрөл	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Хэв маяг
Гадна цахилгаан			
Хөнгөн цагаан голтой поливинилхлорид тусгаарлагчтай ган туузан хуягтай хүчний кабель	м	1189	АВВБ 3x120+1x70
	м	524	АВВБ 3x95+1x50
	м	313	АВВБ 3x50+1x35
	м	2016	АВВБ 3x35+1x16
	м	130	АВВБ 3x25+1x16
Гадна гэрэлтүүлэг			
Хөнгөн цагаан голтой поливинилхлорид тусгаарлагчтай ган туузан хуягтай хүчний кабель		1135	АВВБ 3x35+1x16
	м	110	АВВБ 4x6
16м өндөртэй цамхагт гэрэлтүүлэгч	ком	6	МС-16-К/8+Мо -хФ-IV-Ц
Лед прожекторон гэрэлтүүлэгч 350Вт IP65	ш	48	Led-350

7.3 ДУЛААН ХАНГАМЖ

Улаангом сумын Баруун Логистик төвийн барилгын гадна дулаан хангамжийн зураг төслийг ерөнхий төлөвлөгөө, өндөржилт, зай хэмжээний зураг, халаалт агаар сэлгэлтийн ажлын зураг, газар дээрх тодруулга, судалгаа зэргийг үндэслэн зураг төслийг хийж гүйцэтгэв. Дэвсгэр зурагт тусгагдаагүй инженерийн шугам сүлжээ байгаа эсэхийг газар шорооны ажил эхлэхээс өмнө тодруулах нь зүйтэй.

Гадна дулаан хангамжийн ажлын зургийг хийж гүйцэтгэхдээ:

- БНБД 23-01-09 Барилгад хэрэглэгдэх уур амьсгал ба геофизикийн үзүүлэлт,
- БНБД 41-02-13 Дулааны сүлжээ.



Барилга баригдах газрын цаг уурын нөхцөл:

- Гадна агаарын тооцооны хэм -40.6°C
- Галлагааны үеийн дундаж хэм -13.2°C
- Галлагааны үеийн үргэлжлэх хугацаа -221 хоног

Дулааны эх үүсвэр нь бие даасан дулаан хангамжийн системд холбогдоно. Дулаан зөөгчийн параметр $90/70^{\circ}\text{C}$ байна. Төлөвлөж буй дулааны худагт таслах хаалт, ус буулгагчийн хамт байна. Мөн дулааны шугамд таслах хаалт, ус буулгагчийг зурагт зурсны дагуу угсарна.

Дулааны шугамд хүчитгэсэн ган яндан хоолой хэрэглэнэ. Дулааны шугамыг үл нэвтрэх бетон сувагт, гулсах тулгуур бүхий бетон дэр дээр, 50мм-ийн зузаантай зориулалтын пенополиуретон буюу түүнтэй адил шинж чанар бүхий материалаар дулаалж, дулаалахын өмнө зэврэлтээс хамгаалсан 2 үе түрхлэг хийнэ.

Жишээгээр ган хоолойд гулсах тулгууруудыг $\Phi 38 \times 2.5$ мм голчтой хоолойд:

- шулуун хэсэгт 3.0 м,
- эргэлттэй хэсэгт 1.8 м

Дулааны шугамыг даралттай усаар шахаж шалгахдаа СНИП.050.3-83-н дагуу шалгаад далд ажлын акт үйлдэж хүлээлгэж өгнө. Шахах ажлын даралт 1.6 МПа-с багагүй байна. Далд ажлын акт гарсны дараа сувгийн хавтанг тавьж шороогоор булна.

Гагнуурын ажлыг гүйцэтгэхдээ СНИП 3.05.03-83-ын 5.3-аас 5.13-р зүйлүүдийг мөрдлөг болгон ажиллах хэрэгтэй. Угсралтын ажлыг хийж гүйцэтгэхдээ техник аюулгүй ажиллагааны /БНГД 12-03-04/ норм дүрмийн баримтлан ажиллах хэрэгтэй.


Хүснэгт 7. 3 Дулаан зарцуулалт

Барилга /байгууламж/ өрөөний нэр	Барилгын эзэлхүүн M^3	Гадна агаарын температур $^{\circ}\text{C}$	Дулааны зарцуулалт Вт (ккал/цаг)				Хүйтэн зарцуулалт, Вт	Цахилгаан хөдөлгүүрийн хүчин чадал кВт
			Халаалт	Агаар сэлгэлт	Хэр.хал ус	Нийт		
барилга		-40.6°C	329.4 (283.2)	—	150 (129)	479.4 (412.2)		

Хүснэгт 7. 4 Дулаан хангамжийн төлөвлөлт

Д/Д	Нэр төрөл	Хэмжих нэгж	Тоо хэмжээ		
1	Дулааны шугам	м	458	1,486	1,944
2	Гадна дулааны худаг	ш			8
3	Уурын зуух	ш			2

Зураг 7. 5 Дулаан хангамжийн төлөвлөлт



Дулаан механик:

- Тухайн барилгажих талбай нь төвөөс зайдуу, төвийн дулаанаас хол байгаа тул халаалтыг өөрийн эх үүсвэрээр шийднэ,
- Нам даралтын хатуу түлшний тогоо сонгоно,
- Монгол улсад худалдаалагдаж буй Eurozigi LUX маркийн хатуу түлшний 2 ширхэг тогоо сонгов,
- Халаалтын эргэлтийн болон нэмэлт усны насосыг Grundfos фирмийн насос сонгов,
- Шугамын тэлэлтээс хамгаалах зорилгоор тэлэлтийн сав сонгов,
- Бусад хаалт, арматураар сонгогдоно,
- Увс аймгийн Тариалан сумын Хар тарвагатайн нүүрс түлнэ,

Агаар сэлгэлт:

- Шаардлагатай өрөө, тасалгаануудад агаар оруулах болон сорох механик системтэй байна.
- Бусад өрөө, тасалгаануудад ердийн системтэй байна.
- Агааржуулалтын босоо босоо шугамуудыг шатанд угсарна.



- Агааржуулалтын хэвтээ шугамуудыг ерөөний засалтай уялдуулан будаж цэвэр үзэмжтэй угсрах, эвсэл дүүжин таазны цаана угсрах шаардлагатай.

Зураг 7. 6 Eurozigi фирмийн зуухууд



Еврозиги Инженеринг

Халаалт, халуун ус, сантехникийн бүх төрлийн материал

байгууламж бнбд40-02-16,

- Ариутгах татуурга , гадна сүлжээ ба байгууламж бнбд40-01-14 зэргийг үндэслэв.

Эх сурвалж: www.facebook.com

7.4 УСАН ХАНГАМЖ, АРИУТГАХ ТАТУУРГА

Увс аймаг, Улаангом сум баруун логистик төвд төлөвлөж буй барилгын гадна ус хангамж, ариутгах татуургын шугамын ажлын зургийг хийж гүйцэтгэхдээ:

- Барилгын ерөнхий төлөвлөгөө, өндөржилт
- Инженер-геологийн судалгааны дүгнэлт ("эл эм ланд" ххк архив №014\2022)
- Ус хангамж, гадна сүлжээ ба

Усан хангамж

Тус барилгын унд ахуйн хүйтэн ус нь гүний худгаас уурын зууханд байрлах усан сангаас хангагдана. Хүйтэн усны шугамыг хөлдөхөөс хамгаалж эргэлтийн шугамтай төлөвлөж барилгын узелийн өрөөнд эргэлтийн насос угсарна.

Хэрэгцээний халуун усыг төлөвлөж буй бие даасан уурын зуухын өрөөнд бэлтгэнэ. Ус хангамжийг хоолойг дулааны шугамтай хамт дулаалгатай явахаар төлөвлөв. Угсралтыг дууссаны дараа шугамыг бнбд40-04-16 норм дүрэмд зааснаар шахаж шалгана.

Ариутгах татуурга

барилгын ахуйн бохир усыг соруулж зайлуулах бөгөөд барилга тус бүр бие даасан бохир усны шугамын худаг руу холбохоор төлөвлөв. бохир усны хоолойг рвс-и хуванцар хоолойгоор угсарна. бохир усны хоолой барилгаас гарах хэсэг, худаг руу орох, гарах хэсэгт чигжээсийг сайн хийж битүүмжийг бүрэн хадгалах шаардлагатай.

Геологийн дүгнэлтэд:

- Инженер геологийн дунд зэргийн төвөгтэй нөхцөлтэй
- Хөрсний ус: хөрсний ус илрээгүй.



- Улирлын хөлдөлтийн гүн: том хэмхдэст хөрс -3.0м,
- Газар чичирхийллийн 8 баллын бүсэд хамаарагдана гэж судлагдсан.


Угсралтын ажлыг хийхдээ бнбд40-04-16 ус хангамж, ариутгах татуургын гадна сүлжээ барилга байгууламж нормыг баримтлах шаардлагатай.

Газар шорооны ажил эхлэхийн өмнө холбогдох байгууллагуудаас зөвшөөрөл авах ба бие төлөөлөгч байлган шугам сүлжээтэй огтлолцсон хэсгийг гар аргаар ухаж гүйцэтгэнэ. Дэвсгэр зурагт тусгагдаагүй инженерийн шугам сүлжээ байгаа эсэхийг газар шорооны ажил эхлэхийн өмнө тодруулах нь зүйтэй.

Хүснэгт 7.5 УХАТ материалын тооцоо

Д/Д	УХАТ төлөвлөлт	Хэмжих нэгж	Хэсгийн урт	Нийт урт	Ширхэг
	Цэвэр ус				
1	Цэвэр усны шугам, Ф57	метр	296	444	
2	Цэвэр усны шугам, Ф89	метр	148		
	Бохир ус				
3	Бохир усны шугам, Ф100	метр	30	30	
4	Бохир цооног	Ширхэг			6
	Нийт			474	6

Зураг 7.7 УХАТ төлөвлөлт





7.5 ХОЛБОО МЭДЭЭЛЛИЙН СҮЛЖЭЭ

“Баруун бүсийн Логистик төв”-ын холбоо дохиоллын ажлын зургийг барилгын төлөвлөлт, байгуулалтын дараах зохих стандарт, норм дүрмийг үндэслэн хийж гүйцэтгэв. Үүнд:


- Холбооны кабелийн суурилуулалт, ерөнхий шаардлага MNS 5276:2013 ,
- Телефон сүлжээний кабель. Ерөнхий шаардлага MNS 5015:2001 ,
- Салбар кабелцйн төгсгөлийн төхөөрөмжийн суурилуулалт MNS 5280:2003 ,
- Мэдээлэл холбооны сүлжээний гадна холбооны зургийн тэмдэглэгээ MNS 4908:2017,
- MNS 6305:2012, MNS 6597:2016, MNS 5276:2003, MNS 5279:2003, MNS 6668:2017 стандартуудыг баримтлав.

Оффис лабораторийн барилгын холбооны өрөөний 24-корын шилэн кабелийн төгсгөлийн төхөөрөмжөөс нь агуулахын барилгуудын 4-корын FDF-т холбогдох ба тус FDF-ээс 4-корын кабелиар салаалан авч барилга тус бүр рүү 4-корын FDF-рүү холболтыг хийнэ.

Барилга тус бүр рүү 24-корын шилэн кабель оруулахаар төлөвлөв.

Сувагчлал суурилуулах зай хэмжээг 120-метрээс хэтрэхгүй байхаар тооцох ба эргэлт болон барилгын оролтод зайлшгүй стандартын худаг суурилуулна.

Зураг 7. 8 Холбоо мэдээллийн сүлжээ төлөвлөлт



Төслийн талбайд холбооны сувагчлалыг 800 метрээр байгуулах ба 16 камер суурилуулж 640 метр шилэн кабель татаж холбохоор төлөвлөсөн.



Хүснэгт 7. 6 Холбоо мэдээллийн сүлжээ төлөвлөлт

Д/д	Холбоо төлөвлөлт	Хэмжих нэгж	Тоо хэмжээ
1	Холбооны сувагчлал	метр	800
2	Шилэн кабель - 24 кор	метр	800
3	Гадна хяналтын камер	ширхэг	16
4	Хяналтын камерын шилэн кабель - 24 кор	метр	600
5	Хяналтын камерын шилэн кабель - 4 кор	метр	40

Зураг 7. 9 Холбооны сувагчлал байгуулалт

БҮЛЭГ 8. БАЙГАЛЬ ОРЧНЫ ХАМГААЛАЛ БА ГАМШГИЙН МЕНЕЖМЕНТ

Бүлгийн дэд агуулга:

- ⌘ Ногоон байгууламжийн төлөвлөлт
- ⌘ Хог хаягдлын менежмент
- ⌘ Гамшгийн менежмент

8.1 НОГООН БАЙГУУЛАМЖИЙН ТӨЛӨВЛӨЛТ

Төлөвлөлтийн шийдэл

Баруун бүсийн логистик төв байрших Увс аймгийн Улаангом сумын төвийн цаг агаар, байгаль экологийн төлөв байдал, зэргийг харгалзан, Монгол улсад мөрдөгдөж буй норм стандартын дагуу ногоон төлөвлөлтийг хийсэн. Ногоон байгууламжийг байгуулах ажлын өмнө хөрс, ургамлын нарийн судалгаа хийж, уг хөрсөнд ургах мод, бутлаг ургамлын төрлийг тогтоон ногоон байгууламжид ашиглах мод, бутлаг ургамлын төрлийг тогтооно.

Баруун бүсийн логистик төвийн нутаг дэвсгэрт тохиромжтой гоо зүй, ариун цэвэр эрүүл ахуйн нөхцөлийг хангасан, бичил уур амьсгалын тааламжтай орчинг бий болгох зорилготой нийт 3.4 га талбайд ногоон байгууламж байгуулахаар төлөвлөсөн. Ногоон байгууламжийг төлөвлөхдөө нийтийн хэрэгцээний, тусгай болон хязгаарлагдмал зориулалтын гэж 3 ангилна. Баруун бүсийн логистик төвийн нийт талбайн 18.7% нь ногоон байгууламж байна.

Зураг 8. 1 Ногоон байгууламжийн төлөвлөлт



АРХИТЕКТУР-ОРОН ЗАЙН ТӨЛӨВЛӨЛТТЭЙ УЯЛДУУЛАН ногоон байгууламжийг дараах байдлаар төлөвлөв. Үүнд:

- Ногоон байгууламжийг байгалийн унаган төрх, байгаль экологийн нөхцөл байдлыг харгалзан байгалийн гуу жалгыг ашиглан гаргуугийн ус зайлуулах суваг байгуулах ба түүний орчимд хамгаалалтын ногоон бүс байгуулан микро орчинг бүрдүүлэх,
- Логистик бүсийг бүхэлд нь ногоон бүсээр тусгаарлан холбох “Ногоон сүлжээг” бий болгох,
- Тусгаарлах ногоон гудамд явган зорчих зам талбайг төлөвлөсөн ба барилга байгууламжуудын хоорондох орон зайг ногоон байгууламжаар холбосон ногоон орон зай, ногоон гудамж байгуулна,
- Баруун бүсийн логистик төв ба түүний эдэлбэр газраас гаднах нутаг дэвсгэр хоорондох орон зайд хамгаалалтын ногоон зурвас байгуулна. Энэ ногоон зурвас нь логистик төвийг бусад нутаг дэвсгэрээс тусгаарлан, элдэв үнэр дарахаас гадна, илээр урсах борооны усыг хуримтлуулан ногоон байгууламжийг услах ба боомтын нутаг дэвсгэрээр дамжих авто машины дуу шуугианы бохирдлоос хамгаалах ногоон хэрмийн үүрэг гүйцэтгэнэ,
- Хурдан ургадаг модлог ургамлыг салхины хурдыг багасгах, цасны хунгарлалтаас хамгаалах зорилгоор хамгаалалтын ногоон зурвас байгуулж, авто болон төмөр замын дагуу тарих ба мод үржүүлгийн газруудад шилмүүст мод, навчит мод, бут сөөгийг тарьж, бэлдэж ногоон ургамлын нөөцийг бий болгоно.
- Төслийн талбайд тарих “ногоон ургамлыг” дараах байдлаар төлөвлөсөн. Үүнд:
 - ✓ Хамгаалалтын зурваст - бут сөөг 150 ширхэг,



- ✓ Логистик 41 ширхэг том мод буюу гацуур,
- ✓ Зүлэгжүүлж ногооруулах талбай 3 га талбай,

Төсөлд, зөвхөн шаардлагатай ногоон байгууламжийн ерөнхий тоо хэмжээг төлөвлөсөн ба үүнд, 41 ширхэг мод суулгах талбай 4000 м², зүлэгжүүлэх талбай 30000 м², нийт ногоон байгууламж 30,000 м² буюу 3.4 га байгаа нь нийт логистик төвийн нутаг дэвсгэрийн 18.7% болж байна.

Хүснэгт 8.1 Ногоон байгууламжийн төлөвлөлт

Д/д	Төрөл	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Ногоон байгууламж, га	Нийт мод тоо
1	Зүлэг	м ²	30,000	3.0	
2	Шар хуас	ширхэг	50	0.4	191 ширхэг
3	Гацуур	ширхэг	41		
4	Нохойн хошуу	ширхэг	50		
5	Голт бор	ширхэг	50		
	Нийт			3.4	

Шилжүүлэн суулгах модыг сонгон мөчирт нь тааруулж гол үндсийг нь гэмтээлгүй тойруулж ухна. Модыг ухсанахаа дараа таар болон төмөр утас, резинээр шороог хөдөлгөхгүйгээр сайтар бэхэлж бооно мөн модны мөчрийг 30-40% танана. Модыг автокранаар үндсийг гэмтээлгүйгээр болгоомжтой зөөж модыг суулгах талбайд буулгана. Модоо суулгасны дараа услахын өмнө био ялзмаг хөрсөндөө хийж шаардлагатай бордоо болон эмийг хийж өгнө. Модны нүхийг доод хэсгээс даралттай усаар усалж 1 удаагийн услалтад 600-800 литр ус орно.

Модны нүхний захаас хүрзээр сайтар чигжиж усыг гүн оруулна. 1.5-2 метрийн өргөнтэй тогоо үүсгэнэ. Суулгасан модоо салхинд ганхахаас сэргийлж хамгаалалт тулаас хийж өгнө. Мод, сөөгний нүхийг ухахдаа гараар гүйцэтгэх ба газар доор шугам сүлжээтэй эсэхийг сайтар шалгаж ойртох зайг нь стандартын дагуу баримтлан гүйцэтгэнэ.

Суулгах ургамлын танилцуулга ба тоо хэмжээ

- Шар хуайс – 50 ширхэг

Шар хуайс нь цэцэрлэгжилтийн ажилд өргөн дэлгэр ашиглагддаг бут сөөг юм. Шар хуайсыг ихэнх тохиолдолд хамгаалах чиглэлээр ургамлан хашлаганд тарьдаг. Ингэж тарьж байгаа нь олон талын ач холбогдлыг агуулж байна.



Үүнд:



- Ногоон байгууламжаа хүн, мал амьтан, машин техникийн сөрөг нөлөөллөөс хамгаалдаг. Бүтээн бий болгосон ногоо байгууламжаа , зам талбай болон бусад зүйлээс ялгаварлан зааглаж өгөх зорилгоор тарих.
- Ургамлан хашлагыг ямар ч байдлаар засаж хэлбэржүүлж, гадаад өнгө үзэмжийг сайжруулж болдог сайн талтай.
- Шар хуайсыг тарьсан үеэс л эхлэн ямар ч хэлбэр оруулан хэлбэржүүлж /жилдээ 2 удаа/ болдог. Шар хайс 6-р сард цэцэглэдэг, жижигхэн шар цэцэгтэй, цэцэглэснээс хойш 40-50 хоногийн дараа үр нь боловсордог.
- **Гацуур – 50 ширхэг**

Гацуур нь боомтын ногоон байгууламжийн хэсэгт ландшафтын голлох ансанбал болон тарих юм. Ингэхдээ эргэн тойронд бусад бутлаг ургамлуудыг зураг тусгаснаар ландшафтын архитектурын хэв шинэ агуулан тарина. Ингэснээр гацуур нь ногоон байгууламжийг чимж гоёмсог, онцгой харагдуулдаг. Гацуур нь 1,2-1,8 м өндөр, 0,8-1.3м-ийн диаметртэй, 50-100 жил насалж чаддаг, -40 хэмийн хүйтэнд тэсвэртэй хүлэмжид тарьж ургуулсан гацуурыг сонгож тарих.



- **Нохойн хошуу – 50 ширхэг**

Латинаар: *Rosa canina* L гэдэг ба Сарнайн (*Rosaceae* овгийн сөөг юм. Манай оронд 10 гаруй зүйлийн Нохойн хошуу ургадаг. Нохойн хошуу нь навчаа гөвдөг, 1-5 метр өндөр ургадаг модлог ургамал бөгөөд дэлхийн хойд бүсэд ургадаг өргөст зэрлэг сарнайн төрлийн ургамал юм. Нохойн хошуу нь ягаан, цайвар ягаан өнгийн анхилуун үнэрт цэцэгтэй, гоёмсог, үзэсгэлэнтэй ургамал юм. Монголчууд Нохой хошуу цэцэглэхэд зун цаг ирлээ хэмээн үздэг бөгөөд Улаанбаатарт олон жилийн ажиглалтаар 6 сарын 2-ны үед нохой хошуу цэцэглэж 8 сарын сүүл, 9 сарын эхээр үр жимс нь боловсордог.



- **Голт бор – 50 ширхэг**

Голт борын навч нь зуувандуу бүтэн ирмэгтэй, 5-10 см урт, 3-5 см өргөн, хар ногоон өнгөтэй. Гэрэлд дуртай анхилуун үнэртэй, Хөх ягаан өнгийн цэцэгтэй бөгөөд диаметр нь 1 см, баг цэцэг 10-20 см урт. Манай орны цаг уурын нөхцөлд тарималжин нутагшиж байгаа гоёл чимэглэлийн ач холбогдолтой шинэ таримал сөөг юм. 5-р сарын дундаас 6-р сарын сүүлч хүртэл цэцэглэдэг балт ургамал. Анхилам сайхан үнэртэй учир үнэртэн гоо сайхны бүтээгдэхүүнд хэрэглэдэг. Ганц нэг хэсэг бүлгээр таривал зохимжтой. 60х50 хэмжээтэй нүхэнд тарина. Нүх хооронд 2м-ээс ойргүй тарина. Элс, хар шорооны холимог бүхий бүтэц сайтай хөрсөнд таривал тохиромжтой ба 3-5 м өндөр буталж ургадаг 40-50 жил насалдаг байна.



- **Зүлэг – 30,000 м²**



Өвөлд навчаа гөвдөг, багавтар мод юм уу том хэмжээний сөөг. Навч нь энгийн ээлж дараалсан байрлалтай эрт унадаг дагавар навчтай, цэцэг нь цагаан 5, 5-аараа багцалж байрладаг. Жимс нь хар юм уу бараан хүрэн өнгөтэй, 1 см орчим голчтой бөөрөнхийдүү өндгөн хэлбэртэй. Үрээр болон мөчрөөр тарьж ургуулдаг. Хотын парк цэцэрлэгт тарихад тохиромжтой, гадаад байдлын хувьд гоёмсог цэцэг нь бал агуулдаг. Титмийн хэлбэржүүлэлт хяргалтыг сайн даадаг сөөг юм.



8.2 ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТ

Зорилго ба шалтгаан

Аливаа хог хаягдал нь байгаль орчин, хүний эрүүл мэндэд асар их хор хохирол учруулдаг. Иймээс хүн амьдран байгаа орчиндоо үүсгэн гаргаж буй хог хаягдлаа хэрхэн зүй зохистой ангилан ялгах, зайлуулах, дахин боловсруулах, үйлдвэрлэл явуулах зэрэг асуудлыг байгаль орчинд халгүйгээр иж бүрэн шийдвэрлэх шаардлагатай болдог бөгөөд үүнийг хамгийн энгийн хэллэгээр “Хог хаягдлын менежмент” гэдэг.

Хатуу хог хаягдлыг ангилах, хадгалах, цуглуулах, дахин боловсруулах, эргүүлэн ашиглах, зохистой устгах үйл ажиллагаа нэгдсэн зөв менежментгүй, ангилалгүйгээр зориулалтын бус тээврийн хэрэгслээр зөөж, зохистой боловсруулалтгүйгээр хот суурингийн орчимд ландфил технологиор дарж, булах болон заагдсан цэгт асгадаг бөгөөд зориулалтын бус газар хаясан хууль бус хогийн талбай улам бүр тэлж байгаагаас гадна хөрсний бохирдол тэр чинээгээр ихэсгэдэг.

Энэхүү Баруун бүсийн логистик төвийн хог хаягдлын менежментийн төлөвлөгөө нь бүтээн байгуулалт, барилгын ажлын үе шатны менежментийн багц төлөвлөгөөнүүдийн нэг хэсэг байх бөгөөд барилгын ажлын явцад гарах чулуулаг болон хөрс хуулалт, үйлдвэрлэлийн циклээс гарах ахуйн болон үйлдвэрийн хаягдал, үйлчилгээний байгууллагуудын хуурай, шингэн хаягдлын эх үүсвэр, тээвэрлэлт, устгал зэрэг ажилбаруудыг багтаасан байна.

Мөн төслийн авто зам талбайг барих, сайжруулах, усны цооногийн талбай, ус хангамжийн шугам хоолой байгуулах, төслийн дэд бүтцийн барилгын ажил болон Баруун бүсийн логистик төвийн үндсэн объектуудын бүтээн байгуулалтаас аюултай болон аюулгүй ахуйн хог хаягдлын аль аль нь үүсэж болох юм.

Хүснэгт 8. 2 Баруун бүсийн логистик төвийн хог хаягдлын эх үүсвэр



Эх үүсвэр төрөл	Шийдэл
Бүтээн байгуулалтын шатанд үүсэх барилгын хог хаягдал	Логистик төвийн нутаг дэвсгэрт цуглуулж Сумын төвлөрсөн хог цэг рүү зайлуулах
Үйл ажиллагааны явцад үүсэх ахуйн хаягдал	Логистик төвийн нутаг дэвсгэрт цуглуулж Сумын төвлөрсөн хог цэг рүү зайлуулах

Хог хаягдлын менежментийг буруу хийснээс үүсэх нөлөөллүүдээс дурдвал:

- Хөрс, газрын ургамалжилтад үзүүлэх нөлөөлөл;
- Гүний ба хөрсний усны эх үүсвэрт нэвчиж нөлөөлөх,
- Дахин боловсруулах хог хаягдлын ангилан ялгалтыг муу хийснээс үүсэх нөөцийн үргүй зардал;
- Үзэгдэх нөлөөлөл /үзэмжгүй байдал;
- Ургамал, амьтдад үзүүлэх нөлөөлөл;
- Хүний эрүүл мэндэд үзүүлэх нөлөөлөл (тухайн талбай дахь хортой хог хаягдлыг зохих журмын дагуу хадгалаагүй тохиолдолд);


Төлөвлөлтийн шийдэл

Баруун бүсийн логистик төвийн бүтээн байгуулалт, барилгын үе шатанд үүсэх эрсдэлийн хог хаягдлыг холбогдох стандартууд болон барилга угсралтын үе шатанд үүсэх, эрдсийн хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний дагуу зохицуулах болно.

Хог хаягдлын менежментийн зорилго: Баруун бүсийн логистик төвийн үйл ажиллагаанаас үүдэлтэй хогийг зайлуулах явдал болно.

Логистик төвийн нутаг дэвсгэрт хог цуглуулах бункерыг төлөвлөсөн ба улмаар сумын төвийн төвлөрсөн хогийн цэг рүү зөөвөрлөж зайлуулна.

Зураг 8. 2 Хог хаягдал цуглуулах, зайлуулах схем



Логистик төв дээр сард 121 тн буюу жилд 1.4 мянган тн хог цугларах бөгөөд цугларсан хогийг Улаангом сумын төвийн хогны төвлөрсөн цэг рүү сард 4 удаа зайлуулна.

Хүснэгт 8.3 Хог хаягдлын тооцоо

№	Эх үүсвэрийн төрөл	Хэмжих нэгж	Нэгжид ногдох хаягдлын хэмжээ, хоногийн дундаж	Эх үүсвэр тоо	Хог хаягдлын эх үүсвэрийн хэмжээ	
					Сард, тн	Жилд, тн
1	Ажилчдын хог хаягдал	кг/ажилтан /хоног	0.5	400	6.00	72.00
2	Үйлчлүүлэгчдийн хог хаягдал	кг/үйлчлүүлэгч /хоног	1.917	2,000	115.02	1,380.24
	Нийт				121.02	1,452.24
	Тээвэрлэх рэйс тоо				4	48

8.3 ГАМШГИЙН МЕНЕЖМЕНТ

"Монгол улсын "Гамшгаас хамгаалах тухай" хуулийн 9-р зүйлийн 9,8-д "Гамшгийн үеийн аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох арга хэмжээг хэрэгжүүлэхдээ хүч хэрэгсэл дайчлан гаргаж, хүн ам, эд хөрөнгийг нүүлгэн шилжүүлж болно. Гамшгийн үед хүч хэрэгсэл дайчлан гаргах журмыг Засгийн газар батална" гэсэн заалтыг үндэслэн Засгийн газрын 2011 оны 11-р сарын 30-ны өдрийн 340 дүгээр тогтоолоор "Гамшгийн үед нүүлгэн шилжүүлэх журам" батлагдсан.

Гамшиг болоход нөлөөлөх гол хүчин зүйлүүд:

- Аюулт үзэгдэл
- Ядуурал



- Хотжилт
- Мэдээлэл дутагдалтай байх
- Дайн ба иргэний хөдөлгөөн
- Хүрээлэн буй орчны доройтол
- Шилжилт хөдөлгөөн
- Хүн амын өсөлт

Зураг 8. 3 Гамшиг гэсэн ойлголт дараах хүчин зүйлүүдээр тодорхойлогдоно.



Зураг 8. 4 Гамшгаас хамгаалах менежмент

Гамшгийн өмнө	Гамшгийн үед	Гамшгийн дараа	
Урьдчилан сэргийлэх	Аврах	Хор уршгийг арилгах	Сэргээн босгох
Эрсдэлийн үнэлгээ хийх	Зарлан мэдээлэл	Нэн чухал дэд бүтэц, үйлчилгээ сэргээх	Барилга, байгууламж, дэд бүтцийг сэргээн засварлах
Эрсдэлийг бууруулах	Эрэн хайх, аврах	Хохирлыг тооцох, арилгах	Нийгмийн үйлчилгээг хэвийн болгох
Гамшгаас хамгаалах төлөвлөгөө	Яаралтай тусламж хүргэх	Нөөцөөр хангах	Гамшгийн дараах дүн шинжилгээ, туршлага сургамж
Зарлан мэдээлэх систем	Нүүлгэн шилжүүлэх	Тусламж хүргэх	Дахин төлөвлөлт
Нөөц		Ариутгал халдваргүйжил	
Сургалт, сурталчилгаа			
Дадлага сургууль			

Гамшгийн менежментийг төлөвлөхдөө гамшгаас зарлан мэдээлэх дуут дохио болон гал түймрийн аюулаас хамгаалах галын гидрантуудыг төлөвлөсөн.

Гамшгийн эрсдэлийн үед хүн ам түр цуглах талбайд (үйлчлэх хүрээ R=500м) цуглах ба цуглах талбайг логистик төвөөс гарах гарцад ойр байдлаар 2 байршилд гадаа талбайг сонгож төлөвлөсөн.

Гамшгийн үед албан хаагчид, зорчигч иргэдийн түр цугларах талбайг бий болгож аймаг, Логистик төвийн удирдлага, орон нутгийн удирдлагын захирамжаар баталгаажуулж Онцгой байдлын албаны тусгай хэрэгцээний газар болгож иргэдийн аюулгүй байдлыг хангана.

Зураг 8. 5 Гамшгийн менежмент



Мөн түүнчлэн галын гидрантыг 200 метр радиуст үйлчлэх боломжтой 1 байршилд төлөвлөсөн.

Гал болон бусад гамшгийн менежментийн хүчин зүйлийн үед Гал команд болон Аврах ангийн машин техник саадгүй нэвтрэх үүднээс бүх цэгт хүрэх боломжтой зам талбайг төлөвлөсөн. Төслийн хэрэгжилтийн явцад Уг төлөвлөлтийн шийдлийг алдагдуулахгүй байх нь зүйтэй.

БҮЛЭГ 9. САНХҮҮГИЙН ЭДИЙН ЗАСГИЙН ТООЦОО БА ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ

Бүлгийн дэд агуулга:

- ✂ Хөрөнгө оруулалтын тооцоо
- ✂ Хэрэгжүүлэх арга хэмжээний санал
- ✂ Менежмент төлбөрийг тооцох нь
- ✂ Техник эдийн засгийн үзүүлэлт



9.1 ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТООЦОО

9.1.1 Жишиг норм ба итгэлцүүр

Барилгын төсөвт өртгийн тооцоог хийхдээ УБ хот дахь жишиг үнэлгээг байгалийн зарим хүчин зүйлийн нөлөөллийн болон тээврийн итгэлцүүрүүдээр үржүүлж авлаа. 2016 оны 12 сарын 28-ний өдөр ЗГ-ын 203-р тогтоолоор баталсан “Барилгын байгууламжийн нэгж хүчин чадлын жишиг үнэлгээг хэрэглэх дүрэм” /БД 81-106-16/ ашиглалаа.

Итгэлцүүрүүд дараах байдалтай. Үүнд:

- Логистик төвийн байршил нь Увс аймгийн Улаангом хотод байх тул учир зайны итгэлцүүр 1.15 байна,
- Мөн байгалийн хүчин зүйлийн итгэлцүүр IV зэрэглэл буюу 1.18 байна,
- Түүнчлэн барилгын өндрийн итгэлцүүр нь 1 метр тутамд 5%-иар өсөх болно,
- Үнийн итгэлцүүрийг Барилга, хот байгуулалтын сайдын 2022 оны 03 дугаар сарын 31-ны өдрийн 74 дугаар тушаалын дагуу авсан. Үүгээр Орон сууцны барилга 1.81, Иргэний барилга 1.80, Гадна инженерийн шугам сүлжээ 1.77 итгэлцүүртэй, зардлын ерөнхий индекс 1.79 тус тус байна,
- Автозамын хөрөнгө оруулалтыг тооцохдоо дээрх тогтоолд автозамын үнэлгээ ороогүй болохыг харгалзан үзэж 2010 онд батлагдсан “Барилгын нэгж талбайн төсөвт өртөг, төсвийн жишиг үнэлгээ батлах тухай” МУ-ын ЗГ-ын 336 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтад заасан автозамын үнэлгээг 2016 оны Хот байгуулалтын сайдын 36 дугаар тушаал болон дээрх 2022 оны 74 дугаар тушаалд дурдагдсан зардлын ерөнхий индексүүдээр өсгөж авсан. Энэ нь Улаанбаатар хот дахь 1 м2 автозамыг 231988 төгрөг болгож байна. Мөн үүнд зайны итгэлцүүрийг нэмж тооцно.
- Жишигт өртөгт ороогүй төлөвлөлтийн нэгжүүдийн үнэ-ийг Улаанбаатар хот дахь үнэ саналд үндэслэж зайны итгэлцүүрээр тооцож авсан,



9.1.2 Барилга байгууламж ба тохижилтын хөрөнгө оруулалт

Логистик төвийн барилга байгууламжид 28.6 тэрбум төгрөг, тохижилтын ажилд 0.8 тэрбум төгрөг шаардагдаж байна.

Хүснэгт 9.1 Барилга байгууламжийн хөрөнгө оруулалт

Д/д	Барилга байгууламжийн нэр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	нэгж үнэ, мянган төгрөг	Үнийн итгэлцүүр	БХЗИ	зайны итгэлцүүр	Өндөрийн итгэлцүүр	нийт төсөв, сая төгрөг
1	Оффис, лабораторийн барилга	м2	1,512.00	1,265.55	1.80	1.18	1.15	1.00	4,673.94
2	Хүнсний ногооны агуулах	м2	1,008.00	1,054.55	1.80	1.18	1.15	1.20	3,115.74
3	Өргөн хэрэглээний дулаан агуулах	м2	1,008.00	1,054.55	1.80	1.18	1.15	1.20	3,115.74
4	Хөлдөөгч, хөргүүртэй агуулах	м2	1,008.00	1,054.55	1.80	1.18	1.15	1.20	3,115.74
5	Хөдөө аж ахуйн агуулах	м2	1,008.00	1,054.55	1.80	1.18	1.15	1.20	3,115.74
6	Уурын зуухны барилга	м2	162.00	1,253.67	1.80	1.18	1.15	1.00	496.08
7	Дэд өртөөний барилга	м2	70.00	1,253.67	1.80	1.18	1.15	1.00	214.36
8	Ажилчдын байр, худалдаа үйлчилгээний барилга	м2	1,296.00	1,268.39	1.80	1.18	1.15	1.00	4,015.23
9	Авто засварын төв	м2	882.00	893.08	1.80	1.18	1.15	1.10	2,116.43
10	Аж ахуйн барилга	м2	432.00	1,073.35	1.80	1.18	1.15	1.00	1,132.60
11	Ачаа буулгах тавцан	м2	61.20	68.00	1.80	1.18	1.15	1.00	10.17
12	Авто пүү /дотор/	ширхэг	1.00	160,000			1.15	1.00	184.00
13	Нийтийн бие засах газар	м2	50.41	1,073.35	1.80	1.18	1.15	1.00	132.16
14	Агуулах	м2	1,008.00	1,073.35	1.80	1.18	1.15	1.20	3,171.29
15	Харуулын байр	м2	4.00	691.60	1.80	1.18	1.15	1.00	6.76
16	Авто пүү /гадаа/	ширхэг	1.00	160,000			1.15	1.00	184.00
	НИЙТ								28,799.97

Хүснэгт 9.2 Тохижилтын хөрөнгө оруулалт

д/д	Төрөл	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгж үнэ, мянган төгрөг	Үнийн итгэлцүүр	БХЗИ	Зайны итгэлцүүр	Нийт төсөв, сая төгрөг
1	Зүлэг	м2	30,000	11.70	1.77	1.18	1.15	843.06
2	Шар хуас	ширхэг	50	5.00	1.77	1.18	1.15	0.60
3	Гацуур	ширхэг	41	38.30	1.77	1.18	1.15	3.77
4	Нохойн хошуу	ширхэг	50	5.00	1.77	1.18	1.15	0.60
5	Голт бор	ширхэг	50	5.00	1.77	1.18	1.15	0.60
6	Зарлан мэдээлэх систем	ширхэг	1	10,000.00			1.15	11.50
7	Хогийн бунер	ширхэг	1	5,000.00			1.15	5.75
	Нийт							865.89



9.1.3 Дэд бүтцийн хөрөнгө оруулалт

Логистик төвийн дэд бүтцэд 7.6 тэрбум төгрөг шаардагдаж байна.

Хүснэгт 9.3 Тээврийн дэд бүтцийн хөрөнгө оруулалт

д/д	Зам тээврийн хөрөнгө оруулалт	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгж үнэ, мянган төгрөг	Үнийн итгэлцүүр	БХЗИ	Зайны итгэлцүүр	нийт төсөв, сая төгрөг
1	Гадна бараа буулгах талбай	м2	7,500	68.00	1.79	1.18	1.15	1,238.81
2	Авто зам зогсоол /хашаан дотор/	м2	111,093	62.30	1.79	1.18	1.15	16,811.54
3	Авто зам /хашааны гадна/	м2	11,351	231.99			1.15	3,028.29
4	Явган зам талбай	м2	1,536	48.50	1.79	1.18	1.15	180.95
	Нийт							21,259.59

Хүснэгт 9.4 Дулаан хангамжийн хөрөнгө оруулалт

Д/д	Нэр төрөл	Хэмжих нэгж	Тоо хэмжээ			нэгж үнэ, мянган төгрөг	Үнийн итгэлцүүр	БХЗИ	зайны итгэлцүүр	нийт төсөв, сая төгрөг
1	Дулааны шугам	м	458	1,486	1,944	1197.8	1.77	1.18	1.15	5,592.86
2	Гадна дулааны худаг	ш	8		8	6,767	1.77	1.18	1.15	130.03
3	Уурын зуух	ш	2		2	50,000			1.15	115.00
	Нийт									5,837.88

Хүснэгт 9.5 УХАТ хөрөнгө оруулалт

Д/д	УХАТ төлөвлөлт	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	нэгж үнэ, мянган төгрөг	Үнийн итгэлцүүр	БХЗИ	зайны итгэлцүүр	нийт төсөв, сая төгрөг
1	Цэвэр усны шугам, Ф57	метр	296	155.8	1.77	1.18	1.15	110.77
2	Цэвэр усны шугам, Ф89	метр	148	163.5	1.77	1.18	1.15	58.12
3	Бохир усны шугам, Ф100	метр	30	161.4	1.77	1.18	1.15	11.63
3	Бохир цооног	ширхэг	6	1,570.0	1.77	1.18	1.15	22.63
	Нийт							180.52

Хүснэгт 9.6 Мэдээлэл холбооны хөрөнгө оруулалт

Д/д	Холбоо төлөвлөлт	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	нэгж үнэ, мянган төгрөг	Үнийн итгэлцүүр	БХЗИ	зайны итгэлцүүр	Нийт төсөв, сая төгрөг
1	Холбооны сувагчлал	метр	800	96.4	1.77	1.18	1.15	185.23
2	Шилэн кабель - 24 кор	метр	800	5.3	1.77	1.18	1.15	10.18
3	Гадна хяналтын камер	ширхэг	16	220			1.15	4.05
4	Хяналтын камерын шилэн кабель - 24 кор	метр	600	96.4	1.77	1.18	1.15	138.93
5	Хяналтын камерын шилэн кабель - 4 кор	метр	40	9.8	1.77	1.18	1.15	0.94
	Нийт							339.33



Хүснэгт 9. 7 Цахилгааны хөрөнгө оруулалт

Д/д	Цахилгаан төлөвлөлт	Хэмжих нэгж	Тоо хэмжээ			нэгж үнэ, мянган төгрөг	Үнийн итгэлцүүр	БХЗИ	зайны итгэлцүүр	нийт төсөв, сая төгрөг
			1-р ээлж	2-р ээлж	Нийт					
	Цахилгааны шугам									
1	0.4 кВ 3х35+1х16 мм ²	метр	688	2146	2834	39.3	1.77	1.18	1.15	267.51
2	0.4 кВ 3х70+1х35 мм ²	метр	88	313	401	44.7	1.77	1.18	1.15	43.05
3	0.4 кВ 3х95+1х50 мм ²	метр	1047	524	1571	52.4	1.77	1.18	1.15	197.72
4	0.4 кВ 3х185+1х95 мм ²	метр	116	1189	1305	68.5	1.77	1.18	1.15	214.71
	Гэрэлтүүлгийн агаарын утас									
5	0.4 кВ СИП утастай	метр	176	110	286	31.1	1.77	1.18	1.15	21.36
6	0.4 кВ 3х35+1х16 мм ²	метр	1579	1135	2714	39.3	1.77	1.18	1.15	256.19
	Бусад цахилгаан									
7	Гэрэлтүүлгийн шон	ширхэг	67	34	101	450.0	1.77	1.18	1.15	109.17
8	Цамхагт гэрэлтүүлэгч	ширхэг		6	6	7,000.0		1.18	1.15	56.99
9	Лед прожекторон гэрэлтүүлэгч	ширхэг		48	48	450.0	1.77	1.18	1.15	51.88
10	КТП	ширхэг	1		1	29,300.0	1.77	1.18	1.15	70.38
	Нийт									1,288.97



9.1.4 Нийт хөрөнгө оруулалт

Баруун бүсийн Логистикийн нэгдсэн төвийг бүтээн байгуулах үйл ажиллагаа нь 2022-2030 онд хэрэгжихдээ 58.5 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт шаардагдах ба улсын төсөв, концесс, зээл тусламж, хувийн хэвшлийн санхүүжилтээр хэрэгжинэ.

Хүснэгт 9. 8 Цахилгааны хөрөнгө оруулалт

№	Нийт хөрөнгө оруулалт	Сая төгрөг	тэрбум төгрөг	Эзлэх хувь	Эх үүсвэр, тэрбум төгрөг	
					Улсын төсөв	Хувийн хэвшил
1	Барилга байгууламж	28,799.97	28.80	49.2%	9.90	18.90
2	Замын сүлжээ	21,259.59	21.26	36.4%	21.26	
3	Цахилгаан хангамж	1,288.97	1.29	2.2%	1.29	
4	Дулаан хангамж	5,837.88	5.84	10.0%	5.84	
5	Усан хангамж ариутгах татуурга	180.52	0.18	0.3%	0.18	
6	Мэдээлэл холбооны сүлжээ	339.3	0.34	0.6%	0.34	
7	Тохижилт	865.89	0.87	1.5%	0.87	
	Нийт хөрөнгө оруулалт	58,572.15	58.57	100.0%	39.49	19.08
	Эзлэх хувь			100.0%	68%	32%

9.2 ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ САНАЛ

9.2.1 Хэрэгжүүлэх үе шатны санал

Төслийн хөрөнгө оруулалтаас хамааруулан зураг төслийг 2 үе шаттай байхаар тооцов.


Эхний ээлжийн хөрөнгө оруулалтаар 4.61га талбайд оффис, лабораторийн барилга, 4 ширхэг агуулахын барилга, уурын зуухны барилга, дэд өртөөний барилгуудыг төлөвлөн ажлын зураг болон тухайн барилгуудад хамаарах гадна инженерийн шугам сүлжээний зургийг хийж гүйцэтгэв.

Хоёрдугаар ээлжид 13.61га талбайд болон түүнд хамаарагдах барилгуудын хийж гүйцэтгэнэ.

Тус “Баруун бүсийн логистик төв”-ийн талбайд нийт агуулахын ажилчид ашиглах зориулалттай Аж ахуйн нэгдсэн барилгыг төлөвлөсөн. Үүнд хувцас солих байр, дүш ариун цэврийн өрөө, агуулах зэрэг байрлана. Тус барилга нь хөрөнгө оруулалт санхүүжилтээс хамааруулан 2-р ээлжид ажлын зураг төсөв хийгдэх бөгөөд эхний ээлжийн 4 агуулахын ажилчдыг Оффис лабораторийн барилгад байрлуулна. Мөн талбайд нийтийн ариун цэврийн байгууламж тусдаа 2 ширхгийг төлөвлөсөн бөгөөд тухайн хэсгийн ажилчид заавал хол явахгүйгээр ашиглах боломжтой.

Захиалагч талаас худгийн хайгуулын ажил 2023 оноос хийгдэх тул 1 дэх эх үүсвэрээс бус уурын зуухнаас түгээлтээ хийхээр зургийн ажлыг гүйцэтгэхийг хүссэн болно.

Зураг 9. 1 Хэрэгжүүлэх үе шат





9.2.2 Хэрэгжүүлэх үе шатны хөрөнгө оруулалт

Төслийг хэрэгжүүлэх 1-р шатанд 49.6% буюу 29 тэрбум төгрөг шаардагдах бол 2-р шатанд 50.4% буюу 29.5 тэрбум төгрөг шаардагдах болно.

Хүснэгт 9.9 Үе шатны хөрөнгө оруулалт

Д/д	Хөрөнгө оруулалт төрөл	Нийт хөрөнгө оруулалт	Үе шат хөрөнгө оруулалт		1-р шатанд		2-р шатанд	
			1-р шатанд	2-р шатанд	төр	хувийн хэвшил	төр	хувийн хэвшил
A	Барилга байгууламж							
1	Оффис, лабораторийн барилга	4,673.94	4,673.94		4,673.94			
2	Хүнсний ногооны агуулах	3,115.74	3,115.74			3,115.74		
3	Өргөн хэрэглээний дулаан агуулах	3,115.74	3,115.74			3,115.74		
4	Хөлдөөгч, хөргүүртэй агуулах	3,115.74	3,115.74			3,115.74		
5	Хөдөө аж ахуйн агуулах	3,115.74	3,115.74			3,115.74		
6	Уурын зуухны барилга	496.08	496.08		496.08			
7	Дэд өртөөний барилга	214.36	214.36		214.36			
8	Ажилчдын байр, худалдаа үйлчилгээний барилга	4,015.23		4,015.23			4,015.23	
9	Авто засварын төв	2,116.43		2,116.43				2,116.43
10	Аж ахуйн барилга	1,132.60		1,132.60				1,132.60
11	Ачаа буулгах тавцан	10.17		10.17			10.17	
12	Авто пүү /дотор/	184.00		184.00			184.00	
13	Нийтийн бие засах газар	132.16		132.16			132.16	
14	Агуулах	3,171.29		3,171.29			-	3,171.29
15	Харуулын байр	6.76		6.76			6.76	
16	Авто пүү /гадна/	184.00	184.00		184.00			
	Бүгд	28,799.97	18,031.34	10,768.63	5,568.38	12,462.96	4,348.31	6,420.32
B	Инженерийн дэд бүтэц							
16	Цахилгаан хангамж	1,288.97	530.24	758.73	530.24		758.73	
17	Дулаан хангамж	5,837.88	1,447.69	4,390.20	1,447.69		4,390.20	
18	Усан хангамж ариутгах татуурга	180.52	180.52		180.52			
19	Мэдээлэл холбооны сүлжээ	339.33	339.33		339.33			
	Бүгд	7,646.70	2,497.78	5,148.93	2,497.78	-	5,148.93	-
B	Зам талбай ба тохижилт							
20	Замын сүлжээ	21,259.59	8,503.84	12,755.76	8,503.84		12,755.76	



2								
1	Тохижилт	865.89		865.89				
	Бүгд	22,125.48	8,503.84	13,621.64	8,503.84	-	12,755.76	-
	Нийт	58,572.15	29,032.95	29,539.20	16,569.99	12,462.96	22,253.00	6,420.32
	Эзлэх хувь бүгдэд	100.0%	49.6%	50.4%	28.3%	21.3%	38.0%	11.0%
	Эзлэх хувь үе шатанд				57.1%	42.9%	75.3%	21.7%

9.3 МЕНЕЖМЕНТ ТӨЛБӨРИЙГ ТООЦОХ НЬ

Логистик төвийн менежментийн төлбөрийг тооцохын тулд юун түрүүнд түүний үйл ажиллагааны зардлыг тооцох шаардлагатай. Тус цогцолборын үйл ажиллагааны зардал гэдэгт цалин, ажиллах хүчтэй холбоотой зардлууд, засвар үйлчилгээ, оффис талбайн ашиглалтын зардал болон бусад үйл ажиллагаатай холбоотой зардлууд тооцогдоно.

Зардлуудыг дараах байдлаар нормчилж авлаа. Үүнд:

- ⇒ Нийгмийн даатгалын шимтгэл нь шинээр батлагдсан хуулийн дагуу 12.5%-иар тооцсон,
- ⇒ Засвар үйлчилгээний зардал нь нийт хөрөнгө оруулалтын 0.1%-иар нормчилсон,
- ⇒ Хангамжийн зардал нь 1 ажилтанд сард 15,000 төгрөг,
- ⇒ Үл хөдлөх хөрөнгийн татвар шинэ хуулийн дагуу нийт үнийн дүнийн 0.6%,
- ⇒ Газрын төлбөрийг УВС АЙМГИЙН ИТХ-ын 2022-03-03-ний өдрийн №7/07 тогтоолын 9-р хавсралтад заасны дагуу Логистик төв нь үнэлгээний 1-р ангилалд харьяалагдаж 1 м2 газрын төлбөр 20 төгрөг,
- ⇒ Ашиглалтын зардал нь Улаангом сумын төвийн инженерийн хангагч байгууллагуудын үнийн нөхцөлөөр тооцоолсны дагуу,
- ⇒ Элэгдлийн зардлыг 2019 оны 3 сарын 22-нд шинэчлэн батлагдсан ААНОАТ-ийн тухай хуулийн 17-р зүйлийн дагуу 25 жилээр,
- ⇒ Хөдөлмөр хамгаалал, хамгаалах хэрэгслийн зардал нь 1 ажилтанд жилд 250,000 төгрөг,
- ⇒ Хогны төлбөр тээвэрлэх рейсийн тоогоор тооцоолсноор,
- ⇒ Шуудан харилцаа холбооны зардал нь 1 хүнд сард 20000 төгрөг,
- ⇒ Бусад ба болзошгүй зардал нь нийт мөнгөн дүнгээр тооцсон зардлын 1%,

Дээрх зардлын нөхцөлөөр үйл ажиллагааны тогтмол зардлыг тооцож үзэхэд:

- Элэгдэл зардал оролцуулсан нийт зардал жилд 3.1 тэрбум төгрөг байх бол элэгдэл зардалгүй мөнгөн дүнгээрээ 0.8 тэрбум төгрөг байх болно. Тус Логистик төвийн элэгдэл зардал нь нийт зардлын 74%-ийг бодитоор эзэлж байна,



- Эндээс үүдэлтэйгээр 1м2 барилга тутамд ногдох түрээсийн төлбөр элэгдлийн зардлыг оролцуулсан тохиолдолд 305 мянган төгрөг, элэгдэл зардал тооцоогүй тохиолдолд 60 мянган төгрөг болж байна,
- Элэгдэл зардал тооцоогүй байх үеийн гол зардал нь менежментийн цалин, нийгмийн даатгалын шимтгэл (51.9%), үл хөдлөх хөрөнгийн татвар (29.1%), засвар үйлчилгээний зардлууд (10.1%) байна,



Хүснэгт 9. 10 Үйл ажиллагааны зардал ба 1 м2 талбайд ногдох өртөг

Д/д	Зардлын төрөл, жилд	Хэмжих нэгж	Үзүүлэлт	Нэгж үнэлгээ	Сард	Жилд	1 м2 барилгын талбайд ногдох нь, жилд	Бүгдэд эзлэх хувь	Элэгдэл зардалгүй эзлэх хувь
1	Цалин хөлс	тооцоолсноор			22,400,000	268,800,000	28,049	9.2%	46.1%
2	Нийгмийн даатгалын шимтгэл	цалингийн 12.5%			2,800,000	33,600,000	3,506	1.1%	5.8%
3	Ашиглалт зардал	1 м2 тутамд, сард	9583.11	200	1,916,622	22,999,464	2,400	0.8%	3.9%
4	Элэгдлийн зардал	хуулийн дагуу			195,240,515	2,342,886,178	244,481	80.1%	
5	Засвар, үйлчилгээний зардал	үндсэн хөрөнгөөс, жилд	хувь	0.1	4,881,013	58,572,154	6,112	2.0%	10.1%
6	Хангамжийн материалын зардал	1 ажилтан тутамд, сард	15	15000	225,000	2,700,000	282	0.1%	0.5%
7	Хөдөлмөр хамгаалал, хамгаалах хэрэгсэл	1 ажилтан тутамд, жилд	15	250000	312,500	3,750,000	391	0.1%	0.6%
8	Шуудан харилцаа холбоо, бичиг хэрэг зардал	1 ажилтан тутамд, сард	15	20000	300,000	3,600,000	376	0.1%	0.6%
9	Хог төлбөр	рэйс тоо, сард	4	200000	800,000	9,600,000	1,002	0.3%	1.6%
10	Үл хөдлөх хөрөнгийн татвар	үндсэн хөрөнгөөс, жилд	хувь	0.6	14,141,443	169,697,321	17,708	5.8%	29.1%
11	Газар төлбөр	1 м2 тутамд, жилд	182200	20	303,667	3,644,000	380	0.1%	0.6%
12	Бусад ба болзошгүй зардал				480,802	5,769,629	602	0.2%	1.0%
	Үйл ажиллагааны зардлын дүн, жилд				243,801,562	2,925,618,747	305,289	100.0%	
	Мөнгөн зарлага /ОРЕХ/				48,561,047	582,732,569	60,808	19.9%	100.0%



9.4 ТЕХНИК ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТ

Хүснэгт 9. 11 Техник эдийн засгийн үзүүлэлт

№	Үзүүлэлтүүд	Хэмжих	Одоогийн	Төлөвлөлт- 2030	Эхний ээлж - 2025
1	Төлөвлөлтийн газар нутаг	Га		18.22	4.61
Хүн ам, өрх					
1	Хөдөлмөрийн зах зээл	Ажлын байр		400	160
2	Үйлчлүүлэгчид	хүн/хоног		2000	800
Нутаг дэвсгэрийн бүтэц					
1	Нэвтрэх хэсэг	га		1.18	1.18
2	Худалдаа үйлчилгээ бүс	га		1.68	1.68
3	Хүлээлгийн бүс	га		3.13	
4	Задгай агуулах бүс	га		2.88	
5	Агуулах бүс	га		1.71	1.00
6	Нөөц агуулах бүс	га		6.82	
7	Дэд бүтцийн бүс	га		0.55	0.55
8	Гарах хэсэг	га		0.2	0.20
9	Нийт	га		18.22	4.61
Замын сүлжээ, байгууламж					
1	Гадна бараа буулгах талбай	м2		7,500	3,000
2	Авто зам зогсоол /хашаан дотор/	м2		111,093	44,437
3	Авто зам /хашааны гадна/	м2		11,351	4,540
4	Явган зам талбай	м2		1,536	614
Инженерийн дэд бүтцийн хангамж					
Дулаан хангамж					
1	Дулааны шугам	м		1,944	458
2	Гадна дулааны худаг	ш		8	8
3	Уурын зуух	ш		2	2
Цахилгаан хангамж					
1	0.4 кВ 3х35+1х16 мм2	метр	-	2,834	688
2	0.4 кВ 3х70+1х35 мм2	метр	-	401	88
3	0.4 кВ 3х95+1х50 мм2	метр	-	1,571	1,047
4	0.4 кВ 3х185+1х95 мм2	метр	-	1,305	116
5	Гэрэлтүүлгийн агаарын утас				-
6	0.4 кВ СИП утастай	метр		286	176
7	0.4 кВ 3х35+1х16 мм2	метр		2,714	1,579
8	Гэрэлтүүлгийн шон	ширхэг		101	67
9	Цамхагт гэрэлтүүлэгч	ширхэг		6	-
10	Лед прожекторон гэрэлтүүлэгч	ширхэг		48	-
11	КТП	ширхэг		1	1
Усан хангамж					
1	Цэвэр усны шугам, Ф57	метр		296	296
2	Цэвэр усны шугам, Ф89	метр		148	148
Ариутгах татуурга					
1	Бохир усны шугам, Ф100	метр		30	30
2	Бохир цооног	ширхэг		6	6
Мэдээлэл холбоо					
1	Холбооны сувагчлал	метр		800	800
2	Шилэн кабель - 24 кор	метр		800	800
3	Гадна хяналтын камер	ширхэг		16	16
4	Хяналтын камерын шилэн кабель - 24 кор	метр		600	600
5	Хяналтын камерын шилэн кабель - 4 кор	метр		40	40



Ногоон байгууламжийн төлөвлөлт					
1	Зүлэг	Га		3.00	-
2	Мод	Га		0.40	-
	Нийт	га		3.40	-
Хөрөнгө оруулалтын нэгдсэн тооцоо					
1	Барилга байгууламж	Тэрбум.төг		28.80	18.03
2	Тээврийн дэд бүтэц	Тэрбум.төг		21.26	8.50
3	Инженерийн дэд бүтэц	Тэрбум.төг		8.51	2.50
4	Төхижилт	Тэрбум.төг		0.87	-
	Нийт			58.57	29.03